



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



# 2021-2022 оны хичээлийн ЖИЛИЙН ТАЙЛАН



Улаанбаатар хот  
2022 он

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛЬ**

# **2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2022 он

Хянасан:

Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, дэд профессор, доктор (Ph.D)  
Ж.Арслан

Хянан тохиолдуулсан:

Доктор (Ph.D) Ө.Оюунхүү

Эмхэтгэсэн:

ЗХНГ-ын мэргэжилтэн Ш.Доржсүрэн

Үсгийн гагнитур: Times New Roman

Хэвлэлийн хэмжээ: B5 /176x250/

Хэвлэлийн хуудас:24.66

Хэвлэсэн тоо: 200 ширхэг

ШУТИС, Хэвлэлийн газарт хэвлэв



## ӨМНӨХ ҮГ

ШУТИС-ийн Эрдмийн хамт олон өнгөрсөн 2021-2022 оны хичээлийн жилд “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, их сургууль, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх” үндсэн зорилго, зорилтуудыг дэвшүүлэн амжилттай ажиллалаа. Мөн Боловсролын болон Шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100, 101 жилийн ойг угтаж их сургуулийн хэмжээнд ухаалаг, эко, ногоон орчин бүрдүүлэх талаар манай профессор багш нар, ажилтнууд, оюутан суралцагчид олон сайхан ажлыг санаачлан хийж гүйцэтгэсэн байна. Өнгөрсөн хичээлийн жилийн цахим сургалтын гол онцлог, үр дүн бол шинэ арга зүй, агуулгаар цахим сургалтын системээ хөгжүүлж дэвшилтэт технологиудыг сургалтад идэвхтэй хэрэглэх болсонд орших ба түүнчлэн элсэлт, төгсөлтийг цахим хэлбэрээр гүйцэтгэн, шинээр элсэгчдийн хуваарь сонголтыг улсын хэмжээнд цахимаар явуулсан зэрэг ЦАХИМ шилжилтийг хийж гүйцэтгэсэн явдал юм.

Өнөө үед их сургуульд орчин үеийн судалгааны тэргүүлэх лабораториуд, гарааны компаниуд шинээр байгуулах, Олон улсын Эрдэм шинжилгээний хурал, ОУ-тай хамтарсан судалгааны ажлыг зохион байгуулах зэргээр эрдэм судлалын хөгжилд ахиц дэвшил гарсан жил боллоо. Судалгааны их сургуулийг хөгжүүлэх чиглэлээр бусад их сургуулиудад жишиг болохуйц, дээд боловсролын онол, арга зүйн асуудлаар цуврал нээлттэй хичээлүүдийг (МООС) шинээр бэлтгэн, цахим сургалт явуулах бэлтгэлийг бүрэн хангасан байна.

Түүнчлэн манай их сургуулийн эрдэмтэн багш нар сургалтын орчин үеийн агуулга, стандартад нийцүүлэн их сургуулийн 100 үндсэн сурах бичигтэй болох зорилт тавьж, амжилттай хийж гүйцэтгэлээ.

2021-2022 оны хичээлийн жил “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн 2 жил байлаа. Стратеги төлөвлөгөөний хүрээнд ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтны оролцоонд тулгуурлан 2030 онд дэлхийн шилдэг 1000 сургуулийн эгнээнд багтаж, дэлхийн жишигт нийцсэн их сургууль болон хөгжих, төр бизнесийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэгч нь байх зорилго, зорилтууд дэвшүүлсэн юм.

Иймээс Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдтэй уялдуулан их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх, орон нутаг дахь их, дээд сургуулийн салбаруудыг сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн цогцолбор байдлаар төрөлжүүлэх, тухайн бүс нутаг болон орон нутгийн боловсрол, нийгэм, эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймагт Технологийн сургуулийг шинээр нээж энэ хичээлийн жилд нээлтээ хийснийг хэлэхэд таатай байна.

ШУТИС-ийн харьяа Өмнөговь технологийн сургуульд дотоодын болон олон улсын дээд боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагуудаар магадлан итгэмжлэгдсэн, дэлхийн тэргүүлэх их сургуулиудын хөтөлбөрийг нутагшуулсан, CDIO стандарт арга зүйг нэвтрүүлсэн, “Уул уурхайн ашиглалтын технологи”, “Мэдээллийн технологи”, “Газрын тосны инженер”, “Цахилгааны инженер” хөтөлбөрүүдээр мэргэжилтэн бэлтгэхээр элсэлтээ авсан болно.

ШУТИС-ийн тэргүүлэх хөтөлбөрүүдээр сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн цогцолбор Өмнөговь технологийн сургуульд бэлтгэгдсэн инженер, технологийн



мэргэжилтнүүд эх орныхоо хэрэгцээтэй газарт эзэмшсэн мэргэжлээрээ үр бүтээлтэй ажиллаж, эх орныхоо геологи, уул уурхай, эрчим хүч, барилга, тээвэр, холбоо, хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн болон эдийн засаг, нийгмийн олон салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах цаг удахгүй гэдэгт итгэлтэй байна.

Монгол улсын Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд ШУТИС олон ажлуудыг манлайлан ажиллаж, гүйцэтгэлийг хангах зорилгоор тодорхой төлөвлөгөө гарган, холбогдох ажлын хэсгүүд байгуулсан байна. Тухайлбал, их сургуулийн элсэлтийн шалгалтын олон улсын агуулга, үнэлгээг (SAT г.м.) нэвтрүүлэх, их сургуулиуд оюутнаа өөрсдөө үнэлж элсүүлдэг байх тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулах, бэлтгэл ажлын талаар харьцуулсан судалгаа хийж, энэ талаар тодорхой санал боловсруулсан юм. Мөн их сургуулиуд дундын зарим нэгдсэн сурах бичиг боловсруулж гаргахад идэвхтэй хамтран ажиллалаа.

ШУТИС болон Рио Тинто компани, Оюу толгой компанитай хамтран хэрэгжүүлэх Уул уурхайн геотехникийн мэргэжил олгох, олон улсын судалгааны төв байгуулах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, холбогдох төслийн ажлыг эхлүүлээд байна. Энэхүү Рио Тинто болон Оюу толгой компанийн санхүүжилтээр хэрэгжих төслийн үр дүнд ШУТИС геотехникийн чиглэлээр олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөртэй болно. Ингэснээр бид Азидаа өрсөлдөхүйц хэмжээний сургалт, судалгааны төв болох зорилгоо биелүүлэхэд нэг алхам ойртоод зогсохгүй дан ганц Монголоос гэлтгүй дэлхийн бусад орноос ч бас энэ чиглэлээр оюутан элсүүлж, уул уурхайн мэргэжилтнүүдийг бэлтгэх боломжтой болох юм.

Ийнхүү 2021-2022 оны хичээлийн жил ШУТИС-ийн цаашдын хөгжил, дэвшилд түлхэц өгсөн, зохих үр дүнтэй хичээлийн жил боллоо.

Хичээлийн шинэ жилд бид дээрх ололт, амжилтаа улам бататгаж, “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, улмаар судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих эрхэм зорилтуудаа улам илүү үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах болно.

ШУТИС-ийн Эрхэм хүндэт профессор багш нар, ажилтнууд, оюутан суралцагчид та бүхэнд шинэ хичээлийн жилдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе!

Эрдэм номын эрхэм буян эгнэгт дэлгэрэх болтугай!

РЕКТОР Т.НАМНАН



# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

---

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ШУТИС нь 2020-2021 оны хичээлийн жилд Улаанбаатар хотод 10, орон нутагт 1, нийт 11 бүрэлдэхүүн сургууль, харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, ШУТИС-ийн харьяа ЕБС-ийн ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 2 төв, бүрэлдэхүүн 2, харьяа 2 хүрээлэн үйл ажиллагаа явууллаа.

ШУТИС-ийн захиргаа, удирдлагын түвшинд 5 газар, 8 алба, 4 төвтэй ажиллав. ШУТИС-ийн удирдлагын баг ШУТИС-ийн ректор, Захиргаа, хүний нөөцийн газар, Сургалтын бодлого зохицуулалтын газар, Эрдэм шинжилгээ, инновацын газар, Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газар, Хөрөнгө оруулалт, хангамжийн газар, Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба, Оюутны соёл, үйлчилгээний алба, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба, Маркетинг, олон нийттэй харилцах алба, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба, Байр ашиглалтын нэгдсэн алба, Нээлттэй боловсролын төв, Мэдээллийн технологийн төв, Технологи дамжуулах төв, Эрүүл мэнд, спортын төв, Шинжлэх ухаан технологийн төв номын сан, ШУТИС-Хэвлэлийн газартай тухайн хичээлийн жилд ажиллалаа.

### 1.1. УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

2021-2022 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/125 тоот тушаал, хамт олны төлөөллийг ШУТИС-ийн Захирлын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/199 тоот тушаалаар баталсан удирдах зөвлөл 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл ажиллав.

### ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.1

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
<b>I. Төрийн төлөөлөл</b>			
1	Дарга	Г.Ганбаяр	Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд
2	Дэд дарга	Г.Батнэмэх	Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
3	Гишүүн	Д.Одгэрэл	Боловсрол, шинжлэх ухааны яамны Инновац, технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
4		Б.Ерэн-Өлзий	Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
5		Б.Доржсэмбэд	Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга
6		Б.Анхбаяр	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга
7		Л.Чой-Иш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
8		Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн худалдаа, зохицуулалтын хэлтсийн дарга
9		Г.Чинзориг	Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга
<b>II. Хамт олны төлөөлөл</b>			
10	Гишүүн	Н.Доржбалдан	Барилга, архитектурын сургуулийн Архитектурын сургуулийн ахлах багш
11		Ц.Тэнгис	Мэдээлэл холбооны технологийн сургуулийн Электроникийн салбарын дэд профессор
12		Ч.Ганбаатар	Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрийн инженерчлэлийн салбарын дэд профессор



13	Д.Болор	“Эн Си Эс” ХХК-ийн гүйцэтгэх захирал
14	Л.Баяр-Эрдэнэ	“ШУТИС-Бидний бахархал” төгсөгч, дэмжигчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга
15	Б.Мягмарренчин	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/119 дугаар тушаалаар ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн төлөөллийг шинэчлэн батлав.

Шинэчлэн баталсан Удирдах зөвлөлийн эхний хурал 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр болж, үүсгэн байгуулагчийн санал болгосон Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжлэх ухаан технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар сонгогдов.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн зарим хурлыг цахимаар зохион байгуулсан.

ШУТИС-ийн Удирдах зөвлөл 2021-2022 оны хичээлийн жилд 5 удаа хуралдаж

1. 2021-2022 оны хичээлийн жилийн ШУТИС-ийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ, оюутны байрны төлбөрийг батлах тухай

2. ШУТИС-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүн, аудитын дүгнэлт

3. ШУТИС-ийн 2021 оны төсвийн тодотгол

4. Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа сургууль байгуулах тухай

5. ШУТИС-ийн 2022 оны төсвийн төсөл

6. ШУТИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ

7. ШУТИС-ийн харьяа хүрээлэнгүүдийн талаар авах арга хэмжээний тухай

8. ШУТИС-ийн Удирдах Зөвлөлийн дарга, орлогч даргыг сонгох, нарийн бичгийн дарга томилох тухай.

9. ШУТИС-ийн өнөөгийн байдлын танилцуулга.

10. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд элсүүлэх бакалавр оюутны элсэлтийн хяналтын тоог батлах зэрэг асуудлыг хэлэлцэж 11 тогтоол гаргаж, хурлын шийдвэрийг тухай бүрт нь их сургуулийн веб сайтаар дамжуулан мэдээлэл хүргэсэн байна.

Удирдах зөвлөлийн гишүүд 2021-2022 оны хичээлийн жилийн хугацаанд ШУТИС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уулзалт семинар бусад арга хэмжээнд оролцож, их сургуулийг хөгжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлж ажиллав.

## 1.2. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл 1 удаа хуралдаж, эрдмийн ба хүндэт цол олгох, сургалтын хөтөлбөрт мэргэжлийн чиглэл нэмэх тухай асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэрлэлээ. Тус хуралдаанаар:

- ✓ ШУТИС-ийн Хүндэт профессор цол-3 хүн,
- ✓ Профессор цол-4 хүн,
- ✓ Дэд профессор цол-24 хүнд олгохоор шийдвэрлэв.





**ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал**

*Хүснэгт 1.2*

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
1	Эрдмийн ба хүндэт цол олгох тухай	2022.06.20	№03, 04, 05, 06, 07
2	Сургалтын хөтөлбөрт мэргэжлийн чиглэл нэмэх тухай	2022.06.20	№08

**Дэд зөвлөлийн хурал**

Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд эрдэм шинжилгээний хуанли, төлөвлөгөөний дагуу хуралдсан.

**Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал**

*Хүснэгт 1.3*

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Үр дүн
<b>Инновацын дэд зөвлөл</b>			
1	ШУТИС-ийн технологийн сангийн санхүүжилттэй төслийн тайлан	2022.05.13	Нийт 8 төсөл хэлэлцүүлж, 4 төслийн хугацааг сунгах, 4 төслийн эцсийн тайлан хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэв.
2	ШУТИС-ийн бүтээлийн хуулбарлалтыг шалгах түр журам	2022.04	Журмын төслийг хэлэлцэж, Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
<b>Эрдмийн ба хүндэт цолны зөвлөл</b>			
1	Эрдмийн ба хүндэт цол олгох асуудал	2022.06.06	Хүндэт цолд 3, профессорт 4, дэд профессорт 24 нэр дэвшигчийн асуудлыг хэлэлцэж дэмжив.

**ШУТИС-ийн Хүндэт ба Эрдмийн цол хүртэгчсэд**

*Хүснэгт 1.4*

№	Овог нэр	Байгууллага	ЭЗ-ийн тогтоолын тогтоол
<b>Хүндэт профессор</b>			
1	Лувсанцэрэн Мангал	Барилга, архитектурын сургуулийн төгсөгч, МУ-ын Зөвлөх инженер	2022.06.20, №05
2	Отгон Жадамбаа	Барилга, архитектурын сургуулийн төгсөгч, МУ-ын Зөвлөх инженер	2022.06.20, №06
3	Чулуун Наранцогт	“Оюу толгой” ХХК, хүний нөөцийн менежер /ГУУС-иас нэр дэвшигч/	2022.06.20, №07
<b>Профессор</b>			
1	Баатар Мөнхцэнгэл	ГУУС, Геологи, гидрогеологийн салбарын профессор	2022.06.28, №03
2	Ганбат Батдэмбэрэл	ХШУС, Физикийн тэнхимийн профессор	2022.06.20, №03
3	Бүдээбазар Авид	ШУА-ийн ЭНБД	2022.06.20, №03
4	Бүлтгэр Түмэндэмбэрэл	ХШУС, Үл эвдэх сорилын төвийн захирал	2022.06.20, №03



Дэд профессор			
1	Дамбий Бямбасүрэн	Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газрын дарга	2022.06.20, №04
2	Дашжамц Баярмаа	БУХС, Бизнесийн удирдлагын салбарын дэд профессор	2022.06.20, №04
3	Дашзэвэг Мягмарсүрэн	Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал	2022.06.20, №04
4	Нэргүй Мэнд	ГХС, ЭНБД	2022.06.20, №04
5	Баяраа Батхишиг	ГУУС, Чанарын менежер	2022.06.20, №04
6	Ойдов Мөнхцэцэг	ГУУС, Геологи, гидрогеологийн салбарын профессор	2022.06.20, №04
7	Жигжжав Мягмаржав	МехТС, Тээврийн салбарын гэрээт багш	2022.06.20, №04
8	Цоодол Нямдулам	МехТС, Тээврийн салбарын дэд профессор	2022.06.20, №04
9	Сэндэн Дэлгэрмаа	МехТС, Техникийн механикийн тэнхимийн ахлах багш	2022.06.20, №04
10	Омоонцоо Галаа	МехТС, Машин үйлдвэрлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
11	Самданцоодол Ариунбаяр	МехТС, Тээврийн салбарын дэд профессор	2022.06.20, №04
12	Жанчив Азжаргал	МехТС, Тээврийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
13	Даваадорж Буяндэлгэр	ҮТС, Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын дэд профессор	2022.06.20, №04
14	Дугарсүрэн Батбаяр	ҮТС, Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
15	Баасан Баярцэцэг	ҮТС, Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
16	Осорхүү Гансайхан	ҮТС, Хүнсний инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
17	Сэр-Од Сэржмядаг	ҮТС, Хүнсний инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
18	Эрдэнцог Бат-Эрдэнэ	ХШУС, Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
19	Төмөрсүх Баттөмөр	ХШУС, Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04



20	Алтансүх Доржготов	ХШУС, Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
21	Баясгалан Загдхорол	ЭХС, Цахилгаан техникийн салбарын профессор	2022.06.20, №04
22	Хаянхярваа Сарангэрэл	ЭХС, Цахилгаан техникийн салбарын ахлах багш	2022.06.20, №04
23	Даваажав Пүрэвдаш	ЭХС, Цахилгаан техникийн салбарын дэд профессор	2022.06.20, №04
24	Доржсүрэн Цогзолмаа	Оюутны соёл, үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн	2022.06.20, №04

### 1.3. ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

2021-2022 оны хичээлийн жилд ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах санал бүрэлдэхүүн сургууль, нэгж, захиргааны газар, албадаас авч, нэгтгэн батлуулав.

Тайлант хугацаанд захирлын зөвлөлийн хурал батлагдсан төлөвлөгөөний дагуу 27 удаа хуралдаж элсэлтийн хяналтын тоо, төсөв, төсвийн тодотгол, төлөвлөгөө, тайлан баланс, цалин, элсэлт, төгсөлт, сургалтын үйл ажиллагааны тухай, мэргэжил, сургалтын төлбөр, судалгааны төв, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулах, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, бодлогын баримт бичиг, багш, ажилчдын нийгмийн асуудал, гадаад харилцаа, олон улсын тэмцээнд оролцох тухай, аудит болон дотоод хяналт шалгалтын дүгнэлт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл (хөтөлбөрүүд)-ийн явц, үр дүн, засвар тохижилтын ажил, эрдэм шинжилгээний болон сургалтын нэгдсэн хуанли, цаг үеийн асуудлыг хэлэлцсэн.

Дэлхий нийтэд коронавируст COVID-19 цар тахлын халдвар дэгдсэнтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан захирлын зөвлөлийн хурлыг цахим болон танхимаар зохион байгуулсан.

Захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, хурлын тэмдэглэлийн хэсгээс их сургуулийн <https://www.must.edu.mn/mn/content/t/5> веб хуудаст байршуулан ажиллаж байна.

### Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.5

Д/д	Овог нэр	Албан тушаал	Тайлбар
1	Б.Очирбат	ШУТИС-ийн захирал	2022.02.11-ний өдрийг хүртэл
	Т.Намнан	ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч	2022.02.11-ний өдрөөс
2	Х.Энхжаргал	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал	2021.12.24-ний өдрийг хүртэл
	Н.Ганзориг		2021.12.24-ний өдрөөс
3	Т.Намнан	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал	2022.02.11-ний өдрийг хүртэл
	Д.Цолмонбаатар		2022.04.01-ний өдрөөс
4	Д.Мягмарсүрэн	Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал	
5	Л.Баяр-Эрдэнэ	Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал	
6	Ц.Баатархүү	Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал	



7	Н.Ганзориг	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга	2021.12.24-ний өдрийг хүртэл
	Ж.Арслан		2021.12.24-ний өдрөөс
8	Б.Нарантуяа	БАС-ийн захирал	
9	А.Энхбат	БуХС-ийн захирал	
10	Г.Баттүвшин	БАТС-ийн захирал	
11	Л.Пүрэв	ГУУС-ийн захирал	2021.12.24-ний өдрийг хүртэл
	К.Хавалболот		2021.12.24-ний өдрөөс
12	Ц.Энхбаатар	ГХС-ийн захирал	
13	Ц.Батбаатар	ДаТС-ийн захирал	
14	Д.Цолмонбаатар	МехТС-ийн захирал	2022.04.01-ний өдрийг хүртэл
	Ж.Хашбат	МехТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч	2022.04.01-ний өдрөөс
15	Н.Чулуунбанди	МХТС-ийн захирал	
16	Ж.Туяацэцэг	ҮТС-ийн захирал	
17	Д.Ганхуяг	ХШУС-ийн захирал	2021.12.24-ний өдрийг хүртэл
	В.Өлзийбаяр		2021.12.24-ний өдрөөс
18	Ч.Мангалжалав	ЭХС-ийн захирал	2021.12.24-ний өдрийг хүртэл
	Б.Бат-Эрдэнэ		2021.12.24-ний өдрөөс
19	Д.Ганбат	НБТ-ийн захирал	
20	Д.Зоригтхүү	ЭЦДС-ийн захирал	
21	С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга	
22	Б.Эрдэнэбүрэн	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн	

#### 1.4. СТРАТЕГИ 2030 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

##### 1.4.1. Сургалтын үзүүлэлт

##### Стратеги төлөвлөгөөний зорилтот түвшин болон гүйцэтгэл

Хүснэгт 1.6

Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин (2019 он)	Суурь түвшин (2019 он)	Хүрэх үр дүн		
			2022	2025	2030
Нийт орлогоос суралцагчдад олгосон тэтгэлгийн хувь	<0.1%	1.6%	0.1%	0.3%	0.4%
Гадаад хэл дээр явагдах бакалаврын сургалтын хөтөлбөрийн тоо	0	N/A	10	12	14
Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	38%	44.5%	47%	60%	70%
Сонирхогч талууд (оюутан, гадаад оюутан, багш, төгсөгч, эцэг эх, ажил олгогч)-ын сэтгэл ханамжийн түвшин	-	N/A	3.0<	4.0<	4.5<
Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь	<40%	77.7%	50%	60%	65%
Багш, суралцагчийн тооны харьцаа	1:16	1:16	1:15	1:14	1:13

##### 1.4.2. Судалгаа, шинжилгээний үзүүлэлт

##### Стратеги төлөвлөгөөний зорилтот түвшин болон гүйцэтгэл

Хүснэгт 1.7

Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин (2019 он)	Суурь түвшин (2019 он)	Хүрэх үр дүн		
			2022	2025	2030
Гадаад суралцагчдын (оюутан солилцоогоор ирсэн тоо орно) эзлэх хувь	<0.2%	0.58%	0.5%	2%	5%
Гадаад багшийн эзлэх хувь	<0.02%	-	4%	9%	12%
Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	38%	44.5%	47%	60%	70%



Нэг багшид оногдох олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо	0.6	0.1	2	5	7
ШУТИС-ийн эзэмшилтэй оюуны өмчийн тоо	12	120	150	300	500

### 1.4.3.Инновацын үзүүлэлт

#### Стратеги төлөвлөгөөний зорилтот түвшин болон гүйцэтгэл

Хүснэгт 1.8

Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин (2019 он)	Суурь түвшин (2019 он)	Хүрэх үр дүн		
			2022	2025	2030
Үндэсний болон олон улсад идэвхтэй патентын тоо	3	143	10	30	50
Лицензийн гэрээний тоо	0	1	2	6	10
Гарааны бизнесийн тоо	2	N/A	5	15	30
Нийт орлогод судалгаа, инновацийн орлогын эзлэх хувь	12%	6%	25%	40%	60%
Нийт зардалд судалгаа, инновацад зарцуулсан зардлын эзлэх хувь	8.2%	7%	20%	30%	50%

### 1.4.4. Нийгмийн хариуцлагын үзүүлэлт

#### Стратеги төлөвлөгөөний зорилтот түвшин болон гүйцэтгэл

Хүснэгт 1.9

Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин (2019 он)	Суурь түвшин (2019 он)	Хүрэх үр дүн		
			2022	2025	2030
Сонирхогч талууд (оюутан, гадаад оюутан, багш, төгсөгч, эцэг эх, ажил олгогч)-ын сэтгэл ханамжийн түвшин	-	N/A	3.0<	4.0<	4.5<
Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхөөс суралцаж буй оюутны эзлэх хувь	3%	3.96%	4%	5%	6%
Оюутны байрны багтаамж нь шинээр элсэгчдийн тоотой тэнцүү байхаар тооцож хувилах	24.5%	38%	30%	40%	50%

### 1.4.5. Менежмент, нөөцийн үзүүлэлт

#### Стратеги төлөвлөгөөний зорилтот түвшин болон гүйцэтгэл

Хүснэгт 1.10

Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин (2019 он)	Суурь түвшин (2019 он)	Хүрэх үр дүн		
			2022	2025	2030
Гүйцэтгэх засаглалын үнэлгээ (ашигт ажиллагааны түвшин)	-	?	%	%	%
Хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн тоо (чансаагаар олон улсад эхний 500-д байх)	<28	36	40	50	65

## 1.5. ТӨСӨВ, ТӨЛӨВЛӨЛТ

Цар тахлын улмаас хичээл, сургалтын үйл ажиллагаа цахимаар хичээллэсэнтэй холбогдуулан ШУТИС-ийн 2021 оны төсвийн тодотголыг ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж батлууллаа.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн 2022 оны төсвийн төслийг 2 удаа хэлэлцүүлэг хийж 2 удаа захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 09 тоог тогтоолоор батлууллаа. ШУТИС нь 2022 онд 64,643.5 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж, 64,643.4 сая төгрөгийн зарлагатай, үүний 4,257.0 сая төгрөг нь хөрөнгө оруулалт, бараа ажил үйлчилгээний чиглэлээр хийгдэх ажлууд байхаар ШУТИС-ийн Удирдах зөвлөлөөр батлуулж



бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн батлагдсан төсөв, орлого, зарлагын төсвийн сар, улирлын хуваарь, олгох санхүүжилтийн тооцоог хүргүүлсэн.

Мөн ШУТИС-ийн 2022 оны төсвийг батлуулахтай хамт ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас ДТС-иас бусад бүрэлдэхүүний 2022-2023 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг шинэчлэн тогтоож ШУТИС-ийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 10 тоот тогтоолоор баталлаа.

ШУТИС-ийн багш нарын цалинг 2022 оны 9 дүгээр сарын 01-нээс 20 хувиар, бусад ажилтны цалинг 15 хувиар нэмэгдүүлэхээр ШУТИС-ийн 2022 оны төсөвт суулгасан байсан бөгөөд хамтын гэрээний хэлэлцээрийн дагуу нийт багш ажилтны цалинг 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс 10 хувиар нэмж, үр дүнгийн урамшууллыг сар болгон олгохоор болов. ШУТИС-ийн багш нарын цалинг 2022 оны 9 дүгээр сарын 1-нээс 10 хувь, бусад ажилтны цалинг 5 хувиар нэмэхээр хамтын гэрээнд тусгагдсан болно.


ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11 тоот тогтоолоор ШУТИС-ийн оюутны 5 байранд 2022-2023 оны хичээлийн жилд амьдрах оюутны сарын төлбөрийг баталлаа.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 8-ны өдрийн хурлаар ДаТС-ийн 2022-2023 онд мөрдөх сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг шинэчлэн батлав.


ШУТИС-ийн 2023 оны төсвийн төслийг <http://203.217.139.9/Budget/#> программаар боловсруулагдсан байна.

### Төвлөрсөн бус мэдээллийн статистик


2019-2020 оны хичээлийн жилд 15414 оюутан, 2020-2021 оны хичээлийн жилд 15442 оюутан, 2021-2022 оны хичээлийн жилд 16327 оюутан суралцсан байна. Нэг багшид ноогдох оюутны тоо: 2021-2022 оны хичээлийн жилд 17 оюутан байна.




Зураг 1.1. ШУТИС-д бакалавр, магистр, докторын сургалтад суралцаж буй оюутны тоо (сүүлийн 3-н жилээр)




*Зураг 1.2. Хичээлийн жилд суралцагчдыг курсээр ангилсан байдал*



*Зураг 1.3. Бакалаврт суралцагчдын тоо (сүүлийн 3-н жилээр)*



Зураг 1.4. Магистрт суралцагчдын тоо (сүүлийн 3 жилээр)



Зураг 1.5. Докторантурт суралцагчдын тоо (сүүлийн 3 жилээр)

Нийт суралцагчдын тоо /насны ангиллаар/

Хүснэгт 1.11

Насны ангилал	2019-2020 оны хичээлийн жил	2020-2021 оны хичээлийн жил	2021-2022 оны хичээлийн жил
16 хүргэл	54	86	82
16 настай	44	55	54
17 настай	318	167	234
18 настай	2896	2778	3042
19 настай	2992	2961	2986
20 настай	2668	2748	2773
21 настай	2079	2240	2279
22 настай	1114	1165	1216
23 настай	567	586	642
24 настай	358	334	388






25 настай	224	231	252
26 настай	187	184	204
27 настай	172	150	186
28 настай	193	151	146
29 настай	170	158	160
30-34 настай	794	742	854
35-39 настай	358	432	519
40-өөс дээш	226	274	310
<b>Бүгд</b>	<b>15414</b>	<b>15442</b>	<b>16327</b>

## Нийт суралцагчдын тоо /орон нутгаар/


Хүснэгт 1.12

Орон нутгийн харьяалал	2019-2020 оны хичээлийн жил	2020-2021 оны хичээлийн жил	2021-2022 оны хичээлийн жил
Архангай	1162	1134	1138
Баян-Өлгий	177	187	176
Баянхонгор	333	339	350
Булган	347	361	395
Говь-Алтай	394	366	391
Дорноговь	248	254	273
Дорнод	368	395	417
Дундговь	285	277	302
Завхан	587	551	593
Өвөрхангай	771	726	755
Өмнөговь	281	285	322
Сүхбаатар	252	233	262
Сэлэнгэ	500	498	506
Төв	368	358	412
Увс	655	638	579
Ховд	436	389	397
Хөвсгөл	658	703	693
Хэнтий	378	377	416
Дархан-Уул	774	787	783
Улаанбаатар	5349	5643	6171
Орхон	961	850	890
Говь-Сүмбэр	78	70	79
Гадаад	52	21	27
<b>Бүгд</b>	<b>15414</b>	<b>15442</b>	<b>16327</b>




Зураг. 1.6. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутны тоо (сургууль тус бүрээр)


Улсаар нь авч үзвэл БНХАУ-ын суралцагч хамгийн олон байна. Гадаад оюутны тоо нь нийт суралцагчдын тоонд орсон болно.




Зураг. 1.7. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутан (орон бүрээр)




**Зураг 1.8. ШУТИС-ийн бакалаврын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)**



**Зураг 1.9. ШУТИС-ийн магистрын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)**



Зураг 1.10. ШУТИС-ийн докторын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)




Зураг 1.11. “ШУТИС-КООСЭН” ТК болон Ахлах сургуульд шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)

**ШУТИС-ийг төгсөгчдийн мэдээлэл  
(сүүлийн 3 хичээлийн жилээр)**

Хүснэгт 1.13



№	Төрөл	2019-2020 хичээлийн жил	2020-2021 хичээлийн жил	2021-2022 хичээлийн жил
1	Бакалавр	2394	2753	2616
2	С Диплом /Бакалавр/	131	84	103
3	Магистрын төгсөлт	646	516	612
4	Докторын төгсөлт	23	-	40
5	ШУТАС	57	54	55
6	ШУТИС-КООСЭН ТК	22	19	23
<b>БҮГД</b>		<b>3273</b>	<b>3426</b>	<b>3449</b>




Зураг 1.12. ШУТИС-ийн нийт багш ажилтан


**Нийт багш ажилтны тоо**

Хүснэгт 1.14

Төлөв	Бүрэлдэхүүн сургууль	Ахлах сургууль	Коосэн	Төв ШУТИС	МХБДАЗ-ны нэгж	БҮГД
Удирдах ажилтан	42	1	2	24	5	74
Салбар тэнхимийн эрхлэгч	49		2			51
Үндсэн багш	817	23	13		2	855
Сургалтын ажилтан	192	2	1	6		201
Захиргаа ажилтан	89	2	3	71	28	193
Аж ахуй үйлчилгээ	235	4	1	77	40	357
<b>Нийт</b>	<b>1424</b>	<b>32</b>	<b>22</b>	<b>178</b>	<b>75</b>	<b>1731</b>



Зураг 1.13. ШУТИС-ийн нийт профессор багш нарын тоо (бүрэлдэхүүн сургуулиар)



Зураг 1.14. ШУТИС-ийн профессор багш нарын судалгаа


**ШУТИС-ийн профессор багшийн тоо (2022 оны 3 сарын байдлаар)**

Хүснэгт 1.15

№	Бүрэлдэхүүн сургууль	Үндсэн багш	Үүнээс доктор зэрэгтэй багш
1	БАС	98	31
2	БАТС	10	13
3	БуХС	91	48
4	ГУУС	82	51



5	ГХС	78	27
6	ДаТС	63	18
7	МехТС	66	45
8	МХТС	102	45
9	ҮТС	70	37
10	ХШУС	98	54
11	ЭХС	69	36
12	ЭЦДС	39	9
13	КТК	15	3
14	ЕБАС	12	1
15	ДаТС-АС	7	-
16	Ор-АС	4	-
17	МСҮТ-3 салбар	21	-
<b>БҮГД</b>		<b>948</b>	<b>417</b>



Зураг 1.15. ШУТИС-ийн доктор цолтой профессор багш нарын тоо (бүрэлдэхүүн сургуулиар)

**ШУТИС-ийн профессор багш нарын ангилал**

Хүснэгт 1.16

Он	Салбар, тэнхимийн эрхлэгч	Зөвлөх профессор	Проф	Дэд проф	Ахлах багш	Багш	Даджигч багш	Нийт багш
2020	46	20	36	84	380	366	18	950
2021	47	21	42	92	368	344	17	931
2022	51	28	43	91	320	330	18	881


Жич: Бүрэлдэхүүн 11 сургууль болон “ШУТИС-Коосэн” ТК-ийн багш нарын тоо орсон дүн.



2022 оны 3 дугаар сарын байдлаар 12 бүрэлдэхүүн сургуулийн 863 үндсэн багш, 18 дадлагажигч багш нийт 881 багшаас 320 буюу 36,3% нь ахлах багш. Үүнээс 137 багш буюу 42.8% нь доктор хамгаалсан байна.



Зураг 1.16. ШУТИС-ийн доктор цолтой ахлах багшийн эзлэх хувь (2021 оны 3 сарын байдлаар)



Зураг 1.17. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургуулиудын салбар тэнхимийн тоо

**ШУТИС-ийн багш, оюутны харьцаа**

Хүснэгт 1.17

№	Бүрэлдэхүүн сургууль	Удирдах ажилтны тоо	Захиргааны ажилтны тоо	Сургалтын ажилтны тоо	Үйлчилгээний ажилтны тоо	Багшийн тоо	НИЙТ Оюутан тоо	нэг багшид ноогдох оюутны тоо
1	БАС	3	7	16	25	98	2564	26
2	БУХС	3	7	12	24	91	1265	14
3	БАТС	3	3	2	2	10	594	59
4	ГУУС	5	7	22	19	82	1852	23






5	ДаТС	3	6	17	25	63	1169	19
6	МехТС	3	8	21	30	66	1532	23
7	МХТС	4	8	19	26	102	2332	23
8	ҮТС	4	9	20	30	70	1439	21
9	ХШУС	3	4	21	14	98	324	3
10	ЭХС	3	7	21	14	69	2333	34
11	ГХС	4	5	6	2	78	206	3
12	ОртС	4	18	15	24	39	469	12
13	ШУТИС-Коосэн	2	3	1	1	15	220	15
<b>нийт</b>		<b>44</b>	<b>92</b>	<b>193</b>	<b>236</b>	<b>881</b>		
1	АС	1	2	2	4	23	439	
2	Төв ШУТИС	24	71	6	77			
3	МХБДАЗ-ны нэгж	5	28		40	2	28	
<b>БҮГД</b>		<b>74</b>	<b>193</b>	<b>201</b>	<b>357</b>	<b>906</b>		

### Архив бичиг хэргийн бүрдүүлэлт хадгаламж

Хадгаламжийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажил хийсэн:

ШУТИС-ийн Төв архивт нөхөн бүрдүүлэлт хийх зорилгоор бүрэлдэхүүн сургуулиудын архивт хадгалагдаж байсан багш, ажилчдын Санхүүгийн жилийн эцсийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийн тооцоо, ногдуулалт, цалингийн картын эдгээр баримтуудыг бүртгэж хүлээн авсан.



Зураг 1.18. Архивын хадгаламжид хүлээн авсан материалууд

### Төлбөртэй болон дотоодын албан хэрэгцээний лавлагаа:

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Хур систем”-д төгсөгчдийн мэдээлэл оруулах ажилтай холбогдуулан энэ хичээлийн жилд 500 лавлагаа төлбөртэй гаргаж нийт 1.222,500 төгрөгийн орлого олов. Дотоодын албан хэрэгцээний 121 ба нийт 754 хуудас лавлагааг гаргажээ.

### Баримт данслах, цэгцлэлт:


Хадгаламжийн нэгжийг данс, бүртгэл үүсгээгүй, архивын дүрэм журмын дагуу зохион бүрдүүлээгүй, он цагийн дараалал дамнуулан үдсэн, архивын зориулалтын цаасаар хавтаслаагүй, нүүрлэлт буруу хадгаламжийн нэгжүүд байсныг засаж янзлан, цэгцлэх ажлууд хийгдэж байна.



Зураг 1.19. Архивын хадгаламжийн өрөө


### 1993-2003 оны төгсөгчдийн дипломын дүнгийн хавсралтыг цахим хэлбэрт оруулсан байдал

1993 оноос 2003 он хүртэлх төгсөгчдийн дипломын дүнгийн хавсралтыг цахим хэлбэрт оруулав. Нийт бакалавр-10795, магистр-377 дипломын хавсралтуудыг цахимжуулсан.



**Зураг 1.19. 1993-2003 оны төгсөгчдийн дипломын дүнгийн хавсралтыг цахим болгосон тоон үзүүлэлт**

ШУТИС-ийн төв архивын хадгаламжийн санд хадгалагдаж байгаа төгсөгчдийн дипломын дүнгийн хавсралтуудыг цахим хэлбэрт оруулах ажил хийгдэж байна.



**Зураг 1.19. 1993 оноос 2003 он хүртэлх төгсөгчдийн дипломын дүнгийн хавсралтыг цахим болгосон байдал**


**Архивын өрөө, тасалгааны тохижилт**

Архивын дотор, гадна хана цууралт өгсөн байсан тул зохих алба, газарт хүсэлт гарган засвар, тохижилт хийгдсэн.



*Зураг 1.19. ШУТИС-ийн архивын засвар тохижилт*

Лавлагаа хүсэгчийн мэдээлэл хүлээн авах самбар шинээр байгуулсан. Архиваас лавлагаа хүсэгчид лавлагааны мэдээллийг бүрэн гүйцэт өгөх шаардлагатай ба ингэснээр лавлагааг эрж хайх ажил хурдан шуурхай байдаг тул “Лавлагаа хүсэгчийн самбар”-ыг архивын гадна хананд хийж байршуулсан. Тус самбарт лавлагааны төлбөр, шаардагдах бичиг жагсаалт зэрэг мэдээллийг мөн оруулсан болно.



*Зураг 1.20. Лавлагаа хүсэгчийн мэдээлэл хүлээн авах самбар*

**ШУТИС-ийн музей**

ШУТИС-ийн музей нь ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл 3 ба 5-д дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх стратегийн хүрээнд таван төрлийн ажил төлөвлөн ажиллалаа.

**Төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл 3.1:** 1. Музейд шинжлэх ухаан, технологи, инновац, танин мэдэхүйн танхимыг шинэчлэн байгуулах интерьер төлөвлөлт хийгдэж байна.

Биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологи зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлээр бүрэлдэхүүн сургууль, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэм шинжилгээний төв болон эрдэмтэн багш, оюутан нараас сургалт, техник, технологи, инновацын ач холбогдол бүхий зохион бүтээсэн багаж, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн техник, төрөл бүрийн аппаратууд, технологийн загваруудын үзмэр, биет бүтээлийн цуглуулга хийх ажил хийгдэж байна.

Их сургуулийн эрдэмтэн профессор багш, ажилтан нараас Монгол Улсын төрийн дээд цол хүртсэн багш-алдартнууд, Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан багш-эрдэмтэн нийт 100 шахам хүнийг алдаршуулан мөнхжүүлэхээр сургуулийн түүхэнд хөрөг, намтартай нь үлдээх альбомыг бэлтгэж хэвлэлтэд бэлэн болгосон.

2. Чингис хаан музейд соёлын яамнаас ирсэн шийдвэрийн дагуу археологийн олдворууд нийт 61 дэсийн 113ш үзмэрийг шилжүүлэн хүлээлцэх ажлыг гүйцэтгэсэн.

3. ШУТИС, БУХС-ийн археологийн фондод хадгалагдаж байсан нийт 340ш үзмэрийг хүлээн авч дэглэлтийг гүйцэтгэсэн.

4. ШУТИС-ийн музейд хадгалагдаж байсан 61 дэсийн 113ш үзмэрийн бүртгэл фото хадгалалтын нарийвчилсан бичиг баримтын гүйцэтгэлийг Чингис хаан музейтэй хамтран ажиллаж хүлээлцэх акт баримтыг хийж гүйцэтгэсэн.

5. Шинжлэх ухаан танин мэдэхүйн танхимд шинээр холограмм үзмэрийг ҮТС-ийн оюутнуудтай хамтран гүйцэтгэсэн.

6. Музейн байнгын үзмэрийг нийт 500 орчим багш, сурагч, оюутан суралцагч, гадаад дотоодын элчин сайд, олон нийтэд сурталчлан таниулж байна.

7. МУИС, ПДС, ТИС, ШУТИС, тэдгээрийн бүрэлдэхүүнд ажиллаж байсан, ажиллаж байгаа факультет, сургууль, салбар, тэнхим, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн ойн тэмдэг, эмблем, медаль, дурсгалын эд зүйл цуглуулах, музейн үзмэр болгох ажил хийгдэж байна.



*Зураг 1.21. ШУТИС-ийн музейд шинээр байрлуулсан үзмэрүүд.*

8. ШУТИС, МХТС-иас Олон улсад дэд байр эзэлсэн роботыг музейд албан ёсоор хвлээн авлаа.



*Зураг 1.22. ШУТИС-ийн музейд шинээр байрлуулсан роботууд.*

**Төлөвлөгөөний Тэргүүлэх чиглэл-5:** ОХУ-ын Москвагийн Үндэсний Судалгааны Техник, Технологийн Их Сургууль-Н.Э.Бауманы нэрэмжит Техникийн Улсын Их Сургууль, Үндэсний судалгааны Барилгын Улсын Их Сургууль, Эрхүүгийн Үндэсний судалгааны Техникийн Улсын Их Сургууль, БНХАУ-ын Хөх хот, Үндэсний дээд сургуулийн музейнүүдтэй холбоо тогтоох ажил хийгдэж байна.

Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Кшиштоф Бойко болон Чех улсаас Монгол Улсад суугаа элчин сайд ноён Jan Vytopil, Энэтхэг улсаас Монгол улсад суугаа Элчин ноён MP Singh сайд нар музейд зочилж сургуулийн гарал үүсэл, хөгжлийн түүхэн замнал, Монголын эртний нүүдэлчдийн өв болох археологийн олдвор, Геологи, эрдэс баялгийн дээжтэй танилцав.



*Зураг 1.23. ШУТИС-ийн музейг үзэж сонирхсон гадаадын элчин сайдууд сэтгэгдлээ үлдээж байна.*





# ХОЁРДУГААР БҮЛЭГ

---

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
ЦАХИМ ШИЛЖИЛТ





## ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЦАХИМ ШИЛЖИЛТ

### 2.1. ЭЛСЭЛТ

ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар батлагдсан 2021-2022 оны хичээлийн жилийн Сургалтын нэгдсэн хуанлийн дагуу бакалаврын түвшний сургалтын элсэлт, төгсөлт, явцын сорил, улирлын шалгалт, диплом хамгаалалт гэсэн сургалтын үндсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Мөн ШУТАС, “ШУТИС-Коосэн” Технологийн коллеж, ИТДБ Төслийн хамтарсан бакалавр, бэлтгэл Коосэн хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг удирдлагаар ханган, байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцан ажиллав.


ШУТИС-ийн Захирлын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/67 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2021-2022 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам”-ын дагуу 2021 оны 05 дугаар сарын 15-аас 08 дугаар сарын 20-ны хооронд [www.elseit.edu.mn](http://www.elseit.edu.mn) хаягаар бүртгэж, элсэлтийг зохион байгуулав.

2021-2022 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хяналтын тооны дагуу ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад нийт 3804 оюутан шинээр элсэв.

#### Шинээр элсэн орсон элсэгчид

*Хүснэгт 2.1*

Д/д	Сургууль	Тоо
1	Барилга, Архитектурын сургууль	527
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	324
3	Геологи, уул уурхайн сургууль	449
4	Механик, тээврийн сургууль	345
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	702
6	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	345
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	146
8	Эрчим хүчний сургууль	502
9	Гадаад хэлний сургууль	66
10	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	237
11	Орхон аймаг дахь Технологийн сургууль	161



Зураг 2.1. 2019-2021 оны хяналтын тоо болон элссэн оюутны тоо

## 2.2. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, КРЕДИТ ДҮЙЦҮҮЛЭЛТ

Шилжин ирж суралцах оюутны шилжилт хөдөлгөөнийг хянаж, бүрэлдэхүүн сургуулиудаас ирүүлсэн материалыг шалгаж, Кредит дүйцүүлэх комисст танилцуулан батлуулав. Үүнд :

Бусад их, дээд сургуулиас шилжин ирсэн болон давхар мэргэжлээр шууд элсэн суралцаж байгаа оюутны материалыг хянаж, шилжилтийн тушаал боловсруулж батлуулав. Шилжин ирсэн оюутны тоог сургууль бүрээр гаргавал:

### Шилжилт хөдөлгөөн, кредит дүйцүүлэлт

Хүснэгт 2.2

№	Сургууль	2021-2022 оны хичээлийн жилийн намар							2021-2022 оны хичээлийн жилийн хавар						
		Шилжилт		Давхар мэргэжлээр шууд элсэлт					Нийт	Шилжилт		Давхар мэргэжлээр шууд элсэлт			Нийт
		Гадаадын их, дээд сургууль	Дотоодын их, дээд сургууль	ШУТИС төгссөн	ШУТИС Коосэн ТК төгссөн	Япон. Коосэн төгссөн	Бусад сургууль төгссөн	Гадаадын их, дээд сургууль		Дотоодын их, дээд сургууль	ШУТИС төгссөн	ШУТИС Коосэн ТК төгссөн	Бусад сургууль төгссөн		
1	БАС	7	8	10	5	1	7	38	2		14	1	19	36	
2	БухС	3	17	2			1	23		3				3	
3	ГУУС	2	3	2			3	10	3	1	2			6	
4	ДаТС		3	3			2	8			3		1	4	
5	МехТС	2	3	1	2			8	1	0				1	
6	МХТС	14	23	4	3	7	8	59	2	1	1		1	5	
7	ҮТС	1	6				1	8	1	0	11		10	22	
8	ХШУС						1	1	2	0				2	



9	ЭХС	5	9	1	3	2		20	2	0				2
10	ГХС		1					1						0
11	ЭЦДС	1		4			3	8						0
<b>ШУТИС</b>		<b>35</b>	<b>73</b>	<b>27</b>	<b>13</b>	<b>10</b>	<b>26</b>	<b>184</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>31</b>	<b>1</b>	<b>31</b>	<b>81</b>

Бүрэлдэхүүн сургууль хооронд намар 242, хавар 119 оюутан хөтөлбөр/мэргэжлээ сольж, шилжин суралцжээ.

### Кредит дүйцүүлэлт

- Кредит дүйцүүлэлтийн комиссоос гарсан шийдвэр, дүйцүүлсэн кредитийн мэдээг бүрэлдэхүүн сургуулиудад тухай бүрт хүргэж ажилласан.
- ШУТИС төгсөөд давхар мэргэжлээр суралцаж байгаа 156 оюутан 8479 кредит дүйцүүлэн тооцуулж суралцаж байна.
- Кредит дүйцүүлэх комисст бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн нийт 400 оюутны материал, дүйцүүлэлтийн шийдвэрийг архивт хуулбарлан авч үлдлээ.
- Кредит дүйцүүлэх комиссоос намар 150 оюутны 4398 кредитийн 75,386,264 төгрөгийн, хаврын улиралд 58 оюутны 1316 кредитийн 24,549,196 төгрөгийн, цагийн сургалтын 111 оюутны 3284 кредитийн 67,769,520 төгрөгийн дүйцүүлэлт хийснээс тус хичээлийн жилд өдрийн сургалтын 138, цагийн сургалтын 22 оюутан, магистрант 11 оюутан 79,171,011 төгрөгийн дүйцүүлэлтийн төлбөр төлж дүйцүүлсэн кредит, дүнгээ баталгаажуулж авсан байна. Өмнөх хичээлийн жилүүдэд хийгдсэн дүйцүүлэлтийн төлбөрөөс 155 оюутны 92,003,636 төгрөг, нийт 171,174,647 төгрөг төлөгдсөн байна.

### Кредит дүйцүүлэлтийн тооцоо (сургууль бүрээр)

Хүснэгт 2.3

№	Сургууль	2021-2022 Намар						2021-2022 Хавар					
		ШУТИС төгссөн		Дүйцүүлэлт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр	ШУТИС төгссөн		Дүйцүүлэлт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр
		Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит					Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит				
1	БАС	19	124 <sub>2</sub>	25	674	12,239,840	9,316,080	19	972	28	720	13,086,096	5,586,016
2	БуХС	3	219	18	521	9,295,584	3,008,544			6	100	1,776,000	639,360
3	ГУУС	2	117	10	256	4,648,960	4,322,080	3	164	4	126	2,288,160	1,253,040
4	ДаТС	3	135	5	174	2,759,640	1,554,280	4	169	2	36	570,960	
5	МехТС	3	215	7	189	2,615,040	581,120			5	47	853,520	326,880
6	МХТС	7	273	51	166 <sub>2</sub>	30,181,920	22,300,480	1	39	4	44	1,743,360	108,960
7	ҮТС			9	193	3,504,880	3,377,760	24	162 <sub>3</sub>	2	46	835,360	
8	ХШУС			1	28	444,080				2	30	475,800	475,800
9	ЭХС	5	374	19	564	8,426,240	7,300,320	1	87	3	118	2,142,800	
10	ГХС			1	28	444,080				1	13	206,180	



1	ЭЦДС	4	232	4	59	826,000	826,000			1	36	570,960	
<b>ШУТИС</b>		<b>46</b>	<b>2807</b>	<b>150</b>	<b>4398</b>	<b>75,386,264</b>	<b>52,586,664</b>	<b>52</b>	<b>3054</b>	<b>58</b>	<b>1316</b>	<b>24,549,196</b>	<b>8,390,056</b>

### Цагийн сургалтын кредит дүйцүүлэлт

Хүснэгт 2.4

Дд	Сургууль	2021-2022 Цаг /эчнээ/					
		ШУТИС төгссөн		Дүйцүүлэлт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр
		Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит				
1	БАС	18	1102	24	614	13,374,288	1,312,272
2	ДаТС	11	826	37	1144	21,772,608	6,128,304
3	МехТС	5	109	17	417	8,455,296	2,357,168
4	ЭХС	10	468	33	1109	24,167,328	784,512
<b>ШУТИС</b>		<b>44</b>	<b>2505</b>	<b>111</b>	<b>3284</b>	<b>67,769,520</b>	<b>10,582,256</b>

### Магистрын сургалтын кредит дүйцүүлэлт

Хүснэгт 2.5

Дд	Сургууль	2021-2022 Магистр					
		ШУТИС төгссөн		Дүйцүүлэлт хийгдсэн оюутны тоо	Дүйцүүлсэн кредит	Төлбөр 20 %	Төлсөн төлбөр
		Оюутны тоо	Дүйцүүлсэн кредит				
1	БАТС	6	52	7	29	666,182	528,352
2	БуХС	1	6				
3	ЭХС			1	14	355,936	355,936
4	МХТС	1	5	3	6	152,544	152,544
5	ГУУС	6	50	2	2	50,848	50,848
<b>ШУТИС</b>		<b>14</b>	<b>113</b>	<b>13</b>	<b>51</b>	<b>1,225,510</b>	<b>1,087,680</b>

### 2.3. БАКАЛАВРЫН СУРГАЛТ, ХИЧЭЭЛ ЗОХИЦУУЛАЛТ

2021-2022 оны хичээлийн жилийн намрын улиралд 13169, Хаврын улиралд 11765 бакалавр оюутан, нийт 1024 профессор багш нар, бакалавр, эчнээ, орой, шууд элсэлтийн



сургалтаар намрын улиралд нийт-2514 хичээл, хаврын улиралд 1949 хичээлийн хуваарийг аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг ханган, норм, нормативыг баримтлан (өндөр хүчдэл, химийн хортой нөхцөл гэх мэт) зохион, хичээл зохицуулалтыг хийж ажиллалаа.

### **Хичээл сонголт-2**

2021-2022 оны хичээлийн намар, хаврын улирлын хичээл сургалт цахим болон танхимаар явагдах нөхцөлийг хангаж зохих зохицуулалтыг хийж ажиллав. 2021-2022 намрын улиралд хичээл сонголт 1- 86 %, хичээл сонголт 2-94%, хаврын улиралд хичээл сонголт 1-84 %, хичээл сонголт 2-97% тус тус явагдав.

Бүрэлдэхүүн сургуулиудаас оюутны хичээл сонголт 2-той холбоотой өөрчлөлтийг улирал бүрийн 1-р долоо хоногт хүлээн авч өдөр, орой, эчнээ, шууд элсэлтийн сургалт бүрийн нийт 90 гаруй мэргэжил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй тулган, хянаж, хичээлийн хуваарьт өөрчлөлт, зохицуулалт хийв.

Үүнд: 15 ба түүнээс доош оюутан сонгосон хичээлүүдийг хасаж, оюутны шилжилт хөдөлгөөн, давхар мэргэжлээр суралцахаар шууд элссэнтэй холбоотойгоор нэмж сонголт хийсэн хичээлүүдийг, заах багшийн хамт хичээлийн нэгдсэн хуваарьт тусган, зохицуулалт хийсэн. Элсэлт авахаа больсон мэргэжлүүдийн үлдсэн оюутнуудын хичээлийн хуваарийг холбогдох журмын дагуу зохион байгуулав.

ЭХС, ГУУС, ХШУС, БУХС, МХТС, МТС-ийн нийт 11 хамтарсан хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулан, суралцаж байгаа оюутнуудын хичээл сонголт-2-ыг журамд зааснаас илүү кредиттэй сонгох зохицуулалтыг хийж өгсөн.

Холбогдох бүрэлдэхүүн сургуулиудын инженерийн ахисан түвшний сургалтад намар, хаврын улирлын хичээлийн хуваарьт багш нарын ачаалал, сургалтын өрөө танхимын ашиглалтыг харгалзан зохицуулалт хийж ажилласан.

Тусдаа байртай МХТС, БуХС, МехТС, ҮТС-ийн UNIMIS дахь хичээлийн стандарт болон хичээлийн хуваарийг хянан, цөөн оюутан сонгосон хичээлүүдийн бүлгүүдийг нэгтгэх, оюутнуудын хичээл сонголтыг зохицуулах заавар, зөвлөгөөг хичээл зохицуулагч нарт өгч, удирдлагаар ханган ажиллалаа.

БАС, ЭХС, МТС, ҮТС-ийн нийт 7 мэргэжлийн цагийн сургалтын 1,2,3-р дамжааны , ЭХС-ийн дулааны цахилгаан станц мэргэжлийн оройн, БАС-ийн шууд элсэлтийн сургалтын хичээлийн хуваарийг зохион, сургалтын үйл ажиллагааг намрын улиралд цахим, хаврын улиралд танхимаар зохион байгуулав. Эчнээ, оройн сургалтын намар, өвлийн сургалт тус тус 6 долоо хоног, БАС-ийн Ус хангамж ариутгах татуурга мэргэжлийн шууд элсэлтийн сургалтыг 12 долоо хоногоор тус тус зохион байгуулав.

“Ерөнхийлөгчийн илгээлт-2021” тэтгэлэгт хөтөлбөр хэлний бэлтгэлийн 3 хөтөлбөрийг Гадаад хэлний сургууль дээр 21 хичээлийг модуль загвараар явагдах нөхцөлийг ханган нийт 200 гаруй оюутны сургалтыг зохион байгуулав.

5-р долоо хоногт бүрэлдэхүүн сургуулиудын хичээлийн хуваарьт тусгагдсан нийт 1095 лекцтэй хичээл бүрийн бие даалтын хуваарийг багш, оюутны хоорондын уялдаатай зохион, UNIMIS-д стандартын дагуу бүртгэсэн.

## **2.4. ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ**

### **Үндэсний магадлан итгэмжлэл**

Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь батлагдсан шалгуур шаардлагыг хангаж буй эсэхэд баталгаа өгч, хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, бусадтай жиших, хүлээн зөвшөөрөгдөх, цаашид илүү хөгжүүлэх, сайжруулах олон улсын хэмжээнд дээд боловсролын байгууллагын тавигдах шаардлагад нийцэх, түвшингээ ахиулах боломж олгодог. Мөн тухайн хөтөлбөрөөр суралцахыг хүссэн элсэгчид сонголт хийхэд энэ нь давуу тал болдог. 2021-2022 оны хичээлийн жилийн байдлаар бакалаврын 29, магистрын 1 хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь хүчинтэй байна.



2021-2022 оны хичээлийн жилд бакалаврын 20, магистрын 14, докторын 1 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр төлөвлөн үүнээс БМИҮЗ-өөр бакалаврын 4, магистрын 1 хөтөлбөрийг амжилттай магадлан итгэмжлүүлж гэрчилгээ авсан.

### Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн жагсаалт

Хүснэгт 2.6

№	Сургууль	Хөтөлбөр	Түвшин	Огноо
1	МехТС	Механик инженер	Бакалавр	2022.04.13
2	МехТС	Менежмент	Бакалавр	2022.02.21
3	МехТС	Логистик менежмент	Бакалавр	2022.02.21
4	ҮТС	Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи	Бакалавр	2022.02.21
5	БуХС	Аялал жуулчлалын менежмент	Бакалавр	2022.06.29
6	БАТС	Бизнесийн удирдлага	Магистр	2022.06.29





Зураг 2.2. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гэрчилгээгээ гардан авлаа

Мөн урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг хангасан бакалаврын 4 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж, сургалт эрхлэх зөвшөөрөл авсан болно.

**Магадлан итгэмжлүүлж, тусгай зөвшөөрөл авсан хөтөлбөрүүд**

Хүснэгт 2.7

№	Сургууль	Хөтөлбөрийн индекс	Хөтөлбөр	Түвшин
1	БАС	D073210	Авто замын инженерчлэл	Бакалавр
2	БАС	D073205	Гүүрийн инженерчлэл	Бакалавр
3	МехТС	D078811	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтын технологи	Бакалавр
4	ХШУС	D053303	Хэрэглээний физик	Бакалавр

**Олон улсын магадлан итгэмжлэл**

БуХС-ийн Менежмент хөтөлбөрийн Харилцаа холбооны менежмент, Хөнгөн үйлдвэрийн менежмент мэргэжил, Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийг АНУ-ын ACBSP (Accreditation council for business schools & programs) олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлүүлэв.



## 2.5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛЬ

2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын ахлах сургуульд элсүүлэн суралцуулахад тавигдах шаардлага, сургалтын танилцуулга, элсэлтийн журмыг бэлтгэн элсэгчдэд мэдээлэл хүргүүлсэн. Элсэхийг хүсэгчдийн бүртгэлийг 2021 оны 5 дугаар сарын 12-ноос 6 дугаар сарын 16-ыг хүртэл бүртгэж, шалгалт зохион байгуулан захирлын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны А/174 дугаар тушаалаар 10-р ангид инженер, технологийн чиглэлээр 43, дизайны чиглэлээр 18 суралцагч, 11-р ангид 11 суралцагч элсэлтийн журамд заасан шалгуурыг ханган элсэн суралцав. Ахлах сургуульд цагаар хичээл заах багш нарын материалыг хянаж, хавар, намрын улиралд кредит тооцох хичээл, гүнзгийрүүлэн судлах хичээлүүд, цагаар хичээл заах багш нарын нэрсийг захирлын тушаалаар баталгаажуулсан. 2021-2022 оны хичээлийн жилээс математик, физикийн хичээлийн гүнзгийрүүлсэн хөтөлбөрийг Нийслэлийн Боловсролын газраар батлуулан сургалт явуулж байна. Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/190 тоот тушаалын 3.5 заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Боловсролын үнэлгээний төвийн санаачилсан Оношлох үнэлгээний шалгалтыг 09 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/310 тоот албан бичгийн дагуу ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын Ахлах сургуулийн захирлын 2021.10.30-өдрийн А/30 тоот тушаалаар Сургуульд суурилсан үнэлгээ шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг томилж, давхардсан тоогоор 29 хичээлээр 10,11,12 дугаар ангиудаас шалгалт авав.

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн анги дэвших болон төгсөх, улсын шалгалт, кредит тооцох хичээлийн дүнд анализ хийв. Кредит тооцох хичээлийг 2018-2019 оны хичээлийн жилээс хойш судалж, ШУТИС-д элсэн суралцсан ахлах сургуулийн төгсөгчдийн хичээлийг шууд тооцож байна. 2021-2022 оны хичээлийн жилд ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцсан оюутнуудын ахлах сургуульд судалсан хичээлийн кредит болон үнэлгээг UNIMIS системд бүртгэв.

### 2021-2022 оны хичээлийн жилд кредит тооцох хичээлд хамрагдсан сурагчдаас бакалаврын түвшинд кредит тооцуулах болзол хангасан хичээлүүд

Хүснэгт 2.8

№	Хичээлийн код	Хичээлийн нэр	Кредит	Судалсан сурагчийн тоо	Кредит тооцуулах болзол хангасан сурагчийн тоо
1	S.MT101	Математик I	3	55	26
2	S.PH101	Физик I	3	38	23
3	T.AR210	Хар зураг I	2	17	14
4	T.AR211	Уран зураг I	2	17	12
5	T.AR213	Зохиомжийн үндэс	2	17	12
6	T.AR220	Хар зураг II	2	17	10
7	T.AR221	Уран зураг II	2	17	11
- Элсэлтийн бүртгэл 3 алхамтай байсны 2 болгож хөгжүүлсэн.
- Элсэлтийн бүртгэлийн хураамж төлөх хэсэгт дансаар төлөх боломжийг нэмж өгсөн. Дансаар бүртгэлийн хураамж төлөхдөө Хаан болон Голомт банкны данснууд руу төлбөр төлөх боломжтойгоор хөгжүүлсэн.




**Элсэгч нарт зориулсан гар утасны аппликейшн боловсруулалт - Must elself**



ШУТИС –д шинээр элсэх элсэгч нарт зориулж мэдээлэл өгөх зорилготой гар утасны апплекэйшны өгөгдлийн санг гаргаж, веб сервис программыг хөгжүүлсэн.


Мэдээлэл өгөх зорилго бүхий дараах веб сервисийг хөгжүүлсэн. Үүнд: Элсэлтийн журам, мэргэжил, ЭЕШ, холбоо барих, тэтгэлэг, тэргүүлэх мэргэжил, хамтарсан хөтөлбөр, сургуулийн байршил, зарлал, сургалтын төлбөр зэрэг модулиуд шинээр хийгдсэн.

**Элсэлтийн журам**




**Хамтарсан хөтөлбөр**

**ЭЕШ**



**Мэргэжил**

**Тэтгэлэг**




**Сургалтын төлбөр**

**Тэргүүлэх мэргэжил**




**Холбоо барих**



Зураг 2.45. Мэдээллийн технологийн хүрээнд хэрэгжүүлж, гүйцэтгэсэн бусад ажил, үйлчилгээнүүд

### Сургалтын албаны программ

Сургалтын албаны программ нь оюутан анх элсэн ороход бүртгэлээс эхлээд хичээл сонголт, дүн, хавсралт хэвлэх зэрэг бүхий л үйл ажиллагааг явуулна. Мөн шаардлагатай тайлан нэгтгэлүүдийг гаргана.



Зураг 2.46. Төгсөх оюутны тойрох хуудас бүртгэх хуудас

### Элсэлт-админ

- Элсэлтийн мэдээлэл өгөх зорилготой гар утасны апплэйкнд доорх мэдээллүүдийг оруулах админы хэсэг нэмэгдсэн.
  - Зарлал, мэдээлэл
  - Элсэлтийн журмын мэдээлэл
  - Тэтгэлгийн мэдээлэл



- Магистрын элсэлт мөн бакалаврын шууд элсэлтээр бүртгүүлсэн элсэгч нарт мэдээллийг нь харах оюутны код олгож unimis рүү татах хэсэг хийгдсэн.

№	Төрөл	Гарчиг	Эрэмбэ	Харагдах эсэх	Үүсгэсэн огноо	Үйлдэл
1	Зарлал, мэдээлэл	test	1	Тийм	5/16/2022 12:22:06 PM	Засах Устгах
2	Зарлал, мэдээлэл	ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТ	1	Тийм	4/22/2022 9:16:41 AM	Засах Устгах

Зураг 2.47. Элсэлтийн админ веб Зарлал, мэдээлэл оруулах хэсэг

### Оюутны вэб

- Зөвлөх багшийн мэдээллийг зөвхөн 1-р курсийн оюутнуудад харуулдаг байсныг бүх курсийн оюутнуудад харуулдаг болгов.
- Хичээл сонголтын хүсэлтийг оюутны вебээр авдаг болгов.
- Сорил явцын онооны задаргаа өөрчлөгдсөнтэй холбоотой өөрчлөлтүүдийг цаг тухай бүрд нь оюутны веб дээр оруулав.
- Хувийн мэдээллийн зарим хэсгийг оюутны вебээс оруулах хэсэг хийв.
- Оюутны тодорхойлолт хэвлэдэг хэсгийг баазтай холбож дахин давтагдахгүй токеноор дамжуулдаг болгов.
- Шалгалтын хуваарь харуулах хэсэг шинээр хийв.

### Оюутанд зориулсан гар утасны апплекейшн – Must student

Төлбөрийн мэдээлэл	
Сонгосон кредит:	21
Төлөх төлбөр:	1,906,800
Хөнгөлөлт, Урамшуулал:	0
Өмнөх үлдэгдэл:	309,800
Сургалтын төлбөрийн хэмжээ:	0
Төлбөрийн дутуу:	0
Төлбөрийн илүү:	3,000
<b>СУРГАЛТЫН ТӨЛБӨР ТӨЛӨХ</b>	
Төлбөрийн түүх	


Зураг 2.48. Төлбөр төлөх модуль шинээр хийгдсэн



### U-FINANCE нягтлан бодох бүртгэлийн программ хангамж

Нягтлан бодох бүртгэлийн систем нь санхүү нягтлан бодох бүртгэл, цалин, үндсэн хөрөнгө, бараа материал, сургалтын төлбөр, дотуур байр, төслийн нэгжийн тооцоо зэрэг үйлдлүүдийг багтаасан цогц систем юм. Нягтлан бодох бүртгэлийн систем нь санхүүгийн албаны ажилчдын үйл ажиллагааг хялбарчлан бүртгэл, тооцоо хийгдэж шаардлагатай тайлан мэдээллээр хангаж ажиллана.

1802 зардлын төрлийг задалж, өмнөх гүйлгээнүүдийг шинэ ангилал руу шилжүүлсэн.



Зураг 2.49.Төлбөр төлөх шинээр хийгдсэн модуль /Зардлын төрөл/

### Төсвийн програм

Төсвийн программ нь төсвийн төсөл, хянасан төсвийн төсөл, батлагдсан төсөв, төсвийн хуваарь зэрэг үйлдлүүдийг багтаасан. ШУТИС-ийн жилийн төсвийг салбар нэгж бүрээр төсөвлөн гаргах нэгтгэхэд зориулагдсан систем юм.Дотуур байрны орлогын бүртгэл болон түүнийг орлогын төсвийн төсөлд нэгтгэх хэсэг



Төсвийн хуваарь

Not secure | 203.217.139.9/budget/#/settings5/in\_budget\_dormitory

Нүүр хуудас / in\_budget\_p / Дотуур байрны орлого

Нүүр хуудас | Дотуур байрны орлого

ШУТИС Захиргаа / ШУТИС Захиргаа | Бүгд | 2023

Хайх | Хэвлэх

Өрөөний нэр	Төрөл	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт дүн/ млн.tog/	Тайлдал
БУХС оюутан 2 хүний өрөө	Оюутан	132	950	125,400.0	Засах Устгах
БУХС оюутан 4 хүний өрөө	Оюутан	260	800	208,000.0	Засах Устгах
БУХС айл 2 хүний өрөө	Айл	11	1700	18,700.0	Засах Устгах
БУХС айл 4 хүний өрөө	Айл	11	1880	20,880.0	Засах Устгах
МөхТС оюутан 4 хүний өрөө	Оюутан	212	700	148,400.0	Засах Устгах
МөхТС айл 4 хүний өрөө	Айл	40	1700	68,000.0	Засах Устгах
МХТС оюутан 4 хүний өрөө	Оюутан	212	800	169,600.0	Засах Устгах
МХТС айл 4 хүний өрөө	Айл	22	1200	26,400.0	Засах Устгах
УТС оюутан 4 хүний өрөө	Оюутан	300	800	240,000.0	Засах Устгах

Зураг 2.50. Төсвийн программ хангамжийн хөгжүүлэлт

## ШУТИС-ийн захиргааны ажилчдын мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ


Сүлжээний орчинд ажиллахад компьютерын ажиллагаа доголдож, вирустай, мэдээлэл алдагдахаас сэргийлэн “Kaspersky Endpoint Security for Business Select” вирусийн программыг захиргааны ажилчдын компьютер дээр суулган програмын шинэчлэлт хийж, вирус хайлт хийн илэрсэн вирусийг устгасан.

<b>Пользователь:</b>	University of Science and Technology
<b>ИНН/КПП Пользователя:</b>	
<b>Город:</b>	Ulaanbaatar
<b>Страна:</b>	Mongolia
<b>№ лицензии:</b>	2E9C-220119-090402-970-300
<b>PN:</b>	KL48632ARFQ
<b>Название ПО (продукта):</b>	Kaspersky Endpoint Security for Business - Select. 100-149 Node 1 year Educational Renewal License
<b>Количество объектов:</b>	120 User
<b>Перечень объектов:</b>	120 Node
<b>Срок использования ПО:</b>	с 2022-01-19 до 2023-01-21 00:00:00 UTC
<b>Поставщик (реселлер):</b>	Alllink, LLC Mongolia Ulaanbaatar Sukhbaatar district Ar Mongol Building 505 +79 (769) 909-54-56 batkhuu_2000@yahoo.com http://www.alllink.mn

ШУТИС-ийн 1, 2, 8, Т-байр, Номын сангийн ажилчдыг цахим орчинд хэвийн ажиллах явцад гарч буй сүлжээ тасралт, сүлжээний төхөөрөмжийн гэмтэл, доголдлыг илрүүлэн тухай бүрд нь хурдан шуурхай хэвийн ажиллах боломжийг бүрдүүлэн ажилласан.

### Сүлжээ шинэчлэлт:

МТТөвийн интернэт, техник хангамжийн багийн гишүүд 2 сарын хугацаанд хичээлийн 2-р байрны сүлжээний ACCESS LAYER түвшинд дотоод сүлжээний хурдыг 1000 Mbps хурдтай болгох зорилготой ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 2.51. Хичээлийн 2-р байрны сүлжээний шинэчлэлт хийгдэхээс өмнөх логик топологи

Эцсийн хэрэглэгчдийн сүлжээний олон цуваа холболтыг байхгүй болгох үүднээс бүх багш нарын өрөө болон лабораториудын өрөөнд үндсэн Cisco 2960 switch-ээс шууд холбогдох кабелийг шинээр татаж суурилуулсан.


Шинэ тавигдсан төхөөрөмжүүдийг тусгай хайрцагт суурилуулан, төхөөрөмжийг холбон, тохиргоо, хаягжилт хийлээ.




Д/д	Байршил		Төхөөрөмж		Хүлээлгэж өгсөн хүн	Хүлээн авсан хүн	Тайлбар
	Сургууль	Өрөөний тоот	Хуучин свитчний марк	Шинэ свитчний марк	Овог Нэр	Овог нэр	
1	ЭХС	НС – 401	Байхгүй	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Р.Төрбаг	МТТ – ийн захиралын өрөө
2	ЭХС	8 – 704	Байхгүй	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Ганзориг	Лабораторийн өрөө
3	ЭХС	2 – 633	TP-Link 16 Ports 10/100MB	D-Link 16 Ports 1GB	Т.Оджүү	Б.Батгөр	Багш нарын өрөө
4	ЭХС	2 – 632	TP-Link 8 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	М.Баттулга	Багш нарын өрөө
5	ЭХС	2 – 631	TP-Link 16 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Н.Жигжидсүрэн	Багш нарын өрөө
6	ЭХС	2 – 630	TP-Link 16 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Д.Даваацэрэн	Багш нарын өрөө
7	ЭХС	2 – 625	TP-Link 16 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Б.Цэрэнлхам	Багш нарын өрөө
8	ЭХС	2 – 622	TP-Link 16 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	О.Чимэд	Багш нарын өрөө
9	ЭХС	2 – 619	Байхгүй	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	О.Лхагвасүрэн	Захиралын өрөө
10	ЭХС	2 – 620	TP-Link 16 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Ш.Баасансүрэн	Багш нарын өрөө
11	ЭХС	2 – 627	TP-Link 24 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Т.Батгөмөр	IT инженерийн өрөө
12	ЭХС	2 – 516	D-Link 24 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB / D-Link 16 Ports 1GB	Т.Оджүү	Э.Батцэцэг	Лабораторийн өрөө
13	ЭХС	2 – 515	TP-Link 8 Ports 10/100MB	TP-Link 8 Ports 1GB	Т.Оджүү	Т.Батгөмөр	Багшийн нарын өрөө

Үр дүн:


1. Инженерүүдэд бодит туршлага дадлага болсон.
2. 2-р байрны сүлжээний найдвартай холболттой болсон.
3. 2-р байрны сүлжээний эцсийн хэрэглэгчид монгол ISP-үүдийн дундын MIX сүлжээ рүү шууд 1Gbps хурдаар холбогдох боломжтой болсон.



Зураг 2.52. Хичээлийн 1-р байрны сүлжээний шинэчлэлт хийгдэхээс өмнөх логик топологи



*/Сүлжээ шинэчлэхээс өмнөх тест хийсэн байдал/*



*/Сүлжээ шинэчилсний дараах тест хийсэн байдал/*

**Зураг 2.53. Сүлжээ шинэчлэлтийн харьцуулалт**



# ГУРАВДУГААР БҮЛЭГ

---

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ,  
ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ

## ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ

### 3.1 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭ

“ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрдэм шинжилгээний 2021-2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрдэм шинжилгээний нэгдсэн хуанли-г боловсруулан батлуулсан.

2021-2022 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын дагуу ШУТИС-иас эрхлэн гаргадаг мэргэжлийн сэтгүүлүүдийг олон улсын мэдээллийн санд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, судлаачдын олон улсад хэвлүүлсэн судалгааны бүтээлийг үнэлэх, урамшуулах, сурталчлах, багш, оюутан судлаачдын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, эрдэм шинжилгээний байгууллага-их сургууль-үйлдвэрлэлийн хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрдэм шинжилгээний мэдээллийн санг хөгжүүлэх, орон нутагт инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулан явууллаа.

#### Зохион байгуулсан арга хэмжээ, онцлох үйл явдал

*Хүснэгт 3.1*

№	Огноо	Арга хэмжээ, үйл явдал	Хамтарч ажилласан сургууль, байгууллага, үр дүн
1	2021/10 сар	<p>“MONGOLIAN GEOSCIENTIST” СЭТГҮҮЛ</p> 	<p>ЭШИГ, ГУУС, MongolianJOL:            “Mongolian Geoscientist” сэтгүүл олон улсын байгууллага JPPS-ийн 2 од-ны шаардлагыг хангасан. Энэхүү сэтгүүл нь геологийн салбарын мэргэжлийн сэтгүүл бөгөөд 4 дэх жилдээ олон улсад хянан магадалгаа хийгддэг, онлайн сэтгүүл болж дэлхийн мэдээллийн санд нэвтрээд байна. 2022 оны байдлаар тус сэтгүүлд хэвлэгдсэн 40 бүтээл Dimensions-д бүртгэгдэж, 9 удаа эшлэгдсэн байна.</p>
2	2021/11/25	<p>“BEST RESEARCH PAPER-2021” УРАЛДААН</p> 	<p>ЭШИГ:            Тус уралдаанд нийт 160 гаруй бүтээлд 40 гаруй судлаачдын нэр дэвшсэнээс 7 судлаачид мөнгөн шагнал, өргөмжлөл, “Research Excellence” тэмдгийг гардуулав. Энэхүү уралдаанд бүтээлээрээ амжилттай оролцсон бусад 33 эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлыг дэмжиж тус бүр 300 мянган төгрөгийн урамшуулал, батламж гардуулах арга хэмжээг зохион байгуулсан.</p>
3	2021/11/26	<p>“THE SECOND INTERNATIONAL CONFERENCE ON APPLIED SCIENCES AND ENGINEERING - ICASE 2021”</p>	<p>ХШУС:            Цар тахлын улмаас “ICASE-2021” ОУ-ын хурлыг онлайн хэлбэрээр зохион байгуулж, 12 орны 70 орчим эрдэмтэн, судлаачид оролцож, хэрэглээний математик, хэрэглээний хими, биофизик, биотехнологи, байгаль орчин, нано шинжлэх ухааны чиглэлээр 45 орчим аман болон постер хэлбэрээр илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн. Энэхүү хурлын эмхэтгэлд нийт 39 бүтээл хэвлэгдсэн байна.            Холбоосыг дараах сайтаас харна уу:  <a href="http://icase.mn/icase-2021">http://icase.mn/icase-2021</a>.</p>

			
4	2021/12	<p><b>“JOURNAL of APPLIED SCIENCE and ENGINEERING A” СЭТГҮҮЛ</b></p> 	<p><b>ХШУС:</b> 2022 онд “Journal of Applied Science and Engineering A” сэтгүүлийн 2 дахь дугаарыг хэвлүүлэн гаргасан байна. Тус дугаарт гадаад, дотоодын судлаачдын нийт 10 эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгдсэн байна.</p>
5	2021/12/21	<p><b>“МУ-ААС WOS, SCOPUS-Д ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛ БҮРТГЭЛЖҮҮЛЭХ НЬ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b></p> 	<p><b>ЭШИГ:</b> Төрийн өмчийн 6 их сургуулийн сэтгүүлийн зөвлөл болон их сургуулиудын Эрдэм шинжилгээ хариуцсан захирлууд хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгээр олон улсын мэргэжлийн сэтгүүлийг хөгжүүлэх, зорилго, зорилгоо тодорхойлж, 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулж санал солилцов. Энэхүү төлөвлөгөө, төсвийн саналыг ШУТИС-ийн ажлын хэсэг нэгтгэн 6 их сургуулийн ажлын хэсэгт 3 дугаар сард хүргүүлж ажиллав. ШУТИС-ийн “Mongolian Geoscientist” сэтгүүлийг WOS, Scopus, EBSCO гэсэн олон улсын мэдээллийн сангуудад бүртгүүлэхээр хүсэлтээ хүргүүлээд байна.</p>
6	2020-2021	<p><b>ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ</b></p> 	<p><b>ЭШИГ, ТДТ:</b> Эрдэм шинжилгээний мэдээллийн системийг улам боловсронгуй болгож хөгжүүлэх инновацын төслийг ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжүүлж 2020 оноос хэрэгжүүлж байна. Тайлант онд нийт багш, судлаачдаас өгөгдөл цуглуулах форматыг боловсруулж дууссан. ШУТИС-ийн нийт багш нарын ЭШ-ний Б цагийн тооцоог ШУТИС-ийн цахим хуудаснаас гаргаж тооцдог болох, ЭШ-ийн мэдээллийн бүртгэл программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх, ШУТИС-ийн UNIMIS-ийн системд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Одоогоор цахим хуудсанд оруулах мэдээлэл контентыг бэлдэж, системд Б-цаг тооцох програмчлалыг боловсруулах туршилтын ажил явагдаж байна.</p>



7	2020-2021	<b>ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ</b> 	<b>ЭШИГ, ТДТ:</b> Бүрэлдэхүүн сургуулиуд дотоод, гадаадын их дээд сургууль, байгууллагатай 38 хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажилласны заримыг дурдвал: <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл</li> <li>- Багануур ХХК</li> <li>- ЛСА олон улсын байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газар</li> <li>- Рио Тинто Монгол ХХК, Оюутолгой ХХК .</li> </ul>
8	2022/03/17	<b>“СУДАЛГААНЫ НЭЭЛТТЭЙ ЛАБОРАТОРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ НЬ”</b> 	<b>ЭШИГ:</b> Тус хэлэлцүүлгээр их сургуулийн судалгааны лабораториудыг бүртгэлжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, лабораториудыг уялдаа холбоотой хөгжүүлэх менежментийг бий болгох, хүний нөөц болон материаллаг нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдлийг эрэлхийлэх зорилготойгоор Төрийн өмчийн 6 их сургуулийн хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт “Монгол Улс дахь судалгааны лабораторийн өнөөгийн байдал”, “Судалгааны нээлттэй лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төслийн танилцуулга, “Судалгааны лабораторийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх нь” илтгэлүүдийг хэлэлцүүлээ. Оролцогчид: БШУЯ, ШУТИБХЗГ ШУТСан, ШУА, Биологийн хүрээлэн, Төрийн өмчийн их сургуулиудын төлөөлөл оролцсон байна.
9	2022/03/25	<b>“ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК, ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛГ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”</b> 	<b>ЭШИГ:</b> Тус хэлэлцүүлэгт БШУЯ, ШУТСан, ШУА, Төрийн өмчийн их, дээд сургуулиуд, Нийслэлийн Бизнес, инновац, хөгжлийн газар, Мэдээлэл, технологийн үндэсний парк, ШУ-ны паркийн захиргааны төлөөлөл оролцож, ШУ-ны парк, кластерийг байгуулах үндэслэл, чиглэл, үндэсний инновацын тогтолцоонд ШУ-ны паркийн гүйцэтгэх үүргийн талаар хэлэлцэж байр сууриа илэрхийллээ. Түүнчлэн БНХАУ-ын “Inner Mongolia Suchengda Magnesium Alloy Mining” компанийн Монгол дахь салбарын захирал Su Ying “ШУ-ны парк байгуулсан туршлага (БНХАУ-ын жишээн дээр)” илтгэл тавьж өөрийн орны туршлагыг танилцуулав.
10	2022/04/23-24	<b>“МОНГОЛ ИНЖЕНЕР-2022”</b> 	<b>MexTC:</b> Инженерийн чиглэлийн мэргэжилтэн, багш, оюутан, судлаачдын мэдлэг, ур чадварыг сорих, инженерчлэлийн оновчтой шийдлийг дэмжих тус арга хэмжээ нь дараах чиглэлээр явагдсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг</li> <li>- Техникийн механикийн улсын олимпиад</li> <li>- CAD/CAE/CAM улсын олимпиад</li> </ul>



11	2022/04/28	<p><b>“СУДАЛГААНД СУУРИЛСАН ИХ ХӨГЖҮҮЛЭХ НЬ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b></p> 	<p><b>БШУЯ, ЭШИГ:</b> Тус хэлэлцүүлэгт “Мэдлэгийн институцийн засаглал, менежмент, санхүүжилт”, “Хамтын үр нөлөөний зургаан их сургуулийн бүлэглэл” илтгэл хэлэлцүүлж, судалгааны их сургуулийн онцлог, түүнийг тодорхойлох үзүүлэлтүүд, Монгол Улсад судалгааны их сургуулийг хөгжүүлэх бодлого, удирдлага, менежмент, санхүүжилтийн түвшин, түүнийг бодлогын түвшинд хэрхэн зохицуулах талаар оролцогчид санал солилцлоо.</p>
12	2022/04/28-29	<p><b>МАГИСТР, ДОКТОР ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ</b></p>	<p><b>ЭШИГ, СБЗГ:</b> Тус хуралд техникийн ухааны чиглэлээр 26, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр 22, байгалийн ухааны чиглэлээр 8 илтгэл хэлэлцүүлж, магистрантын 9, докторантын 9 илтгэлийг шилдэг илтгэлээр шалгаруулан 18 оюутанд нийт 36 кредитийн урамшуулал олгосон. Магистр, доктор оюутны 22(5)-293 дугаар бүхий эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг нэгтгэн гаргалаа.</p>
13	2022/05/11-12	<p><b>ШУТИС-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b></p> 	<p><b>ЭШИГ:</b> ШУТИС-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үйл ажиллагаатай танилцах, хамт олны санал бодлыг сонсох, их сургууль-хүрээлэнгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, бодлогын түвшинд шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор захиргааны баг ОМССХ, ХҮСХХ, УУХ, ДТҮЭХ дээр ажиллав.</p>
14	2022/05/13	<p><b>ИННОВАЦЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ</b></p>	<p><b>ЭШИГ:</b> ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжилттэй 8 төслийн явц болон эцсийн тайлан хэлэлцүүлэв. Эдгээрээс 4 төслийг хүлээлгэн өгөх, 4 төслийн гэрээг сунгахаар шийдвэрлэв.</p>
15	2022/05/18	<p><b>“ШУТИС-ИЙН СУДЛААЧДЫН ОУ-Д ХЭВЛЭГДСЭН БҮТЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ” СЕМИНАР</b></p>    	<p><b>ЭШИГ:</b> ШУТИС-ийн судлаачдын олон улсад хэвлүүлсэн бүтээлүүд, түүнийг үнэлэх арга зүйг тодорхойлох зорилготой зохион байгуулагдсан тус семинарт “Web of science group мэдээллийн санд Монгол улсаас хэвлэгдсэн бүтээлийн үр нөлөөг байгууллагын түвшинд сайжруулах нь”, “ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа”, “Mongolian Geoscientist”, “Journal of Applied Science and Engineering A” сэтгүүлийн хөгжүүлэлт ба бүтээл хэвлүүлэх боломж” танилцуулгууд хийгдэж ШУТИС-ийн судлаачдын олон улсад хэвлэгдсэн бүтээлүүдийн үнэлгээг хийх аргачлалыг хэлэлцэв.</p>
16	2022/05/16-20	<p><b>“ИННОВАЦЫН ДОЛОО ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭ</b></p>	<p><b>БШУЯ, ЭШИГ, БуХС, БАТС:</b> “Шинэ сэргэлтийн нээлттэй инновац” уриа дор инновацын талаарх ойлголт, мэдлэг, соёлыг түгээх, дамжуулах, бүтээлч сэтгэлгээг</p>

			<p>төлөвшүүлж, инновацын олон талт түншлэлийг өргөжүүлэх, нээлттэй инновацын тогтолцоог хөгжүүлэх зорилготойгоор дараах олон талт арга хэмжээг хамарч амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Инновацын түншлэл-2022” онол, практикийн хурал</li> <li>- “Нээлттэй инновац” үзэсгэлэн</li> <li>- “Монгол улсад ноолуурын кластер хөгжүүлэх арга зам” семинар-хэлэлцүүлэг</li> <li>- “Гавал толгой” оюутны инновацын шилдэг бүтээл шалгаруулах уралдаан</li> <li>- “Best Paper Award-2022” залуу судлаачдын ЭШ-ний хурал</li> <li>- “ISO56000 Инновацын менежментийн тогтолцоо: Олон улсын стандарт болон ШУТИС-ийн иннова судлал” бүтээлүүдийн танилцуулга – семинар</li> <li>- “MUST Innovation Talk” шууд ярилцлага</li> <li>- “Инновац ба энтрепренэршипийн хөгжил” ОУ-ын хурал</li> </ul>
17	2022/05/26	<p><b>ӨМНӨГОВЬ АЙМАГТ ШУТИС-ИЙГ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ, БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН</b></p>	<p><b>ШУТИС, ЭШИГ:</b> Өмнөговь говь аймагт ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын сүүлийн үеийн олон амжилтыг танилцуулах үзэсгэлэнг зохион байгуулж бүх бүрэлдэхүүн сургууль, судалгааны хүрээлэнгүүд, судлаачид болон оюутны бүтээлээр үзэсгэлэн гаргаж их сургуулийг таниулах арга хэмжээнд хамтран амжилттай зохион байгуулж оролцов.</p>
18	2022/06/05	<p><b>“ABU ROBOSON -2022” ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН</b></p>	<p><b>БШУЯ, МҮОНРТ, ТДТ:</b> Тэмцээнд инженер технологийн чиглэлийн их сургуулиудын 10 баг өрсөлдөж, тэргүүн байрын төлөө ШУТИС-МХТС-ийн “SICT” болон ШУТИС-МехТС-ийн “Монхорус” багууд өрсөлдөж 65:55 онооны давуугаар “SICT” баг үндэсний аваргын цомын эзэн болж олон улсад оролцох эрхтэй боллоо.</p>
19	2022/06/13	<p><b>ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТАЙЛАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b></p>	<p><b>ЭШИГ, Захиргааны зөвлөл:</b> ШУТИС-ийн харьяа ОМССХ, ХҮССХ, УУХ, ДТҮЭХ-ийн захирлын 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлсэн. Тус хурлаар хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг дүгнэж тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн.</p>
20	2022/06/20	<p><b>ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН</b></p>	<p><b>Эрдмийн зөвлөл, ЭШИГ:</b> Тус хуралдаанаар ШУТИС-ийн Хүндэт профессор 3, профессор 4, дэд профессор 24 хүн цол хүртсэн. Мөн бакалаврын сургалтын хөтөлбөрт мэргэжлийн чиглэл нэмэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.</p>
21	2021-2022	<p><b>ХАМТЫН АЖИЛЛАГАА</b></p>	<p><b>ЭШИГ, ТДТ, Бүрэлдэхүүн сургууль</b> Тайлант онд эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд дараах үйлдвэр бизнес, төрийн байгууллагуудтай шинээр гэрээ байгуулан ажилласан. Үүнд:</p>




			Орхон аймгийн ЗДТГ Халдварт өвчин судлалын үндэсний төв Өмнөговь аймгийн ЗДТГ
22	2021-2022	<p><b>“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫГ ОРОН НУТАГТ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ АЯН”</b></p>	<b>БШУЯ, ШУТСАН, ЭШИГ, ТДТ:</b> Өмнөговь, Эрдэнэт, Дархан аймгуудад болсон үзэсгэлэнд бүрэлдэхүүн сургууль болон хүрээлэнгийн судлаачид бүтээлээрээ оролцов.

ШУТИС-ийн хэмжээнд тайлант онд бүрэлдэхүүн сургуулиудаас зохион байгуулсан арга хэмжээ: Олон улсын эрдэм шинжилгээний 15 хурал, улсын хэмжээний хурал 26, профессор, багш нарын эрдэм шинжилгээний хурал 10, ахисан түвшний оюутны хурал 17, оюутны эрдэм шинжилгээний 24, үзэсгэлэн 22, олимпиад 23, уралдаан тэмцээн 29, бусад сургалт семинар 36 тус тус зохион байгуулагдлаа.

### Бүрэлдэхүүн сургуулиудын зохион байгуулсан арга хэмжээ /2021-2022/

Хүснэгт 3.2

БС	ОУ-ын ЭШХ	Улсын хэмжээний ЭШХ	Багш эрдэмтдийн ЭШХ	Ахисан түвшний судлаачдын ЭШХ	Оюутны ЭШХ	Үзэсгэлэн	Олимпиад	Уралдаан тэмцээн	Бусад арга хэмжээ	нийт
БАС	0	4	0	1	2	0	3	1	4	15
БАТС	1	1	0	0	0	0	0	0	0	2
БуХС	5	11	0	2	1	7	3	7	11	47
ГУУС	2	2	2	5	8	0	2	0	2	23
ДаТС	1	2	3	1	4	8	4	10	3	36
МехТС	0	1	0	0	1	0	2	0	0	4
МХТС	0	1	3	3	2	4	1	4	1	19
ҮТС	2	1	0	1	1	2	0	1	0	8
ХШУС	1	1	0	2	3	0	3	2	1	13
ЭХС	2	2	1	1	1	0	2	1	1	11
ГХС	1	0	1	1	1	1	3	3	13	24
<b>нийт</b>	<b>15</b>	<b>26</b>	<b>10</b>	<b>17</b>	<b>24</b>	<b>22</b>	<b>23</b>	<b>29</b>	<b>36</b>	<b>202</b>



**Зураг 3.1. Бүрэлдэхүүн сургуулиудын Эрдэм шинжилгээний арга хэмжээний тоон мэдээлэл**


### 3.2 СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

2021-2022 оны хичээлийн жилд Эрдэм шинжилгээ, инновацын газар нь “ШУТИС-д Төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын холбогдох заалтуудыг үндэслэн төсөл хэрэгжиж буй харьяа бүрэлдэхүүн сургуулиудын эрдмийн зөвлөлөөр гадаад, дотоодын санхүүжилттэй төслүүдийн явц, үр дүнг хэлэлцүүлэх, төслийн даалгавар, санхүүгийн гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх зэргээр ажиллав.

#### 3.2.1 Гэрээт ажил

ШУТИС-ийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 115 аж ахуйн гэрээт ажлын гэрээг байгуулж, үүнээс 107 гэрээт ажилд санхүүжилт авч хэрэгжүүлсэн байна. Эдгээр хэрэгжүүлсэн аж ахуйн гэрээт ажлын нийт төсөвт өртөг 1.56 тэрбум төгрөг бөгөөд 2021-2022 оны хичээлийн жилд 1,07 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.

**ШУТИС-ийн Бүрэлдэхүүн сургуулиудын хэрэгжүүлсэн гэрээт ажлын тоо**




**Зураг 3.2. Бүрэлдэхүүн сургуулиудын гүйцэтгэсэн аж ахуйн гэрээт ажлын тоо**




Дээрх графикаас харахад нийт гэрээт ажлын 53% буюу 60 аж ахуйн гэрээт ажлыг Барилга, архитектурын сургуулийн профессор, багш нар дангаараа хийж гүйцэтгэж, идэвхтэй судалгааны ажил хэрэгжүүлсэн байна.

ШУТИС-ийн хэмжээнд хэрэгжүүлсэн аж ахуйн гэрээт ажлын тоог дүгнэж үзвэл 53%-ийг БАС, 9%-ийг БуХС, ЭХС, ГУУС-ийн профессор, багш нар тус бүр 9%-ийг буюу 10 гэрээт ажил хэрэгжүүлсэн байна.



**Зураг 3.3. Аж ахуйн гэрээт ажлын санхүүжилт, шимтгэлийн мэдээлэл**

Нийт гэрээт ажлын 987.7 сая төгрөгийн орлогыг дүгнэж үзвэл 29% буюу 282.6 сая төгрөгийг БАС, 23% буюу 225.3 сая төгрөгийг ЭХС, 17% буюу 172.3 сая төгрөгийг ГУУС, 8% буюу 80.5 сая төгрөгийг БуХС, 6% буюу 57.3 сая төгрөгийг МехТС зэрэг сургууль, нэгжүүд гүйцэтгэснээс харвал барилга, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэрлэл, хүнс, нийгэм хүмүүнлэгийн салбарт хэрэгжүүлсэн аж ахуйн гэрээт ажлуудын нэгж үнэлгээ өндөр байсан нь харагдаж байна.



**Зураг 3.4. Аж ахуйн гэрээт ажлаас ШУТИС-д төвлөрсөн шимтгэл бүрэлдэхүүн сургуулиудын эзлэх хувь**



2021-2022 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн аж ахуйн гэрээт ажлаас ШУТИС-д нийт 98.9 сая төгрөгийн шимтгэл төлөлт төвлөрсөн. Үүнээс томоохон үнийн дүн /20 саяас дээш/ бүхий гэрээт ажлыг түүвэрлэн доорх хүснэгтэд харуулав. /Нийт гэрээт ажлын 54% буюу 534.1 сая төгрөг/

**Өндөр үнийн дүн бүхий гэрээт ажлын жагсаалт**

Хүснэгт 3.3

№	Гэрээт ажлын нэр	Гэрээт ажлын удирдагч	Сургуулийн нэр	2021-2022 оны санхүүжилт
1	Цэргийн төв эмнэлгийн оношилгоо	Я.Дүйнхэржав	БАС	20,000,000
2	Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах	Б.Мөнхбаяр	БАС	30,000,000
3	REVIT Сургалт зохион байгуулах	Н.Саранчимэг	БАС	25,440,000
4	Археологийн авран хамгаалах малтлага судалгаа	Д.Хатанбаатар	БуХС	27,362,360
5	Мерит Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	П.Жаргалтуяа	БуХС	24,640,000
6	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ус хангамжийн цехийн цахилгаан хангамжийн аудит	Д.Содномдорж	ЭХС	46,000,000
7	Өмнөговь аймгийн Ханбогд суманд баригдах 148 МВт-ын чадалтай салхин цахилгаан станцын горим ба тогтворжилтын тооцоо	Д.Содномдорж	ЭХС	20,000,000
8	Орхон аймгийн нутаг дэвгэрийн аянга буултын цэгүүдийг тодорхойлох	Б.Сэргэлэн	ЭХС	42,500,000
9	Ухаалаг сүлжээний бодлогын баримт бичиг	Х.Энхжаргал	ЭХС	52,800,000
10	Турбины конденсаторын хөргөлтийн усыг оксигенилдидифосфорын хүчлээр боловсруулах гэрээт ажил	Б.Оюунсүвд	ЭХС	35,000,000
11	Эрдэнэтийн хүрдийн ил уурхайн уул тээврийн тоног төхөөрөмжийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх судалгаа	К.Хавалболот	ГУУС	32,400,000
12	VI-BBR-TRN-0013 туннел байгууламжийн талбайн геофизикийн техникийн ажил	Т.Бямбасүрэн	ГУУС	63,980,000
13	Цувих аргаар бэлдсэн 40, 80, 100 мм-ийн ган бөөрөнцгийн илчний боловсруулалтын горимын судалгаа	Ц.Мөнхтуяа	МехТС	20,000,000
14	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ. (Жилийн хүчин чадал 30.0 сая тонн)	Б.Пүрэвтогтох	Уул уурхайн хүрээлэн	24,193,950
15	Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт орших Баянтээгийн уурхайн нүүрсээр сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ.	Х.Жаргалсайхан	Уул уурхайн хүрээлэн	34,870,000
16	Булган, Орхон аймгийн Орхон, Жаргалант сумын нутагт орших Шандын зэс, молибдений ордыг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ	Х.Жаргалсайхан	Уул уурхайн хүрээлэн	34,960,000



Дээрх хүснэгтээс харахад ГУУС-ийн багш Т.Бямбасүрэн, К.Хавалболот, ЭХС-ийн багш Х.Энхжаргал, Д.Содномдорж, Б.Сэргэлэн, Б.Оюунсүвд, БАС-ийн багш Б.Мөнхбаяр, БУХС-ийн багш Д.Хатанбаатар, УУХ-ийн судлаач Х.Жаргалсайхан нарын гүйцэтгэсэн аж ахуйн гэрээт ажлууд 30 сая төгрөгөөс дээш санхүүжилттэй байна. Өөрөөр хэлбэл 2021-2022 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн 114 гэрээт ажлаас 16 гэрээт ажил нь 20 сая төгрөгөөс дээш санхүүжилтийг авсан байна. Энэ нь нийт гэрээт ажлын орлогын дүнд эзлэх хувь 54% байна. Эдгээр гэрээт ажлууд нь ШУТИС-ийн хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна ШУТИС-д оруулсан шимтгэл нь эрдэм шинжилгээ, судалгааг дэмжихэд өндөр хувь нэмэр оруулж байгаа билээ.

### 3.2.2. Хамтын ажиллагаа

“ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан судалгаа, инновацын хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх зорилтын хүрээнд дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх санаачилга гарган ажиллалаа. Эрдэм шинжилгээ, инновацын газар, Технологи дамжуулах төвөөс 2021-2022 оны хичээлийн жилд Эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв, Орхон аймгийн ЗДТГ, Оюу толгой ХХК, Өмнөговь аймгийн ЗДТГ, Эрдэнэт-үйлдвэр ТӨҮГ, Эрдэнэс-Тавантолгой ХК, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Хэнтий аймгийн ЗДТГ, Багануур ХК, ШУТСан зэрэг байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Мөн тус хичээлийн жилд дараах байгууллагуудтай гэрээ, санамж бичгүүдийг байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна.



*Зураг 3.5. Эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд хамтран ажиллах санамж бичиг зурлаа*






Бүрэлдэхүүн сургуулиуд гадаад, дотоодын их дээд сургууль, байгууллагатай 2021-2022 оны хичээлийн жилд Эрдэм шинжилгээ, туршилт судалгааны чиглэлээр нийт 109 хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажилласан байна.




Тухайлбал: Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, ДЦС-3 ТӨХК, УБЦТС ТӨХК, Эрдэнэтийн ДЦС ТӨХК, Хэнтий аймгийн ЗДТГ, Монголын үндэсний музей, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Таван Богд, НИК ХХК, Бороо гоулд ХХК, "Монголросцветмет" ТӨҮГ, Скайтел ХХК, Хаан банк ХХК, Сэрүүн ХХК гэх мэтийг дурдаж болох юм.



**Зураг 3.6. Эрдэм шинжилгээ, инновацийн чиглэлээр байгуулсан гэрээний тоо**

Манай их сургуулийн бүрэлдэхүүн нэгжүүдийн бусад аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээг авч үзвэл ГУУС, БУХС, МХТС, БАС, ЭХС, ГХС тус бүр 2021-2022 оны хичээлийн жилд 10-аас дээш гэрээ байгуулж, судалгаа инновацийн хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэн ажилласан байна.



**Зураг 3.7. 2021-2022 оны хичээлийн жилд байгуулсан гэрээ /хамтын ажиллагааны чиглэлээр/**

### 3.2.3 Гадаадын санхүүжилттэй бусад төсөл

ШУТИС-ийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд гадаадын санхүүжилттэй нийт 32 төсөл хэрэгжиж байгаагаас ИТДБ төслийн 10 төсөл, бусад эх үүсвэрийн 22 төсөл байна. ИТДБ төслөөс 4 төсөлд 35.9 сая төгрөг, гадаадын санхүүжилттэй бусад 22 төслөөс 9 төсөлд 800.96 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна.

Санхүүжилтээ авч судалгааны ажлаа гүйцэтгэж буй төслүүдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

#### 2020-2021 оны гадаадын санхүүжилтээр хэрэгжсэн төслүүдийн жагсаалт

*Хүснэгт 3.4*

№	Төслийн нэр (Гэрээний дугаар, хугацаа)	Төслийн удирдагч	Батлагдсан төсөв /сая.төг/	2020-2021 оны санхүүжилт /сая.төг/	Шимтгэл төвлөрүүлэлт		Сургуулийн нэр
					ШУТИС Тех сан	БС	
1	Баянхонгор аймаг дахь гэр хорооллын агаар бохирдлыг бууруулах хоол бэлтгэх халаалт дулаалгын бүтээгдэхүүн үйлчилгээний цэвэр хэмнэлттэй хүртээмжтэй багцыг хөгжүүлэх таниулах төсөл /2020-06-2021-06/ НҮБ Хүүхдийн сан MGLA/2880/2019/00 1-PCA	Б.Мөнхбаяр	159.13	169.51	4.03	1.60	БАС
2	Гадаад төсөл Berg Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг	Г.Ухнаа	200.00	184.10	9.20	9.20	ГУУС



	тухайн ашигт малтмалд хэрэгдэх аргачилсан зөвлөмж төсөл						
3	Гадаад төсөл АМЕР II 7 ашигт малтмалын аргачилсан зөвлөмж	Г.Ухнаа	231.25	223.75	11.19	11.19	ГУУС
4	Сумдын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах. 2020.01.10-2021.03.20	Ц.Банзрагч	78.30	66.50		3.92	ОМССХ
5	Монгол улсын ногоон ICT хөгжүүлэлт төслийн санал бичгийн ТЭЗҮ бэлтгэл	Г.Хишигжаргал	12.70	12.70	0.64	0.64	МХТС
6	Erasmus PLUS	Б.Мөнххүж	180.00	45.10			ЭШИГ
7	Erasmus UNIVERSITA DEGLI STUDI DELLA AQUILA, I INSATLLMENT	Т.Намнан	60.00	28.20			ЭШИГ
8	Ашигт малтмалын салбарын сургалтын цогц хөтөлбөр	Т.Намнан	150.00	42.30			ЭШИГ
9	Erasmus CC water төсөл	Б.Аюурзана	200.00	28.80			ЭШИГ
<b>Нийт</b>			<b>1,271.38</b>	<b>800.96</b>	<b>25.06</b>	<b>26.55</b>	

Эдгээр төслүүдээс 2021.07.05-ны өдрийн урьдчилсан дүнгээр гадаадын санхүүжилтээр 2020-2021 оны хичээлийн жилд нийт 800.96 сая төгрөгийн санхүүжилт авч ШУТИС-ийн Технологийн санд 25.06 сая, Бүрэлдэхүүн сургуулиудад 26.55 сая төгрөг, ШУТИС-ийн хэмжээнд нийт 51.66 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрсөн байна.

Инженер технологийн дээд боловсрол төслийн хүрээнд 2020-2021 онд гэрээний санхүүжилтээ авч судалгааны ажлаа гүйцэтгэж буй төслүүдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.


**ИТДБ төслийн хүрээнд 2020-2021 онд санхүүжилт авч хэрэгжүүлсэн төслүүдийн жагсаалт**

*Хүснэгт 3.5*

№	Төслийн нэр (Гэрээний дугаар, хугацаа)	Төслийн удирдагч	Батлагдсан төсөв /сая.төг/	2020-2021 оны санхүүжилт /сая.төг/	Сургуулийн нэр
1	Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн инновацын судалгаа	Б.Сэргэлэн	80.00	10.00	ЭХС
2	Дижитал технологид суурилсан судалгаа хөгжүүлэлт	Г.Хишигжаргал	80.00	5.90	МХТС
3	Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Д.Ганбат	80.00	10.00	МехТС



4	Монголын тэнгэрийн дэд бүтэц: Аэро хөдөлгүүр, байгаль орчны мониторинг, механик болон тээврийн инженерчлэлийн хэрэглээний ШУ, холбооны технологи ба боловсрол	Б.Эрдэнэбат	80.00	10.00	МехТС
Нийт			320.00	35.90	



**Зураг 3.8. Бүрэлдэхүүн сургуулиудын гүйцэтгэсэн гадаадын их дээд сургууль, ОУБ болон дотоодын ААН, бусад эх үүсвэрийн санхүүжилттэй төслүүдийн тоо**

Гадаадын их дээд сургууль, ОУБ-ын санхүүжилттэй болон дотоодын үйлдвэр аж ахуйн нэгж, бусад эх үүсвэрийн санхүүжилтээр бүрэлдэхүүн сургуулиудын хэрэгжүүлсэн төслүүдийн тоон мэдээллийг дээрх графикт харуулав.

### 3.3 "ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ" (MJEED)ТӨСӨЛ

ШУТИС-ийн тэргүүлэх чиглэл болох: 1) Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл, 2) Эрчим хүч байгаль орчны инженерчлэл, 3) Автоматжуулалт, системийн инженерчлэл, 4) Био инженеринг чиглэлүүдээр “Инженер технологийн дээд боловсрол” төслийн хамтарсан судалгааны төслүүд тус сургууль 2015-2023 онд хэрэгжиж байна. Төслийн зорилго нь МУ-д өндөр ур чадвар бүхий инженер технологийн мэргэжилтэн бэлтгэх, тэдний ур чадварыг сайжруулах, хүний нөөцийг бэхжүүлэх, сургалт судалгааны орчныг сайжруулах явдал юм.

Хамтарсан судалгааны хөтөлбөрийн хүрээнд 10 судалгааны төслийн баг Япон улсын 20 орчим их дээд сургуулийн судлаач, профессоруудтай хамтран судалгаа явуулж, үр дүнг түгээн дэлгэрүүлж байна.


Хамтарсан судалгааны 10 багийн үйл ажиллагаа доорх 3 чиглэлийн хүрээнд хэрэгжиж байна.

1. Судалгааны хүний нөөцийг чадавхжуулах
2. Судалгаа боловсруулалтын ажил
3. Судалгааны орчныг сайжруулах хүрээнд судалгааны лаборатори байгуулах



### 3.3.1 Судалгааны хүний нөөцийг чадавхжуулах

Уг чиглэлийн хүрээнд зэргийн, зэргийн бус, зочин судлаач хөтөлбөр хэрэгжиж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 380 багш судлаач хамрагдахаар төлөвлөснөөс 2022 оны байдлаар 367 багш судлаач хамрагдаад байна. Үүнээс зэргийн буюу магистр, докторын сургалтад 90 багш, судлаач хамрагдахаар төлөвлөсний 70 багш, судлаач 2022 он хүртэл хамрагдаж нийт зардалд 13,340,000,000 төгрөгийн санхүүжилтийг төслийн нэгжээс олгосон.



Зураг 3.9. Зэргийн хөтөлбөрт хамрагдсан багш, судлаачдын тоон үзүүлэлт

ШУТИС-ийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/172 дугаар тушаал; ШУТИС-ийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар дараах төслийн багийн ахлагчдыг шинэчлэн томиллоо /Хүснэгт 3.6/.

#### Шинээр томилогдсон судалгааны профессорын ахлагчид

Хүснэгт 3.6

№	Төслийн нэр	Бүрэлдэхүүн сургууль	Төслийн багийн ахлагч	Шинээр томилогдсон багийн ахлагч
1	Монголын тэнгэрийн дэд бүтэц	МехТС	Б.Эрдэнэбат	Т.Эрдэнэбат
2	Монголын хүнсний зарим бүтээгдэхүүний хатаах аргын харьцуулсан судалгаа	ҮТС	Ц.Одбаяр	Ө.Одгэрэл
3	Хүний тогтвортой хөгжлийг хангах био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	МехТС	Д.Ганбат	Х.Батбаяр

2021-2022 оны хичээлийн жилд зэргийн хөтөлбөрөөр магистрт 2 судлаач, зэргийн бус хөтөлбөрт 7 судлаач хамрагдсан ба 1 зочин судлаач ирж ажилласан. Тайлант онд зэргийн хөтөлбөрт хамрагдсан 7 судлаач доктор (Ph.D) -ын зэргээ амжилттай хамгааллаа.

2022 оны 06-р сарын 08-ны өдөр хуралдсан ШУТИС-ийн ажлын хэсгийн хурлаар зэргийн бус болон зочин судлаач хөтөлбөрт 2022 оны сүүлийн хагас жилд хамрагдах багш,



судлаачдын асуудлыг хэлэлцүүлсэн бөгөөд нийт 30 хүнийг дэмжиж, холбогдох материалын хамт төслийн нэгжид хүргүүлсэн /Хүснэгт 3.7/.

### Зэргийн бус болон зочин судлаач хөтөлбөрт хамрагдах судлаачид

Хүснэгт 3.7

№	Хамтарсан судалгааны багийн нэр	Судалгааны багийн ахлагч	Сургууль	Зэргийн	Зэргийн бус	Зочин судлаач
1	Монгол орны эрдэс баялгийн суурь судалгаа	С.Жаргалан	ГУУС	1	1	-
2	Дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ ба ахуйн ухаалаг системийн хөгжүүлэлтийн судалгаа	Г.Хишигжаргал	ГУУС	2	8	1
3	Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн инновацын судалгаа	Б.Сэргэлэн	ЭХС	-	3	2
4	Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Х.Батбаяр	МехТС	-	-	1
5	Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт	М.Дэлгэрмаа	МехТС	1	-	7
6	Монголын тэнгэрийн дэд бүтэц	Т.Эрдэнэбат	МехТС	-	-	3
<b>НИЙТ</b>				<b>4</b>	<b>12</b>	<b>14</b>

### 3.3.2. Судалгаа боловсруулалтын ажил

Хамтарсан 10 судалгааны багийн 3 багт 2021-2022 оны хичээлийн жилд судалгаа боловсруулалтын ажлыг нь дэмжих зорилгоор төслийн нэгжээс нийт 30 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

### ШУТИС-ийн судалгааны багт олгогдсон санхүүжилт

Хүснэгт 3.8

№	Төсөл, ажлын нэр	Гүйцэтгэгч байгууллага	Удирдагч	2021-2022 оны санхүүжилт
1	Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах, ногоон ирээдүй төсөл	БАС	Д.Сүнжидмаа	10.000,000
2	Монголын тэнгэрийн дэд бүтэц	МехТС	Т.Эрдэнэбат	10.000,000
3	Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн инновацын судалгаа	ЭХС	Б.Сэргэлэн	10.000,000
<b>НИЙТ</b>				<b>30.000,000</b>

Хамтарсан судалгааны ажлын үр дүнд 10 судалгааны багаас эрдэм шинжилгээний гадаад өгүүлэл 37, дотоод өгүүлэл 35, олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл 16, дотоодын эрдэм шинжилгээний хурлын илтгэл 26, баталгаажуулсан оюуны өмч 3 тус тус гарсан байна.



Судалгааны ажлын үр дүн

Хүснэгт 3.9

Судалгааны сэдэв	Багийн ахлагч, харьяа сургууль	Судалгааны ажлын үр дүн				
		ОУС-д хэвлүүлсэн ЭШӨ	Дотоодын сэтгүүлийн ЭШӨ	ОУЭШ Хурлын илтгэл	Дотоодын ЭШХурлын илтгэл	Оюуны өмч
Монгол орны эрдэс баялгийн суурь судалгаа	С.Жаргалан, ГУУС					
Үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах ногоон технологи	Д.Сүнжидмаа, БАС	4	2	0	0	1
Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа	М.Дэлгэрмаа, МехТС	14	12	7	11	1
Монгол дахь тэнгэрийн дэд бүтэц: Агаар сансрын механик инженерийн мэдлэг ба логистик, хүрээлэн буй орчны хяналт шинжилгээ	Т.Эрдэнэбат, МехТС	1	3	0	0	
Хүрээлэн орчны бохирдлын хяналтын цогцолбор судалгаа, тогтвортой хөгжил: Төв Монголын Туул, Хараа голын ай савуудын жишээн дээр	О.Мөнхцэцэг, ГУУС					
Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн инновацын судалгаа	Б.Сэргэлэн, ЭХС	6	10	1	2	1
Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа	Ц.Цоггэрэл, БАС	1	2	0	3	
Дижитал технологид суурилсан судалгаа хөгжүүлэлт	Г.Хишигжаргал, МХТС	3		6	5	
Монголын хүнсний зарим бүтээгдэхүүн хатаах аргын харьцуулсан судалгаа	Ц.Одбаяр УТС	0	0	0	2	
Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Х.Батбаяр, МехТС	8	6	2	3	
		37	35	16	26	3

3.3.3. Судалгааны орчныг сайжруулах хүрээнд судалгааны лаборатори байгуулах

Хамтарсан судалгааны 10 багийн лабораторийн тоног төхөөрөмжид олгогдсон нийт санхүүжилтийг хүснэгтээр харуулав. /Хүснэгт 3.10/



## Судалгааны багийн лабораторийн мэдээлэл /2017-2022 онд/

Хүснэгт 3.10

№	Хамрагдсан ээлж	Судалгааны багийн нэр	Тоо хэмжээ	Үнийн дүн /ам.доллар/
1	Худалдан авалтын 1-р ээлж, 2017-2019 онд	Үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах ногоон технологи	12 нэр төрлийн 13 ширхэг т/төх.	872,959
2		Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн инновацийн судалгаа	8 нэр төрлийн 8 ширхэг т/төх.	392,994
3		Монгол орны эрдэс баялгийн суурь судалгаа	4 нэр төрлийн 4 ширхэг т/төх.	285,692
4	Худалдан авалтын 2-р ээлж, 2019-2021 онд	Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа	19 нэр төрлийн 19 ширхэг т/төх.	1,173,186.38
5		Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	14 нэр төрлийн 18 ширхэг т/төх.	601,113.62
6		Хүрээлэн орчны бохирдлын хяналтын цогцолбор судалгаа, тогтвортой хөгжил: Төв Монголын Туул, Хараа голын ай савуудын жишээн дээр	8 нэр төрлийн 8 ширхэг т/төх.	456,300
7		Монголын хүнсний зарим бүтээгдэхүүн хатаах аргын харьцуулсан судалгаа	29 нэр төрлийн 36 ширхэг т/төх.	522,800
8	Худалдан авалтын 3-р ээлж, 2020-2022 онд	Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа	11 нэр төрлийн 42 ширхэг т/төх.	834,000
9		Дижитал технологид суурилсан судалгаа хөгжүүлэлт	39 нэр төрлийн 113 ширхэг т/төх.	1,159,948.66
10		Монгол дахь тэнгэрийн дэд бүтэц: Агаар сансрын механик инженерийн мэдлэг ба логистик, хүрээлэн буй орчны хяналт шинжилгээ	21 нэр төрлийн 51 ширхэг т/төх.	Дахин тендер зарлах
<b>Нийт дүн</b>			<b>144 нэр төрлийн 261 ширхэг т/төх.</b>	<b>6,298,993.66</b>

10 судалгааны багаас нийт 9 судалгааны багт 6,2 сая ам долларын үнэ бүхий 144 нэр төрлийн 261 ширхэг судалгааны тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

2022 онд 3 судалгааны лаборатори бүрэн ашиглалтад орсон бөгөөд өнөөгийн байдлаар дээрх 9 лабораторийн 5 нь ашиглалтад ороод байна. Үлдсэн 4 лабораторийн тоног төхөөрөмж суурилуулагдаж дууссан ба сургалтын ажил хүлээгдэж байна.

**2021-2022 онд ашиглалтад орсон лабораториудын мэдээлэл**

**“Байгалийн нөөц судлал”-ын лаборатори:** 2022/03/14-ний өдөр нээлтээ хийсэн.

Тус лабораторид Laser Raman Spectrophotometer, Stereo Microscope зэрэг 285 мянга гаруй ам.долларын өртөг бүхий орчин үеийн судалгааны 4 төрлийн тоног төхөөрөмж нийлүүллээ. Уг тоног төхөөрөмжийг ашигласнаар Монголоос олборлосон ашигт малтмал, эрдсийн шинжилгээний чанар сайжирч, энэ чиглэлээр суралцаж буй оюутнуудын сургалт судалгааны өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.





Зураг 3.10. “Байгалийн нөөц судлал”-ын лаборатори

### “Дэвшилтэт технологиудын судалгаа хөгжүүлэлтийн лаборатори”

2022/04/18-ны өдөр нээлтээ хийлээ. Мэдээлэл, холбооны технологийн сургуульд 727,000 ам.долларын үнэ бүхий судалгааны лабораторийн тоног төхөөрөмж хүлээлгэн өглөө. Эдгээр багаж тоног төхөөрөмж нь үйлдвэрлэл, технологиор тэргүүлэгч улс орнуудад үйлдвэрлэгдсэн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи байхын зэрэгцээ ихэнх нь ШУТИС-д төдийгүй, Монгол улсад анх удаа орж ирж буй шинэ төрлийн багаж, тоног төхөөрөмж болж байгаагаараа онцлогтой юм.



Зураг 3.11 “Дэвшилтэт технологиудын судалгаа хөгжүүлэлтийн лаборатори”

“Цахилгаан хангамжийн судалгааны лаборатори”: 2022/05/20-ны өдөр нээлтээ хийв. Эрчим хүчний сургуульд 393,000 ам долларын үнэ бүхий судалгааны лабораторийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Хамтарсан судалгаа хөтөлбөрийн хүрээнд тус сургуулиас төсөлд хамрагдаж буй судалгааны багийн захиалгын дагуу шаардлагатай туршилт судалгааг хийх 8 ширхэг багаж, тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлж, 1 багаж дээр (Winding analyzer) онлайн сургалт авч, бусад тоног төхөөрөмжийн заавруудыг видеогоор төслийн багт илгээх ажлуудыг зохион байгуулж, хүлээлгэн өгөв. Мөн эдгээр шинэ тоног төхөөрөмж дээр ажиллах мэргэжилтнүүдийг тус төслийн зэргийн болон зэргийн бус сургалтын хүрээнд Япон улсад суралцуулан бэлтгэж байна.





Зураг 3.13. ШУТИС-ийн харьяа хүрээлэнгүүд дээр 2022/05/11-12

Судалгааны хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн нэгтгэл /2021 он/

Хүснэгт 3.11

Үзүүлэлт	УУХ	ОМССХ	ХҮССХ	ДТҮЭХ	НИЙТ
Гүйцэтгэсэн төсөл гэрээт ажил /тоо/	9	7	17	9	42
Лабораторид хийгдсэн туршилт судалгааны ажлын тоо	180 дээж	23	4 төслөөр 68 шинжилгээ	3	251
Гадаадад хэвлүүлсэн бүтээл	1	3	-	-	4
Дотоодод хэвлүүлсэн бүтээл	21	2	24	5	52
Баталгаажуулсан оюуны өмч	2	-	2	-	4
ЭШ-ний арга хэмжээ	3	2	10	7	22
Инновацийн үйл ажиллагаа	5	3	13	4	25
Хамтын ажиллагаа	1	2	61	3	67

Тайлбар: УУХ-Уул уурхайн хүрээлэн;  
 ОМССХ-Ой модны сургалт судалгааны хүрээлэн;  
 ХҮССХ- Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн;  
 ДТҮЭХ-Дулааны техник, үйлдвэрлэл, экологийн хүрээлэн.

Эдгээр хүрээлэнгүүд 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажил нийт 42, лаборатори дээр хийгдсэн туршилт, судалгааны ажил 274, гадаадад 4 бүтээл, дотоодод 52 бүтээл хэвлэгдэж, 4 оюуны өмчийг баталгаажуулсан бөгөөд зохион байгуулсан эрдэм шинжилгээний арга хэмжээ 22, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн бүтээл 25, гадаад, дотоодын байгууллагатай байгуулсан хамтын ажиллагаа 67 гэх мэт үр дүнтэй ажилласан байна.

3.4.1 Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн

Хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажил /2021/

Хүснэгт 3.12

№	Төслийн нэр	Удирдагчийн нэр	Хэрэгжих хугацаа	Гүйцэтгэл
Шинжлэх ухаан, технологийн төсөл-2				
1	“Арьс, шир бэлтгэлийн чанарын системийг боловсронгуй болгох судалгаа”	Т.Төрмөнх	2019.06-2022.12	2021 онд санхүүжилт хийгдсэн /гэрээний дагуу бол 2020 оны ажлууд/ төлөвлөсөн ажлууд 85%-ын гүйцэтгэлтэй байна. 2021 оны санхүүжилт оройтож хийгдсэн 2022 онд багтааж дуусгахаар ажиллаж байна.
2	Нүүдлийн соёл, орчин үеийн чиг хандлага хосолсон хувцас загвар зохион бүтээхэд малын	Р.Бадмаанямбуу	2019.06-2021.12	2021 онд төлөвлөсөн ажлууд 91% гүйцэтгэлтэй. 2022 оны 3 сард үлдэгдэл санхүүжилт хийгдэж, хувцас загварын коллекцыг Парисын загварын долоо хоногт 2022-03 сард танилцууллаа. ШУ-



	гаралтай түүхий эдийг ашиглах нь			ны мэдлэг шингэсэн, ноолууран бүтээгдэхүүний “Бүүвэй” брэндийг танилцуулах арга хэмжээг УБ-т 2022-06-07 өдөр зохион байгууллаа. 2022 оны 6-р сард төслийн тайлангаа хүлээлгэн өгнө.
Суурь судалгааны төсөл-1				
1	Арьс шир боловсруулах хими технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлэх нь	Доктор (Ph.D) С.Цэрэндулам	2020.09- 2023.12	Төслийн эхний жил /2021 онд/-д хийж гүйцэтгэх ажлуудаа календарчилсан төлөвлөгөөний дагуу 100 хувь хийж гүйцэтгэсэн.
Олон улсын санхүүжилттэй төсөл -3				
1	Лабораторийн шинжээч нарыг бэлтгэх” сургалт зохион байгуулах төсөл  /ADB-ийн санхүүжилтээр/	Ноос, ноолуур судлалын салбар	2020.06- 2021.01	"Ноос ноолууран бэлэн бүтээгдэхүүний сорилтын лабораторийн шинжээч бэлтгэх" сургалт - 9 хүн, 2. "Ээрэх үйлдвэрлэлийн дотоод хяналтын сорилтын лабораторийн шинжээч бэлтгэх" сургалт- 14 хүн, 3. "Анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийн дотоод хяналтын сорилтын лабораторийн шинжээч бэлтгэх" сургалт- 24 хүн, 4. Нэхмэлийн үйлдвэрлэлийн химийн сорилтын лабораторийн шинжээч бэлтгэх сургалт 13 хүн, Нийт 6 удаагийн сургалтад 60 хүн хамрагдсан.
2	“Текстилийн үйлдвэрлэлийн ноосон ээрмэлийн чанарыг дээшлүүлэх үйлчилгээ”  /НУБ-ын ЮНИДО/	Ноос, ноолуур судлалын салбар	2020.08- 2021.05	Автомат машинаар хяргаж бэлтгэсэн хонины ноосны үнэрийг багасгаж, цагааны зэргийг дээшлүүлэх технологиор угааж, ноосон ээрмэл үйлдвэрлэсэн. Үйлдвэрлэсэн ээрмэлээр сүлжмэл бүтээгдэхүүн болон жин хөнгөрүүлсэн хөнжил үйлдвэрлэсэн.
3	“Зах зээлийн холбоос, хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт ба загварын арга хэмжээ”. /НУБ-ын ЮНИДО/	Доктор (Ph.D) Т.Төрмөнх	2020.09- 2021.05	Ноос ноолууран бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг дизайнерууд, сургагч багшийн хамт гүйцэтгэж, арьс ширэн цүнх гутал урлаачдын дунд уралдаан зохион байгуулж, гэрээт байгууллагуудтай хамтран цахим сургалтын танхим, загварын шоу, үзэсгэлэн, хөнгөн үйлдвэрийн салбарыг олон нийтэд таниулах нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж ажилласан.
Гэрээт ажил -11				

### Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлүүд

- *Бог малын арьсны ар хуулах төхөөрөмж УБД 20-0003413*
- *Бод малын арьсны ар хуулах төхөөрөмж УБД 20-0003414*




- Технологийн судалгаа, үйлдвэрлэлд нэвтэрсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ
  1. Эвсэг технологийн үйлдвэрлэлд нэвтрүүлэлт -3
  2. Түүхий эдийн бэлтгэл, чанарын хамгаалалт технологи -2
  3. ТЭЗҮ-24. Технологийн заавар -2
  5. Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн ажил -4 тус тус гүйцэтгэлээ.



Зураг 3.14. Технологийн судалгаа, үйлдвэрлэлд нэвтэрсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ

Судалгааны лабораторийн үйл ажиллагаа



Хүрээлэнгийн Сорилтын төвийн Текстилийн итгэмжлэгдсэн лаборатори нь ээлжит итгэмжлэлийн үнэлгээндээ хамрагдан, MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангасан тул Үндэсний итгэмжлэлийн төвөөс сорилт гүйцэтгэх эрхийн итгэмжлэлийн гэрчилгээгээ (2021-2024 он) авсан.



## 3.4.2 Уул уурхайн хүрээлэн

## /Хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажил /2021/

Хүснэгт 3.13

№	Төслийн нэр	Удирдагчийн нэр	Хэрэгжих хугацаа	Гүйцэтгэл
Суурь судалгааны төсөл-1				
1	“Уурхайн геотехникийн судалгаа”	Х.Жаргалсайхан	2017-2020	Суурь судалгааны хүрээнд чулуулгийн физик-механик, геотехникийн шинж чанарыг тодорхойлох арга, аргачлалыг боловсруулан, Эрдэм шинжилгээний гэрээт ажлаар “Баянтээгийн сайжруулсан шахмал түлшний технологийн туршилт”, Занарын хийжүүлэлтийн судалгаа”-төслийг аж ахуйн нэгжийн захиалгаар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна. Мөн нүүрс, төмрийн хүдэр, жоншны 37 ордын 472 дээжид чулуулгийн геомеханикийн шинж чанарыг тодорхойлох судалгааг хийж, үр дүнг нь хүлээлгэн өгөөд байна.
ТЭЗҮ-8				

## Лабораторийн шинжилгээ, судалгаа

Хүснэгт 3.14

№	Хийж гүйцэтгэсэн ажлын нэр	Гэрээний санхүүжилтийн нийт /мян төг./	Тухайн онд авсан санхүүжилтийн дүн /мян төг./	Захиалагч компани
2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улиралд магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг техник, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны чиглэлээр 3 салбар хуралдаан зохион байгуулсан. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хуралд техникийн ухааны чиглэлээр 26, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр 22, байгалийн ухааны чиглэлээр 8 илтгэлийг тус тус хэлэлцүүлж, магистрантын 9, докторантын 9 илтгэлийг шилдэг илтгэлээр шалгаруулан батламж, их сургуулийн Захирлын 2022 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн А/147 тоот тушаалаар 18 оюутанд нийт 36 кредитийн урамшуулал олгосон. Магистр, доктор оюутны 22(5)-293 дугаар бүхий эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг нэгтгэн гаргалаа.



*Зураг 3.33. Магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцож шилдэг илтгэлээр шалгарсан бүтээлүүд*

*Хүснэгт 3.40*

№	Овог, нэр	Сургууль, төв	Илтгэлийн сэдэв	Эзэлсэн байр
<b>ТЕХНИКИЙН УХААНЫ САЛБАР /магистрант/</b>				
1	П.Чулуундорж	МехТС	Баяжуулах үйлдвэрийн металл хийцийн өнөөгийн нөхцөл байдал ба зэврэлтэд өртсөн даралтат савны бат бэх, найдвартай ажиллагааг инженерийн симуляц, тооцоолоор үнэлэх судалгаа	I
2	А.Отгонбаяр	МХТС	Бага нягтаршилтай инфра мэдрэгч ашиглан өдөр тутмын үйлдэл таних нь	II
3	С.Мөнхбаатар	ДарТС	Бетоны бат бэхийг сайжруулах боломжийн судалгаа	III
<b>ТЕХНИКИЙН УХААНЫ САЛБАР /докторант/</b>				
1	Ц.Ганболд	ҮТС	Хонины ноосон ширхэгтийн үнэрт нэгдлийг арилгах боломж, судалгааны үр дүнгээс	I
2	Б.Жавхлан	МехТС	Цутгамлын гадаргууг бөхжүүлэх холимгийн найрлагыг оновчлох туршилтын үр дүн	II
3	Н.Саранчимэг	БАС	Металл дамнуурууны гал тэсвэршлийн судалгаа	III
<b>НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР /магистрант/</b>				
1	Д.Баяржаргал	ДарТС	Химийн хичээлд асуудалд суурилсан сургалтын аргыг туршсан зарим үр дүн	I




2	Ж.Бат-Эрдэнэ	БАТС	Эрчим хүчний зүүн түгээх төвийн үйл ажиллагааны эдийн засгийн үр ашигтай байдлыг сайжруулах боломж (Намгархаг болон зөөлөн хөрстэй газарт байрлах тулгуурын бэхлэгээний жишээн дээр)	II
3	М.Алтаннавч	БАТС	Ковид-19 үеийн цахим сургалтын чанарыг үнэлэх нь (Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн жишээн дээр)	III
<b>НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР /докторант/</b>				
1	Ж.Мөнхдэлгэр	БуХС	Монгол шагайн харвааг геоантропологиин үүднээс судлах нь	I
2	Б.Алтанхуяг	БАТС	Монгол орны элсэн манханыг түшиглэн адал явдалт аялал жуулчлал хөгжүүлэх нөөцийн судалгаа	II
3	Э.Сувд	НБТ	Орон зайн төсөөлөх чадвар хөгжүүлэх сургалтыг ТИР загвараар төлөвлөж, үр нөлөөг шинжлэх нь	III
<b>БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР /магистрант/</b>				
1	Э.Уранчимэг	МХТС	Био-молекулын харилцан үйлчлэлийн сүлжээ, чанарын шинжилгээ	I
2	Э.Энхтуул	ХШУС	Улаанбаатар хотын дулааны арал (УН)-ын орон зайн тархалтын зураглалыг боловсруулах нь	II
3	О.Бадамцэцэг	БАС	Ховд хотын ус хэрэглээний горимд хийсэн шинжилгээ	III
<b>БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР /докторант/</b>				
1	Ш.Насанжаргал	ХШУС	Байгалийн түүхий эдэд суурилсан материалаар усан орчноос хүнд металлыг ялгах судалгаа	I
2	Г.Батчимэг	ХШУС	Сарлагийн хөөврийн меланины судалгаа	II
3	А.Элбэгжаргал	ХШУС	Гашуун сухайтын нүүрсний тээвэрлэлтийн алдагдсан боломжийн судалгаа	III

### 3.12.2 Докторантурын сургалтын төгсөлтийн үйл ажиллагаа

2021-2022 оны хичээлийн намрын улиралд докторантын сургалт, судалгааны ажлын явцын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах удирдамжийг батлуулан, докторантын сургалт, судалгааны ажлын түвшнийг тогтоож, мэргэжлийн нэгдсэн шалгалт авах ажлыг хичээлийн жилийн явцад 2 удаа зохион байгуулсан.

Докторантурын сургалт дүүргэсэн гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан докторант нарын материалыг хүлээн авч хяналтын магадалгаа хийн, их сургуулийн Захирлын 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А-97 тоот тушаалаар 30, 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А-217 тоот тушаалаар 53 докторантад доктор (Ph.D)-ын сургалтыг дүүргэснийг гэрчлэх гэрчилгээ олгож, нийт 83 докторантыг 2021-2022 оны хичээлийн жилд горилогчоор баталсан.



Зураг 3.34. Докторантурын сургалт дүүргэж сертификат авсан горилогчдын судалгаа (Бүрэлдэхүүн сургууль, төв тус бүрээр)




### 3.12.3 Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалж, төгссөн эрдэмтдийн мэдээлэл

Сүүлийн 5 жилийн байдлаар ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, төвийн докторантурын сургалтыг дүүргэж, 94 горилогч доктор(Ph.D)-ын зэрэг хүртсэн байна.

#### ШУТИС-ийн докторантур төгсөгчдийн тоо (2017-2022 оны байдлаар)

Хүснэгт 3.41

Сургууль, төвийн нэр	Хичээлийн жил /он/					Нийт
	2017/2018	2018/2019	2019/2020	2020/2021	2021-2022	
БАС	3	0	0	1	5	5
БАТС	5	4	3	3	7	20
БуХС	1	0	2	0	2	4
ГУУС	5	1	1	0	8	9
МехТС	1	4	6	0	4	13
МХТС	3	1	0	1	3	5
ҮТС	0	2	0	0	3	3
ХШУС	1	6	1	1	4	13
ЭХС	1	1	5	1	2	9
ОУДБСТ/НБТ	2	3	1	1	1	7
ГХИ/ГХС	1	1	4	0	1	6
Нийт	23	23	23	8	40	94



Зураг 3.35. Доктор(Ph.D)-ын зэрэг хүртсэн эрдэмтдийн тоо

2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улиралд ШУТИС-ийн Захирлын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн тоот тушаалаар 2, 6 дугаар сарын 17-ны өдрийн А/191 тоот тушаалаар 11, намрын улиралд 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/247 тоот тушаалаар 6, 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/215 тоот тушаалаар 5, 10 дугаар сарын 25-ны өдрийн А/189 тоот тушаалаар 9, 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/154 тоот тушаалаар 7, нийт 40 горилогч докторын зэрэг хамгаалуулах 5 зөвлөл дээр докторын диссертациа амжилттай хамгаалан, доктор(Ph.D)-ын зэрэг хүртсэн.

БШУС-ын 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/181 тоот тушаалаар “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн баглах тухай”, БШУС-ын 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/92 тоот тушаалаар “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм” тус тус батлагдаж, 2021 оны 6 дугаар сараас эхлэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байна.



## Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан эрдэмтэд /2021-2022/

Хүснэгт 3.42

д/д	Овог, нэр	Докторын зэрэг	Судалгааны ажлын сэдэв
1	Аюушийн Тунгалаг	Техникийн ухааны	Шинэсэн ( <i>larix sibirica</i> ldb.) Зүсмэл материалыг түллэгийн хийн аргаар хатаах технологийн судалгаа, боловсруулалт
2	Онхын Цогбаяр	Техникийн ухааны	Цахилгаан шугам сүлжээний цахилгаан энергийн дамжуулалтын оновчлолын математик загварууд
3	Галсанжамцын Ойнбаяр	Нийгмийн ажлын	Хүүхдийн нийгмийн ур чадварыг хөгжүүлэх нь (Асрамжийн төвийн жишээн дээр)
4	Балжиннямын Баттогтох	Техникийн ухааны	Нүүрсний исэлдэлт, өөрөө шаталт, агаарын урсгалын хамаарлын судалгаа
5	Үржинцэрэнгийн Пүрэвжав	Техникийн ухааны	Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх биологийн идэвхт бэлдмэл (бин5) - ийг гарган авах хими технологийн судалгаа
6	Намсрайжавын Жигжидсүрэн	Техникийн ухааны	Цахилгаан эрчим хүч ба ачааллыг хүчин зүйлийн шинжлэлийн аргуудаар загварчлах судалгаа
7	Нямдоржийн Одонтуяа	Техникийн ухааны	Барилгын буурийн суумтгай ул хөрсөнд геосинтетик арматуртай хөрсөн дэр ашиглах судалгаа
8	Жигмэдийн Даваацэрэн	Техникийн ухааны	Саарал ус цэвэрлэх технологид үнсэн шүүгүүр материал ашиглах судалгаа
9	Буянхишигийн Басбиш	Техникийн ухааны	Суумтгай ул хөрсөнд бэхжүүлсэн хөрсөн буурь ба цутгамал шон суурь төсөөлөх судалгаа (Дархан хотын геотехникийн нөхцөлийн жишээгээр)
10	Наранцогтын Насанбаяр	Техникийн ухааны	Улаанбаатар хотын газрын доорх усны нөөцийг зохиомлоор нэмэгдүүлэх судалгаа (Туул гол-Хужирбулангийн хэсгийн жишээн дээр)
11	Ганжуурын Оюунгэрэл	Физикийн ухааны	Лазерын гэрлийн динамик сарнилын аргаар бодисын бөөмийн хэмжээг тодорхойлох нь
12	Бэгзийн Анхбаяр	Боловсролын удирдлагын	Дээд боловсролын байгууллага дахь жендерийн тэгш байдлын үнэлгээний индекс боловсруулсан нь (ШУТИС-ийн жишээн дээр)
13	Балдандоржийн Бүрэнжаргал	Менежментийн	Ажиллагчдын орлогын тогтолцоог шинэчлэх боломжийн судалгаа (Хөнгөн үйлдвэрийн жишээн дээр)
14	Баттулгын Дэлгэрцэцэг	Урлаг судлалын ухааны	Монгол хэв шинж бүхий сав, баглаа боодлын дизайны судалгаа (Сүү, сүүн бүтээгдэхүүний сав баглаа боодлын жишээн дээр)
15	Сонинхүүгийн Жаргалмаа	Химийн ухааны	Зарим ордын нүүрсний халууны задралын кинетик судалгаа
16	Очирын Отгонбаяр	Менежментийн ухааны	Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн судалгаа
17	Бадам-Одсэрийн Дөлгөөн	Менежментийн ухааны	Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээний төлөвлөлтийг боловсронгуй болгох асуудал
18	Магсарын Бат-Очир	Менежментийн ухааны	Оюутны спортыг хөгжүүлэх менежментийн асуудал
19	Дүгэржавын Бадрах	Техникийн ухааны	Хөдөлгөөний тусгай горимоор ажиллах цахилгаан автомашины хүч дамжуулах ангийн судалгаа
20	Нэргүйн Мөнхзул	Техникийн ухааны	Автомашины резин дугуйн техникийн үйлчилгээний үечлэлийг тогтоох судалгаа
21	Галсандоржийн Амармэнд	Техникийн ухааны	Нисэх аппаратын далавчны өргөх хүчийг нэмэгдүүлэх боломжийн судалгаа
22	Үүрийнцэцэгийн Ариунаа	Математикийн ухааны	Зарим шугаман бус гиперболлог дифференциал тэгшитгэлийн системийг бодох $ale$ нэг алхамт $weno$ арга
23	Ломбодоржийн Батзориг	Техникийн ухааны	Инерцийн болон гидродинамикийн хүчнүүдийг ашиглан цусан дахь микро-эсүүдийг ялгах био-чипийн хөгжүүлэлтийн судалгаа
24	Эрдэнэнэмэхийн Ганзориг	Техникийн ухааны	Лазер сканерын технологиор хадгалах савны геометр үзүүлэлтийг тодорхойлох арга зүй
25	Ганболдын Өлзийсайхан	Техникийн ухааны	Геодезийн хэмжилт зураглал, тандан судлалын аргаар сэдэвчилсэн зургийн суурийг бэлтгэх арга зүй
26	Цэрэнцогзолын Одончимэг	Хэл шинжлэлийн	Усны барилга байгууламжийн нэр томьёо бүрэлдэн тогтох үйл явц, бүтэц, утга зүйн судалгаа



27	Төмөрбаатарын Оюунбилэг	Нийгмийн ажлын	Оюутны үнэт зүйлд суурилсан нийгмийн ажлын үйлчилгээний загвар боловсруулах нь /ШУТИС-ийн жишээн дээр/
28	Батаагийн Жавзандулам	Техникийн ухааны	Сансрын зурагт суурилан том масштабын байр зүйн зураг хийх арга зүй
29	Дамбаева Ирина Жаргаловна	Техникийн ухааны	Уул уурхайн бүс нутгийн оролцогч талуудын өмнө хүлээх хариуцлагын хүрээнд уул уурхайн компанийн бизнесийн загварыг хөгжүүлэх судалгаа
30	Доржхүүгийн Энхбаатар	Техникийн ухааны	Авто замын засвар шинэчлэлтийн ажилд хүйтнээр дахин боловсруулах технологийг нутагшуулах судалгаа
31	Санжсүрэнгийн Оюунбат	Геологи-эрдэс судлалын	Нуурын бүсийн улаан дэл газрын ховор элементийн ордын геологи ба бодисын найрлага
32	Батболдын Дэмбэрэлсүрэн	Геологи-эрдэс судлалын	Өмнөд монголын баруун наран ордын нүүрсний хуримтлагдсан нөхцөл
33	Энхбаатарын Сугарсүрэн	Менежментийн	"Х болон мянганы үе"-ийн ажилтнуудын ажлын сэтгэл ханамж, ажилтны сэтгэлтэй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа
34	Амаагийн Оюунгэрэл	Бизнесийн удирдлагын	Компанийн удирдлагын зохион байгуулалтын хүчин зүйлсийн судалгаа
35	Бямбын Баттайван	Менежментийн	Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, үр дагаврыг үнэлэх арга зүйн асуудал
36	Жанчивын Билэгсайхан	Техникийн ухааны	Ураны хүдрийн ордыг ашиглах технологийн харьцуулсан судалгаа (монголын ураны ордуудын жишээн дээр)
37	Содномын Энхтуяа	Техникийн ухааны	Монгол улсын өндрийн тогтолцоог хиймэл дагуулын технологиор шинэчлэх арга зүй
38	Довдоны Энхзол	Техникийн ухааны	Бичвэрээс зураг үүсгэх аргаар жиргээний хандлагыг шинжлэх нь
39	Эрхэмбаатарын Нарантуяа	Техникийн ухааны	Мэдээлэл холбооны технологийн хөгжлийн үзүүлэлтийг энтропид тулгуурлан тодорхойлох боломжийн судалгаа
40	Ганбаатарын Ганбат	Техникийн ухааны	Криптосистемд зориулсан молекул тооцооллын алгоритм хөгжүүлэх нь


### 3.12.4 Докторантурт суралцагчдын голч дүнгийн судалгаа

2021-2022 оны хичээлийн жилд докторантурт суралцагчдын голч дүнд шинжилгээ хийж үзэхэд доктор оюутны голч дүнгийн дундаж 3.75 байна.

#### Доктор оюутны голч дүнгийн судалгаа

Хүснэгт 3.43

№	Бүрэлдэхүүн сургууль	2021-2022 Намар	2021-2022 Хавар	Үнэлгээний голч дүн
1	Барилга, архитектурын сургууль	3.60	3.78	3.69
2	Бизнесийн ахисан түвшний сургууль	3.51	3.86	3.69
3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	3.93	3.84	3.89
4	Гадаад хэлний институт	3.87	3.20	3.50
5	Геологи, уул уурхайн сургууль	3.81	3.79	3.80
6	Механик, тээврийн сургууль	3.82	3.95	3.80
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	3.84	3.97	3.90
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	3.81	3.93	3.87
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	3.45	3.74	3.60
10	Эрчим хүчний сургууль	3.99	3.80	3.90
11	Нээлттэй боловсролын төв	3.55	3.61	3.60
<b>ШУТИС-ийн дундаж голдүн(GPA)</b>				<b>3.75</b>



**Зураг 3.36. Доктор оюутны голч дүнгийн судалгаа  
(Бүрэлдэхүүн сургууль, төв тус бүрээр)**

### 3.13 БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТЫГ ШАЛГАХ ПРОГРАММ ХАНГАМЖ

Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичгийн төлөвлөгөөнд эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн цахим сан байгуулах, бүтээлийн хулгайтай тэмцэх ажлыг хэрэгжүүлэх ажлууд тусгагдсаны дагуу Захирлын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/16 тоот тушаалаар ШУТИС-ийн бүтээлийн хуулбарлалт (плагаризм) шалгах программ хангамжийг нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулагдаж, багаараа ажлын хэсэгт орж ажилласан.



Дээрх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Гадаад, дотоодын их сургуулиудын бүтээлийн хулгайтай хэрхэн тэмцэж буй талаар нарийвчлан судалгаа хийв.
2. UNISOLUTION PARTNERS компанитай хамтран ажиллаж, бүтээлийн хуулбарлалтыг шалгах программ хангамжийг ажиллуулж эхлэв.
3. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Бүтээлийн хуулбарлалтыг шалгах түр журам”-ыг боловсруулан хэлэлцүүлж, Захирлын 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/127 тоот тушаалаар батлуулав.
4. 2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улиралд төгсөх магистр, доктор оюутны диссертацийн ажлын агуулгын давхцалын хувь хэмжээг туршилтаар тогтоож эхлэв.
5. Төгссөн докторант нарын судалгааны ажилд агуулгын давхцалын хувь хэмжээг тогтооход бага нь 9.5, хамгийн их нь 17.5 хувьтай дүн гарав.
6. 2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улирлаас Бүтээлийн хуулбарлалтыг шалгах программ хангамжийг нэвтрүүлж, түр журам хэрэгжиж эхэлснээр мэдээллийн дэвшилтэт технологид тулгуурлан оюутан, судлаачдын оюуны бүтээлийг баталгаажуулах, хамгаалах, сургалтын чанарыг сайжруулах цаашлаад судалгаанд суурилсан сургалтын арга барилыг хөгжүүлэх үйл явцад томоохон түлхэц болно гэж үзэж байна.

#### 3.13.1. Бүтээлийн хуулбарлалт шалгах программ хангамжийн ашиглалт, үр дүн

Оюуны өмчийг хамгаалах, бүтээлийн хуулбарлалтыг шалгах ажлын хүрээнд 2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улиралд доктор, магистрын төгсөгчдийн 52% нь



судалгааны ажлаа хуулбарлалтын программ /Plagscan/-аар шалгасан байна. Тус программын нэгдсэн баазад ШУТИС-ийн судалгааны сангийн 5,315 магистр, 444 докторын зэрэг горилсон бүтээлийг нэмж оруулсан байна. (Хүснэгт 3.44)

ШУТИС нь бүтээлийн хуулбарлалт шалгах зааварчилгаа, гарын авлага, төрийн өмчит 6 сургуулийн багш, оюутнуудын номын сангаар үйлчлүүлэх заавар, электрон каталог болон мэдээллийн санг ашиглах зөвлөмж, мэдээллийн сангуудын мэдээллийг уншигчдад танилцуулж, тухай бүрт цахим хуудсаар мэдээлэл хүргэж ажиллав.

**Бүтээлийн хуулбарлалт шалгах программд оруулсан мэдээллийн сангийн бааз**


Хүснэгт 3.44

№	Сургууль	Текстэн	Зурган файлаас текстэд хэлбэрт хөрвүүлсэн	Нийт оруулсан
<b>Магистрын зэрэг горилсон бүтээл</b>				
1	БАС	301	132	433
2	ГУУС	614	187	801
3	ЭХС	454	72	526
4	МехТС	192	35	227
5	МХТС	208	113	321
6	ҮТС	196	448	644
7	БуХС, БАТС	1070	456	1526
8	ХШУС	184	211	395
9	ГХС	81	20	101
10	ОУДВСТ	17	44	61
11	ДаТС	101	84	185
12	ЭрТС	14	55	69
<b>Докторын зэрэг горилсон бүтээл</b>				
13	ШУТИС	281	163	444
<b>Нийт</b>		<b>3,713</b>	<b>2,020</b>	<b>5,733</b>

**Бүтээлийн хуулбарлалт шалгах программын линк илгээсэн болон хуулбарлалт шалгасан оюутны тоо**

Хүснэгт 3.45

№	Сургууль	Линк илгээсэн огноо	Линк илгээсэн оюутны нийт тоо	Материал шалгасан оюутны тоо /2022.06.16-ны байдлаар/	Гүйцэтгэл /хувиар/
<b>Магистрант</b>					
1	БАС	2022.05.06	38	16	42%
2	ГУУС	2022.05.05	68	41	60 %
3	ЭХС	2022.05.09	45	21	47 %
4	МехТС	2022.05.09	20	4	20 %
5	МХТС	2022.05.09	30	8	27 %
6	ҮТС	2022.05.05	22	6	27 %
7	БуХС	2022.05.05	4	3	75 %
8	БАТС	2022.05.05	132	95	72 %
9	ХШУС	2022.05.05	10	1	10 %
10	ГХС	2022.05.05	2	0	-
11	НБТ	2022.05.31	5	0	-
12	ДаТС	2022.05.09	37	17	46 %
<b>Докторант</b>					
13	ШУТИС		6	6	100 %
<b>Нийт</b>			<b>419</b>	<b>218</b>	<b>52 %</b>



**Зураг 3.37. Бүтээлийн хуулбарлалт шалгах программын линк илгээсэн болон хуулбарлалт шалгасан магистрантын тоо**

- “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд 34 төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр зорьсон боловч одоогоор тэдгээрээс 15 нь огт хэрэгжиж эхлээгүй байна. Иймд 2030 оны зорилтот түвшинд хүрэх асуудалд онцгой анхаарал хандуулах;
- Зарим төсөл, хөтөлбөрийн томъёолол, зорилго, зорилт, хамрах хүрээ, үр нөлөөг дахин судалж, тодорхойлох;
- Зорилтот түвшин, тэргүүлэх чиглэлүүдэд үйл ажиллагааг төвлөрүүлэх
- Байгууллагын дотоод таатай уур амьсгалыг бүрдүүлэх, багш ажилчдын дунд эерэг зөв харилцаа, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэх; (Ж.нь Work & Walk...etc)
- Захиргааны нэгж, алба болон бүрэлдэхүүн сургуулиудын ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах идэвхжүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх; (Job evaluation & Point factor ranking....etc)
- ШУТИС-ийн хөгжлийн бодлого, шийдвэр гаргалтад бүрэлдэхүүн сургуулиудын оролцоог хангах асуудалд анхаарах шаардлагатай байна.







# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

---

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



## ДӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

### 4.1. ГАДААД ТОМИЛОЛТ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

2021-2022 оны хичээлийн жилд ОХУ, БНСУ, Турк, Испани, Австри, АНУ, Швед, Казакстан зэрэг улсуудын их, дээд сургууль, судалгааны байгууллагууд дээр зохион байгуулагдсан ОУ-ын эрдэм шинжилгээний хурал, семинар, мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 29 гаруй багш, ажилтан зохион байгуулагч талын болон хамтарсан төсөл, хөтөлбөрийн зардлаар томилогдон оролцсон байна.

Мөн хамтын ажиллагааны шугамаар ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, Япон зэрэг улсуудын их, дээд сургууль болон олон улсын байгууллагуудаас онлайнаар зохион байгуулсан ОУ-ын эрдэм шинжилгээний хурал, төслийн сургалт, семинарт нийт 90 гаруй багш, ажилтан оролцлоо.

*(Энэ хичээлийн жилийн эхний хагаст хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад тухайн улсын тэтгэлэгт хөтөлбөрөөр магистр, докторын ахисан түвшиний сургалтад хамруулан сургах, олон улсын хурал, хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажилд биечлэн оролцуулахаар төлөвлөгдсөн зарим багш, ажилтны гадаад томилолт КОВИД-19-тэй холбоотой гарсан тухайн улс орны хилийн хориг, хууль журмын үйлчлэх хугацааны улмаас цуцлагдсан болно.)*

### 4.2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ

2021-2022 оны хичээлийн жилд гадаад, дотоодын болон олон улсын нийт 16 сургууль, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээг шинээр байгууллаа.

#### Шинээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан гадаадын их дээд сургууль, ОУ-ын болон дотоодын байгууллагууд

*Хүснэгт 4.1*

д/д	Сургууль, байгууллагын нэр	Улс	Гэрээний ангилал
1	КОИСА байгууллагын МХТС-д төсөл хэрэгжүүлэх гэрээ	БНСУ	гэрээ
2	Ази-Номхон далайн нийгэмлэг	БНСУ	гэрээ
3	Сивасын Жүмхүрэг их сургууль	Турк	гэрээ
4	Шинь шинь ХХК	БНХАУ	санамж бичиг
5	Хокүёо их сургууль	Япон	гэрээ
6	Дай-Ичи технологийн институт	Япон	гэрээ
7	Чосүны их сургууль	БНСУ	гэрээ
8	Уфимын нефтийн технологийн улсын их сургууль	ОХУ	гэрээ
9	Сибирийн мэдээлэл, холбооны улсын их сургууль	ОХУ	гэрээ
10	Сибирийн Хобооны их сургууль	ОХУ	гэрээ
11	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгчийн газар	ОУ-ын	санамж бичиг
12	Орхон аймаг засаг даргын тамгын газар	Монгол	санамж бичиг
13	Дорнод Их сургууль	Монгол	гэрээ
14	Ажиа гэгээний “Зөв” тэтгэлэг сан ТББ	Монгол	гэрээ



15	Жи Эс Эй Эс ХХК	Монгол	санамж бичиг
16	Трансгейт Интернэшнл ХХК	Монгол	санамж бичиг
17	Металл Боловсруулалт, Инженерчлэлийн Холбоо	Монгол	санамж бичиг
18	“Ай Си Ти групп” ХК	Монгол	санамж бичиг
19	Өмнөговь аймаг	Монгол	санамж бичиг
20	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	Монгол	санамж бичиг
21	Монгол дахь Гёте-Институт	Монгол	санамж бичиг
22	Монголын Цэс, цайр үйлдвэрлэгчдийн холбоо	Монгол	санамж бичиг
<b>Нийт 21</b> Үүнд:			Эдгээрээс:
	Монгол	12	гэрээ-11
	БНСУ	3	
	ОХУ	3	санамж бичиг-11
	БНХАУ	1	
	Япон	2	
	Турк	1	
	ОУ-ын	1	

Мөн дээр дурдсанаас гадна Монгол дахь гадаадын ОУ-ын байгууллагууд, төлөөлөгчийн газруудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал: Дээд боловсролыг хөгжүүлэх “1000 инженер” төслийн хүрээнд Японы ОУ-ын ЖАЙКА, Мэдээллийн технологийн сургалт, судалгааны ажлыг хөгжүүлэхэд БНСУ-ын ОУ-ын КОЙКА, дээд боловсролын чиглэлээр ОУ-ын ЮНЕСКО байгууллагатай хамтран ажиллаж сургалт судалгааны чиглэлээр олон төслүүдийг хэрэгжүүлж байна.

### 4.3. ГАДААДЫН МЭРГЭЖИЛТЭН, БАГШ ЗОЧИН ПРОФЕССОР

2021-2022 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургууль, сайн дурын болон олон улсын байгууллагаас нийт 8 багш, мэргэжилтэн ШУТИС-д ирж ажиллалаа.

(Энэ хичээлийн жилийн эхний хагас жилд ирэхээр төлөвлөгдсөн гадаадын зарим зочин профессор, мэргэжилтэн багш нар КОВИД-19–тэй холбоотой гарсан тухайн улс орны хилийн хориг, хууль, журмын үйлчлэх хугацааны улмаас цуцлагдсан болно.)

#### ШУТИС-д ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, багш нар


Хүснэгт 4.2

Харьяалагдах гадаадын байгууллага, төсөл	Ажиллаж буй сургууль	Тоо
БНСУ-ын WITN байгууллагын мэргэжилтэн	ҮТС	1
ХА-ны шугамаар (АНУ)	ДаТС	2
Япон хэлний гэрээт багш	ГХС	1
АНУ-ын Төрийн Департаментээс англи хэлний багш	ГХС	1
БНСУ-ын Конжүгийн их сургуультай хамтарсан “Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, мэргэжилтний ур чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн (1 зочин профессор, 3 багш)	МеТС	3
	БУХС	1
<b>Нийт</b>		<b>8</b>




#### 4.4. ОЮУТАН СОЛИЛЦОО, ГАДААДЫН ТЭТГЭЛЭГ

2021-2022 оны хичээлийн жилд ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, Казакстан, Турк зэрэг улсаас ШУТИС-д нийт 90 гадаад оюутан суралцаж байна. Үүнээс бакалаврын хөтөлбөрт 7, магистрантурын хөтөлбөрт 43, докторантурын хөтөлбөрт 41 оюутан тус тус суралцаж байна.



Зураг 4.1. Гадаад оюутны тоо улс орноор




	БАС	БУХС	БАТС	ГУУС	МехТС	МХТС	УТС	ХШУС	ЭХС	ГХИ	НБТ	ДаТС	ЭЦДС
Гадаад оюутнууд бүрэлдэхүүн сургуулиар	9	0	25	13	4	8	15	4	2	7	3	0	0

Зураг 4.2. Гадаад оюутны тоо (бүрэлдэхүүн сургууль, төв)




#### 4.5. ГАДААДЫН ТЭТГЭЛГҮҮД

Японы Санко-Сеики групп, Японы Сүмитомо корпораци, Японы Мицүбиши корпораци, Тоёота-ШУТИС сан зэрэг гадаадын байгууллага, сангийн 31 сая төгрөг, 10000 ам.долларын тэтгэлгийг ШУТИС-ийн 52 оюутанд олгоод байна.



Зураг 4.3. Тэтгэлэгт хамрагдсан оюутнууд



Зураг 4.4. Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо бүрэлдэхүүн сургуулиар

#### 4.6. ГАДААДЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Гадаадын байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны хүрээнд ШУТИС дээр дараах томоохон төслүүд хэрэгжиж байна.

Үүнд:

- ✓ Энэтхэг улсын хөрөнгө оруулалтай Мэдээлэл Холбооны технологийн сургуулийн сургалтын “Аутсорсингийн Төв” төсөл (Нийт өртөг **20 сая ам. Доллар**)



- ✓ Рио Тинто Оюу Толгой компани “Уул уурхайн геотехникийн мэргэжил олгох, олон улсын судалгааны төв байгуулах төсөл” (Нийт өртөг **2.5 сая ам. доллар**)
- ✓ “Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийг бэхжүүлэх” ахисан түвшний сургалт, судалгааны лаборатори байгуулах төсөл ( Нийт өртөг **6 сая ам. Доллар**)
- ✓ Европын Холбооны улсын ERASMUS хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байгаа RECOASIA төсөл (сургалтын тоног төхөөрөмж) (Нийт өртөг **5800 евро**)
- ✓ Инженерийн дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, боломжуудтай уялдуулан шинэчилж, цахим сургалт, виртуал шилжилт хөдөлгөөн хийх замаар орчин үеийн ОУ-ын хэмжээнд хүргэх зорилго бүхий Европ-Монголын инженерийн дээд боловсролыг шинэчлэх төсөл (Нийт өртөг **103001 евро**)
- ✓ БНСУ-ын Конжүгийн их сургуультай хамтарсан Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, мэргэжилтний ур чадавхыг бэхжүүлэх төсөл (Нийт өртөг **2.5 тэрбум вон**)



# ТАВДУГААР БҮЛЭГ

---

ОЮУТНЫ ХӨГЖИЛ,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ





## ТАВ. ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### 5.1 ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨЛӨВШИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА


ШУТИС-ийн 2021-2022 оны хичээлийн жилд үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусган зохион байгууллаа. Энэ хичээлийн жилд манай албаны хувьд бүрэлдэхүүн төрийн болон төрийн бус байгууллагууд, төрийн өмчийн их сургуулиуд, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд, оюутны холбоо, мэргэжлийн болон сайн дурын клубүүдтэй хамтран 11 төрлийн сургалт, 30 гаруй төвлөрсөн арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 13000 орчим оюутан хамруулсан бөгөөд 2680 оюутныг тэтгэлэг, кредитийн урамшуулалд, 4408 оюутныг нийтийн тээврийн хөнгөлөлтөд хамруулжээ. Мөн “Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”, “ШУТИС-ийн оюутнуудад кредит урамшуулал олгох журам”-ыг нэгтгэн өөрчлөлт оруулж ШУТИС-ийн захирлын зөвлөлөөр батлуулсан.

#### 5.1.1 Сургалт, судалгаа



Бид суралцагчдад зориулсан сургалт, судалгаа, хувь хүний хөгжлийн ажлуудыг элсэгч, суралцагч, төгсөгч гэсэн гурван хэсэгт хуваан зохион байгуулж байна.

Элсэгчдэд зориулсан “Оюутны хөгжил” хөтөлбөрийг ажлын төлөвлөгөөний дагуу хүргэсэн бол суралцагч нийт оюутнуудад клубийн системээр дамжуулан сургалт судалгааны ажлуудыг амжилттай зохион байгуулж байна. Мөн төгсөгч оюутнуудад зөөлөн ур чадвар- ажил эрхлэлтэд чиглүүлэх цуврал сургалтыг тус тус зохион байгуулан ажилласан. Эдгээр сургалт үйл ажиллагааг цахим болон танхимаар хүргэсэн нь тодорхой үр дүнд хүрч байна.


“Оюутны хөгжил” хөтөлбөрт тусгагдсан ажлын хүрээнд нэгдүгээр курсийн оюутнуудад “ШУТИС 2021-2022 элсэгчид” групп. Нэгдүгээр курсийн оюутнуудыг зөвлөн чиглүүлэх зөвлөх багш нарт чиглэсэн “2021-2022 нэгдүгээр курсийн зөвлөх багш нар” группийг тус тус нээн ажиллуулсан. Цар тахлын улмаас оюутанд хүргэх нэгдсэн сургалт мэдээллийн чанартай үйл ажиллагааг бүрэлдэхүүн сургуулиудад албан бичиг хүргүүлэн хамтран ажиллаж байгаагаас гадна ХААИС-ийн бичлэгийн студи мөн ШУТИС-ийн НБТ-д чанарын өндөр түвшинд бичүүлж, архив үсгэсэн бичлэгүүдээ оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусгасан хуваарийн дагуу дээрх 2 группээр шинэ оюутан багш нарт мэдээллийг хүргэн хамтран ажиллав. Цахим сургалт, шинэ оюутанд чиглэсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг зөвлөх багш нарт нэг удаа, БАС-ийн урилгаар тус сургуулийн зөвлөх багш нарт нэг удаа тус тус мэдээлэл хийсэн.



Зураг 5.1. “ШУТИС 2020-2021 элсэгчид” группэд хамрагдсан оюутны судалгаа



Зураг 5.2. Энэхүү группэд 1400 гаруй шинээр элсэгчдийн мэдээлэл (Элсэгчдийн 61.9% эрэгтэй, 38.1% эмэгтэйчүүд байна)



Зураг 5.3. Группийн оюутнууддаа нэгдсэн зар мэдээллийг хүргэхээс гадна сургалт семинар зохион байгуулав.

Энэ группээр дараах сургалтуудыг хүргэсэн. Үүнд:

- ✓ Танд тусалъя- Чиглүүлэгч оюутан
- ✓ “Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ оюутны нэгдсэн уулзалт” өдөрлөг
- ✓ Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли
- ✓ “Амжилттай суралцах” тухай лекц
- ✓ ШУТИС-ийн клубүүдийн танилцуулга
- ✓ “Хувь хүний ёс зүй, төлөвшил”
- ✓ “Эрүүл зөв хооллолт” цахим
- ✓ Оюутан оролцоо идэвхийг дүгнүүлэх дүгнэх хуудсаа бөглөх зөвлөмж сургалт зэрэг сургалт, семинар багтана.


Бид энэхүү Facebook group-ээр дамжуулан элсэгчдэдээ сургуулиа төгсөх хүртэл нь системтэй мэдээллийг хүргэх, сурч боловсрох, хувь хүний хөгжил-soft skills чиглэсэн сургалт семинарыг тогтмол хүргэн хамтран ажилладаг. Тус үйл ажиллагаануудыг цаг хугацаанд нь чанартай хүргэхэд клубүүдийн оролцоо их байдаг.

Бүрэлдэхүүн сургуулиуд шинэ оюутны хөгжил хөтөлбөрт тусгагдсан “Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ оюутны нэгдсэн уулзалт”-ыг сургуулиуд тус бүртээ зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнгийн тайлангаа ирүүлснийг нэгтгэн үзүүлэв (хүснэгт 5.1).

**Бүрэлдэхүүн сургуулийн талаарх мэдээлэл авсан шинэ оюутны тоо**

Хүснэгт 5.1


Д/д	Сургууль	Хамрагдсан оюутны тоо	Зөвлөх багш нарын тоо
1	БАС	178	17
3	БуХС	172	15
8	ГХС	65	14
2	ГУУС	375	15
4	МехТС	150	12
5	МХТС	701	17
6	ҮТС	299	-
7	ЭХС	15	-



Зураг 5.4. МехТС, МХТС-ийн нэгдсэн уулзалт

### Эрүүл мэнд, нөхөн үржихүйн сургалт

ШУТИС-ийн I, II курсийн оюутнуудад түүн дотор оюутны байранд эцэг эхийн хяналтаас хол бие даан амьдарч буй оюутнуудад хүргэх зорилгоор "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол" олгох сургалтыг 2 цувралаар, “Сэтгэлзүйгээ хэрхэн зөв удирдах вэ” сургалтыг тус тус зохион байгуулав. Бичлэгийг тус бүр хийж оюутны байрны группэд тавиулж нээлттэй хүргэж ажиллав.



Зураг 5.5. “Сэтгэлзүйгээ хэрхэн зөв удирдах вэ” цахим сургалт

### Манлайлал сургалт



ШУТИС-ийн оюутны холбооны тэргүүн, Оюутны зөвлөлийн дарга, клубийн ахлагч нарт чиглэсэн Удирдан манлайлах, багийн ажиллагааг удирдахад чиглэсэн сургалтыг лектор А.Энхцэцэг хичээлийн VIII байр хурлын танхимд оров. Сургалтад нийт 50 орчим удирдах оюутнууд оролцлоо.



Зураг 5.6. Удирдан манлайлах, багийн ажиллагааг удирдахад чиглэсэн сургалт

### Харилцаа ба хандлага сургалт

ШУТИС-ийн зөвлөх багш нар, сургалтын алба, номын сангийн ажилтан болон бусад үйлчилгээний ажилтанд зориулсан “Харилцаа, хандлагад тулгамдаж буй асуудал” сургалт зохион байгуулаа. Сургалт TEAMS-ээр явагдсан. Нийт 110 орчим багш, ажилтан нар хамрагдсан үр дүнтэй сургалт болсон.



### Архи тархины нууц сургалт


“Архины хэрэглээгүй залуус” аяны хүрээнд НЦГ, МУАБ –ын зөвлөлийн зөвлөх, доктор Н.Цогцсугар нартай хамтран “Оюун тархины нууц” сургалтыг зохион байгуулж, бичлэг хийж нийтийн хүртээл болгохоор бэлтгэсэн.



Зураг 5.7. “Оюун тархины нууц” сургалт

### Эрдэм шинжилгээний хуралд бэлтгэх нь сургалт

Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюутнуудыг бэлтгэл сургалтуудыг оюутны үйлчилгээний хуанлид тусгасан цаг хугацаанд ШУТИС-ийн сайт болон оюутны группүүдэд байршуулан мэдээллийг 2 удаа цуврал лекцээр хүргэсэн.



*Зураг 5.8. Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюутнуудыг бэлтгэл сургалт*

### Таны эрх таны оролцоо сургалт

ШУТИС-ийн оюутнуудыг төлөөлөн ёс зүйн “Соёмбо” клубийн судалгааны багийн 5 оюутан Нийслэлийн авилагтай тэмцэх газраас зохион байгуулсан Залуучууд авлигыг тэвчихгүй нээлттэй өдөрлөг “Таны эрх, таны оролцоо” авлигалд үгүй гэж хэлье өдөрлөг, сургалтад идэвхтэй оролцож Батламж авсан.



*Зураг 5.9. Залуучууд авлигыг тэвчихгүй нээлттэй өдөрлөг*

### Ёс зүйн сургалт /клубийн ахлагч/

ШУТИС-ийн Клубүүдийн ахлагч нарт ёс зүйн жил, ёс зүйн талаар сургалт зохион байгуулсан. ШУТИС-ийн оюутны ёс зүйн дүрмийг танилцуулах сургалтыг 2022

оны 05 сарын 12-нд хичээлийн I байр 321 тоот танхимд зохион байгуулсан. Тус сургалтад нийт 21 ахлагч нар оролцов. Сургалтаар Ёс зүйн талаарх ойлголт өгч, ШУТИС-ийн оюутны ёс зүйн дүрмийг танилцуулж, цаашид дүрмийг сайжруулах асуудлын талаар ярилцав. Мөн бүх клубийн ахлагч нарт оюутнуудад фэйсбүүк группүүдээрээ дамжуулан оюутны ёс зүйн дүрмийн танилцуулга бичлэгийг түгээн танилцуулахыг даалгав.





Зураг 5.10. Ёс зүйн сургалт

### ШУТИС-ийн төгсөх курсийн оюутнууддаа зориулсан сургалт

Төгсөгчдийг ажил эрхлэлтэд чиглүүлэх, зөөлөн ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн цуврал сургалтыг оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусгасан цаг хугацаандаа сургалтын төлөвлөгөөний дагуу БУХС-ийн менежментийн салбарын багш нарын Алтангадас клуб, MSDI proHR консалтинг компанитай хамтран зохион байгуулж байна.

2021-2022 оны намрын улирлын Төгсөгчдөд чиглэсэн “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 20-12 дугаар сарын 24 хүртэл цахим болон танхимаар хүргэлээ. Цахимаар хүргэхийн тулд “2021-2022 намар төгсөгч сургалт” групп үүсгэн ажилласан. Тус группэд нийт 610 гаруй оюутан хамтрагдсан бөгөөд тогтмол бүртгэлээ хийлгэж идэвхтэй хамрагдсан 108 оюутанд сургалтад хамрагдсан батламжийг дипломын хамт хүргүүллээ.



Зураг 5.11. ШУТИС-ийн төгсөх курсийн оюутнууддаа зориулсан сургалт

## Төгсөгчдийг ажил эрхлэлтэд чиглүүлэх сургалтын үйл явц

Төгсөгчдөд чиглэсэн “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” цуврал сургалтыг хамтран зохион байгуулсан MSDI ProHR консалтинг компанид Талархал олгов. Тус байгууллагаас 5 жил хамтран ажилласан талаар ярилцлага хийж нийтийн хүртээл болголоо.

Мөн 2021-2022 оны хаврын улирлын Төгсөгчдөд чиглэсэн “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” цуврал сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 16-наас 5 дугаар сарын 18 хүртэл үргэлжлэв. Тус сургалт 4 удаа цахим, 6 удаа танхимаар зохион байгуулагдав. Сургалт TEAMS-ээр бүрэн явагдсан сургалтыг НБТ-ийн хамт олноос бичиж, бичлэгийг группт нээлттэй тавьж оюутнууддаа хүргэсэн. Цахимаар хүргэхийн тулд “2021-2022 хавар төгсөгч сургалт” групп үүсгэн ажилласан

Сургалтын хүрээнд 2022 оны 04 сарын 27-ны өдрийн “Байгууллагатай танилцъя” сургалтыг хичээлийн VIII байрны 12 давхарт зохион байгуулж музей, Нээлттэй боловсролын төв, VIII байрны бүтэц зохион байгуулалттай төгсөх оюутнууддаа танилцууллаа. ШУТИС-ийн музейн тайлбарыг музейн зөвлөх Л.Гүрбазар хийлээ.



Зураг 5.12. “Байгууллагатай танилцъя” сургалт



Зураг 5.13. ШУТИС-ийн музейтэй танилцах



Нээлттэй боловсролын төвийн танилцуулгыг НБТ-ийн мэргэжилтэн А.Гандолгор, Хичээлийн VIII байр ямар зохион байгуулалтаар ашиглагдаж, ямар үйл ажиллагаа явагддаг талаар Технологи дамжуулах төвийн мэргэжилтэн Н.Бадрах нар хийж, “Байгууллагатай танилцъя” сургалтыг MSDI Pro-HR консалтинг компани гүйцэтгэх захирал А.Амар удирдав.



*Зураг 5.14. “Байгууллагатай танилцъя” сургалт*


Сургалтад байгууллагын зочноор ШУТИС-ийн 2018 оны төгсөгч, “Эрдэнэ силвер ресорс” ХХК-ийн төлөвлөлтийн инженер Б.Мөнх-Эрдэнэ уригдан оролцлоо.



*Зураг 5.15. “Эрдэнэ силвер ресорс” ХХК-ны төлөвлөлтийн инженер Б.Мөнх-Эрдэнэ лекц уншлаа*

### Сургалтын батламж гардуулах үйл ажиллагаа

Зочин илтгэгчээр: “The Apprentice Mongolia” шоуны ялагч, “Ард Холдинг Интернейшнл” компанийн Гүйцэтгэх захирал Ц. Бархас “Зорилгоо тавиад урагш тэмүүл” сэдвээр, Миний сүлжээ ХХК-ийн “Миний ирээдүй миний гарт хөтөлбөр”-ийн анхны төгсөгч салбарын дэд захирал Д.Номин-Эрдэнэ нар оролцож сонирхолтой мэдээлэл өгөв.



Зураг 5.16. “Зорилгоо тавиад урагш тэмүүл” сэдвээр лекц уншив.

Үйл ажиллагааны төгсгөлд ШУТИС-ийг 2021-2022 оны хичээлийн хаврын улиралд төгсөж буй оюутнуудаас “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” 10 модуль сургалтад бүрэн хамрагдан батламж авах шаардлага хангасан 84 оюутанд батламж гардуулсан.



Зураг 5.17. “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” сургалт

## 5.2 ЭРДЭМ, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ

Монгол Улсын их сургуулиудын оюутнуудын дунд зохион байгуулах “Эрдмийн XXI чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах, шилдэг бүтээл шалгаруулах 2 төрлөөр явагдлаа.

I. Шилдэг өгүүлэл шалгаруулах арга хэмжээ 2022 оны 04 дүгээр сарын 08-нд болсон.

Хурлыг нээж: ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал доктор (Ph.D), дэд профессор Д.Цолмонбаатар Эрдэм шинжилгээний нэгдсэн чуулган ШУТИС-ийн бүрэлдэхүүн 9 сургууль орон нутгийн 2 сургуулиас гадна бусад 5 их сургуулийн оюутнууд оролцож. Чуулганыг 4 салбар хуралдаанаар нийт 43 илтгэлээр 90

гаруй оюутан, багш нар хамтын судалгаа шинжилгээний ажлаа хэлэлцүүлэхээр оролцож байгаад баяр хүргээд нийт оюутан, багш, шүүгчид, зочид төлөөлөгч нартаа амжилт хүслээ. Оюутны эрдэм судлалын ажлыг дэмжихэд чиглэсэн “Эрдмийн XXI чуулган”-ийг Монгол улсын их сургуулиудын хүрээнд 21 дэх удаагаа тасралтгүй зохион байгуулж буйгаар онцлог юм.



Зураг 5.18. ШУТИС-ийн “Эрдмийн XXI чуулган”

Хурлын үйл ажиллагаанд зочин илтгэгчээр МХТС-ийн КУС-ын дэд профессор, доктор (Ph.D) Д.Золзаяа “Аж үйлдвэрийн IV хувьсгалд хиймэл оюуны нөлөө” сэдвээр судлаач оюутнуудад илтгэл тавьж, судалгааны ажил, үр дүнгээ танилцуулан илтгэл тавьсан.

**“Эрдмийн XXI чуулган” шилдэг илтгэлийг 2 үе шаттай, 4 салбар хуралдаанаар зохион байгуулав.**

- *Техник, технологийн салбар* Хичээлийн I байр “Хурлын танхим”-д
- *Байгалийн ухаан, экологийн салбар* ШУТТНомын сангийн 504 тоот танхимд
- *Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар* ШУТТНомын сангийн 405 тоот танхимд
- *Эдийн засаг, менежментийн салбар* БУХС-ийн 205 тоот танхимд (Эдийн засаг менежментийн салбар хуралдаан “Эрдмийн шувуу”) тус тус боллоо.





Зураг 5.19. “Эрдмийн XXI чуулган” шилдэг илтгэлийн уралдаанд оролцогчид

### “Эрдмийн XXI чуулган” шилдэг илтгэл шалгаруулах хурлын шагнал гардуулах ёслолын ажиллагаа

Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, комиссын дарга, доктор (Ph.D), дэд профессор Н.Ганзориг комиссын гишүүд, эрдэмтэн багш, оюутнууд оролцлоо. Оюутан багш нартаа баяр хүргэж комиссын дарга доктор (Ph.D), дэд профессор Н.Ганзориг, шүүгчдийг төлөөлж МХТС-ийн Холбооны салбарын дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор Ш.Ганболд нар үг хэллээ.



Зураг 5.20. “Эрдмийн XXI чуулган” шилдэг илтгэл шалгаруулах хурлын шагнал гардуулах ёслолын ажиллагаа

“Эрдмийн XXI чуулган” шилдэг илтгэлүүдийг комиссын салбар зөвлөлийн гишүүдийн шүүснээр дараах илтгэлүүд шагналт байрыг эзэллээ.

#### Техник, технологийн салбар хуралдааны илтгэлүүдээс

##### **ТЭРГҮҮН БАЙРАНД**

БАС-ийн БМҮТ-IV курсийн оюутан Ц.Нямбаяр, Б.Энхтүвшин, О.Мөнхбаяр, Г.Дулмаа нар “МОНГОЛ ОРНЫ ТҮҮХИЙ ЭДИЙГ АШИГЛАН ХУУРАЙ ПААЛАН БОЛОН ЭМУЛЬС ГАРГАН АВАХ ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА” сэдвээр

Удирдсан багш: Д.Сүнжидмаа /БАС-ийн БМҮТ-ийн салбарын профессор, доктор (PhD), дэд профессор/

##### **ДЭД БАЙРАНД**

МХТС Автоматжуулалтын систем IV курсийн оюутан С.Мөнхжавхлан “ХӨДӨЛГӨӨНТ РОБОТЫН ЗАМЫГ ВИРТУАЛ ТАЛБАРЫН АРГААР ЗАГВАРЧЛАХ НЬ” сэдвээр

Удирдсан багш: Ц.Хүрэлбаатар /МХТС-ийн ЭС-ын дэд профессор, Доктор (Ph.D), дэд профессор/



### **ГУТГААР БАЙРАНД**

ҮТС-ийн Хүнс үйлдвэрлэлийн технологи IV курсийн оюутан Г.Уранчимэг, О.Буянтогтох нар **“ТАЛХ БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА”** сэдвээр  
**Удирдсан багш:** Э.Энхцэцэг, Ц.Минжмаа /ҮТС-ийн ХИС-ын эрхлэгч доктор /Ph.D/, дэд.проф, ХИС-ын багш

**Байгалийн ухаан, экологийн салбар хуралдааны илтгэлүүдээс:**

### **ТЭРГҮҮН БАЙРАНД**

ХШУС-ийн ХИ-IV курсийн оюутан М.Төгөлдөр, Г.Хонгорзул, У.Имүжин нар **“ЗҮЛЭГТИЙН БАЛ ЧУЛУУНЫ БАЯЖМАЛААС ГРАФИН ОКСИД ГАРГАН АВАХ СУДАЛГАА”** сэдвээр

**Удирдсан багш:** Т.Баттөмөр (ХШУС-ийн Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш, доктор (Ph.D))

### **ДЭД БАЙРАНД**

ХШУС-ийн ХИ-IV курсийн оюутан Г.Бүрэнтогтох **“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДЛААС ҮНЭТ МЕТАЛЛ ЯЛГАХ СУДАЛГАА”** сэдвээр

**Удирдсан багш:** А.Доржготов (ХШУС-ийн Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш, доктор (Ph.D))

### **ГУТГААР БАЙРАНД**

МХТС-ийн АС- III курсийн оюутан О.Отгонбилэг, Н.Бүрэндэлгэр, Б.Биндэръяа нар **“АВТОМАТЖУУЛСАН ХҮЛЭМЖИЙН СИСТЕМИЙГ АЛСААС УДИРДАХ НЬ”** сэдвээр

**Удирдсан багш:** Ц.Сугир /МХТС-ийн ЭС-ын ахлах багш/

**Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар хуралдааны илтгэлүүдээс**

### **ТЭРГҮҮН БАЙРАНД**

МХТС-ийн Өгөгдлийн ухааны инженерчлэл-II курсийн оюутан М.Анужин, М.Билгүүн нар **“BLOCKCHAIN”-Д СУУРИЛСАН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ** сэдвээр

**Удирдсан багш:** Г.Мөнхбат/МХТС-ийн МТС-ын багш/

### **ДЭД БАЙРАНД**

ҮТС-ийн Интерьер дизайн III курсийн оюутан Б.Бурмаа, Т.Номин, О.Есүлэн, А.Арин-Үжин **“ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛД БАЙРЛАХ ХҮҮХДИЙН ГАДНА ТОГЛООМЫН ТАЛБАЙН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ”** сэдвээр

**Удирдсан багш:** Б.Энхжаргал /ҮТС-ийн ДС-ын багш/

### **ГУТГААР БАЙРАНД**

МХТС-ийн Тээврийн менежмент IV курс курсийн оюутан Т.Хүрэлбаатар, Д.Анударь, Б.Нацагдорж, Т.Ганзул нар **“ЗҮҮН ДӨРВӨН ЗАМЫН ЯВГАН ХҮНИЙ ГҮҮРЭН ГАРЦЫН СУДАЛГАА”** сэдвээр

**Удирдсан багш:** Л.Чулуунцэцэг /МеХТС-ийн ТС-ын ахлах багш/

**Эдийн засаг, менежментийн салбар хуралдааны илтгэлүүдээс**

### **ТЭРГҮҮН БАЙРАНД**

ШУТИС-ий БуХС-ын Санхүүгийн менежмент мэргэжлийн 4-р курсийн оюутан Б.Минжинсор **“Хувьцаат компаниудын санхүүгийн стратегийн сонголт”** сэдвээр

**Удирдсан багш:** Ц.Баярцог (ШУТИС-ийнм БуХС-ын Бизнесийн удирдлагын салбар, ахлах багш)

### **ДЭД БАЙРАНД**

Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэл-Аудит-4-р курсийн оюутан Э.Эрдэнэбилэг

**“Ковид -19 цар тахлын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл”** сэдвээр

**Удирдсан багш:** Ж.Гантулга (Мандах их сургуулийн Эдийн засгийн тэнхимийн багш, Магистр)

### **ГУТГААР БАЙРАНД**

ШУТИС-ийн БуХС-ийн Санхүүгийн менежмент мэргэжлийн 4-р курсийн оюутан Б.Хэрлэн “Монгол улсын хөрөнгийн зах зээлд арилжааны банкууд IPO гаргах нь” сэдвээр

**Удирдсан багш:** Ц.Баярцог (ШУТИС-ийн БуХС-ийн Бизнесийн удирдлагын салбар, Ахлах багш нар тус тус шалгарч өргөмжлөлөө гардан авлаа.



Зураг 5.21. “Эрдмийн XXI чуулган”-д шалгарсан шилдэг илтгэл

“Эрдмийн XXI чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааны шагналын сан Тэргүүн байр 800 000 төгрөг, Дэд байр 500 000 төгрөг, Гутгаар байр 300 000 төгрөгөөр тус тус шагнан урамшууллаа.

#### **ШИЛДЭГ УДИРДАГЧ БАГШААР:**

**Техник, технологийн салбараас** УТС-ийн ХҮТИС-ын дэд профессор доктор /Ph.D/, дэд.профессор Р.Мядагмаа

**Байгалийн ухаан, экологийн салбараас** ХШУС-ийн Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш, доктор (Ph.D) Т.Баттөмөр

**Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбараас** МХТС-ийн МТС-ын багш Г.Мөнхбат

**Эдийн засаг, менежментийн салбараас** ШУТИС-ийн БуХС-ын Бизнесийн удирдлагын салбар, Ахлах багш Ц.Баярцог нар шалгарлаа.



Зураг 5.22. “Эрдмийн XXI чуулган”-д шалгарсан шилдгүүд

Илтгэл хэлэлцүүлсэн оюутнуудын илтгэлийг эмхэтгэн ШУТИС-ийн ЭШ-ний бичигт хэвлэн нийтэлнэ.


“Эрдмийн XXI чуулган ” шилдэг илтгэл шалгаруулах үйл ажиллагааны талаарх мэдээллийг Like TV-ээр цацагдсан болно. Тус TV-д Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал доктор (Ph.D), профессор Д.Цолмонбаатар, Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, доктор (Ph.D), дэд профессор, комиссын дарга Н.Ганзориг нар ярилцлага өгөв.

Оюутны ЭШ-ний шилдэг өгүүллийг нэгтгэн ЭШ-ний бичигт №22(9)-297 дугаараар хэвлүүлээ.



*Зураг 5.23. “Эрдмийн XXI чуулган” шилдэг илтгэл шалгаруулах үйл ажиллагааны хаалтын ажиллагаа*

II. Шилдэг бүтээлийн уралдаан 2022 оны 04 дүгээр сарын 29-нд хичээлийн VIII байр 12 давхарт “Ирээдүйнхээ төлөө бүтээе” инновацын бүтээлийн уралдаанаар зохион байгуулагдав.




*Зураг 5.24. Ирээдүйнхээ төлөө бүтээе” инновацын бүтээлийн уралдаанд оролцогсад*



Уралдаанд ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор Д.Цолмонбаатар оролцож үг хэллээ. Тэрээр “Дэлхийн оюуны өмчийн өдөр болж байна. Бид оюутан залуучуудынхаа судалгаа шинжилгээ, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрдэм шинжилгээний чуулганыг шилдэг өгүүлэл, шилдэг бүтээл шалгаруулах уралдаанаар өргөн хүрээнд зохион байгуулж байна” гээд шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээнд нийт 40 бүтээлээр 110 гаруй оюутан 23 багш удирдан ажиллаж буй талаар мөн цаашлаад их сургуулийн зүгээс зохион бүтээгч оюутан залуусаа хэрхэн бодлогын хүрээнд дэмжин ажиллах талаар танилцууллаа. Зочин илтгэгчээр: Оюуны өмчийн газрын ахлах шинжээч, Дэлхийн оюуны өмчийн TISC (Технологи инновацыг дэмжих үндэсний сүлжээ) хөтөлбөрийн зохицуулагч Б.Одгэрэл оролцож зохион бүтээгч оюутан залууст оюуны өмчөө хамгаалах ач холбогдлын талаар танилцууллаа.



*Зураг 5.25. Оюуны өмчийн газрын ахлах шинжээч, Дэлхийн оюуны өмчийн TISC(Технологи инновацыг дэмжих үндэсний сүлжээ) хөтөлбөрийн зохицуулагч Б.Одгэрэл оюуны өмчөө хамгаалах ач холбогдлын талаар танилцууллаа.*



*Зураг 5.26. Оюутнуудын бүтээлийг шалгаруулалт*

**ШУТИС-ийн “Эрдмийн чуулган” шилдгүүд**

*Хүснэгт 5.2*

ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ					
д/д	Бүтээлийн нэр	Оюутны овог нэр	Сургууль, курс	анги,	Удирдсан багш
<b>ТЭРГҮҮН БАЙР</b>					





1.	<b>УХААЛАГ АНАЛИТИКИЙН СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ</b> <b>ВИДЕО</b>	Э.Мөнх-Оргил Б.Очирсүх Б.Баттулга Ж.Марал Д.Ууганбаяр А.Дашням М.Болортоль	МХТС Компьютерын ухаан 3, 4 курс, Програм хангамж 4-р курс, Мэдээллийн технологи 4-р курс, Хиймэл оюун оюун 1-р курс	МХТС-ийн Компьютерын ухааны салбарын багш Х.Хулан
<b>ДЭД БАЙРАНД</b>				
2.	<b>УСАНД ШУМБАГЧ СОРИЛ ШИНЖИЛГЭЭНИЙ РОБОТ</b>	М.Мөнх-Эрдэнэ, Г.Цэдэндамба	МеХТС-ийн Үйлдвэрлэлийн автоматжуулалт IV курс	МехТС-ийн ахлах багш, доктор (PhD) Ц.Баярсайхан, дэд профессор, доктор (PhD), дэд профессор Э.Наранбаатар
<b>ГУТГААР БАЙРАНД</b>				
3.	<b>ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ГЭРЛЭН ДОХИОГ СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮРЭЭР ХАНГАЖ, УДИРДАХ БОЛОМЖ</b>	М.Төгөлдөр, Б.Бат-Эрдэнэ, Т.Билгүүн	ДаТС-ЦСА-IV	ДаТС-ийн ЭХМТС-ын Багш Б.Лхагва
<b>ДИЗАЙН, ХҮМҮҮНЛЭГ, БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАРТ ТЭРГҮҮН БАЙР</b>				
1.	<b>ХАЯГДАЛ ЦААСААР ТҮЛШ ҮЙЛДВЭРЛЭХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА</b>	Т.Даваадорж, Б.Гантулга	ДаТС-ДЦС-III	ДаТС-ийн ЭХМТС-ын Багш нар Л.Оюунчимэг, Н.Мөнхзул
<b>ДЭД БАЙРАНД</b>				
2.	<b>“МОНГОЛЫН УЛААН НОМОНД ОРСОН АМЬТАД”-МЕДАЛЬОН</b>	С.Оюунбилэг	ҮТС, Интерьер дизайны II курс	ҮТС-ийн ДС-ын багш, Э.Эрдэнэбат
<b>ГУТГААР БАЙРАНД</b>				
3.	<b>“ШУТИС-ИЙН ХУВЦАСНЫ БРЭНД”</b>	“Inspiration” хувцас загварын клуб	ҮТС, Хувцас дизайны оюутнууд	ҮТС-ийн ДС-ын ахлах багш, П.Болормаа ДС-ын багш, Б.Гэрэлмаа, ХСТ-ийн ЭША Т.Баярмаа





*Зураг 5.27. Оюутнуудын шилдэг бүтээлийн шагнал гардуулах ёслол*

**ШИЛДЭГ УДИРДАГЧ БАГШААР:**

**Техник технологийн салбараас:** БАС-ийн Барилгын инженерийн салбарын профессор доктор (PhD), дэд профессор Д.Сүнжидмаа  
**Дизайн, Хүмүүнлэг, Байгалийн ухааны салбараас:** ҮТС-ийн ДС-ын багш, Э.Эрдэнэбат нар шалгарч Батламж, мөнгөн шагналаар шагнууллаа.



*Зураг 5.28. Шагнал гардуулах ёслолын ажиллагаанд*

Төрийн өмчийн 6 их сургуулийн инновацын бүтээлийн уралдаанд дараах 5 бүтээлийг оролцуулахаар ажлын хэсэг шалгаруулалтыг хийж инновацын 7 хоногт оролцлоо.

**Төрийн өмчийн 6 их сургуулийн инновацын бүтээлийн уралдаанд шалгарсан бүтээлүүд**

*Хүснэгт 5.3*

№	Бүтээлийн нэр	Зохион бүтээгч оюутны нэр	Сургууль
1	Усанд шумбагч сорил шинжилгээний робот	М.Мөнх-Эрдэнэ, Г.Цэдэндамба	Механик инженерийн сургууль
2	Дотор мах, дайвар түүхий эдийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт технологи	С.Мөнх-Очир Г.Ням-Очир О.Хаш-Эрдэнэ А.Билгүүн Ц.Жаргалдалай Э.Анударь Э.Энхсүвд Ө.Энхжин	Үйлдвэрлэлийн технологийн сургууль
3	Ухаалаг видео аналитикийн системийн хөгжүүлэлт	Э.Мөнх-Оргил Б.Очирсүх Б.Баттулга Ж.Марал Д.Ууганбаяр А.Дашням М.Болортоль	Мэдээлэл, холбооны технологийн сургууль
4	Хиймэл оюун ухааныг ашиглан нийтийн тээврийн сүлжээнд зорчилтын маршрутыг төлөвлөх нь	Д.Ууганболд О.Түвшинбаяр	
5	Бэлэгтэй хогны сав	О.Отгонбилэг	



### 5.3 ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ

Төр болон нийгмийн үйлчилгээнд оюутныг хамруулсан байдал Сан, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан байдал

Хүснэгт 5.4

№	Тэтгэлгийн нэр	Тэтгэлэг авсан оюутны тоо	Нийт тэтгэлгийн хэмжээ /төгрөг/
1	Ректорын нэрэмжит тэтгэлэг	47	62,328,000
2	Голомт банкны тэтгэлэг	9	9,000,000
3	Хаан банкны нэрэмжит тэтгэлэг	10	10,000,000
4	Оюутолгой ХХК-ийн тэтгэлэг	12	139,584,000
5	Эрдэнэс таван толгой ХХК-ийн тэтгэлэг	18	18,000,000
6	Кредитийн урамшуулал	2584	432,435,000
	<b>Нийт</b>	<b>2680</b>	<b>671,347,000</b>

#### 5.3.1. Ректорын нэрэмжит тэтгэлэг “Шилдэг элсэгч” оюутан

“Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ын дагуу оюутны амжилт, амьдралын боломж бололцоо буюу санхүүгийн дэмжлэг зайлшгүй авах шаардлагатай 2021-2022 оны хичээлийн жилд шинээр элсэгч 11 оюутанд 30 кредитийн хөнгөлөлт буюу 29 сая 964 мянган төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгов.

“ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-т хамрагдсан “Шилдэг элсэгч” оюутны нэрс:

Хүснэгт 5.5

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Кредит
1	Барилга, Архитектурын сургууль	Барилгын Менежмент	Ёндонцогзол	Цэнд-Аюуш	30кр
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Нийгмийн Ажил	Батдорж	Санжаасүрэн	30кр
3	Геологи, уул уурхайн сургууль	Уул Уурхайн Цахилгаан Тоног Төхөөрөмжийн Ашиглалт	Ганзүрх	Тэнгис	30кр
4	Дарханы технологийн сургууль	Программ Хангамж	Жамсранжав	Баясгалан	30кр
5	Механик, тээврийн сургууль	Хөнгөн Үйлдвэрийн Автоматжуулалт	Хуан	Адил	30кр
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Мэдээллийн Технологи	Дэлгэрсайхан	Мөнх-Оргил	30кр
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Программ Хангамж	Гансүх	Ган-Эрдэнэ	30кр
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хоол Зүй, Тэжээхүй Ухаан	Мягмаржав	Номундарь	30кр
9	Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль	Наношинжлэх Ухаан, Инженерчлэл	Баянмөнх	Отгонмөнх	30кр
10	Эрчим хүчний сургууль	Цахилгаан Системийн Автомажуулалт	Ганбаяр	Ханхүү	30кр
11	Гадаад хэлний сургууль	Техник, Технологийн Орчуулга /Хятад Хэл/	Ганзориг	Лхагвамаа	30кр



### 5.3.2. Ректорын нэрэмжит тэтгэлэг “Шилдэг суралцагч” оюутан

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хамгийн нэр хүндтэй тэтгэлэг болох “Ректорын нэрэмжит тэтгэлэг” гардуулах ёслолын ажиллагаа 2022 оны 05-р сарын 19-ний өдөр боллоо.

Тэтгэлэг гардуулах ёслолын ажиллагаанд ШУТИС-ийн захирал доктор, профессор Т. Намнан оролцож 2021-2022 оны хичээлийн жилийн шилдэг суралцагч оюутнуудад хандан үг хэлж “Ректорын нэрэмжит тэтгэлэг”-ийг гардууллаа. Сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спорт, олон нийтийн идэвх оролцоо, мэргэжлийн ур чадвараараа сургуулийнхаа оюутнуудыг манлайлсан шилдэг 11 оюутан тус бүрд 30 кредитийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлж дурсгалын зүйлээр шагнав.



Зураг 5.29. Шилдэг суралцагч оюутнууд

### “ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-г хамрагдсан “Шилдэг суралцагч” оюутнууд

Хүснэгт 5.6

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр
1	Барилга, Архитектурын сургууль	Хүрээлэн Буй Орчны Инженер	Ширэнэн	Урангоо
2	Барилга, Архитектурын сургууль	Иргэний Ба Үйлдвэрийн Барилга	Батжаргал	Бат-Ирээдүй
3	Барилга, Архитектурын сургууль	Архитектур	Өлзийбаяр	Дагийсүрэн
4	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Олон Улсын Бизнесийн Менежмент	Баярхүү	Билгүүн
5	Гадаад хэлний сургууль	Техник, Технологийн Орчуулга /Хятад Хэл/	Өлзийбат	Бадамцэцэг
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Системийн Аюулгүй Байдал	Баттулга	Оюунтөгс
7	Мэдээлэл, холбооны	Мэдээллийн Системийн	Мөнхбат	Жүгдэрнамжил



	технологийн сургууль	Аюулгүй Байдал		
8	Механик, тээврийн сургууль	Механик Инженер	Ганбаатар	Гүнбилэг
9	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Интерьер Дизайн	Батсайхан	Хулангоо
10	Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль	Химийн Инженерчлэл	Гаваасүрэн	Бүрэнтогтох
11	Бизнесийн ахисан түвшний сургууль	Олон Улсын Бизнесийн Менежмент	Цэрэндорж	Мөнхцэцэг

### 5.3.3. Нийтийн тээврээр зорчих хөнгөлөлтөд хамруулсан байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/740 дүгээр захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 6/21 тогтоолоор батлагдсан “Цахим карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан “Их, дээд сургуулийн оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, сунгах ажлыг зохион байгуулах удирдамж”-ын дагуу 2021-2022 оны намрын улиралд 4148 оюутан автобусны хөнгөлөлттэй картаар зорчиж байна.

#### 2021-2022 оны хичээлийн жилд нийтийн тээврийн хөнгөлөлтийн карт захиалсан оюутны тоо

Хүснэгт 5.7

№	Сургууль	Шинээр карт захиалсан оюутны тоо	Карт сунгуулсан оюутны тоо	Нийт
1	БАС	319	527	846
2	БуХС	191	227	418
3	ГУУС	242	319	561
4	МехТС	154	193	347
5	МХТС	446	441	887
6	ҮТС	255	135	390
7	ХШУС	63	69	132
8	ЭХС	303	412	715
9	ГХС	42	52	94
10	ШУТИС-Коосен	11	7	18
	<b>ДҮН</b>	<b>2026</b>	<b>2382</b>	<b>4408</b>

### 5.3.4. Төгсөгч оюутан анкет

Хичээлийн жилийн намар, хаврын улиралд төгсөгч оюутан “Төгсөгч оюутан анкет”-ийг бөглөдөг. Ингэснээр ажил олгогч, боловсон хүчнээ хайж байгаа байгууллагуудтай холбож өгөх, төгсөгч оюутнуудыг мэргэжлийн дагуу ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулж байна.

#### 2021-2022 оны хичээлийн жилд Төгсөгч оюутны анкет бөглөсөн оюутны тоо

Хүснэгт 5.8

№	Сургууль	2022 оны 01 сар	2022 оны 06 сар	Нийт
1	БАС	96	87	183
2	БаТС	8	4	12
3	БуХС	68	59	127
4	ГУУС	44	60	104
5	МехТС	39	115	154



6	МХТС	53	65	118
7	ҮТС	70	220	290
8	ХШУС	11	63	74
9	ЭХС	87	152	239
10	ГХС	27	22	49
11	ДаТС	35	81	116
	<b>ДҮН</b>	<b>538</b>	<b>928</b>	<b>1466</b>

## 5.4 НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

### 5.4.1. 2021-2022 оны намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын бакалаврын 87, магистрын 49 дахь удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагаа 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр цахимаар зохион байгуулагдлаа. Энэ удаагийн төгсөлтөөр докторын зэргийн дипломтой 6, магистрын зэргийн дипломтой 330, бакалаврын зэргийн дипломтой 800 төгсөгч төгссөнөөс онцлох дипломтой 41, мэргэжлийн дипломтой 27 төгсөгч байна. Түүнчлэн гадаадын их, дээд сургуультай хамтарсан бакалаврын хөтөлбөрөөр 29 төгсөгч төгсөн гарлаа. Үүнд: Эрчим хүчний сургуулийн БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай хамтарсан “ДУЛААНЫ ИНЖЕНЕР 2+2” хөтөлбөрөөр 7 төгсөгч, Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн БНСУ-тай хамтарсан “СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ 2+2” хөтөлбөрөөр 1 төгсөгч, БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний сургуультай хамтарсан “СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ 2+2” хөтөлбөрөөр 8 төгсөгч, БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний сургуультай хамтарсан “ЦАХИЛГААН ХАНГАМЖ 2+2” хөтөлбөрөөр 11 төгсөгч, Механик тээврийн сургууль, Япон улсын Нийгата ШУТИС-тай хамтарсан “МЕХАНИК ИНЖЕНЕР” 2+2 хөтөлбөрөөр 2 төгсөгч тус тус төгссөн байна. Мөн суралцах хугацаандаа сурлага, эрдэм шинжилгээ, нийгэм олон нийт, спорт, урлагаар бусдыгаа манлайлсан бакалаврын “Шилдэг төгсөгч” шагналаар 11 оюутан, магистрын “Шилдэг судлаач” 1, бакалаврын “Тэргүүний төгсөгч” 2 оюутныг тус тус шагнаж урамшуулав.



Зураг 5.30. 2021-2022 оны намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа



**Бакалаврын “Шилдэг төгсөгч” намрын улирлын оюутны нэрс**

*Хүснэгт 5.9*

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч	Кредит
1	Барилга, Архитектурын сургууль	АРХИТЕКТУР	ДҮГЭРСҮРЭН	ГЭРЭЛМАА	3.62	160
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	НИЙГМИЙН АЖИЛ	ХАРЦАГА	МӨНХЖИН	3.64	122
3	Геологи, уул уурхайн сургууль	УУЛ УУРХАЙН МЕНЕЖМЕНТ	АМГ АЛАНБААТАР	ОЮУ-ЭРДЭНЭ	3.83	125
4	Дарханы технологийн сургууль	ИРГЭНИЙ БА ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА	БААТАР	ШИНЭБАЯР	3.86	130
5	Механик, тээврийн сургууль	АВТОМАШИНЫ АШИГЛАЛТ, АВТО АЖ АХУЙ	ЭНХТҮВШИН	ЗАГАРЗҮСЭМ	3.65	130
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	АВТОМАТЖУУЛАЛТЫН СИСТЕМ	БАТТОГТОХ	ХАС-ОЧИР	3.53	125
7	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДИЗАЙН	ОТГОНТӨГС	УЯНГА	3.19	128
8	Эрчим хүчний сургууль	ЦАХИЛГААН ХАНГАМЖ	БАТХУЯГ	САНДУЙ	3.86	135
9	Гадаад хэлний сургууль	ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ОРЧУУЛГА /ЯПОН ХЭЛ/	МӨНХТУЛГА	НОМИНГЭРЭЛ	3.78	128
10	“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	ЦАХИЛГААН СИСТЕМИЙН АВТОМАЖУУЛАЛТ	БАТБОЛД	НАРАНГАРАВ	3.7	130
11	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ХИМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ	БАЯРСАЙХАН	ДАЛАЙНОМУН	3.38	119

**Магистрын “Шилдэг судлаач” оюутны нэр**

*Хүснэгт 5.10*

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч	Кредит
1	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	НҮҮРСНИЙ БОЛОВСРУУЛАЛТЫН ХИМИЙН ТЕХНОЛОГИ	ДАШНАМЖИЛ	УЯНГА	3.92	34

**5.4.2. ШУТИС-ийн урлагийн клубүүдийн “Оюутны хавар” тайлан тоглолт**

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн урлагийн клубүүдийн “Оюутны хавар” тайлан тоглолтыг 2022 оны 5-р сарын 11-нд амжилттай зохион байгуулав. Тоглолтод дуулаачийн клуб, хөглөгчийн клуб, цэнгээнт бүжгийн клуб “Хос-Уянга” хамтлаг, Чөлөөт бүжгийн клуб, Морин хуур, MUST Comedy клубийн авьяаслаг оюутан залуус оролцсон юм. Энэхүү тоглолт нь жил бүр уламжлал болон зохион

байгуулагдах бөгөөд цаашид байнгын үйл ажиллагаатай ШУТИС-ийн дэргэдэх чуулгыг байгуулах зорилготой юм. Энэ удаагийн Оюутны хавар тайлан тоглолт эх орны сэдэвтэй уран бүтээлүүд эгшиглэсэн онцлогтой болов.



*Зураг 5.31. ШУТИС-ийн урлагийн клубүүдийн “Оюутны хавар” тайлан тоглолт*

### 5.4.3. “MUST OPEN MIC”

ШУТИС-ийн оюутны соёл, үйлчилгээний албаны дэргэдэх дуулаачийн клубээс зохион байгуулсан “MUST Open Mic” болж өндөрлөлөө. Энэхүү арга хэмжээ нь оюутнуудын авьяасыг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой бөгөөд урлагийн авьяастай хэн бүхний өмнө нээлттэй. Урлагийн аль ч төрлөөр оролцох боломжтой юм. Энэ удаагийн “MUST Open Mic” ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн 27 оюутан өөрийн авьяас, чадвараа бусдад таниулан дууны төрлөөр оролцсон юм. Чөлөөт бүжгийн клуб, MUST Comedy club-үүд мэндчилгээ дэвшүүлэн оролцон нэг, өдрийг хамтдаа урлагийн ертөнцөд өнгөрөөлөө. Энэхүү арга хэмжээ нь цаашид уламжлал болон зохион байгуулагдана.





Зураг 5.32. “MUST OPEN MIC” уралдаан

#### 5.4.4. Хотын соёл аян

Нэгдүгээр курсийн оюутнууддаа оюутан болсон эхний цаг мөчид нийслэлийн соёлтой иргэн болох, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулдаг үйл ажиллагааг жигд хүргэдэг нэг чухал ажлыг бид БуХС-ийн ХүУС-ын Монголын түүхийн багш нарын лекцийн хичээлээр дамжуулан ЦЕГ-ын УСХ-тэй хамтран нийт 15 багшийн лекцээр 1253 шинэ оюутанд хүргэсэн.



Зураг 5.33. ШУТИС-ийн шинэ элсэгчдэд зориулж “Хотын соёл” арга хэмжээ зохион байгуулав




Зураг 5.34. "Соёмбо" клубийн үйл ажиллагаа


Тус аяны хүрээнд ёс зүйн "Соёмбо" клуб идэвхтэй сайн ажиллаж сургуулийн хөл хөдөлгөөн ихтэй газруудад завсарлагааны үеэр шат болон хаалганы үүдээр зогсон хэв журмыг сахиулж баруун гарын дүрэм мөрдүүлэн хэвшил болгох талд анхааруулан ажилласан бөгөөд дийлэнх оюутнууд нааштай хүлээн авч алдаагаа засаж байсан.

2021 оны 10 сарын 11-ээс 2021 оны 10 сарын 13-ны хооронд оюутнуудын зөрчил 10-15% тай байсан бөгөөд 2021 оны 10 сарын 16 гэхэд 5% болтлоо буурч үр дүн үзүүлсэн байна. Соёмбо клубийн оюутнуудын тавьсан шаардлагыг багш, оюутнууд зөргөөр хүлээн авч, зөрчил дутагдлаа тухайн үедээ шууд засаж залруулж үр дүнтэй үйл ажиллагаа болсон.

2022 оныг БШУЯ-наас “Ёс зүйн” жил болгосонтой холбогдуулан ШУТИС-ийн ёс зүйн Соёмбо клубийн оюутнуудтай хамтран “Хотын соёл” аяны арга хэмжээг нэг сарын хугацаанд 4 шатлалт үйл ажиллагаагаар хэрэгжүүлэн туршсан. Үүнд 1. Баруун гарын дүрэм хэрэгжүүлэх 7 хоног. 2. Ёс зүйт зөв харилцааг төлөвшүүлэх 7 хоног. 3. Уламжлалт ёсоо дээдлэх 7 хоног. Танин мэдэхүй, орчны соёлыг төлөвшүүлэх 7 хоног. Энэ хугацаанд тандалтын судалгаа хийж ажилласан. Энэ хугацаанд Монголын түүхийн хичээл сонгон судалж буй оюутнуудад “Хотын соёл, стандарт” сургалтыг хичээлийн багш нар оюутнуудад явуулсан. “Хотын соёл, стандарт” сургалтыг хичээлийн хүрээнд тандалтын судалгааг явуулсан үр дүнг зураг 5.34-т үзүүлэв.



### Зөрчил гаргасан оюутан



- Зөрчилгүй
- Зөрчилтэй

#### Зураг 5.35. Тандалтын судалгааны үр дүн (хичээлийн 2-р байрны хувьд)

Оюутан оюутандаа шаардлага тавьж ажилласны үр дүнд зөрчил дутагдал гаргах оюутны тоо цөөрч, үр дүн гарч байна.

#### 5.4.5. Англи хэлний олимпиад

Англи хэлний олимпиадыг оюутны үйлчилгээний хуанлид тусгасан хуваарийн дагуу ГХС-ийн АХТ-тэй хамтран зохион байгуулсан. Тус олимпиадыг зохион байгуулахад шаардагдах зардлыг оюутны үйлчилгээний 2022 оны төсөвт суулгасан. Ингэснээр багш нарын ажлын ачааллыг хөнгөлж багш зөвхөн оюутнаа дэмжин, чиглүүлэн олимпиадад бэлтгэх боломжоор хангах нэг том дэмжлэг болно. Тус олимпиадад “Speaking” клуб хамтран ажиллаж байна. 2021-2022 оны хичээлийн жилийн Англи хэлний олимпиадад бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа 2560 оюутан оролцож, англи хэлний мэдлэг ур чадвараа хөгжүүлэв. Олимпиад нь оюутнуудын англи хэлний мэдлэгийг сайжруулж, сурах сонирхлыг өрнүүлэх, англиар ярих, илтгэх чадварыг хөгжүүлэх, багаар ажиллах дадал эзэмшүүлэх, оюутанд үзэл бодлоо бүтээлчээр, чөлөөтэй илэрхийлэх чадварыг хөгжүүлэх чухал ач холбогдолтой ажил боллоо.



Зураг 5.36. Англи хэлний олимпиад

#### 5.4.6. Монгол хэл бичгийн олимпиад

ГХС-ийн Ази судлалын тэнхимийн багш нартай ШУТИС-ийн оюутнуудын дунд Монгол бичгийн олимпиадыг 2 шаттай зохион байгууллаа. Тус олимпиадад I шатанд нийт 256 оюутан II шатанд 100 оюутан шалгаруулснаас дараах оюутнууд тэргүүн байруудыг эзэлж өргөмжлөл, кредитийн урамшууллаар урамшууллаа.

#### Монгол бичгийн олимпиадын шилдгүүд

Хүснэгт 5.11

№	Овог нэр	Сургууль	Анги курс	Оюутны код	Олимпиадын нэр	Гаргасан амжилт
1.	М.Жүгдэрнамжил	МХТС	2	B200970011	Монгол бичгийн олимпиад	Тэргүүн байр
2.	О. Мягмардулам	БУХС	1	B210580138	Монгол бичгийн олимпиад	Дэд байр
3.	Д.Мишээл	БАС	2	B201320144	Монгол бичгийн олимпиад	Гутгаар байр
4.	Д.Шинэ - Эрдэнэ	БАС	1	B211350124	Монгол бичгийн олимпиад	Гутгаар байр

Олимпиадад оролцсон нийт оюутнуудын бүтээлээр үзэсгэлэн гаргаж нийтийн хүртээл болгосон. Олимпиад санаачлан зохион байгуулсан болон идэвхтэй сайн ажилласан багш нартаа батламж гардуулсан.



Зураг 5.37. Монгол бичгийн олимпиадын

#### 5.4.7. Чөлөөт уншлага төсөл

2021-2022 оны хичээлийн хэлний мэдлэгээ дээшлүүлэх хүсэлтэй оюутнуудыг дэмжих зорилгоор бүрэлдэхүүн сургууль тус бүрээс 8 оюутныг сонгон авч нийт ШУТИС-ийн 72 оюутны дунд “ЧӨЛӨӨТ УНШЛАГА” төслийг амжилттай хэрэгжүүлсэн. ШУТИС-ийн оюутнуудын англи хэл сурах сонирхлыг дэмжих, өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх, унших, илтгэх чадварыг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Extensive Reading” төслийг ГХС-ийн Англи хэлний тэнхимийн багш нартай хамтран хэрэгжүүлэв.



Зураг 5.38. “ЧӨЛӨӨТ УНШЛАГА” төслийн хүрээнд явагдсан сургалт.

Уг хөтөлбөрт ШУТИС-ийн салбар сургуулийн 18 багш, ажилтан 2022 оны 4 сарын 5-наас эхлэн хамрагдаж, уншсан сэдвийн хүрээнд мэтгэлдэх, хэлэлцүүлэг өрнүүлэх, өөрийн сэтгэгдлийг бичих зэрэг даалгавар гүйцэтгэж англи хэлний мэдлэг, ур чадвараа хөгжүүлж байна. “Extensive Reading” хөтөлбөрийг англи хэлний тэнхимийн ахлах багш А.Болормаа (Ph.D) удирдаж, АНУ-ын мэргэжилтэн багш Скотт Пүгит, багш Э.Саруул, Л.Долгорсүрэн нар хамтран ажилласан. Тус төслийн үр дүнд ШУТИС-ийн

оюутнуудад чиглэсэн англи хэлний “Чөлөөт уншлага” клубийг А.Болормаа багшийн удирдлага дор байгуулж байгаагаараа онцлог боллоо.

#### 5.4.8. ШУТИС-ийн урлагийн XIX наадам

Сүүлийн хоёр жил цар тахлаас болж хойшлогоод байсан ШУТИС-ийн оюутан залуучуудын хүсэн хүлээдэг ШУТИС-ийн “Оюутны урлагийн XIX их наадам нь амжилттай зохион байгуулагдлаа. Урлагийн их наадам нь хоёр үе шаттайгаар зохион байгуулагдсан бөгөөд I шат 2022 оны 4 сарын-23,24-нд, II шат буюу Гала тоглолт 5 сарын 1-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. Тус наадмаар оюутнуудын авьяасыг нээн илрүүлж урлагийн гоо зүйн мэдрэмж, ёс суртахууны хүмүүжлийг урлагаар дамжуулан олгосон. Шинжлэх ухаан, технологийн сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын түвшний I-V курсийн оюутнууд оролцож тус тус шилдгүүдээ тодруулсан.



Зураг 5.39. ШУТИС-ийн урлагийн XIX наадамд нийлбэр дүнгээр тэргүүн байр эзэлсэн Бизнес удирдлага, Хүмүүнлэгийн сургууль

### 5.5 ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН САНАМЖ БИЧИГТ ТУСГАГДСАН “ОРЛОГОТОЙ ОЮУТАН” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

#### 5.5.1. “Орлоготой оюутан” хөтөлбөрийн судалгаа

Орлоготой оюутан хөтөлбөр, төрийн өмчийн 6 их дээд сургуулийн хамтран ажиллах санамж бичигт тусгагдсан /хэрэгжүүлэх/ ажлын хүрээнд оюутны цагийн болон байнгын хөдөлмөр эрхлэлтийн талаар асуумжийг сургууль тус бүрийн оюутан, эцэг эхээс авав. Сургуулиудын судалгаанд хамрагдсан тоон мэдээллийг дор хүснэгт 5.12-т үзүүлэв.

**“Орлоготой оюутан” хөтөлбөрийн судалгаа***Хүснэгт 5.12*

№	Сургуулийн нэрс	Судалгаанд хамрагдсан тоо
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	284
2	Монгол улсын их сургууль	180
3	Монгол улсын боловсролын их сургууль	231
4	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	253
5	Хөдөө аж, ахуйн их сургууль	148
6	Соёл, урлагийн их сургууль	214
	<b>Нийт</b>	<b>1310</b>

**Судалгааны дүгнэлтээс дурдвал :**

**МУБИС :** Оюутнуудын цагийн болон байнгын ажил эрхлэх байдлын талаар эцэг эх, оюутныг оролцуулсан асуумж бүхий судалгаа байсан бөгөөд дийлэнх эцэг эхчүүд хүүхдээ сурахын хажуугаар орлого олж, хөдөлмөр эрхлэх байдлыг нь дэмжиж эерэг байдлаар хандаж байгаа нь судалгааны үр дүнгээр илэрхий байна.

Мөн аж ахуйн нэгжүүд ажлын байрны нөхцөл байдалд анхаарах, оюутнуудын хичээллэж буй цагт тохируулан уян хатан хандаж ажиллуулах, их дээд сургуулиудад ажлын байрны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах, сургуулийн оюутан хариуцсан албатай хамтарч уялдаа холбоотой ажиллах, оюутнуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион явуулах зэрэгт анхаарах нь чухал.

**ХААИС:** Цагийн болон байнгын хөдөлмөр эрхлэлтийн талаар асуумжид Хөдөө аж ахуйн их сургуулиас 148 оюутан оролцсон бөгөөд 37.8% цагийн ажил хийдэг, 62.2%, Суралцахын хажуугаар хөдөлмөр эрхэлдэг 52.7%, үгүй 45.3%, Үүнээс цагийн ажил хийдэг 68.2%, улирлын ажил 15.5%, байнгын ажлыг 9.5%, гэрээт ажил 6.8% хийдэг гэсэн дүн гарсан байна. Цаашид оюутнууд орлоготой байхын тулд цагийн ажил хийх хүсэл сонирхолтой байна.

**5.5.2. “Би Орлоготой Оюутан” видео контентын уралдаан**

“Би орлоготой оюутан” контентын зорилго нь оюутнуудад цагийн ажил эрхлэх боломж, нөхцөлийг сурталчлан, хичээлийн бус цагаар сургуулиас тогтоосон цагийн хязгаар дотор “цагийн хөдөлмөр” болон түр хугацааны гэрээт ажил хийх, судалгаа, инновацын ажилд оролцох, бие даан бүтээл туурвих, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх замаар орлого олох, хөдөлмөрийн харилцаанд суралцах сонирхол бүхий хууль тогтоомжид заасан шаардлагыг ханган ажиллахыг уриалга болгон зохион байгуулав.

Тэргүүн байр – Анагаахын шинжлэх, ухааны үндэсний их сургууль

Дэд байр – Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Гутгаар байр – Монгол улсын их сургууль



**Зураг 5.40. “Би Орлоготой Оюутан” видео контентын уралдаан” шагналт байрын оюутнууд**

Төрийн өмчийн 6 их сургуулийн хамтарсан ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Орлоготой оюутан хөтөлбөр”-ийн хүрээнд оюутнуудад цагийн болон байнгын ажил эрхлэх боломж, нөхцөлийг танилцуулав. Энэхүү өдөрлөгөөр хичээлийн бус цагаар сургуулиас тогтоосон цагийн хязгаар дотор “цагийн хөдөлмөр” болон түр хугацааны гэрээт ажил хийх, судалгаа, инновацын ажилд оролцох, бие даан бүтээл туурвих, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх замаар орлого олох, хөдөлмөрийн харилцаанд суралцах сонирхол бүхий хууль тогтоомжид заасан шаардлагыг ханган ажиллахыг сурталчлан ажлын байранд зуучлав. Мөн уг өдөрлөгт төрийн өмчийн 6 их сургуулийн оюутны албаны төлөөллүүд өөрсдийн сургууль дээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг арга туршлагаасаа хуваалцлав.






Зураг 5.41. “Орлоготой оюутан хөтөлбөр”-ийн нээлтийн үйл ажиллагаа

### 5.5.2. "Хотын соёл" аяны төрийн өмчийн 6 сургуульд хэрэгжүүлнэ

ШУТИС-д 7 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж буй "Хотын соёл" аяны арга хэмжээг НЗДТГ-аас ШУТИС-ийн туршлагаар 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн Төрийн өмчийн их сургуулийн шинэ оюутнуудад хүргэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу "Хотын соёл, стандарт" лекцийг ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор Д.Цогзолмаа уншиж бичлэг хийв. Тус бичлэг болон холбогдох контентыг Улсын их сургуулиудын шинэ оюутнуудад судлуулах ажлыг НЗДТГ-ын ХСОАБХЗГ-аас зохион байгуулсан.



Зураг 5.42. буй "Хотын соёл" аяны арга хэмжээ

Төрийн их сургуулиудад Хотын соёл, стандарт сургалтын бичлэг (НЗДТГ-ын ХСОАБХЗГ-ын дарга Н.Ариунтуяа, ШУТИС-ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор Д.Цогзолмаа ЦЕГ-ийн УСХ-ны ахлах мэргэжилтэн, доктор Б.Алтанзул,)

### 5.5.3. Оюутны үнэт зүйлийн судалгаа

Төрийн өмчийн 6 их сургуулийн хамтын ажиллагааны оюутны хөгжлийн асуудал хэлэлцэх ажлын хэсэгт ажиллаж 2022 онд хамтын ажиллагааны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гаргасан. Энэ ажлын хүрээнд хийгдэх эхний ажил Оюутны үнэт зүйлийн судалгаанд 1-5 курсийн нийт 1100 гаруй оюутны судалгааг авч хамруулсан.

### 5.5.4. 2021-2022 оны хичээлийн жилийн Хаврын улирлын “Ажлын байрны үзэсгэлэн яармаг” өдөрлөг

“Ажлын байрны үзэсгэлэн яармаг-2022” үйл ажиллагаа 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 11:00-16:00 цагийн хооронд ШУТИС-ийн хичээлийн I байр 3 давхар “Хурлын танхим”-д зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай топ 35 байгууллага оролцон оюутнуудыг анкет бөглүүлэх, шууд ярилцлага хийн ажлын байраар хангах зэрэг ажлууд хийгдэв.

Мөн зочин илтгэгчээр “The Apprentice Mongolia” шоуны ялагч, “Ард Холдинг Интернейшнл” компанийн Гүйцэтгэх захирал Ц. Бархас “Зорилгоо тавиад урагш тэмүүл” сэдвээр, Миний сүлжээ ХХК-ийн “Миний ирээдүй миний гарт хөтөлбөр”-ийн анхны төгсөгч салбарын дэд захирал Д.Номин-Эрдэнэ нар оролцож сонирхолтой мэдээлэл өгсөн.




Зураг 5.43. “Ажлын байрны үзэсгэлэн яармаг” өдөрлөгийн хүрээнд Зочин илтгэгч Ц. Бархас илтгэл тавив.



Зураг 5.44. “Ажлын байрны үзэсгэлэн яармаг” өдөрлөгийн хүрээнд ажил олгогчидтой уулзалт хийв.

### 5.5.5. Төгсөгч оюутныг мөшгөх судалгаа

БШУЯ-ны гаргасан ДБ мэдээний загварт тохируулж зарим өөрчлөлтийг оруулж нэгтгэлийг өөрчилсөн байна. ДБУМС-д тухайн судалгааг оруулж, түүнээс ДБ35, ДБ36 гаргаж ажиллаж байна. *Дээд боловсролын сургалтын өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь жил бүрийн 2 сарын 25, 7 сарын 25-ны дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд шивэн илгээх болон маягтаар ирүүлнэ!* мэдээллийг ДБУМС-д оруулахаар ДБ35, ДБ36 статистик мэдээ гаргаж байна.



Зураг 5.45. Төгсөгч оюутны мөшгөх судалгааны үр дүн

### 5.5.6. “Оюутан цэрэг” мэргэжил олгох сургалт

МУ-ын Ерөнхийлөгчийг 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 92 дугаар зарлиг “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн ЗГ-ын 2014 оны 40 дүгээр тогтоол “Оюутан цэрэг хөтөлбөр”, БХЯ, БСШУ-ны сайдын 2014 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан А/49, А/56 дугаар тушаал “МУ-ын их дээд, сургууль, коллежид суралцаж байгаа оюутан залуусыг суралцах хугацаанд нь цэргийн сургалтад хамруулж цэргийн алба хаалгах журам”, 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “Оюутан цэрэг” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн юм.

Мөн ЗГ-ын 2017 оны 32 дугаар тогтоол “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам шинэчлэгдэн баглагдаж энэхүү журмын дагуу оюутан цэрэгт хамрагдах хүсэлтэй оюутны судалгааг гаргаж шаардлага хангасан оюутнуудыг Оюутан цэрэг хөтөлбөрт хамруулдаг.

ШУТИС-ийн хувьд жил ирэх тусам Оюутан цэрэг хөтөлбөрт хамрагдах оюутны тоо нэмэгдэж байгаа ч гэсэн цэргийн штабаас ирэх хяналтын тоо багассаар байгаа. Сүүлийн 2018, 2019 онуудад хяналтын тоо 71 байлаа.


2020, 2021 онуудад ковид цар тахалтай холбоотойгоор оюутан цэрэг хөтөлбөр хэрэгжээгүй. 2022 оноос E-mongolia системээр оюутан цэрэг бүртгэл явагдаж ШУТИС-аас 105 оюутан хамрагдсан болно.



**Оюутан цэрэг хөтөлбөрт хамрагдсан тоо**

*Хүснэгт 5.13*

Сургуулийн нэр	Хамрагдсан оюутны тоо
БАС	29
БуХС	2
ГУУС	8
ГХС	0
МеХТС	8
МХТС	32
ҮТС	3
ЭХС	21
ХШУС	2
<b>Нийт</b>	<b>105</b>



*Зураг 5.46. Оюутан цэрэг хөтөлбөрт хамрагдсан тоо*



*“Оюутан цэрэг-2022” танхимын сургалт*



*“Оюутан цэрэг-2022” хээрийн сургалт*





**ХИЧЭЭЛИЙН ХУВААРЬ**

Хичээлийн нэр	Хичээл орох өдөр цаг	Оюутан багш	Оюутан багшийн дугаар	Зөвлөх багш
Математик-1	Даваа гараг 6 паар	С.Ариунтунгалаг	96390949	М.Энхцэцэг
Математик-1	Лхагва гараг 3 паар	М.Надин-эрдэнэ	80872840	Г.Батцэцэг
Харилцааны англи хэл	Баасан гараг 6 паар	Б.Од	88070237	М.Даваажав
Харилцааны англи хэл	Лхагва гараг 5 паар	Ц.Биндэръяа	88299218	М.Пямдолгор
Хими-1	Мягмар гараг 4 паар	Г.Бурэнтогтох	89181090	Р.Долгоржав
Ердийн дифференциал тэгшитгэл	Лхагва гараг 6 паар	Г.Хангал	99545050	Г.Батцэцэг
Физик-1	Баасан гараг 2 паар	Б.Ану	99340808	Б.Одонтуяа
Дүрслэх геометр	Даваа гараг 6 паар	Д.Энхбаяр	94320322	Х.Дамчаасүрэн
Дүрслэх геометр	Даваа гараг 5паар	Ш.Сугар-од	88214426	Х.Дамчаасүрэн



*Зураг 5.48. Багшийн туслах оюутан клубийн ажлын хуваарь*

Мөн БТОК-ийн оюутнууд ЕБС-ийн ЭЕШ өгөхөөр бэлтгэж буй сурагчдад Оюутан нас тууштай сэтгэл сэдвийн хүрээнд лекц уншиж, бичлэг хийж ШУТИС-ийн мэргэжил сурталчлах зорилготойгоор нийт ЭЕШ өгөх сурагчдад МА-тай хамтран ажиллаж байна.



*Зураг 5.49. ШУТИС-ийн мэргэжил сурталчлах ажлын хүрээнд Багшийн туслах оюутан клубээс хийсэн ажил*

-Empowerment клуб, хөтлөгчийн клубүүдэд гэрээт багш ажиллуулсан. Мэтгэлцээний холбооны сургагч багш: Ч.Сайхнаа 2021 оны 10 сарын эхнээс 12 сарын 15 хүртэл сургалтыг танхимаар TV заланд зохион байгуулан идэвхтэй ажилласан.




*Зураг 5.50. Empowerment клуб, хөтлөгчийн клубүүдийн үйл ажиллагаа*



Сургалтаар клубийн гишүүдэд мэтгэлцэх арга техник хамгийн гол дараах чадваруудын талаар цаг баримтлал, багаар ажиллах ур чадвар, харилцааны арга техникүүд, үнэт зүйлээ тодорхойлох зэрэг сургалт болов.

Мэтгэлцээний клубийн амжилтаас дурдвал: Улсын их дээд сургуулийн дунд зохион байгуулсан уран илтгэлийн уралдаанд О.Билгүүн байр, “Нийгмийн витаминжуулалт улсын илтгэх ур чадварын тэмцээнд” уралдаанд БАС-ийн Архи-V курсийн оюутан Х.Оюунтүлхүүр тэргүүн байр, БАС-ийн Архи-IV курсийн оюутан Б.Бат-Ирээдүй гутгаар байрыг тус тус эзэлсэн амжилт үзүүлсэн.



Зураг 5.51. Мэтгэлцээний клубийн үйл ажиллагаа

"Оюутны Оюуны Давлагаа-IV" улсын аварга шалгаруулах уран илтгэлийн тэмцээнд Empowerment клубийн гишүүн О.Билгүүн тэргүүн байр эзэлсэн ба улсын аварга илтгэгч боллоо.





*Зураг 5.52. "Оюутны Оюуны Давлагаа-IV" улсын аварга шалгаруулах уран илтгэлийн тэмцээний ТЭРГҮҮН БАЙРЫН шагналт Empowerment клубийн гишүүн О.Билгүүн*

ШУТИС-ийн science FM94.1 радиод empowerment клубийн гишүүд радио хөтлөгчөөр суралцан ажиллаж байна.



*Зураг 5.53. ШУТИС-ийн science FM94.1 радиод "Empowerment" клубийн гишүүд ажиллаж байгаа нь*

2021-2022 оны намрын улирал-цар тахалтай энэхүү цаг үед дараах клубүүд үйл ажиллагааны тайлангаа хэлэлцүүлээ



- |                     |                        |
|---------------------|------------------------|
| Мэргэжлийн клуб     | Сайн дурын клуб        |
| 1. CCS клуб         | 1. Улаан загалмай клуб |
| 2. Finde клуб       | 2. Хятад хэл клуб      |
| 3. Inspiration клуб | 3. MUST Comedy клуб    |
| 4. WHIZZ клуб       | 4. Дуулаачийн клуб     |
| 5. СЭХ клуб         | 5. Соёмбо клуб         |
| 6. Энергетик клуб   | 6. Хөтлөгчийн клуб     |



7. Залуу экологич клуб
8. SysCo Tech клуб
9. Звёздочка клуб
7. Empowerment клуб
8. Хос уянга клуб
9. Багшийн туслах оюутан клуб
10. Patiar клуб
11. Шагай харваа клуб

Тайлан хэлэлцэх комисст дараах багш нар ажиллав. Үүнд Мэргэжлийн клубүүдийн тайлангийн хуралд

1. Д.Цогзолмаа ОСҮА- ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D)
2. В.Алимаа ГУУС-ийн Газрын тос, өрөмдлөгийн салбарын дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор
3. М.Цас-Оргилмаа БАС-ийн Инженерийн байгууламжийн салбарын ахлах багш, доктор (Ph.D)



**Зураг 5.54. ШУТИС-ийн оюутны клубүүд үйл ажиллагааны тайлангаа хэлэлцүүлээ.**

Тайлан дүгнэсэн дүнгээр хамт олноо манлайлсан МХТС-ийн “Sys&CoTech” клубийг Академич Х.Энхжаргалын нэрэмжит шагналаар шагнуулахаар шалгаруулсан бол Мэргэжлийн шилдэг клубээр ҮТС-ийн “WIZZ” клуб, шилдэг клубийн ахлагчаар ГХС-ийн “Звёздочка” клубийн ахлагч М.Самбууням, Мэргэжлийн клубийн шилдэг гишүүнээр ХШУС-ийн “Залуу Экологи” клубийн гишүүнийг тодруулахаар тогтов.


Сайн дурын клубүүдээс шилдэг клубээр “Соёмбо” клуб, Шилдэг клубийн ахлагчаар “Empowerment” клубийн ахлагч Х.Оюунтүлхүүр, клубийн шилдэг гишүүнээр “Patiar” клубийн гишүүнийг тодруулахаар тогтов. Шилдэг клубүүдийн шагналыг гардуулах бэлтгэл ажил явагдаж байна Мөн клубүүдийн тайланг эмхэтгэн цахим <https://www.must.edu.mn/media/uploads/2022/06/07/tailan.pdf> болон хэвлэмэл байдлаар нийтийн хүртээл болгов.



Хаврын улиралд нийт 21 клуб тайлангаа хэлэлцүүлж дүгнүүлсэн. Тус тайланд ДаТС-иас мэргэжлийн 3, сайн дурын 2 клуб үйл ажиллагаагаа танилцуулж дүгнүүлсэн. Тайлангаа хэлэлцүүлсэн клубүүдийн тайлан Ррт-г вебд байршуулан нийтэд танилцуулж байна. Мэтгэлцээний клуб, хөтлөгчийн клубүүдэд мэргэжлийн гэрээт багшийг улирал бүр ажиллуулж байна.


### 5.6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ

ШУТИС-ийн эмнэлэг 2021-2022 оны хичээлийн жилд эрүүл мэндийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрлөө сунгуулж үйл ажиллагаа явуулж эхэлсэн.




Зураг 5.55. Эрүүл мэндийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл

### 5.6.1. Амбулаторийн үзлэгийн мэдээ



Зураг 5.56. 2021-2022 оны 9,10,11,12,1, 2, 3, 4, 5, 6 сарын үзлэгийн мэдээ

Зураг 5.56-аас харахад 10, 11, 3, 4, 5 сард улирал солигдохтой холбоотой амьсгалын замын томуу, томуу төст, ковид-19 вирусийн өвчлөл ихэссэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвийн үйлчлүүлэгчдийн тоо ихсэж ачаалал нэмэгдэж байна.




Зураг 5.57. Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн үзлэгт хамрагдсан байдал

Зураг 5.57-аас харахад ШУТИС-ийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн анхан үзлэгт хамрагдаж байгаа нь эрүүл мэндийн шалтгаанаар болон улирлын өвчлөлтэй холбоотойгоор үзлэгт хамрагдсан байна. Давтан үзлэг нь 2,3-р



шатлалын нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, эмчилгээ бичүүлсэн оюутан, багш ажилчдын эмчилгээг хийж гүйцэтгэсэн байна.



**Зураг 5.58. Эрүүл мэндийн төвөөс явуулсан урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдал**

Мөн байнга манай хяналтад байдаг үйлчлүүлэгчид орж байна. Урьдчилан сэргийлэлт нь Ковид-19 өвчний ойрын хавьтал сэжигтэй тохиолдлын үзлэг орсон байна. Хамтын гэрээний дагуу 2021 оны 11-н сар болон 2022 оны 4,5-н саруудад багш, ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.

### 5.6.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээ

*Хүснэгт 5.14*

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭР	ХУГАЦАА	ХААНА	Зохион байгуулагч	Хамрагдсан хүний тоо	ҮР ДҮН
1	Томуугийн эсрэг вакцин	8 сарын 26, 10 сарын 1	БуХС	“Ази фарма”, “Жи Ди Би” ХХК, БуХС	150	Ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Ази фарма”, “Жи Ди Би” ХХК-тай гэрээ хийн томуугийн эсрэг вакцинд багш, ажилтан, оюутнуудыг хамруулсан.
2	Тусгаарлалтын бүсэд батлагдсан тохиолдол эмчлэх	9 сараас 12 сар хүртэл	Оюутны байр 1	ЭМСТ	46	Ковид-19 халдвар авч батлагдсан тохиолдлыг тусгаарлах өрөөнд 10 хоног 46 батлагдсан тохиолдол болон 86 ойрын хавьтлыг эмчилсэн.
3	Тусгаарлалтын бүсэд батлагдсан тохиолдол эмчлэх	9 сараас 12 сар хүртэл	Оюутны байр 3	ЭМСТ	56	Ковид-19 халдвар авч батлагдсан тохиолдлыг тусгаарлах өрөөнд 10 хоног 56 батлагдсан тохиолдол болон 130 ойрын хавьтлыг тусгаарлан эмчилсэн. Ковидын дараах эмчилгээг 13 оюутанд хийсэн.



4	Тусгаарлалтын бүсэд батлагдсан тохиолдол эмчлэх	9 сараас 12 сар хүртэл	Оюутны байр 4	ЭМСТ	24	Ковид-19 халдвар авч батлагдсан тохиолдлыг тусгаарлах өрөөнд 10 хоног 24 батлагдсан тохиолдол болон 35 ойрын хавьтлыг тусгаарлан эмчилсэн.
5	“Тусгаарлалтын бүсэд батлагдсан тохиолдол эмчлэх	9 сараас 12 сар хүртэл	Оюутны байр 5	ЭМСТ	17	Ковид-19 халдвар авч батлагдсан тохиолдлыг тусгаарлалтын өрөөнд 10 хоног 17 батлагдсан тохиолдол болон 13 ойрын хавьтлыг тусгаарлан эмчилсэн.
6	Сахуу татрангийн эсрэг вакцин	09 дүгээр сарын 09, 12-нд	ОБ 5-р байр	ЭМСТ, “Энх титэм” ӨЭМТ	15	Дархлаажуулалтын товлолын дагуу МСҮТ-ийн 15 сурагчдыг Сахуу татрангийн эсрэг вакцинд хамруулсан
7	Сахуу татрангийн эсрэг вакцин	10 сарын 25-26	ОБ 5-р байр	ЭМСТ, “Энх титэм” ӨЭМТ	117	Дархлаажуулалтын товлолын дагуу МСҮТ-ийн 117 сурагчдыг сахуу татрангийн эсрэг вакцинд “Энх титэм” ӨЭМТ вакциinatorтай хамтран ажилласан.
8	Багш ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	11 сард	“Сөүл” эмнэлэг, УХТЭ	ГУУС, ҮТС, ГХС, ХШУС	413	Хамтын гэрээний дагуу ГУУС, ГХС, ҮТС, ХШУС-ийн 413 багш, ажилтны урьдчилан сэргийлэх үзлэгийг “Сөүл” эмнэлэг, УХТЭ эмнэлгийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвд зохион байгуулсан.
9	“MUST CUP-2021” ШУТИС-ийн багш, ажилчдын хөл бөмбөгийн тэмцээнд хамтран ажиллав	11 дүгээр сарын 6, 7-нд	“Дэрэн”-гийн хөл бөмбөгийн талбайд	ШУТИС Захиргаа, ХШУС БТСТ	БУХС, МехТС, МХТС, ХШУС, ЭХС, Захиргаа, 6 баг	Нийт 6 баг тэмцээнд оролцсоноос 10 хүнд анхны тусламж үзүүлэв.
10	Оюутны байранд амьдардаг оюутнуудад урьдчилан сэргийлэх үзлэг	11,12, 03 саруудад	Оюутны байр 1,3,4,5	ЭМСТ	762	Нийт 762 оюуган эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан бөгөөд ХДХВ/Тэмбүүгийн шинжилгээний хариу сөрөг гарсан.
11	КОВИД-19 Түргэвчилсэн шинжилгээг зохион байгуулах	11 сарын 21	Оюутны байр 1	ЭМСТ	74	ОБ 1-р байрны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 74 тамирчнаас ковид-19 түргэвчилсэн шинжилгээ авсан. Шинжилгээний хариу сөрөг гарсан.
12	Элсэгчдийн аварга шалгаруулах 2021 оны сагсан	11 сарын 26, 27-нд	Хичээлийн 2-р байр спорт заал	ОСҮА, ОХ, ХШУС БТСТ	15 баг	Нийт 15 баг тэмцээнд оролцсоноос 35 хүнд анхны тусламж үзүүлж



	бөмбөгийн тэмцээнд хамтран ажилласан					ажилласан.
13	МСҮТ-ийн оюутан сурагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулав	11 сарын 11, 17-нд	Оюутны байр 5	ЭМСТ	169	ХУДЭМТ-ийн өсвөрийн эмч, сүрьеэгийн эмч, ДОХ/ХДХВ эмч нарын үзлэгээр МСҮТ-ийн оюутан сурагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулсан.
14	КОВИД-19 нэмэлт дархлаажуулалт	11 сарын 22-12-р сарын 10 хүртэл	ШУТИС	СБДЭМТ, БГДЭМТ ШУТИС ЭМСТ	3094	ШУТИС ЭМСТ, ОСҮА, ОХ хамтран ажилласан.
15	КОВИД-19 нэмэлт дархлаажуулалт	11 сарын 27, 12 сарын 4	Оюутны байр 1, 3, 5	СБДЭМТ, ХУДЭМТ, БГДЭМТ	94	Оюутны байр 1, 3, 5 дээр ковид-19 вакцины явууллын цэг ажиллаж нийт 94 оюутан дархлаажуулалтад хамрагдсан.
16	ЭТТА 4-н төрөлт тэмцээнд хамтран ажилласан	12 сарын 4, 5-нд	БуХС спорт заал, Хичээлийн 2-р байр спорт заал	ЭТТА	16 баг	Нийт 16 баг тэмцээнд оролцсоноос 38 хүнд анхны тусламж үзүүлж ажилласан.
17	“Эрүүл мэнд эрхэм баян” сэдэвт өдөрлөг	12 сарын 1	БуХС	ЭМСТ	Нийт оюутнууд	ДОХ-той тэмцэх өдрөөр эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулсан.
18	Тусгаарлалтын бүсэд батлагдсан тохиолдол эмчлэх	12 сараас 06 сар хүртэл	Оюутны байр 1	ЭМСТ	2	Ковид-19 халдвар авч батлагдсан тохиолдлыг тусгаарлах өрөөнд 10 хоног 2 батлагдсан тохиолдол болон 6 ойрын хавьтлыг эмчилсэн.
19	Багш ажилчдын 6-н төрөлт тэмцээн	1 сарын 6-12	Хичээлийн 2-р байр Спорт заал, БуХС	ЗАА, ХШУС БТСТ	Нийт багш ажилчид /104 хүнд тусламж үзүүлсэн/	Тэмцээнд оролцохдоо бэртэж гэмтсэн тамирчдад Ковид-19-ын халдвар хамгааллын дэглэмийг сахиулан эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, хамраа хугалсан, хөмсгөө сэтэлсэн тамирчдад анхны тусламж үзүүлэн, яаралтай дараагийн шатны эмнэлэгт шилжүүлсэн. Тэмцээнийг үзэгчгүй, талбай дээр тоглож байгаа баг тамирчдаас бусад нь амны хаалтаа зүүж, тоглолт хооронд заалыг халдваргүйжүүлж агаарын сэлгэлт хийж, халдвар хамгааллын сахиулан ажилласан.
20	Дархан уул аймаг дахь технологийн сургуульд дотоод аудитын шалгалт	1 сарын 13	ЭМСТ	ЗАА	9	Дархан уул аймаг дахь технологийн сургуульд дотоод аудитын шалгалтаар явах



						ажилчдад Ковид-19-ын түргэвчилсэн шинжилгээ авч, 1 хүний шинжилгээний хариу эерэг гарсныг дараагийн шатанд шилжүүлсэн.
21	Ерөнхийлөгчийн тэтгэлэг гардах ёслол	2 сарын 17	МУИС Номын сан	ШУТИС ЗАА	142	Төрийн ордонд Ерөнхийлөгчөөс тэтгэлэг авах оюутнуудад ковид-19-ын түргэвчилсэн шинжилгээ хийсэн ба 1 хүүхэд эерэг гарсан оюутны 1-р байранд тусгаарлаж эмчилсэн.
22	Ковид-19 вакцины дархлаа өдөөх чадвар болон үр нөлөөг үнэлэх “Инвайт -Монгол” судалгаа	3 сарын 11	Хичээлийн 2-р байр Урлаг заал	“Элэгний төв”, “Оном сан”	6	Ковид-19 вакцинд хамрагдсан оюутан, ажилчдад вакцины дархлаа тогтоц, үр нөлөөг нь үе шаттай судлах, элэгний В,С вирусийг илрүүлэх, илэрсэн нөхцөлд идэвхийг нь шалгасан.
23	Багш ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	4, 5 сард	“Монгол-Японы эмнэлэг”, “Рexamed”, “Сөүл”, “Family medical” эмнэлгүүд	ЗАА, МХТС, БуХС, МеТС, БАС, ЭХС, ДАТС	719	Хамтын гэрээний дагуу ЗАА, МХТС, МеТС, БуХС, БАС, ЭХС багш, ажилтанг “Монгол-Японы хамтарсан эмнэлэг”-т 516, “Рexamed” 100, “Сөүл” 17, “Family medical” 86 эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвд зохион байгуулсан. Шинжилгээний хариуг хүн тус бүрд тайлбарлаж, шинжилгээ өөрчлөлттэй ажилчдыг дараагийн шатны эмнэлэгт үзүүлэхийг зөвлөж, эмчилгээг хийлээ.
24	Хачигны вакцин 1	4 сарын 26	ЭМСТ	СБДЭМТ	48	Үйлдвэрлэлийн дадлагад гарах оюутнуудад хачигт халдварын вакцины эхний тунг хийсэн.
25	Спорт явган аялалын хичээл	5 сарын 7-8	“Буянт-Ухаа”, “Чингисийн хүрээ”	ХШУС БТСТ	1000	ШУТИС-ийн 1-р курсийн оюутнуудад спорт явган аяллын хичээлд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлсэн.
26	Ковид-19 дархлаа идэвхжүүлэх нэмэлт тун	5 сарын 10-11	Хичээлийн 2-р байр Урлаг заал	МУЗН, СБДУЗН, НЭМГ	10	Их дээд сургуулийн оюутнуудыг Ковид-19-ын халдварын дархлаажуулалтад идэвхтэй хамруулах, нэмэлт тунтай холбоотой ташаа мэдээллийг залруулах ач холбогдлыг таниулах зорилготой ажиллаа.



27	Хачигны вакцин 2	5 сарын 26	ЭМСТ	СБДЭМТ	26	Үйлдвэрлэлийн дадлагад гарах оюутнуудад хачигт халдварын вакцины хоёр дугаар тунг хийсэн.
28	Нөхөн сэргээх эмчилгээ	Хичээлийн жилийн эхний хагаст	ШУТИС	ЭМСТ	1645	2021-2022 оны хичээлийн жилийн эхний хагаст нийт давхардсан тоогоор 1645 багш, ажилчид, оюутнуудад физик эмчилгээ /бумба, улаан туяа, УВЧ шарлага, лаа, бариа, нөхөн сэргээх эмчилгээ/ үйлчилгээ үзүүлсэн.
29	Өдрийн эмчилгээ	Хичээлийн жилийн эхний хагаст	ШУТИС	ЭМСТ	1786	2021-2022 оны хичээлийн жилийн эхний хагаст нийт давхардсан тоогоор 1786 багш, ажилтан, оюутнуудад дусал тариа, булчин, судас тариа өдрийн эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн.

### 5.6.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Хүснэгт 5.15

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭР	ХУГАЦА А	ХААНА	ЗОХИОН БАЙГУУЛАГ Ч	ХҮНИЙ ТОО	ҮР ДҮН
1	Хичээл эхлэхтэй холбогдуулан хичээлийн байруудын цэвэрлэгээ, ариутгал бэлэн байдлыг хангах	8 сарын 29, 9 сарын 10	Хичээлийн 1, 2, 3, 4, 8-р байр, MeTC, БУХС, МХТС, Оюутны байрууд	ШУТИС ЗАА, ЭМСТ, СБЗА, БАНА	Нийт байрууд	ШУТИС-ийн хэмжээнд Ковид-19 коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу гэрээт “Мэргэн насан”, “УБ Ариутгал”, “Ариун сан нар” ХХК-р вшавж, мэрэгчгүйтгэл, халдваргүйтгэл хийлгэж, хяналт тавин зохих журмын дагуу заавар зөвлөгөөг өгч ажилласан.
2	Цэвэрлэгээ халдваргүйтгэлийг хэрхэн зөв хийх, халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ	9 сарын 1, 6	MeTC, Оюутны байр, МСҮТ	ЭМСТ	17	Оюутны байр, МСҮТ, MeTC-ийн үйлчилгээний ажилтнуудад сургалт мэдээлэл хийсэн.
3	Тусгаарлах өрөө тохижуулалт бэлэн болгох	09 сард	Хичээлийн 1, 2, 4, 8, MeTC, МХТС, БУХС, ОБ 1, 3, 4, 5	ШУТИС ЗАА, ЭМСТ	Нийт байрууд	КОВИД-19 цар тахлын үед бэлэн байдлыг хангаж хичээлийн байр, оюутны байрууд тус бүрт орох гарах хэсэгтэй ойр





						тусгаарлах өрөөг тохижуулан халдваргүйтгэл хийж, иж бүрдлүүдийг байрлуулан ковид-19 батлагдсан тохиолдол, ойрын хавьтлыг тусгаарлан эмчилж ажилласан.
4	Халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ, зааврын тухай сургалт	9 сарын 17	Хичээлийн 1, 2, 3, 4, 8-р байр, номын сан	ЭМСТ	26	Хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотой ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг хэрхэн найруулах, ашиглах, халдваргүйжүүлэлт хийхдээ хувийн хамгаалах хэрэгслийн талаар үйлчилгээний ажилтнуудад сургалт хийсэн.
5	Нөхөн сэргээх, өдрийн эмчилгээний өрөөнүүдэд засвар	9 сарын 17	ШУТИС ЭМСТ	ЭМСТ	Нөхөн сэргээх эмчилгээний өрөө	Эмнэлгийн анхан шатны үйлчилгээг цэвэр цэмцгэр орчинд үзүүлэх, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс Нөхөн сэргээх эмчилгээний өрөө, Өдрийн эмчилгээний өрөөний хананд замаск татаж, эмульс хийж будсан.
6	Халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ автомаск, мананцар үүсгэгчийг хэрхэн ашиглах, ажиллуулах талаар сургалт	9 сарын 21	Оюутны байр -1	ЭМСТ	3	Оюутны байранд халдваргүйжүүлэлт хийхэд хэрэглэх клорсепт-17 бодисын хэрэглээ, мананцар үүсгэгч, автомаскыг яаж ашиглах талаар үйлчилгээний ажилтнуудад сургалт хийсэн.
7	“Тамхины хор нөлөө”, “КОВИД-19” халдвараас урьдчилан сэргийлэх талаар сургалт	10 сарын 21, 22	MeTC	ЭМСТ	115	МУСТ-ийн 2-р ангийн сурагчдад тамхины хор нөлөө, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулав.
8	“Нэн түрүүнд ХАБ” 2021 бага хурал	10 сарын 21, 22	Хичээлийн 8-р байр 12 давхарг	MOSHPA, ШУТИС	172	Тухайн өдөрлөгт оролцсон бүх хүмүүсийн биеийн температурыг үзэж, бүртгэл хөтлөн, халдвар хамгааллын дэглэм баримтлуулан, гар болон орчны халдваргүйтгэлд хяналт тавин оролцов.
9	КОВИД-19 халдвар урьдчилан	10 сарын 26	MeTC	ЭМСТ	22	МУСТ-ийн ХММЗ-ийн 16 ангийн сурагчдад ковид-19



	сэргийлэх талаар сургалт					халдвараас хамгаалах сургалт байгуулав.	хэрхэн талаар зохион
10	КОВИД-19 халдвар урьдчилан сэргийлэх талаар сургалт	09-р сар	“Коосен” ТК	ЭМСТ	300	“Коосен” ТК-ийн нийт сурагчдад халдвараас хамгаалах сургалт байгуулсан.	ковид-19 хэрхэн талаар зохион
11	Эрдэм шинжилгээний онол практикийн хөтөлбөр	10 сарын 26, 27	Хичээлийн 8-р байр, Номын сан	ШУТИС УТС	Нийт оролцогчид	Арга хэмжээнд оролцсон халдвар дэглэмд хяналт тавив.	хүмүүст хамгааллын
12	“Цохилох зүрх бүхнийг аваръя” донорын өдөрлөг	11 сарын 19	Хичээлийн 1-р байр урлаг зааланд	ШУТИС ЭМСТ, ОХолбоо,	80	“Цохилох зүрх бүхнийг аваръя” цусны донорын өдөрлөгөөр 80 оюутан, ажилчид цусаа хандивласан.	
13	КОВИД-19 цар тахлын үед сургалтын ажиглагаа эхэлсэнтэй холбоотой ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байдал	Хичээлийн жил	ШУТИС, БуХС, МеТС, ХМТС, ОБ-1, 3, 4, 5	ШУТИС ЭМСТ, БАНА	Нийт байрууд	Бүх хичээлийн байр, Байрууд, Салбар сургуулиудад ковид-19 цар тахлын үед сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаатай холбоотой ариутгал халдваргүйтгэлийг манацар үүсгэгч, автомакс, шүршигч буу, шүршигч сав ашиглан клорсепт-17 халдваргүйжүүлэх бодисын уусмалаар халдваргүйжүүлэлтийг өдөр бүр хийв.	
14	“Эрүүл мэнд эрхэм баян”	12 сарын 01	БуХС, Хичээлийн 2 байр	ЭМСТ, ШУТИС ЗУЗК	65	Хичээлийн байруудаар оюутнуудад ДОХ өвчний талаарх брошур хэвлэл тарааж мэдээлэл өгөв.	
15	“Зөв дадал”	12 сарын 18	БуХС	ЭМСТ	10	Эрүүл зөв хооллолт, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгууллаа.	
16	Цэвэрлэгээ халдваргүйтгэлийг хэрхэн зөв хийх, халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ	01 сарын 27	Хичээлийн 1-р байр	ЭМСТ	10	Хичээлийн 1-р байрны 108 тоотод ГУУС, УТС, ГХС, ХШУС-ийн үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулав.	
17	Хичээл тэнхимээр эхлэхтэй холбогдуулан хичээлийн байруудын ариун цэвэр бэлэн байдлыг хангах	02 сарын 07	Хичээлийн 1,2,3, 4, 8-р байр, МеТС, БуХС, МХТС, Оюутны байрууд	ЭМСТ, БАНА	Нийт байрууд	ШУТИС-ийн хэмжээнд Ковид-19 короно вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу	



						хичээлийн байрууд халдваргүйтгэл хийхэд хяналт тавин зохих журмын дагуу заавар зөвлөгөө өгөв.
18	Сургуулийн орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ	02 сарын 11	Хичээлийн 2-р байр	ЭМСТ	22	Хичээлийн 2-р байрны 302 тоотод ЭХС, БАС, ГУУС-ийн үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулав.
19	Цэвэрлэгээ үйлчилгээнд ариутгалын бодис хэрэглэх	02 сарын 21	БУХС	ЭМСТ	8	Халдваргүйжүүлэлтийн бодисыг хэрхэн зөв найруулж хэрэглэх талаар үйлчилгээний ажилтнуудад сургалт хийв.
20	“Хэв журмын зөрчил, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хувь хүний мэдлэг чухал”	03 сарын 01, 02, 03	ОСҮА, ЭМСТ	Оюутны байр 1, 3, 4, 5	300	ЦЕГ-ийн УСХ-ийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа доктор Б.Алтанзул дотуур байрны оюутнуудыг сургалтад хамруулав.
21	Тамхинаас татгалзъя	3 сарын 23-4 сарын 22	МХТС	ЭМСТ, Чанарын менежер	Нийт оюутнууд	МХТС-ийн багш ажилчид, оюутнуудын дунд тамхинаас гарах сарын аян зохион байгууллаа.
22	“Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо, Бэлгийн замаар дамжих халдвар”	3 сарын 11, 22	ОСҮА, ЭМСТ	Оюутны байр 1, 3, 4, 5	500	Нөхөн үржихүйн эрүүл мэнд бэлгийн боловсрол олгох чиглүүлэгч багш Х.Баярсайхан ШУТИС-ийн дотуур байрнуудын оюутнуудад цахим, танхимаар сургалт зохион байгуулав.
23	“Сэтгэл зүйгээ зөв удирдахад анхаарах асуудал”	4 сарын 14	ОСҮА, ЭМСТ	Оюутны байр 1, 3, 4, 5	200	Сэтгэл судлаач эмч Ж.Гантулга дотуур байрны оюутнуудад цахим, танхимаар сургалт хийв.
24	“Хар тамхи мансуурах бодисын хор нөлөө”	4 сарын 19	Оюутны байр 5	ХУД ЦГ, ЭМСТ	35	Хар тамхитай тэмцэх хэлтсийн ахлах мэргэжилтэн хошууч О.Эрдэнхишиг ХУД-ийн 1- хэлтсийн ГХУС-ийн ахлах мэргэжилтэн ахмад Ц.Хандсүрэн нар оюутнуудад сургалт хийж, оюутнуудаас илрүүлэг тест авлаа.
25	“Мэргэжилтээ шалтгаалах өвчин”	4 сарын 26	БУХС	ЭМСТ	25	Мэргэжилийн зан үйлтэй холбоотой өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах сэдвээр цахим танхимаар хичээл заасав.



2 6	“Хүний хөгжил”	5 сарын 9	БухС	ЭМСТ	50	Хүний хөгжил хичээл үзэж байгаа 20 оюутантай хамтарч эрүүл мэндийн үзлэг, ДОХ, Тэмбүүгийн шинжилгэ, АД үзэв.
2 7	“Сурах эрх”	5 сарын 12	БСШУЯ	ЭМСТ, ОСҮА, СБЗГ	5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, оюутнуудын чуулга уулзалтад тусгай хэрэгцээт 2 оюутны хамт оролцож, санал өгөв.

#### 5.6.4. Корона вирусийн халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хяналт тандалт

Дэлхий дахинд COVID-19 халдвар дэгдсэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Захиргаа удирдлага, Эрүүл мэнд, спортын төвөөс хамтран дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Ковид-19 цар тахлын үед бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг нээж байгаатай холбоотой “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай”, “ШУТИС-ийн хэмжээнд КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж” боловсруулав.
- Сэжигтэй тохиолдлыг тусгаарлах, түр тусгаарлах 55-н өрөөг УОК 41-р тушаалын түр тусгаарлах өрөөг бэлдэх зааврын дагуу бэлтгэв. Үүнд: Хичээлийн байрууд, Салбар сургуулиуд, Оюутны байрууд
- Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комисс, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас өгсөн чиг үүргийн дагуу хичээлийн байр, дотуур байруудад анхааруулах хуудас, зөвлөмж тарааж байршуулав.
- Хичээлийн байр, дотуур байруудад мананцар үүсгэгч, автомакс, шүршигч буу, гадаргуу халдваргүйжүүлэх шүршигч савнууд, цэвэрлэгээний бодисууд, халдваргүйтгэл хийх бодис материал тараасан болно.
- Үйлчилгээний ажилчдад халдваргүйжүүлэх уусмалыг зөв найруулах, хэрэглэх, халдваргүйжүүлэлт хийхэд хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх зааврын талаар сургалт хийв.
- 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах тухай А/642 дугаар тушаал, “Дархлаажуулалтын ажлын хэсгийг байгуулах тухай” А/375 дугаар захирамжуудын хүрээнд дархлаа сэргээх тунг багш, ажилтан, оюутнуудын дунд 2021 оны 11 дүгээр сарын 22-оос 12 дугаар сарын 10 дуустал нийт 3094 хүнийг нэмэлт тунд хамруулжээ.
- Цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавьж ажиллалаа.
- Хичээлийн байрнуудад орох гарах тэмдэглэгээ, урсгалын чиглэл, зай барих тэмдэглэгээ, халдвараас хамгаалах зурагт хуудас, болон автомат халуун хэмжигчтэй, гар халдваргүйжүүлэгчтэй ариутгалын хаалга байршуулж, нэвтэрч буй хүн бүрт маск зүүх санамж байршуулав.
- Хичээлийн байруудад “Ариун сан нар”, “Улаанбаатар ариутгал”, “Ууган хангай”, “Мэргэн насан” ХХК компаниудаар шавьжгүйтгэл, мэргэгчгүйтгэл, халдваргүйтгэлийг хийлгэсэн болно.
- (Ковид-19)-ын Сэжигтэй тохиолдол болон батлагдсан тохиолдол гарсан анги танхим, өрөө, хичээлийн байрыг өдөр бүр автомаксаар халдваргүйжүүлэлт хийсэн.




- 2022 оны 04 дугаар сарын 21-ний өдрийн №01/126 “Коронавируст халдварын дархлаажуулалтыг эрчимжүүлэх зорилгоор нийслэлийн их дээд сургуулиудад дархлаажуулалтын өдөрлөг зохион байгуулах компанит ажлын удирдамж”-ийн дагуу 17-25 насны залуучуудын нэмэлт тунд 10 оюутан хамрагдсан байна.
- Нийт салбаруудад тандалтын баг гаргаж, танхимаар хичээллэж буй багш, ажилтан, оюутнууд, Оюутны байруудын ажилтан, оюутнуудын ирц болон (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол, ойрын хавьтал, сэжигтэй тохиолдлын мэдээг өдрөөр, 7 хоногоор, сараар нэгтгэн УОК, НОК, ЭМЯ, НЭМГ зэрэг холбогдох газруудад цаг тухайд нь мэдээ мэдээллийг өгч, хариу арга хэмжээ авч ажилласан.
- Эмнэлгийн халдвартай хог хаягдал болон Ковид-19-ын хог хаягдлыг Элемент ХХК-тай гэрээ байгуулан устгалд өгсөн.

**Оюутны байруудын Ковид-19 өвчлөлийн мэдээлэл**

*Хүснэгт 5.16*

№	Оюутны байр	Нийт оюутны тоо	Батлагдсан тохиолдол	Ойрын хавьтал	Сэжигтэй тохиолдол
1	Оюутны байр-1	263	46	86	74
2	Оюутны байр-3	322	56	130	23
3	Оюутны байр-4	156	24	35	8
4	Оюутны байр-5	91	17	13	6
5	Дархан ОБайр	109	50	90	20
<b>Нийт</b>		<b>941</b>	<b>193</b>	<b>354</b>	<b>131</b>



**Зураг 5.59. ШУТИС-ийн оюутны байруудын “Ковид-19” өвчлөлийн мэдээлэл**

Оюутны байруудын (Ковид-19)-ын өвчлөлийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Шинжилгээ болон эмнэлзүйгээр батлагдсан оюутанд эмчилгээний багцыг өрхийн эмнэлгээс авч, тусгаарлах улаан бүсийн өрөөнд 10-14 хоног тусгаарлан эмчилсэн. (Улаан, шар бүсэд байгаа үед гадагшаа гарахгүй гаднаас хүн орохгүй зөвхөн эмч, ажилтан хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсөж нэвтэрнэ.)
- Ойрын хавьтлын оюутнуудыг тусгаарлах шар бүсийн өрөөнд 6-7 хоног тусгаарлаж 6 дахь хоногт ковид-19 шинжилгээ өгч хариу сөрөг бол 7дох хоногт тусгаарлалтаас гаргасан. (Тусгаарлалтын хугацаанд хичээлээ цахимаар хийж, тусгаарлалтын өрөөнөөс гарахгүй)
- Сэжигтэй тохиолдол өрөөндөө биеэ ажиглаж, шинж тэмдэг зовуурь илэрсэн үед шинжилгээ өгөх
- Эмч үзлэг дууссаны дараа түр тусгаарлах өрөөнд нэг удаагийн хамгаалалтын хувцас хэрэглэлийг тайлж зориулалтын хог хаягдлын саванд хаяв.
- “Ковид-19”-ийн халдвартай хог хаягдлыг зориулалтын саванд хийж, Элемент ХХК-тай гэрээний дагуу Эмнэлгийн халдвартай хог хаягдлыг устгуулав.

### Хавсралт зураг



Зураг 5.60. Хачигт халдвараас сэргийлэх вакцин



*Зураг 5.61. “Ковид-19”-ийн нэмэлт дархлаажуулалт*



Зураг 5.62. 12 САРЫН 1 “ДОХ-той ТЭМЦЭХ ӨДӨРЛӨГ”







*Зураг 5.63. Цусны донорын өдөрлөг*



*Зураг 5.64. Хичээлийн байрны халдваргүйжүүлэлт*



Зураг 5.65. Сургалт мэдээ мэдээлэл





# ЗУРГААДУГААР БҮЛЭГ

---

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,  
ХЭВЛЭН НИЙТЛЭЛ



## **ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХЭВЛЭН НИЙТЛЭЛ**

### **6.1. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НОМЫН САН**

2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын үйл ажиллагаа цар тахалтай холбогдуулан цахим хэлбэрээр, хаврын улирлын үйл ажиллагаа хэвийн горимд шилжин, танхимаар явагдлаа.

Шинжлэх ухаан технологийн номын сан нь их сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагааг дэмжин ажиллаж, сан хөмрөгийн бүрдүүлэлт, уншигчдад танхимын болон цахим үйлчилгээг чанартай хүргэх, олон улсын мэдээллийн санг таниулан сурталчлах, номын санчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэж ажиллалаа.

Хичээлийн жилийн намрын улиралд СБЗГ-тай хамтран нийт оюутан суралцагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан цахим ном, сурах бичиг, гарын авлагын хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллав. Зохиогчийн эрхийн хүрээнд цахим ном, материалыг ШУТИС-ийн уншигч /багш, ажилтан, суралцагчид/ нэвтрэх эрхээр үзэх боломжтой ба гаднын уншигчдад хаалттай, хамгаалалттай байдаг юм.

Тус хичээлийн жилд төрийн өмчийн 6 их сургуулийн (ШУТИС, МУИС, ХААИС, АШУҮИС, МУИС, МУБИС) хамтран ажиллах санамж бичигт тусгагдсан оюуны өмчийг хамгаалах, бүтээлийн хуулбарлалтыг шалгах, номын сангийн нэгдсэн системийг нэвтрүүлж, хамтран ашиглах зэрэг ажлууд хэрэгжиж, багш, оюутан, судлаачид харьяалал харгалзахгүй номын сангаар харилцан үйлчлүүлж байна.


Номын сангийн нэг цэгийн үйлчилгээгээр профессор багш нарын сурах бичиг, хүрээлэнгүүдийн брэнд бүтээгдэхүүнийг гэрээний дагуу худалдан борлуулж, хэрэглэгчдэд хүргэж байна.

ШУТНС нь 2021-2022 оны хичээлд хүний нөөцийн чадамжийг тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд “Мэдээлэл боловсруулах арга зүй” сэдвийн дор нийт 8 удаагийн шаталсан сургалтыг төлөвлөгөөний дагуу номын санчдад зохион байгуулсан.

### **6.2. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ФОНД БҮРДҮҮЛЭЛТ**


Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Төв болон бүрэлдэхүүн сургуулиудын /БУХС, БАТС, МХТС, МехТС, ДаТС, Эрдэнэт цогцолбор дээд сургууль/ номын сангаас бүрдсэн 7 салбар номын сан танхимын болон цахим үйлчилгээг хүргэж ажиллалаа.

ШУТИС-ийн номын сан нь нийт 73,091 нэр төрлийн 317,494 ширхэг ном, материалын сан хөмрөгтэй. (Зураг 6.1.) Уншлагын танхимаар болон гэрээр ном олгох фондоор давхардсан тоогоор нийт 87,866 уншигчдад 142,122 ном, сурах бичгийг олгож ажилласан байна. (Зураг 6.3.) Цахим судалгааны сангаас давтагдсан тоогоор 31,658 уншигч 79,366 цахим ном, судалгааны ажлыг цахимаар үзэж, үйлчлүүлсэн байна. Төрийн өмчийн 6 их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд багш, оюутнуудад ном, хэвлэлийн үйлчилгээг нээлттэй хүргэж ажиллалаа.




**Зураг 6.1. Ном, материалын нэр төрөл, тоо ширхгийн статистик үзүүлэлт**

Электрон каталогт нийт 294,336 удаа хайлт хийгдсэнээс ШУТИС-ийн профессор багш, оюутан, судлаачид 62,548 удаа кодоор нэвтэрч цахим материал, лавлагаа ном зүй, мэдээллээр үйлчлүүлсэн байна. (Зураг 6.2.)




**Зураг 6.2. Электрон каталогийн хайлтын үр дүн**




Зураг 6.3. 2021-2022 оны хичээлийн жилийн үйлчилгээний статистик үзүүлэлт

Сүүлийн 3 жилийн үйлчилгээний статистик үзүүлэлтийг харьцуулахад 2021-2022 оны хичээлийн жил цахим болон танхимын үйлчилгээ хосолсон байдлаар явагдсан ч судалгаагаар танхимын үйлчилгээ өмнөх жилүүдээс өсөлттэй байна.



Зураг 6.4. Сүүлийн 3 жилийн үйлчилгээний статистик үзүүлэлт

Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар хууль тогтоомжийн эмхэтгэл, гадаад, дотоодын мэргэжлийн болон эрдэм шинжилгээний сэтгүүл, өдөр тутмын сонин хэвлэмэл болон цахимаар хэлбэрээр үйлчилгээг хүргэж ажиллав.



Зураг 6.5. Тогтмол хэвлэлийн сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлт

Ном сэргээн засварлах, хувилах үйлчилгээгээр эргэлтэд их гарсан 90 гаруй ном, сурах бичгийг сэргээн засварлаж үйлчилгээнд гаргаж, багш нарын захиалгын дагуу зохиогчийн эрх нь шийдвэрлэгдсэн 38 ном, сурах бичгийг хувиран олшруулах үйлчилгээ үзүүллээ.

**Фонд бүрдүүлэлт:** ШУТНС-ийн фонд бүрдүүлэлт нь “Номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг үндэслэн хийгддэг.

2021-2022 оны хичээлийн жилд бүрэлдэхүүн сургуулиуд профессор багш нарын сурах бичиг, гарын авлага болон техник технологийн сургалт, судалгааны нийт 588 нэр төрлийн 5,255 ширхэг номыг 159.6 сая төгрөгөөр худалдан авч, фондын бүрдүүлэлт хийсэн байна (Хүснэгт 6.1). Мөн олон улсын EBSCO мэдээллийн сангийн хандалтын судалгааг үндэслэн Инженерчлэлийн багцын эрхийг 19.6 сая төгрөгөөр авч судлаачдад эрдэм шинжилгээ, судалгаа хийх боломжийг бүрдүүлж ажилласан.


### ШУТНС-ийн номын фонд бүрдүүлэлтийн тоон үзүүлэлт

Хүснэгт 6.1


№	Номын сангууд	Нэр төрлөөр	Тоо ширхэг	Үнийн дүнгээр
1	ШУТТөв номын сан	246	2,576	82,181,682
2	БУХС-ийн номын сан	136	554	20,060,326
3	МехТС-ийн номын сан	28	270	6,846,000
4	МХТС-ийн номын сан	20	413	11,198,000
5	ДаТС-ийн номын сан	50	243	5,288,185
6	БАТС-ийн номын сан	36	277	12,525,000
7	Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн номын сан	72	922	21,572,500
<b>НИЙТ:</b>		<b>588</b>	<b>5,255</b>	<b>159,671,693</b>

Тус хичээлийн жилд төв болон бүрэлдэхүүн сургуулийн номын сангийн фондын бүрдүүлэлтийг үнийн дүнгээр (Зураг 6.6), нэр төрөл, тоо ширхэгээр (Зураг 6.7) харьцуулж, хүснэгтээр үзүүллээ.





Зураг 6.6. Фонд бүрдүүлэлтийн үнийн дүнгийн харьцуулсан судалгаа



Зураг 6.7. Фондын бүрдүүлэлтийн судалгаа  
а. Нэр төрдөөр б. Тоо ширхгээр

### 6.3. НОМЫН САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ШУТИС-ийн номын сан уламжлалт үйлчилгээг цахим үйлчилгээтэй хослуулан хүргэж байна.

**Цахим сан хөмрөгийн баяжилт:** 2019 оноос эхлэн ШУТНС-ийн цахим сангийн тоо тасралтгүй өссөөр байгаа ба төгсөгчдийн судалгааны ажил /магистр, докторын зэрэг горилсон бүтээл/, эрдэм шинжилгээний бичиг, уншигчдын хэрэгцээ шаардлага, зохиогчдын хүсэлтийг үндэслэн мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг ШУТНС-ийн электрон каталогт оруулж, цахим хуудсаар дамжуулан уншигчдад мэдээлэл хүргэж байна.




2021 оны 10 дугаар сараас EBSCO олон улсын мэдээллийн сангийн Engineering Source багцын эрхийг 1 жилийн хугацаатай авч уншигчдадаа үйлчилж байна (Зураг 6.8). Тус мэдээллийн санд 3000 гаруй ном, сэтгүүл, эрдэм шинжилгээний өгүүлэл байгаагаас 1600 гаруйг бүрэн эхээр /full text/ үзэх боломжтой, инженерийн салбарын мэргэжилтнүүд, судлаачдад зориулсан шилдэг мэдээллийн сан юм.


**Мэдээллийн сангуудыг ашигласан байдал:** Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн үнэтэй болон үнэгүй олон улсын мэдээллийн сангийн эрх авахыг авч ашиглаж байна.

EBSCO мэдээллийн сангаас ШУТИС-ийн уншигчдад зориулан 2021 оны захиалгын урамшууллаар дараах боломжуудыг олгосон.


1. Өөрийн компанийн тусгайлан цуглуулсан цахим номуудыг /OA/ ашиглах боломжийг олгож, эрхийг нь үнэ төлбөргүй нээв. Уг сангаас 7,600 гаруй цахим номыг бүрэн эхээр нь татаж авч унших боломжтой.
2. Inspec инженерийн мэдээллийн сангийн туршилтын эрхийг 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн гурван сарын хугацаатай нээсэн болно. Тус сан нь физик, цахилгаан инженерчлэл, электроник, компьютер, удирдлага, механик, үйлдвэрлэлийн инженерчлэл гэсэн үндсэн дөрвөн салбараас гадна тэдгээртэй хамаарал бүхий материал судлал, далай судлал, цөмийн инженерчлэл, геофизик, био анагаахын инженерчлэл зэрэг холбогдох салбаруудын 18 сая эрдэм шинжилгээний мэдээлэл, 5,000 гаруй шинжлэх ухаан, техник технологийн сэтгүүл, 2,500 хурлын эмхэтгэл, ном, видео судалгааны материалууд багтсан байна.



Зураг. 6.8. “Engineering Source” мэдээллийн сангийн ашиглалтын судалгаа



Зураг. 6.9. “Inspec” мэдээллийн сангийн ашиглалтын судалгаа



Зураг. 6.10. Цахим номын хандалтын судалгаа

Мөн дараах сангуудыг онлайн үйлчилгээндээ ашиглаж байна. Үүнд:

- Reseach4life – ARDI /Шинжлэх ухаан, техник/, AGORA /Хөдөө аж ахуй/, OARI /Байгаль орчин/, GOALI /Хууль/, HINARI /Эрүүл сэнд/ гэсэн 5 үндсэн мэдээллийн сантай. Мөн тус сангаар дамжуулан Scopus-ыг төлбөргүйгээр ашиглах боломжтой байдгаараа давуу талтай. Мэдээллийн санг ашиглахын тулд ШУТИС-ын тусгай нэвтрэх нэр, нууц үгийг ашиглана.

**ШУТИС-ийн сүлжээнээс үнэгүй ашиглах боломжтой сангууд:**

Springer Nature – Олон улсын мэдээллийн сан. Тус сангаас 1800 гаруй ном, 2700 гаруй сэтгүүлээс мэдээлэл татаж авч үзэх боломжтой.

- DOAJ - Directory of Open Access journals нь дэлхийн 82 орчим хэлээр 15631 орчим эрдэм шинжилгээний сэтгүүлээс 5,523,239 орчим эрдэм шинжилгээний




бүтээлүүдийг онлайн, үнэ төлбөргүй үзэх боломжтой. Тус платформд Монгол улсаас 4-н эрдэм шинжилгээний сэтгүүл одоогоор бүртгэлтэй байдаг.

- DOAB - Directory of Open Access Books нь дэлхийн 408 эрдэм шинжилгээний салбарын хэвлэлийн газрын 33,731 орчим номуудыг онлайн, үнэ төлбөргүй орж үзэх, татаж үзэх боломжтой. Тус платформд Монгол улстай холбоотой 18 ном одоогоор бүртгэлтэй байдаг.
- Theses - Тус платформд 40,100 гаруй эрдмийн зэрэг хамгаалсан дипломууд онлайн, үнэ төлбөргүй орж үзэх, татаж авах боломжтой.
- Dimensions – Open access filter ашиглан 30 гаруй сая мэдээллээс хайлт хийж, үзэх боломжтой.
- Hindawi - Үнэгүй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг үзэх боломжтой.
- Chinese National Knowledge Infrastructure(CNKI) - Тус платформд бүртгэлтэй 2 сая орчим эрдэмтдийн 170 сая гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, докторын диссертаци, ном, статистик, тайлбар толь бичгүүдийг 2022 оны 7 дугаар сар хүртэл үзэх эрхтэй.

### Үйлчилгээний программ:

ШУТИС нь үйлчилгээндээ Lib4u программыг ашиглаж байгаа бөгөөд төрийн 6 их сургуулийн номын сангийн нэгдсэн системийг бий болгох ажлын хүрээнд олон улсын нээлттэй Коха программыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Koha систем нь анхны Нээлттэй эрхтэй номын сангийн систем (ILS- integrated library system), сүүлийн хувилбар нь Koha 21.11, mysql өгөгдлийн сан дээр тулгуурласан, өгөгдлийн 130 гаруй хүснэгттэй, Zebra хайлтын систем, олон улсын номзүйн MARC21 стандарт, номзүйн мэдээллийг дамжуулах Z39.50 протоколыг дэмжин ажилладаг систем юм.



Зураг 6.11. Олон улсын нээлттэй Коха програмын загвар

## 6.4. НОМЫН САНГИЙН СОЁЛЫН ХӨТӨЛБӨРТ АЖИЛ:

Жил болгон үндэсний хэмжээнд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагддаг “Номын баяр”-ын үйл ажиллагаанд ШУТИС-ийн профессор багш нарын бүтээлийг худалдан борлуулах, таниулан сурталчлах зорилгоор оролцлоо. Хоёр удаагийн энэхүү үйл ажиллагаанд Үндсэн сурах бичиг, Инженерийн лавлах бүтээлүүдээр номын үзэсгэлэн гаргаж танилцуулснаас гадна 7 бүрэлдэхүүн сургуулийн нийт 240 гаруй багшийн 1,300 орчим сурах бичиг, гарын авлагаас 540 орчим номын борлуулалт хийсэн байна (Зураг 6.12).



**Зураг 6.12. “Үндэсний номын баяр”-ын үзэсгэлэн, худалдаа**

Тус хичээлийн жилд Өмнөговь аймагт зохион байгуулагдсан ШУТИС-ийн “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын төсөл танилцуулах арга хэмжээнд профессор багш нарын бүтээлийг сурталчилж үзэсгэлэн гаргасан. (Зураг 6.11.)



**Зураг 6.13. “Профессор, багш нарын бүтээл”-ийн үзэсгэлэн**

ШУТИС нь жил бүрийн 4 дүгээр сарын 23-нд “Дэлхийн номын өдөр”-ийг угтаж олон талт арга хэмжээ зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ өдрийн хүрээнд зохиолч, яруу найрагч Р.Эмүжинтэй "Уншигчийн уулзалт", ХШУС-ийн профессор багш нарын бүтээлийг таниулан сурталчлах нээлттэй хэлэлцүүлэг, "Номын сугалаат худалдаа", танин мэдэхүйн “АХА” асуулт, хариултын тэмцээн зэрэг арга хэмжээг уншигчдын дунд зохион байгуулав. (Зураг 6.13)

“Дэлхийн номын өдөр”-ийн хүрээнд төв болон бүрэлдэхүүн сургуулийн номын санчдын дунд эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зарлаж, “Номын сангийн хөгжлийн чиг хандлага” сэдвээр эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгууллаа.




Зураг 6.14. “Дэлхийн номын өдөр”-ийн хүрээнд явагдсан үйл ажиллагаа

### 6.5. ШУТИС-ИЙН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР, ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

ШУТИС-ийн Хэвлэлийн газар нь 2021-2022 оны хичээлийн жилд “ Соёлтой шуурхай үйлчилгээ, эелдэг боловсон харилцаа” гэсэн зорилго тавин ажиллав.

Хэвлэлийн газар нь профессор багш нар, оюутан суралцагчид, гадны болон дотоодын байгууллага, хувь хүний ном сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний товхимол, нэрийн хуудас, танилцуулга гэх мэт бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг чанарын өндөр түвшинд хурдан шуурхай хийж гүйцэтгэж ирлээ.

Энэ хичээлийн жилд ШУТИС- ийн Хэвлэлийн газраас ном сурах бичиг – 12,548 ш, сэтгүүл 480ш, Эрдэм шинжилгээний эмхэтгэл -852ш, гарын авлага – 3,496 ш, тайлан -638ш, ахисан түвшиний оюутны диплом -862ш, ШУТИС –ийн багшийн дэвтэр-1002ш, хавтас, албан бланк- 1069ш, нэрийн хуудас- 12355ш, урилга, өргөмжлөл, сертификат, танилцуулга- 3590ш гэх мэт захиалгат ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 6.15. ШУТИС- ийн Хэвлэлийн газраас ном сурах бичиг

**“Профессор багш нарын туурвисан сурах бичиг, эрдэм шинжилгээний эмхэтгэл, гарын авлагын товч танилцуулга**

Хүснэгт 6.2

№	Бүтээлийн нэр	Сургуулийн нэр	Байр
<b>Сурах бичиг</b>			
1	Геологи уул уурхайн зураг зүйн үндэс	ГУУС	II
2	Англи хэлний хэл зүй	Захиргаа	I
3	Их дөрөлж, паалуу хэцүү тээгийн хадны зураг	БУХС	III
4	Барилгын материал	БАС	II
5	Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй		
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй		
7	Ойн үйлдвэрлэлийн түүхий эдийн технологийн үзүүлэлтийн судалгааны онол арга зүйн үндэс, хэрэглээ	КООСЭН	
8	Монголын эртний нүүдэлчдийн өв		
<b>Эрдэм шинжилгээний эмтгэл</b>			
1	Хоолны 100 жил	ҮТС	I
2	Менежмент ба инноваци түншлэл 2022	БУХС	III
3	Профессор, багш нарын эрдэм шинжилгээний бүтээл № 22/7/	ЭША	I
<b>Гарын авлага</b>			
1	Чанарын гарын авлага	НБТөв	I
2	Магистрын гарын авлага	БУХС	III
3	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер мэргэжлийн бакалаврын дипломын төслийг бичих заавар	БАС	II
4	Autocad ба revit программ	МХТС	
5	Математик I	ХШУС	I



Зураг 6.16. “Профессор багин нарын туурвисан сурах бичиг, эрдэм шинжилгээний эмхэтгэл, гарын авлага



2021-2022 оны хичээлийн жилд хэвлэгдсэн  
ШУТИС-ийн үндсэн сурах бичгүүд

Хүснэгт 6.3

№	Үндсэн сурах бичгийн нэр	Хичээлийн код, нэр
<b>Барилга, архитектурын сургууль</b>		
1	Дэлхийн урлагийн түүх	Дэлхийн урлагийн түүх
<b>Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль</b>		
2	Хүний хөнжил	Хүний хөгжил
<b>Геологи уул уурхайн сургууль</b>		
3	Уурхайн машин тоног төхөөрөмж	Уурхайн машин тоног төхөөрөмж
<b>Гадаад хэлний сургууль</b>		
4	Техникийн англи хэлзүй I	Техникийн англи хэлзүй I
5	Техникийн англи хэлзүй II	Техникийн англи хэлзүй II
6	Техникийн англи хэлзүй III	Техникийн англи хэлзүй III
7	Техникийн англи хэлзүй IV	Техникийн англи хэлзүй IV
8	Хятад хэлний сурах бичиг	Хятад хэлний сурах бичиг
9	Солонгос хэлний сурах бичиг	Солонгос хэлний сурах бичиг
<b>Механик тээврийн сургууль</b>		
10	Агаарын хөлгийн хийн турбинт хөдөлгүүрийн хийц бөх бат чанар	Агаарын хөлгийн хийн турбинт хөдөлгүүрийн хийц бөх бат чанар
<b>Мэдээлэл, холбооны технологийн сургууль</b>		
11	Хагас дамжуулагч хэрэгсэл	Хагас дамжуулагч хэрэгсэл
<b>Үйлдвэрлэлийн технологийн сургууль</b>		
12	Ноос ноолууран ээрмэл үйлдвэрлэх технологи	Ноос ноолууран ээрмэл үйлдвэрлэх технологи
<b>Эрчим хүчний сургууль</b>		
13	Тоон сигналын боловсруулалтын үндэс	Тоон сигналын боловсруулалтын үндэс
14	Автомат удирдлагын онол	Автомат удирдлагын онол
<b>Эрдэм шинжилгээ инновацын газар</b>		
15	Нарны эрчим хүч	Нарны эрчим хүч



*Зураг 6.17. 2021-2022 оны хичээлийн жилд хэвлэгдсэн ШУТИС-ийн үндсэн сурах бичгүүд*



## Цаашид хэвлэлтэд орохоор төлөвлөж буй үндсэн сурах бичгүүд

Хүснэгт 6.4

№	Үндсэн сурах бичгийн нэр	Сургуулийн нэрс
1	Ил уурхайн ашиглалтын технологи	ГУУС
2	Өрөмдлөг	ГУУС
3	Инженер геодез	ГУУС
4	Санхүүгийн менежмент	БУХС
5	Үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежмент	БУХС
6	Модон бүтээц	БАС
7	Усны барилга байгууламж	БАС
8	Геологи, уул уурхайн зураг зүйн үндэс	БАС
9	Гидравликийн машин	БАС
10	Техникийн хэмжил ба хэмжүүр	ЭХС
11	Конвекцийн дулаан солилцоо	ЭХС

Мөн гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд зориулан “Монголын эртний нүүдэлчдийн өв” ШУТИС-ийн танилцуулгыг чанарын өндөр түвшинд хэвлэн нийлүүлсэн.

Хэвлэлийн газраас ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад болон мэргэжлийн ангийн оюутнуудын дунд хэвлэлийн үйл ажиллагааны орчин үеийн хөгжлийн чиг хандлага, энэ мэргэжлийг эзэмшсэнээр хувь хүн ирээдүйд юу хийж болох, ямар амжилтад хүрч болох талаар сурталчилгаа лекц 2 удаа зохион байгуулав.



## **ДОЛООДУГААР БҮЛЭГ**

---


**ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

## ДОЛОО. ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

### 7.1 БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 21001:2018 СТАНДАРТ

#### 7.1.1 Чанарын талаарх мэдлэг, ойлголт

ШУТИС-ийн үйл ажиллагаанд боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 стандартыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамт олны дунд үе шаттай сургалт, семинарыг явуулж байна. Тус хичээлийн жилийн эхэнд ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцоонд багш ажилтны оролцоо, чанарын менежерийн үүргийг мэдээлж, ойлгуулах зорилгоор 9 бүрэлдэхүүн сургуулийн 780 орчим буюу 80% дээш ирцтэй багш, ажилтныг хамруулсан онлайн сургалт явуулж, тэдний санал, тэтгэгдлийг авч, нээлттэй ярилцсан.



Зураг 7.1. “ШУТИС-ийн Чанарын бодлого, зорилт, чанарт багш ажилтны оролцоо” сэдэвт ярилцлага

Мөн бид харилцан суралцах, туршлагатай танилцах зорилгоор Чанарын менежерүүд, сургуулийн дэд захирлуудын дунд дараах нэгжүүдэд аялал зохион байгуулсан. Үүнд:

- Төрийн тусгай албан хаагчийн эмнэлэг- Green hospital
- ШУТИС-ийн Мэдээлэл холбоо, технологийн сургууль
- ШУТИС-ийн Механик тээврийн сургууль





*Зураг 7.2. Харилцан суралцах, туриллага суралцах танилцах аялал*

Чанарын аргачлал болох үйл явцын хандлага, тасралтгүй сайжруулалтын мөчлөг PDCA-г таниулж ойлгуулах, хэрэглүүлэх ажлуудын хүрээнд ханын самбар, зураглалыг хийж, сургуулиудад байршуулсан. Тус ажлын хүрээнд шинэчлэн гаргаж буй бүх журмуудыг үйл явцын аргачлалаар уялдаа холбоог ханган, холбогдох зураглалыг хийж байна.



*Зураг 7.3. Үйл явцын хандлага, Тасралтгүй сайжруулалтын мөчлөгийг мэдээлсэн байдал*

ШУТИС-ийн хамт олонд зориулж [www.edx.edu.mn](http://www.edx.edu.mn) платформ дээр ББМТ ISO 21001:2018 стандартын танилцуулах шатны MOOC сургалтын материалыг боловсруулж, байршуулсан. Одоогоор тус хичээлийг нийт 61 хүн судалж, дуусгасан байна.



ISO 21001:2018 (Management systems for educational organizations)

Enroll in ISO\_21001

About This Course

Include your long course description here. The long course description should contain 150-400 words.

This is paragraph 2 of the long course description. Add more paragraphs as needed. Make sure to enclose them in paragraph tags.

Requirements

Add information about the skills and knowledge students need to take this course.

View About Page in studio

Course Number	ISO_21001
Classes Start	Dec 28, 2021
Classes End	Jul 1, 2023
Estimated Effort	06:00

Зураг 7.4. ISO 21001-ын нийтэд зориулсан нээлттэй онлайн хичээл

### 7.1.2 Эрсдэлийн менежмент

ШУТИС-д чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхдээ эрсдэлд суурилсан сэтгэлгээг хэрэглэж, бүрэлдэхүүн сургууль тус бүрд эрсдэл болон боломжийн үнэлгээг хийж, эрсдэлд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

ШУТИС-ийн эрсдэлийн үнэлгээний мэдээлэл

Ажлаас	Төлөвлөх үнэлгээ				
	1	2	3	4	5
1. Мэдээлэл	1	2	3	4	5
2. Өрх	1	2	3	4	5
3. Өрх	1	2	3	4	5
4. Өрх	1	2	3	4	5
5. Өрх	1	2	3	4	5
6. Өрх	1	2	3	4	5
7. Өрх	1	2	3	4	5
8. Өрх	1	2	3	4	5
9. Өрх	1	2	3	4	5
10. Өрх	1	2	3	4	5

Эрсдэлийн үнэлгээний мэдээлэл

1. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

2. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

3. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

4. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

5. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

6. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

7. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл


8. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

9. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

10. Эрсдэл болон боломжийн үнэлгээний мэдээлэл

Зураг 7.5. Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын удирдамж

Бүрэлдэхүүн сургууль болоод захиргааны багш, ажилтнуудтай харилцан мэдээлэл солилцох замаар эрсдэл, боломжийг илрүүлсэн. Эндээс ШУТИС-ийн хэмжээнд илрүүлсэн эрсдэлийг нэгтгэн боловсруулахад давхардалгүйгээр нийт 75 эрсдэлийг үнэлсэн. Үүнд:



Нийт 75 эрсдэл



■ Өндөр ■ Дунд ■ Бага

Зураг 7.6. ШУТИС-ийн нийт эрсдэл, түвшингээр ангилсан байдал



Зураг 7.7. Нийт эрсдэлийн тоо, ангиллаар


Эрсдэлийн ангилал	Эрсдэлийн нэр	Ангилгдах болон хугацаа	Томилдох магадлал /1-5 оноо/	Аюулгүй байдал, эрүүл мэндэд нөлөөлөх байдал	Сургуулийн нэр хүндэд нөлөөлөх байдал	Байгууллагын санхүүд нөлөөлөх байдал	Үйлчилгээний чанарт нөлөөлөх байдал	Үр дагавар /1-5 оноо/	Эрсдэлийн үнэлгээ
Хүний нөөцийн эрсдэл	Цалин болон үнэлгээний систем хүмүүсийг ялгаж гаргаж чадахгүй, хийсэн хийгээгүй ажил үнэлэгддэг, ижил цалин, нэмэгдэл авдаг нь ажил хийгүй байх хандлага ихэсгэх	(5) Тогтмол буюу өдөр, 7 хоног тутам	(5) Байнга	1- Осол гэмтэл, эрүүл мэнд муудахгүй	3- Салбарын хэмжээнд	2- >1% зардлын өсөлт	3- Байгууллагын хэмжээнд	(3) Дунд зэрэг	15
Гадаад хүчин зүйлсийн буюу бусдаас хамаарах эрсдэл	Улс төрийн оролцооноос хамаарч их сургуулийн нэр хүнд муудах, улс төрийн томилого хэтэрхий их орж ирснээр хэрэгт үүрдэллэгтэй болох	(4) Сар	(4) Боломжтой	1- Осол гэмтэл, эрүүл мэнд муудахгүй	4- Улсын хэмжээнд	1- Эд хөрөнгө, санхүүгийн хохиролгүй	3- Байгууллагын хэмжээнд	(3) Дунд зэрэг	12
Сургалтын эрсдэл	Танхимын сургалтад хэрэглэж байсан сургалтын тоног төхөөрөмж цэвэр сургалтын шаардлагад нийцэхгүй байх, шаардлагатай тоног төхөөрөмж хуралцдаг мөн байгүйн улмаас сургалт тасалдах	(4) Сар	(4) Боломжтой	1- Осол гэмтэл, эрүүл мэнд муудахгүй	2- Хамт олны дунд	2- >1% зардлын өсөлт	4- 1< сараар үйл ажиллагаа тасалдах	(3) Дунд зэрэг	12
Сургалтын эрсдэл	Цалин бага байдлаас башу судлаачид давхар орлого олох ажил хийх, үндсэн ажлаа цалгардуулах	(4) Сар	(4) Боломжтой	1- Осол гэмтэл, эрүүл мэнд муудахгүй	3- Салбарын хэмжээнд	2- >1% зардлын өсөлт	3- Байгууллагын хэмжээнд	(3) Дунд зэрэг	12
Сургуулийн орчны аюулгүй байдал, хамгаалтын эрсдэл	Өрөө тасалгаа, анги танхим, лабораториудад цахилгааны асуудлаас болж гэрэл үе үе шатах, цахилгаан хэрэгслийн ачааллыг хэт ихэсгэн техник тоног төхөөрөмжийг гэмтэх, галын аюул үүсэх (барилга байгууламжийн цахилгаан, дулаан, сантехникийн хуучирсан)	(4) Сар	(4) Боломжтой	3- Эмнэлгийн эмчилгээ шаардлагатай гэмтэл, хөгжлийн бэрхшээлтэй болж болохгүй	2- Хамт олны дунд	2- >1% зардлын өсөлт	2- Зөвхөн эрэлт ид/холбогдох салбаруудад	(3) Дунд зэрэг	12
Төсөв, санхүүгийн эрсдэл	Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй төсвийг уусдуулан төсөвлөж, төсөв хэмнэлтийн горимд шилжсэнээр төлөвлөгөөт амлудыг гүйцэтгэхэд төсөв санхүү хүрэлцэхгүй байх, сургуулийн төсвийн зардал багасах, зарим санхүүжилт хасагдах, төсөв тангагдах	(4) Сар	(4) Боломжтой	1- Осол гэмтэл, эрүүл мэнд муудахгүй	2- Хамт олны дунд	2- >1% зардлын өсөлт	3- Байгууллагын хэмжээнд	(3) Дунд зэрэг	12





### 7.1.3 Үл тохирол, залруулах арга хэмжээ

ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны тасралтгүй сайжруулалтыг хангахын тулд бид үл тохирлыг хянах, зохих арга хэмжээг авч байна. Үүний хүрээнд бүрэлдэхүүн сургууль тус бүрт үл тохирлын бүртгэл хөтөлж, одоогоор дараах байдлаар залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Нийт илэрсэн үл тохирлын дийлэнх хувийг Сургалт, судалгаа болон ажиллах орчин нөхцөл, мэдээллийн аюулгүй байдал, хүний нөөцийн менежментийн асуудал эзэлж байна. Үүнд:



Зураг 7.8. Нийт үл тохирол, төрлөөр

Ангилал	Тодорхойлолт
Үл тохирол	Байгууллагын дотоод эсвэл гадны дүрэм, журам, стандартын шаардлага зөрчсөн бол <b>үл тохирол</b> гэж тооцно. Шаардлага бол мэдээжийн ба албан журмын шинжтэй баримт бичиг байна. Шаардлагыг тодорхой хэмжээнд хангаж байгаа бол үл тохирол гэж үзэхгүй.
Анхаарах зүйлс	Засаж залруулахгүй бол үл тохирол болох магадлалтай асуудлууд зөрчил, дутагдлууд.
Сайжруулах санал	Шаардлагыг тодорхой хэмжээнд хангаж байгаа боловч сайжруулах шаардлагатай зүйлс

Хамгийн их илэрсэн үл тохирлыг ангилбал:

- Дүрэм, журмын мөрдөлт**
  - ✓ Багшийн цаг тооцох журмын заалт зөрчсөн
  - ✓ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бүртгэл хөтлөөгүй
  - ✓ Дүрэм журам, зохицуулалтын шинэчлэл, өөрчлөлтийг хичээлийн эхэнд баталж мөрдүүлэхгүй
- Физик орчны үл тохирол**
  - ✓ Анги танхимын халаалт, дулаан
  - ✓ Анги танхимын агааржуулалт, гэрэлтүүлэг
  - ✓ Анги танхимын засвар үйлчилгээ
  - ✓ Ариун цэврийн өрөө
  - ✓ Гадаад орчин, ногоон байгууламж
- Интернэт, тоног төхөөрөмж, Программ хангамжийн үл тохирол:**
  - ✓ Техник хэрэгсэл хуучирсан, дутагдалтай
  - ✓ Интернэт сүлжээ тасрах, программ гацах
  - ✓ Тоног төхөөрөмжийн техник үйлчилгээ, тохиргоо



### 7.1.4 Баримтжуулсан мэдээлэл

ШУТИС-ийн чанарын менежмент, чанарын баталгаажуулалтын тогтолцоог хангах хүрээнд захиргаа болоод бүрэлдэхүүн нэгжүүдийн баримт бичиг, бүртгэлүүдийг цэгцлэх, сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна. “Нийтлэг хөтлөх хэргийн жагсаалт”-ыг шинэчлэн боловсруулж, холбогдох нэгжүүд болон ажилтнуудын хариуцсан баримтжуулсан мэдээллийг цахим эвсэл хэвлэмэл хэлбэрээр байршуулж, хадгалуулах ажлыг зохион байгуулсан.

БТАБГА: Чанарын менежмент, үзэгдлийн албын дарга <i>А.Нанжир</i> Э.Халуун								
Бүрэлдэхүүн сургуулийн нийтлэг хөтлөх хэргийн баримтын жагсаалт								
2021 оны 11 дугаар сарын 13	Улаанбаатар хот							
Дэд бүртгэлийн ангид	Мэдээлэл нэр	Хяналтын хугацаа	Хяналтын ажилтан	Хяналтын ажлын үр дүнд	Хяналтын ажлын үр дүнд	Хяналтын ажлын үр дүнд	Хяналтын ажлын үр дүнд	
1	2	3	4	5	6	7	8	
1	1.13	Захирагч тусгай А	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	6.1	Хяналтын ажлын үр дүнд
2	1.12	Захирагч тусгай А	байгаа	Дэглэгч	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1	Хяналтын ажлын үр дүнд
3	1.13	Захирагч тусгай Б	70 жил	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1	Хяналтын ажлын үр дүнд
4	1.4	Захирагч тусгай Б	байгаа	Дэглэгч	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1	Хяналтын ажлын үр дүнд
5	1.2	Сургуулийн менежерийн хөтөлгөөний албын дарга	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1.2	Хяналтын ажлын үр дүнд
6	1.6	Сургуулийн менежерийн хөтөлгөөний албын дарга	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1.2	Хяналтын ажлын үр дүнд
7	1.7	Мэргэжлийн үйлчилгээний албын дарга	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1.2	Хяналтын ажлын үр дүнд
8	1.8	Мэргэжлийн үйлчилгээний албын дарга	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1.2	Хяналтын ажлын үр дүнд
9	1.9	Мэргэжлийн үйлчилгээний албын дарга	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	5.1.2	Хяналтын ажлын үр дүнд
10	1.10	Ажилчин бичиг	18 жил	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	7.4	Хяналтын ажлын үр дүнд
11	1.11	Ажилчин бичиг	10 жил	Дэглэгч	Захирагч тусгай	Захирагч тусгай		Хяналтын ажлын үр дүнд
12	1.12	Ажилчин бичиг	18 жил	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай		Хяналтын ажлын үр дүнд
13	1.13	Ажилчин бичиг	10 жил	Дэглэгч	Захирагч тусгай	Захирагч тусгай		Хяналтын ажлын үр дүнд
14	1.14	Ажилчин бичиг	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	6.4	Хяналтын ажлын үр дүнд
15	1.15	Ажилчин бичиг	байгаа	Хяналтын ажлын үр дүнд	Захирагч тусгай	Захирагч тусгай	6.4	Хяналтын ажлын үр дүнд
16	1.16	Ажилчин бичиг	5 жил	Дэглэгч	Захирагч тусгай	Захирагч тусгай	4.2, 6.1, 6.2	Хяналтын ажлын үр дүнд
17	1.17	Ажилчин бичиг	5 жил	Дэглэгч	Захирагч тусгай	Захирагч тусгай	4.2, 6.1, 6.2	Хяналтын ажлын үр дүнд

Зураг 7.9. Нийтлэг хөтлөх хэргийн жагсаалт

### 7.1.5 Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудит

ШУТИС-ийн захирлын 2021.12.21-ны А/241 тоот “чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийх тухай” тушаалын дагуу 2021.01.12-14-ий хооронд ШУТИС-ийн нийт бүрэлдэхүүн сургууль, захиргааны 14 нэгжүүдийг хамруулан анхны дотоод аудитыг амжилттай зохион байгуулсан. Тус дотоод аудит нь дараах үе шаттайгаар хэрэгжсэн байна.



Зураг 7.10. ЧМТ-ны дотоод аудитыг хэрэгжүүлсэн үе шат





Дотоод аудитын багийг ЧХШҮА-ны дарга Э.Халиун удирдан ажилласан ба багийн гишүүдийг 5 дэд багт хуваарилан зохион байгуулсан. Дотоод аудитын багийн бүрэлдэхүүнд ШУТИС-ийн багш, ажилтнаас бүрдсэн нийт 26 аудитор, гадны байгууллагын мэргэшсэн 4 аудитортай нийт 30 хүн орсон байна. Үүнд:

I баг	II баг	III баг	IV баг	V баг
<ul style="list-style-type: none"> <li>• Э.Халиун (Ахлагч, ЧХШҮА)</li> <li>• Б.Батхишиг (Гишүүн, ЧМ ГУУС)</li> <li>• Ц.Булган (Гишүүн, ЧМ ДаТС)</li> <li>• Ч.Алдармаа (Гишүүн, ХШУС)</li> <li>• Б.Санжидмаа (Гишүүн, ЧХШҮА)</li> <li>• Э.Энхтүвшин (Гишүүн, ШУТГНС)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Г.Нямсүрэн (Ахлагч, ЧМ МХТС)</li> <li>• Ц.Балжинням (Гишүүн, ЧМ ХШУС)</li> <li>• С.Бархас (Гишүүн, ГХС)</li> <li>• Ө.Оюунхүү (Гишүүн, Коосэн ТК)</li> <li>• С.Янжинлхам (Гишүүн, МехТС)</li> <li>• М.Зулбаяр (Гишүүн, ЭШИГ)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Д.Өнөрсайхан (Ахлагч, ЧМ МехТС)</li> <li>• Д.Наранцацрал (Гишүүн, ЧМ БУХС)</li> <li>• Э.Оюунзаяа (Гишүүн, ЧМ БАС)</li> <li>• Ш.Даваахүү (Гишүүн, ЭХС)</li> <li>• Ш.Цэнгэл (Гишүүн, СНББА)</li> <li>• А.Ариунболд (Гишүүн, БУХС)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Д.Туяа (Ахлагч, ЧМ ГХС)</li> <li>• М.Ганхүлэг (Гишүүн, ЧМ ЭХС)</li> <li>• Э.Баярмаа (Гишүүн, ЧМ ҮТС)</li> <li>• Д.Гэрэлт-Од (Гишүүн, СБЗГ)</li> <li>• С.Пүрэвдулам (Гишүүн, ЗХНГ)</li> <li>• Ж.Ганчимэг (Гишүүн, БАТС)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Д.Дуламсүрэн (Ахлагч- АМУ консалтинг ХХК)</li> <li>• Ц.Баттогтох (Гишүүн)</li> <li>• Э.Энхтуяа (Гишүүн)</li> <li>• Л.Шинэцэцэг (Гишүүн)</li> <li>• Б.Ариунзаяа (Гишүүн, МХТС)</li> <li>• Б.Ганбилэг (Гишүүн, ЧХШҮА)</li> </ul>

**Зураг 7.11. ШУТИС-ийн дотоод аудитын багийн бүрэлдэхүүн**

Дотоод аудитын үед ШУТИС-ийн нийт ажилтны 1/5 буюу 387 хүнтэй уулзаж арилцсан байна.





*Зураг 7.12. ШУТИС-ийн дотоод аудитын явц*

Дотоод аудитын дэд багууд 14 нэгжид хуваарилагдан ажиллахдаа нэгж тус бүрт урьдчилсан тайланг боловсруулж, танилцуулсан. Эдгээр урьдчилсан тайланд үндэслэн ШУТИС-ийн дотоод аудитын нэгдсэн тайланг гаргаж, ШУТИС-ийн захирлын зөвлөлд танилцуулсан болно.



*Зураг 7.13. ШУТИС-ийн дотоод аудитын тайланг захирлын зөвлөлд танилцуулсан нь*



Дотоод аудитын үр дүн:

Аудитын үр дүн: Т= тохирол, ҮТ= үл тохирол, АЗ= анхаарах зүйлс, СС= сайжруулах санал

Table with 12 columns (Standartын бүлэг, 4.1-4.4, 5.1-5.2, 5.3-5.4, 6.1-6.2, 6.3) and 10 rows (Standartын бүлэг, Үл тохирол, Анхаарах зүйл, Сайжруулах санал).

Зураг 7.14. Дотоод аудитын үр дүн

Дотоод аудитын үр дүнд ISO 21001 стандартын НИЙТ 136 шаардлагаас: Үл тохирол 2, Анхаарах зүйлс 17, Сайжруулах санал 13 гарсан байна. ШУТИС-ийн дотоод аудитын үр дүнгээс 78 төрлийн залруулах арга хэмжээг төлөвлөж, бүрэлдэхүүн нэгжүүдэд хүргүүлсэн ба нэгжүүд арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.


Left: Document cover of 'ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын үр дүнгээс залруулах арга хэмжээг авах тухай'. Right: Table of audit findings with columns for standard, corrective measures, dates, and status.

Зураг 7.15. ШУТИС-ийн дотоод аудитаар илэрсэн үл тохирлуудыг залруулах шийдвэр



### 7.1.6 Удирдлагын дүн шинжилгээний уулзалт

ШУТИС-ийн дээд удирдлагуудын дунд 2022.05 сард “Удирдлагын дүн шинжилгээний уулзалт”-ыг анх удаа зохион байгуулсан.

**БАТЛАВ:**  ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч Т.НАМНАН

**ШУТИС-ийн удирдлагын дүн шинжилгээний уулзалтын хөтөлбөр**

**Уулзалтын зорилго:** ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны гүйцэтгэлийг үнэлж, сургуулийн стратегийн чиглэл, зорилгод нийцжээ, үр нөлөөтэй буй эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашдын өөрчлөлт, сайжруулалтыг тодорхойлоход оршино.


**Уулзалтын өгнөг:** 2022.04.16-ны өдөр 09:30-17:00 цаг


**Байршил:** Горм дэд давдлаагч полгогон

**Оролцогчид:** ШУТИС-ийн захирал, дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд

Удирдлагын дүн шинжилгээний оролт	Сэдэв	Илтгэх хугацаа	Илтгэгч
1. УДШ-НИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР-ийг танилцуулах	Оролцогчидод хурлын хөтөлбөр танилцуулна.	10 мин	Ц.Баатархүү ХШУЭ дэд захирал
2. УДШ-НИЙ ОРЛОЛУУД	Аюуны хурал тул хэлэлцэхгүй.		
a. Өмнөх УДШ-ий дагуу сайжруулсан ажлууд	2022 оны ШУТИС-ийн орчны шинжилгээ (SWOT, PESTLE) -ний тайлан	15 мин	Д.Бямбасурэн ХАТТ дарга
b. Байгууллагын төлөв байдал	2020, 2021 онд сонирхогч талуудаа ирсэн өргөдөл, гомдлын нэгтгэл, дүн шинжилгээний үр дүн	10 мин	Э.Халиун ЧХШУА дарга
c. Гүйцэтгэл	2020, 2021 онд авсан суралцаж, ажил олгогч, төгсөгийн сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ, дүн шинжилгээний үр дүн	15 мин	Д.Гэрэлт-Од СБЗГ дарга
2. Чанарын бодлого	ШУТИС-ийн чанарын бодлого, зорилт, түүний төлөвлөгөө ба биелэлт		
3. Үйл явцын гүйцэтгэл	Дүрэм, журмын өөрчлөлт, сайжруулалтын байдал	20 мин	Э.Халиун ЧХШУА дарга
4. Үл тохирол, зарлуулах арга хэмжээ	2020, 2021 онд гарсан үл тохирол, авсан арга хэмжээ, түүний үр нөлөөтэй байдлын талаарх тайлан		
5. Хяналт, хэмжээний үр дүн	2020, 2021 онд сургалтын хөтөлбөрийн хяналт, хэмжээний үр дүн.	15 мин	Д.Гэрэлт-Од СБЗГ дарга

	иларсан үл тохирол, авсан арга хэмжээ		
	2020, 2021 онд эрдэм шинжилгээ, инновацийн ажлын хяналт, хэмжээний үр дүн, иларсан үл тохирол, авсан арга хэмжээ	15 мин	Т.Энхцэцэрлэг ЭШИГ дарга
6. Аудитын үр дүн	Хөндөгчийн байгууллагын аудитын үр дүн	15 мин	П.Баяр-Эрдэнэ СХОЭ дэд захирал
7. Гадны нийлүүлэгчийн гүйцэтгэл	2020, 2021 онуудад гэрээт байгууллагуудын гэрээний гүйцэтгэл, үнэлгээ	15 мин	Г.Жавхлан ХОХГ дарга
8. Суралцагчийн сургалтын өмнөх, дараах үнэлгээний үр дүн	Сүүлийн 3 жилийн суралцагчийн гомч дүн, шалгалтын үнэлгээний үр дүн	20 мин	Д.Батдорж СХБА дарга
d. Нөөцийн хангалттай байдал	2020, 2021 онуудад багц, ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа, түүнтэй холбоотой ажилтнуудаас ирсэн санал	15 мин	Г.Жавхлан ХОХГ дарга
e. Ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа, түүнтэй холбоотой ажилтнуудаас ирсэн санал	Хүний нөөц бүрдүүлэлт, шилжилт хөдөлгөөн ба төлөв байдал. Хүний нөөцийн сэтгэл ханамжийн үнэлгээ	20 мин	Ж.Арслан ЭХНГ дарга
f. Эрсдэл боломжийн дагуу авсан арга хэмжээ	2020, 2021 онуудад багц, ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа, түүнтэй холбоотой ажилтнуудаас ирсэн санал	15 мин	Э.Халиун ЧХШУА дарга
g. Тасралтгүй сайжруулах боломжууд	Сайжруулалтын төлөвлөгөөний санал	10 мин	Ц.Баатархүү ХШУЭ дэд захирал
	Бүрэлдэхүүн сургуулиудад тулгамдаж буй асуудал, түүнийг зарлуулах, сайжруулах санал	120 мин	Бүрэлдэхүүн сургуулийн захирлууд
	Хурлаас гарах шийдвэрийг хэлэлцэх	30 мин	Оролцогчид
	<b>Нийт</b>	6 цаг	24 хүн

Хинасан:  Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал Ц.Баатархүү

Боловсруулсан:  Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний албаны дарга Э.Халиун

Зураг 7.16. ШУТИС-ийн удирдлагын дүн шинжилгээний уулзалтын хөтөлбөр



Зураг 7.17. ШУТИС-ийн удирдлагын дүн шинжилгээний уулзалтын явц

Тус уулзалтаас гарсан дүн шинжилгээний үр дүнгээс цаашид авч хэрэгжүүлэх 25 арга хэмжээг төвлөж, холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн байна.



БАТЛАВ: ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ .....Т.НАМНАН



**ШУТИС-ийн УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

УДШ хийсэн огноо: 2022.05.10, 14:00-18:00

Оролцогчид: ШУТИС-ийн захирал, 5 дэд захирал, 9 бүрэлдэхүүн сургуулийн захирал, 5 газрын дарга, 2 албаны дарга нар.

№	УДШ оролт	УДШ гаралт / авах арга хэмжээ	Хэрэгцээт нөөц	Хариуцагч	Гүйцэтгэх огноо
1	Байгууллагын төлөв байдал	Судалгааны их сургуулийн чиг хандлага, SDG-2050-тэй үйлдүүлж бодлого төлөвлөлт, бизнес загварыг хөгжүүлэх	Мэдлэг	ХБТЭДЗ, ХХТГ	2023.01
2		ШУТИС-аар бахархах сэтгэгдэл, соёлыг төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах, дотоод нөөцийг ашиглан PR идэвхижүүлэх	Мэдлэг	ХБТЭДЗ, ХХТГ	2023.05
3		ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулж, сургалтын бус орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх	-	СХОЭДЗ, ХОХГ, ГХХАА, ЭШИГ, ХХТГ	2023.12
4	Суралцагч болон бусад үр шим хүртэгчдийн санал гомдол болоод сэтгэл ханамжийн үр дүн	Захиргаа болон бүрэлдэхүүн сургуулиадад өргөдөл, гомдлын бүртгэлийг давхардуулж бүртгэх асуудал гарч байгаа тул дундын өгөгдлийн санг үүсгэж, цахимаар бүртгэл хөтөлөлтийг хийдэг болох, тайлан мэдээг талуудад түгээх, мэдээлэх	Програм хангамж	ХШҮЭДЗ, ЧХШҮА	2023.04
5		Сургалт, оюутан хариуцсан нэгжүүд их тоотой гарч байгаа өргөдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийж, багасгах арга хэмжээг авах	Програм хангамж	СОАЭДЗ, СБЗГ	2023.12
6	Суралцагч болон бусад үр шим хүртэгчдийн санал гомдол болоод сэтгэл ханамжийн үр дүн	Сонирхогч талуудын (элсэгч, суралцагч, төгсөгч, ажил олгогч, багш ажилтан) сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг шинэчлэн, судалгааг авч, мэдээллийн сан үүсгэж, хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах. Сэтгэл ханамжийн үр дүнгийн график үзүүлэлтийг удирдлагуудад тогтмол харах, хянах боломжийг бүрдүүлэх	Програм хангамж	СОАЭДЗ, СБЗГ, ЧХШҮА	2022.12
7		Зөвлөх багшийн үйл ажиллагаатай холбогдох зааварчилгаа боловсруулж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх	Програм хангамж	СОАЭДЗ, СХБА	2022.12

Хуудас 1|4

**Зураг 7.18. ШУТИС-ийн удирдлагын дүн шинжилгээний уулзалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө**

ШУТИС-д менежментийн тогтолцооны олон улсын стандартыг хэрэгжүүлж буй нөхцөл байдлыг стандартын шаардлагын бүлгээр үнэлэхэд дараах үр дүн гарч байна.

**Гарааны нөхцөл /2018.06/**



**Одоогийн нөхцөл /2022.06/**




**Зураг 7.19. ШУТИС-д менежментийн тогтолцооны олон улсын стандартыг хэрэгжүүлсэн үнэлгээ**



## 7.2 “ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ”

Боловсрол шинжлэх ухааны яам, Сингапурын Темасек сан, Политехникийн их сургуультай ШУТИС хамтран "Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд "Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо" хөтөлбөрийн 5 багц сургалтад 2020.11-2021.10 сар хүртэлх хугацаанд хамрагдаж, 2021.11-2022.02 сарын хооронд мастер багшаар бэлтгэгдсэн. Одоогоор "Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын гарын авлага" боловсруулалтад оролцон ажиллаж байна.



Зураг 7.20. Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын доорх 5 үндсэн чиглэл





## 7.2 ДОТООД ХЯНАЛТ

### 7.2.1 БУХС-ийн 2019-2020 оны сургалтын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийв.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын цагийн тооцооны үйл явцад хяналт шинжилгээг 2018 оноос хийж байна. Тус хичээлийн жилд БУХС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн доктор, магистр, бакалаврын ангийн хичээлийн хуваарийг сургалтын төлөвлөгөөтэй тулган, багш нарын А болон Б цагийн тооцоо, санхүүгийн баримт зэргийг “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх” журмын дагуу шалгаж тайлан боловсруулав.

#### Хяналт шинжилгээний үр дүн

Хүснэгт 7.1

№	Алдаа, зөрчлийн төрөл	БУХС	
		Илүү олгосон мөнгөн дүн	Дутуу олгосон мөнгөн дүн
1	Багшийн ноогдол илүү, дутуу тогтоосон.	-315'485	+749'670
2	Дипломын комисс, зөвлөх, шүүмж, нарийн бичиг, дүн тулгалт	-10'944	
3	Илүү олгосон кредит	-866'700	
4	Суутгал илүү, дутуу хийсэн.	-661'045	+365'670
5	Нэг кредитийн үнэлгээ буруу тогтоосон.	-790'448	+30'096
6	Амралтын цалин буруу олгосон.	-225'230	
<b>Нийт</b>		<b>2'869'852</b>	<b>+1'145'436</b>

#### Зөрчлийн шалтгаан:

- Багшийн кредитийн гүйцэтгэлийн тооцоог хянаагүй баталгаажуулсан.
- Өвчтэй, чөлөөтэй байсан профессор багш нарын А, Б цагийн кредитийн ноогдлыг буруу тогтоосон.
- Журмын заалтыг буруу ойлгосноос Б цагийн суутгал илүү авсан.
- Гадны гэрээт багшийн нэг кредитийн үнэлгээг буруу бодож илүү, дутуу олгосон.
- Илүү цагийн кредитийг буруу олгосноос мөн өвөл, зуны сургалтын цалинг оруулж тооцсоноос амралтын цалин буруу бодогдсон.

ЭХС, БАС, БУХС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн багш нарын цагийн тооцооны зөрчил арилгах тухай ШУТИС-ийн захирлын тушаал 2022.04 сард гарсан.

### 7.2.2 ШУТИС-ийн 2021, 2022 оны эхний хагас жилийн хугацааны ил тод байдлын хууль эрх зүйн актын хэрэгжилтийг гаргаж, хяналт шинжилгээ хийсэн

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, ШУТИС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журамыг баримтлан сургуулийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг тодорхойлсон хууль эрх зүйн актуудыг судлан үзэж, <https://must.edu.mn/mn/> цахим хуудас болон бүрэлдэхүүн 12 сургуулийн цахим хуудсыг хянан үзсэн.

Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг тодорхойлсон хууль эрх зүйн актуудыг хянан үзэж, шалгуур үзүүлэлтийг бэлтгэж, үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт /төсөв санхүү худалдан авах үйл ажиллагаа/-ны ил тод байдал гэсэн агуулгын хүрээнд хууль эрх зүйн актын хэрэгжилтийг гаргаж, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн.



Ил тод нээлттэй байдлыг тодорхойлсон 5 хууль эрх зүйн актын хэрэгжилтийг дундаж 76.5 % В буюу тодорхой үр дүнд хүрсэн хэрэгжих шатанд /шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай/ гэж үнэлж байна. Ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх явцад ил тод нээлттэй байдлыг хангах үйл ажиллагаанд тодорхой зөрчил дутагдал илэрч байх тул зөрчил дутагдлыг арилгахад анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.

#### **Санал зөвлөмж:**

Сургуулийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын түвшнийг дээшлүүлэх, нээлттэй байдлыг тодорхойлсон эрх зүйн актуудын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор дараах санал, зөвлөмжийг өгч байна. Сургуулийн цахим хуудсанд ил тод гэсэн цэс үүсгэж, үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүү худалдан авалтын чиглэлээр дэд цэс үүсгэж, холбогдох мэдээллийг ил тод мэдээлэх. Үүнд:

- ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулиуд цахим хуудсандаа стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн мэдээлэх
- БУХС, МХТС, ЭХС, ШУТИС харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Коосэн технологийн коллежийн цахим хуудсандаа бүтэц зохион байгуулалтыг мэдээлэх
- Хяналт шинжилгээний алба, Дотоод аудитын алба ажлын төлөвлөгөө болон хийж гүйцэтгэсэн хяналт шалгалт, хяналт -шинжилгээ үнэлгээний тайланг мэдээлэх.
- ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулийн цахим хуудсанд хүчингүй болон энд тэнд давхцуулж байршуулсан, дүрэм журмын мэдээллийг цэгцлэх, үйл ажиллагаандаа мөрдөх Монгол улсын хууль, тогтоомж Засгийн газрын шийдвэр бусад эрх зүйн актыг байршуулах
- ШУТИС, бүрэлдэхүүн сургуулиуд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг гаргаж, мэдээлэх.
- ШУТИС-ийн хэмжээнд эзэмшиж байгаа газрын жагсаалт, эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийг мэдээлэх
- ШУТИС-д хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журамтай болох
- Сул орон тооны мэдээлэл болон хүний нөөцийн удирдлагын ил бод байдлыг хангах чиглэлээр авах хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлэх
- БУХС, ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Коосэн технологийн коллеж цахим хуудсандаа шилэн дансны бие даасан цэс, шилэн дансны баннер байршуулах.
- Шилэн дансны мэдээлэл өгөх захирал ахлах нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлэх
- ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулиуд шилэн дансны тухай хуульд заасны холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулах

#### **7.2.3 ШУТИС-ийн захирлын тушаалаар шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.**

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Захирлын 2022.04.04-ний өдрийн А/101 тоот тушаалаар батлагдсан Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч ажиллалаа.

### 7.3 Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, захиргаа, санхүүгийн үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод нээлттэй явуулах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 72 удирдах албан тушаалтанд "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг" сэдэвт сургалтыг 2022.01.14-ний өдөр цахимаар зохион байгуулсан. ШУТИС-ийн удирдах албан тушаалд 2022 оны 2-р сарын 1-ний өдрөөс хойш томилогдсон 10 албан тушаалтанд ЭБАТ-ийн зүгээс зохих заавар зөвлөгөөг өгч, мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага болон хууль тогтоомжийн гарын авлагыг тараав.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвөөс зохион байгуулсан сургалтад Соёмбо клубийн 5 оюутныг хамруулав. Эдгээр оюутнууд "Авлигын тухай ойлголт шалтгаан хор хөнөөл" сэдвийн хүрээнд бусад суралцагчдад мэдээлэл хүргэхээр төлөвлөж, сургалтын материалыг бэлтгэсэн болно.



*Зураг 7.21. Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдсан Соёмбо клубийн оюутнууд*

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон ШУТИС-ийн 2016-2021 онуудад авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2022.03.22-нд Монголын их дээд сургуулиудын консорциумд хүргүүлэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэний төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах зорилгыг дэвшүүлсэн. Тус зорилгын хүрээнд ШУТИС-ийн S.SS115 кодтой 3 кредитийн Хүний хөгжил хичээлийн хөтөлбөрт авлигал ба эрх зүйн бусад асуудал асуудлууд сэдвээр лекц, шударга ёсны асуудлууд сэдвээр семинарын хичээл орохоор туссан. Хүний хөгжил хичээлийг 2021/2022 оны хичээлийн жилийн намрын улиралд **443** оюутан, хаврын улиралд **333** оюутан сонгон суралцаж, авлигын тухай ойлголт, түүний хор хөнөөл, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зохицуулалтыг судалсан байна.

#### 7.3.1 Мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн ажил

ШУТИС-д 2022 онд шинээр удирдах албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **10** нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/, материалыг АТГ-аар хянуулах ажлыг зохион байгуулж, холбогдох дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж, томилогдсоноос хойш хуулийн хугацаанд багтаан дээрх албан тушаалтнуудын 2021 оны ХАСХОМ-ыг гаргуулах ажлыг зохион байгуулсан. ШУТИС-ийн хэмжээнд 2021



оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг 2022.01.08-ны өдөр гарган Боловсрол, Шинжлэх Ухаан Яаманд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тайлант жилийн 02.15-ны дотор /хуулийн хугацаанд/ сургуулийн мэдүүлэг гаргагч 72 албан тушаалтнуудын 2021 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргаж, мэдүүлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан. Улмаар хуулийн хугацаанд багтааж 2021 оны мэдэгдэл, мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайланг гарган Боловсрол, Шинжлэх Ухааны Яаманд хүргүүлсэн. 2021 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргаагүй, хууль зөрчсөн асуудал гараагүй. 2022.06.01-ний өдрийн байдлаар хяналт шалгалт хийх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, гэрээ хэлцэл байгуулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон ажилтан ажилчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх 90 мэдэгдлийг сургуулийн ЭБАТ-д хүлээн авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүртгэсэн. 2022 оны ЭБАТ-ын бүртгэлүүд цаасан болон цахим системийн бүртгэлүүд бүрэн хийгдсэн болно.

#### 7.4 МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба нь 2021-2022 оны хичээлийн жилд их сургуулийн сургалт судалгааны ажлын явц, үр дүнг олон нийтэд танилцуулан сурталчлах, байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны хамрах хүрээг тэлэх, байнгын болон зорилтот хэрэглэгчийг сэдэлжүүлэх зорилго дэвшүүлэн ажиллалаа.


2021-2022 оны хичээлийн жилд ШУТИС-ийн үйл ажиллагааны давуу талыг таниулах, нэр хүндийг өсгөх, тодорхой имижийг бүрдүүлэх зорилгоор телевизийн цаг үеийн мэдээ, мэдээлэл 17, телевизийн ярилцлагын нэвтрүүлэг 6, сонин, сэтгүүлийн ярилцлага 3, веб, сайтын мэдээлэл 142, радиогийн цуврал нэвтрүүлэг 9, социал сурталчилгаа (постер, инфографик 94, шинэчилсэн постер 115, live 12, видео контент 53, видео танилцуулга 5, оюутнуудын контент 19, twitter 36, instagramm пост 110, YouTube бичлэг 124) SCIENCE 94.1 фм радиогийн нэвтрүүлэг 74, мэргэжил танилцуулах булан 147, мэргэжил танилцуулах цахим уулзалт семинар 2, “ШУТИС-ТУР” мэргэжил танилцуулах уулзалт семинар 15, мэргэжил танилцуулах үзэсгэлэн яармагт 2 удаа оролцож нийт 1003 контент гүйцэтгэсэн байна.

#### ШУТИС-ийг сурталчлах үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажлууд

Хүснэгт 7.2

Чиглэл	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
Телевизийн мэдээ, мэдээлэл	91	53	15	17
Телевизийн ярилцлага нэвтрүүлэг	3	0	24	6
Сонин сэтгүүлийн ярилцлага	3	11	12	3
Сайтын мэдээлэл	0	15	9	142
Телевизийн цуврал нэвтрүүлэг	13	20	0	
Радиогийн нэвтрүүлэг	0	24	21	9
Подкаст	0	62	21	
Шууд дамжуулалт	0	0	16	3
Социал контент	0	131	250	568
ФМ 94.1 радиогийн нэвтрүүлэг				74
ФМ 94.1 радиогийн мэргэжил сурталчлах булан				147
Цахим уулзалт				2

"ШУТИС-ТУР" танилцах аялал				15
Мэргэжил сурталчлах үзэсгэлэн яармаг				2
Зохион байгуулсан сургалт				15
<b>Нийт</b>	<b>110</b>	<b>316</b>	<b>368</b>	<b>1003</b>



Зураг 7.22. Үйл ажиллагааны үзүүлэлт

### 7.4.1 Мэргэжил сурталчлах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба нь элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, их сургуулийн үйл ажиллагааг сурталчлах, бүх шатны сургалтын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор үндсэн 5 чиглэлээр үйл ажиллагаа явууллаа.

1. “ШУТИС-ТУР” зохион байгуулах
2. “Боловсролын үзэсгэлэн яармаг” оролцох
3. “ШУТИС-ийн мэргэжил сурталчлах өдөрлөг”:
4. “Цахим уулзалт семинар” зохион байгуулах
5. “Цахим контент” хөгжүүлэх

**“ШУТИС-ТУР” арга хэмжээ:** “ШУТИС ТУР” уламжлалт арга хэмжээг 15 удаа зохион байгуулсан. Тус аялын зорилго нь их сургуулийн орчин үеийн сургалт, судалгааны орчныг сурагчдад танилцуулах, их сургуулийн хичээлийн явцтай биечлэн танилцах, хичээлд оролцож үзэх боломжийг бүрдүүлэх, суралцах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, улмаар инженер, технологийн мэргэжил сонгож ШУТИС-д суралцах хүсэл сонирхлыг төрүүлэх, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх юм.

“ШУТИС-ТУР” танилцах аялалд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 546 сурагч, багш, эцэг эхийн төлөөллийн хамт оролцсон байна.

### “ШУТИС-ТУР” танилцах аялалд оролцсон байдал

Хүснэгт 7.3

№	Сургууль	Огноо	Сурагчийн тоо	Танилцсан сургууль, нэгж
1	Шинэ Эрин олон улсын сургууль	22-12-08	20	ХШУС
2	Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв	22-12-22	30	ЭХС, ГУУС
3	НЕБ-ийн 7 дугаар сургууль	22-3-29	25	ГУУС, ХШУС
4	СБД-ийн 11 дүгээр сургууль	22-4-08	38	БАС, ЭХС
5	БГД-ийн “СЭТГЭМЖ” цогцолбор сургууль	22-3-28	59	БАС, ЭХС
6	133-р сургууль	22-4-15	80	БАС, МХТС, ХШУС
7	НЕБ-ын 50 дугаар дунд сургууль	22-5-12	50	ГХС, БУХС, БАС, ҮТС, ХШУС, ГХС
8	“Логарифм” бүрэн дунд сургууль	22-5-12	40	ГХС, БУХС, БАС, ҮТС, ХШУС, ГХС
9	БГД-ийн “СЭТГЭМЖ” цогцолбор сургууль	22-3-28	59	ЭХС, ХШУС, БАС
10	“Монгол билэг оюун” сургууль	22-4-04	20	ОСҮА, БАС, ҮТС, ГУУС
11	“Оюунлаг” сургууль	22-4-05	20	ОСҮА, БАС, ҮТС, ГУУС
12	84-р сургууль	22-4-18	25	ОСҮА, БАС, ҮТС, ГУУС
13	Дархан-Уул аймаг, 19 сургууль	22-3-05	25	ГУУС
14	24-р сургуулийн сургууль	22-5-03	30	ГХС, БУХС, БАС, ҮТС, ХШУС, ГХС
15	Жаргалан сургууль	22-5-05	25	
			<b>546</b>	

“ШУТИС-ТУР” танилцах аялалд оролцсон ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдаас мэргэжил сонголт хэрхэн хийх талаар судалгаа авсан болно.



Зураг 7.23. “ШУТИС-ТУР” танилцах аялалд оролцсон ЕБС-ийн төгсөх ангийн сурагчид



**ХӨТӨЛБӨР**

	СЭДЭВ	Байршил
12:00-12:20	ШУТИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн танилцуулга Х.Отгон-Эрдэнэ, МОНХА-ны дарга, доктор, дэд профессор	ШУТТНС-гийн 6 давхарт Хурлын танхим
12:20-12:40	ХШУС-ийн бакалаврын мэргэжлийн танилцуулга ШУТИС-ийн ХШУС-ийн дэд захирал Б.Тунгалагтамир, доктор, дэд профессор (88116045)	ШУТТНС-гийн 6 давхарт Хурлын танхим
12:40-13:00	ЭХС-ийн бакалаврын мэргэжлийн танилцуулга ШУТИС-ийн ЭХС-ийн дэд захирал Ч.Улам-Оргил, доктор, дэд профессор (99108471)	ШУТТНС-гийн 6 давхарт Хурлын танхим
13:00-13:10	Шинжлэх ухаан, технологийн төв номын сангийн танилцуулга Э.Энхтүвшин, ШУТТНС-ийн мэргэжилтэн, (99270127)	ШУТТНС-гийн байр
13:10-14:10	ШУТИС-ийн БАС-ийн Хүрээлэн буй орчин, инженерийн салбарын лабораторийн танилцуулга БАС-ийн ХБОИС-ын зөвлөх профессор С.Чулуунхуяа (99106743) БАС-ийн ХБОИС-ын оюутнууд	ШУТИС-ийн 2 дугаар байр 207 тоот ШУТИС-ийн 2 дугаар байр 101 лаборатори ШУТИС-ийн 2 дугаар байр 102 лаборатори
14:10-14:50	"Шинжлэх ухааны гайхамшиг музей" үзэх Д.Соджаргал, Музейн ажилтан (86171787)	ШУТИС-ийн VIII байрны 10-11 давхар
14:50-15:00	"ШУТИС-ТУР" дурсгалын зураг Бүх оролцогчид	ШУТТНС-гийн 1 байр


Холбоо барих утас: 99247798 (Х.Отгон-Эрдэнэ), 89007983 (ЕБС-ийн багш Ц.Бямбажав)  
 ШУТИС-ийн вэб хуудас: [must.edu.mn](http://must.edu.mn)  
 ШУТИС-ийн онлайн бүртгэлийн хуудас: [www.elseft.edu.mn](http://www.elseft.edu.mn)  
 ШУТИС-ийн пэйж хуудас, facebook хаяг: Шинжлэх ухаан, технологийн их сургууль




Зураг 7.24. “ШУТИС-ТУР” аялал, хөтөлбөр

“Боловсролын үзэсгэлэн яармаг”: “Боловсролын шинэчлэл” үзэсгэлэн яармагт 2022 оны 4 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулагдсан. “Боловсролын шинэчлэл-2022” үзэсгэлэнд ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, эцэг, эх, багш нар оролцон Монгол улсын их дээд сургуулиудын сургалтын үйл ажиллагаа, нийгэмд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлүүдийн талаар мэдээлэл авсан. Тус үзэсгэлэнд ШУТИС нь “SMART MUST” уриатай оролцон, элсэгчдэд зориулсан гар утасны апплейкешен хэрэглэх заавар, ШУТИС-ийн сургалтын хөтөлбөр, хамтарсан хөтөлбөр, оюутны тэтгэлэгт хөтөлбөр, элсэлтийн бүртгэлийн шаардлагатай заавруудын талаар танилцуулан, олон нийтэд дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл өгсөн.





Зураг 7.25. “Боловсролын үзэгсэлэн яармаг”



Зураг 7.26. Элсэлтийн тоон үзүүлэлт

“ШУТИС-ийн мэргэжил сурталчлах өдөрлөг”:

Өмнөговь аймгийн Даланзадгад хотноо 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр ШУТИС-ийн сургалт, судалгаа, инновацийн ажлын үр дүнг танилцуулах өдөрлөг зохион байгуулагдсан. Тус өдөрлөгт ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулиуд, ШУТИС-Коосэн технологийн коллеж, Ерөнхий боловсролын ахлах сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт судалгааны төвийн төлөөлөл нийт 70 гаруй эрдэмтэн, багш нар оролцож олон нийтэд сургалт, судалгаа, инновацийн ажлын үр дүн болох 300-гаад бүтээлийг танилцуулав. ШУТИС-ийн мэргэжил сурталчлах өдөрлөг нь хөдөө орон нутагт суралцаж буй сурагчдад их сургуулийн сургалтын хөтөлбөрүүдтэй танилцах, ирээдүйн мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх боломж, бололцоог нээж өгч байгаагаараа онцлог юм.

ШУТИС-ийн мэргэжил сурталчлах өдөрлөгт Монгол Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Өмнөговь аймгийн удирдлагууд, ШУТИС-ийн захирал Т.Намнан болон бусад албаны төлөөллүүд оролцсон.





Зураг 7.27. “ШУТИС-ийн мэргэжил сурталчлах өдөрлөг”

Тус арга хэмжээнд МОНХАЛба нь видео сурталчилгааны контент бэлтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллав.

“Цахим уулзалт семинар” зохион байгуулах:

Дундговь аймгийн боловсрол шинжлэх ухааны газраас зохион байгуулсан Дундговь аймгийн 12-р ангийн төгсөгч, багш, эцэг эхчүүдэд мэргэжил сонгох, их сургуулийн элсэлт, бүртгэл, тэтгэлгийн талаар танилцуулах зорилготой “Дундговь Боловсрол Экспо 2022” арга хэмжээнд оролцож ШУТИС-ийн элсэлтийн мэдээллийг танилцуулсан. Говь-Алтай аймгийн Насан туршийн боловсролын төв нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын хүрээнд Монголын шилдэг 10 их дээд сургуулийг танилцуулах үйл ажиллагааг Ерөнхий боловсролын сургуулийн 10-аас 12 дугаар ангийн сурагчдад зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд цахимаар оролцсон болно.

Цахим контент хөгжүүлэх: ШУТИС-ийн сургалтын хөтөлбөр, оюутанд үзүүлэх үйлчилгээ, сургалтын орчин нөхцөлийн талаар хэрэглэгч, олон нийтэд мэдээлэл өгөх зорилготойгоор сурталчилгааны контентыг цахим сургалт, шинээр нээгдэж буй мэргэжил, сургалтын орчин, цахим төгсөлтийн талаар нийт 16 лайв, оюутан залуусын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, суралцаж буй мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх зорилготой “My Way” сэдэвт видео контентын уралдааны хүрээнд нийт 19 видео, сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн талаар 5 видео, бүрэлдэхүүн сургуулийн салбарын эрхлэгч нарыг оролцуулсан мэргэжил танилцуулах видео 29, ШУТИС-ийн хичээлийн I, II, T-байр, VIII, ШУТТНС-гийн байрны 5 виртуал танилцуулга, ХНХЯ-ны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн ХАБЭА-н газрын дарга Г.Нямдэжидийг оролцуулан 1 видео бичлэг нийт 75 видео бичлэг хийж ШУТИС-ийн албан ёсны YouTube суваг дээр байршуулсан байна.

## Цахим контент хөгжүүлэлт

Хүснэгт 7.4

№	Арга хэмжээ	Видео контент	Тоо	Нийт хугацаа
1	Боловсролын шинэчлэл-2022	Ярилцлагын лайв	4	64
2	Монгол инженер-2022	Видео контент	2	6
3	ШУТИС-ТУР-2022	Ярилцлагын лайв	2	10
4	Ректорын нэрэмжит тэтгэлэг	Ярилцлагын лайв	3	15
5	Өмнөговь Даланзадгад	Ярилцлагын лайв	4	56
6	Ахлах сургуулийн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн-2022"	Ярилцлагын лайв	2	40
7	"Sharks" багийн тоглолт-2022	Ярилцлагын лайв	6	102
8	Элсэлт-2022	Ярилцлагын лайв	1	75
	<b>НИЙТ</b>		<b>24</b>	



Зураг 7.28. ШУТИС-ийн YOUTUBE видео сувагт байршуулсан зарим нэвтрүүлэг

#### 7.4.2 Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр (сонин, телевиз, сайт г.м) дамжуулан сурталчлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 тоот тогтоол гарсантай холбогдуулан хэвлэлийн мэдээллийн зардал төсвийг хэмнэх, хамтын ажиллагааны хүрээнд төлбөрийг бууруулах чиглэл баримтлан ажилласан болно.

Нийт бэлтгэсэн телевизийн мэдээ 15 мэдээ (EAGLE TV, NTV, MYONPT), телевизийн ярилцлагын нэвтрүүлэг 6, сайтын мэдээлэл 2 бэлтгэн хүргэсэн байна.



### Телевизийн мэдээний жагсаалт

Хүснэгт 7.5

№	Суваг	Огноо	Агуулга	Байгууллага
1.	NTV	21/IX-21	Нийгмийн инноваци, түншлэл үндэсний форумын мэдээлэл	ШУТИС, БуХС
2.	MGL	21/10/12	ШУТИС эчнээ сургалтын элсэлтийн мэдээлэл	ШУТИС
3.	EAGLE	21/11/30	БуХС-ийн профессор Б.Батхүрэл багшийн нэрэмжит магистр, докторын ЭШХ-ын мэдээ	ШУТИС, БуХС
4.	EAGLE	21/12/24	Ашигт малтмалын талаарх ЭШХ-ын мэдээ	ШУТИС, ГУУС
5.	EAGLE	22/1/31	Эрдмийн баярын мэдээ, мэдээлэл	ШУТИС, Захиргаа
6.	EAGLE	22/2/1	Эрдмийн баярын мэдээ, мэдээлэл	ШУТИС Захиргаа
7.	NTV	22/3/28	Барилга байгууламжийн геотехникийн хурлын мэдээлэл	ШУТИС БАС
8.	TV-6	22/3/28	Барилга байгууламжийн геотехникийн хурлын мэдээлэл	ШУТИС БАС
9.	EAGLE	22/3/28	Магистр, докторын судалгааны танхимын нээлт хийв.	ШУТИС, БАС
10.	EAGLE	22/5/12	УРЛАХУЙН ЕРТӨНЦ-2022 хувцас загварын наадам	ШУТИС, ҮТС
11.	EAGLE	22/5/13	Ахлах сургуулийн хүүхдүүд бүтээлээрээ үзэсгэлэн гаргасан тухай	ШУТИС, Ахлах сургууль
12.	EAGLE	22/5/20	Инновацийн долоо хоног эрдэм шинжилгээний бага хурлын мэдээлэл	ШУТИС Захиргаа
13.	EAGLE	22/6/20	ШУТИС-ийн диплом гардуулах ёслолын ажиллагааны мэдээлэл	ШУТИС Захиргаа
14.	TV-9			
15.	TV-6			

### Ярилцлага, нэвтрүүлэг

Хүснэгт 7.6

№	Огноо	Суваг	Сэдэв	Цаг	Албан тушаал	Нэр
1	VI.16	EAGLE	2022-2023 оны элсэлт	30 минут, цацалтын цаг 16:00, давталт 10:30	СХБА-ны дарга	Д.Батдорж
2	VI.17	EAGLE	2022-2023 оны элсэлт	30 минут, цацалтын цаг 16:00, давталт 10:30	БУХС-ийн захирал	А.Энхбат
3	VI.20	EAGLE	2022-2023 оны элсэлт	30 минут, цацалтын цаг 16:00, давталт 10:30	ГУУС-ийн захирал БАС-ийн захирал	К.Хавалболот Б.Нарантуяа
4	VI.22	EAGLE	2022-2023 оны элсэлт	30 минут, цацалтын цаг 16:00, давталт 10:30	МТС-ийн захирал ЭХС-ийн захирал	Ж.Хашбат Б.Бат-Эрдэнэ
5	VI.24	EAGLE	2022-2023 оны элсэлт	30 минут, цацалтын цаг 16:00, давталт 10:30	ҮТС-ийн захирал	Ж.Туяацэцэг
6	VI.29	EAGLE	2022-2023 оны элсэлт	30 минут, цацалтын цаг 16:00, давталт 10:30	ХШУС-ийн захирал ГХС-ийн захирал	В.Өлзийбаяр Ц.Энхбаатар



### МҮОНР-гийн цуврал нэвтрүүлгүүд

Хүснэгт 7.7

№	Сувар	Нэвтрүүлэг		Огноо	Оролцогч
1	МҮОНР	“Боловсрол” нэвтрүүлэг	Үр дүнд суурилсан боловсрол	2021-09-15	НБТ-ийн лабораторийн эрхлэгч О.Ариунболор
2	МҮОНР	“Боловсрол” нэвтрүүлэг	Үүлэн технологид суурилсан чиг хандлага ба давуу тал	2021-10-4	МХТС-ийн профессор Б.Зоригтхүү
3	МҮОНР	“Боловсрол” нэвтрүүлэг	Боловсролын хос хөтөлбөрийн загварууд, ахлах сургууль болоод их сургуулийн залгамж холбоог бий болгохын давуу тал	2021-10-11	ШУТИС-ийн Ахлах сургуулийн захирал Д.Буянтогтох
4	МҮОНР	“Хүн гараг” нэвтрүүлэг	“Гэгээн тэргэл өдрүүд” хөрөг найруулал	2021-10-26	ШУТИС-ийн БАС-ийн зөвлөх профессор, Академич Д.Дашжамц
5	МҮОНР	Хөрөг найруулал	“Уулсын цараа холын бараатай” хөрөг найруулал	2021-12-14	ШУТИС-ийн МХТС-ийн зөвлөх профессор О.Балдангомбо
6	МҮОНР	Хөрөг найруулал	"Он цагийн орчил" хөрөг найруулал	2021-12-28	ШУТИС-ийн ГХС-ийн профессор Г.Томтогтох
7	МҮОНР	Хөрөг найруулал	“Ханашгүй хөх орчлон” хөрөг найруулал	2022-1-11	ШУТИС-ийн ГУУС-ийн профессор Д.Чулуун
8	МҮОНР	Хөрөг найруулал	“Шувууд сүрэглэх цаг” хөрөг найруулал	2022-3-1	ШУТИС-ийн ЭХС-ийн профессор Ч.Мангалжалав
9	МҮОНР	Хөрөг найруулал	“Айсуй цагийн анир”	2022-5-3	ШУТИС-ийн ГУУС-ийн профессор С.Жаргалан

#### 7.4.3 ШУТИС, МХТС-ийн “SCIENCE FM 94.1” ФМ радио

ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Маркетинг, олон нийттэй харилцах албаны хамт олон харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “SCIENCE 94.1” богино долгионы радиог ажиллуулж байна.

“SCIENCE 94.1” богино долгионы радио нь оюутан залуучуудад орчин үеийн шинжлэх ухаан, технологийн шинэ хандлага, ололт амжилтыг сурталчлан таниулах, бие биеэ хүндэтгэх, эх орон, эх дэлхий, эцэг эхээ хайрлах ухамсрыг төлөвшүүлэх, залуучуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах идэвхтэй иргэн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Тус радио нь Монгол улсын эрдэмтэн, судлаачид, ШУТИС-ийн профессор багш нарын сургалт, судалгааны ажлын үр, боловсролын салбарын шинэ мэдээ, мэдээллийг сонсогчдын сонорт хүргэх зорилготой.



**Нэвтрүүлгүүдийн товч танилцуулга:**

“Шинэ өглөө” мэдээ, мэдээллийн хөтөлбөрөөр эх орны үйл амьдрал, шинжлэх ухаан, боловсролын салбар, ШУТИС-ийн хүрээнд өрнөх үйл явдлын мэдээ, мэдээллийг олон нийтэд дамжуулна.

“Сайн уу, ШУТИС” мэдээ, мэдээллийн хөтөлбөрөөр ШУТИС-ийн хүрээнд өрнөх үйл явдлын мэдээ, мэдээллийг олон нийтэд дамжуулна.

“Tenure профессор” зохиомжит нэвтрүүлгээр эрдэмтэн, багш, судлаачид, намтар баян түүхийн эздийн амьдрал үйлс, өв уламжлал, эрдэм сургаал, туршлага сургамжийг хүргэнэ.

“Хандлагын хүч” зохиомжит нэвтрүүлгээр оюутан залуустай танин мэдэхүйн гүүр бол харилцааны соёл, хандлагын тухай ярилцах зорилготой. Тус нэвтрүүлэгт сэтгэл зүйчид, илтгэгчид, өөрийн байгууллагадаа хандлагын соёл нэвтрүүлж буй удирдлага, ажилтнуудыг урьж оролцуулна.

“Нэрийн хуудас” ярилцлагын нэвтрүүлгээр эх орондоо болон дэлхийд танигдаж бүтээлчээр амьдарч, амжилтын эзэд болж, үзэл хандлага, зорилго тэмүүлээрээ манлайлж яваа залуустай ярилцах зорилготой.

“ШУТИС-ийн SHARKS” ярилцлагын нэвтрүүлгээр амьдрал хувь тавилангийн замаа бүтээх эхлэл босгон дээр яваа оюутан залуусын сэтгэлийн нандин үг, алдаа оноо, амжилт бүтээл, туршлага мэдлэг, олж нээсэн шинэ содон амжилт, эерэг зөв хандлагыг хуваалцаж, дуу хуур, хайр мөрөөдөл, гэгээн нандин бүхнээ сэтгэл дэлгэн ярилцах нэвтрүүлэг.

“ШУТИС-ийн цаг” нэвтрүүлгээр ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын төлөөлөл оролцож, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны талаарх шинэ мэдлэг, мэдээллээ түгээнэ.

“Амжилтын түүх” нэвтрүүлгээр дэлхийн хүн зоны амжилт хэрхэн бүтсэн, ямар замаар явж, ямар бэрхшээл туулж энэ бүхнийг цогцлоосон талаарх цуврал.

“Номын ертөнцөөр” ярилцлагын эрдэмтэн судлаач, зохиолч, яруу найрагчидтай ярилцаж юм.

“English Time” радио цуврал хичээл нь оюутан суралцагчдад гадаад хэлний ярианы чадвараа сайжруулах, сэргээх, шинээр хэл сурахад дэмжлэг үзүүлэх зорилгоор англи хэлний үгийн дуудлага, мэргэжил сонголт, карьер хөгжил, англи хэлний олимпиад, олон улсын стандарт шалгалтад хэрхэн бэлтгэх, гадаадад суралцах тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж зэрэг сэдвээр оюутан, суралцагчдад мэдээлэл өглөө. Радио хичээлийн онцлог нь англи хэлээр ойлгомжтой, тодорхой байдлаар дугаар бүр өөр өөрийн онцлог бүхий харилцан яриа хэлбэртэй юм.



## “English Time” радио цуврал хичээл

Хүснэгт 7.9

№	Сэдэв	Бэлтгэсэн багш нар
1	English Time №1. <b>Welcome Speech and Introduction</b>	<i>Guest:</i> Scott Poteet (English Language Fellow, School of Foreign Languages, MUST)
2	English Time №2. <b>Pronunciation of English Words</b>	<i>Guest:</i> Scott Poteet (English Language Fellow, SFL, MUST)
3	English Time №3. <b>My Major</b>	<i>Guests:</i> Doctor E.Chimedlkham (Vice director, SFL, MUST), D.Oyuntuya (Student, School of Civil Engineering and Architecture, MUST) S.Chinguun (Student, School of Power Engineering, MUST) <i>Host:</i> D.Odonchimeg (Lecturer, SFL, MUST)
4	English Time №4. <b>Career Development</b>	<i>Guests:</i> Scott Poteet (English Language Fellow, SFL, MUST) G.Tugsbus (Student, School of Power Engineering, MUST) G.Enkhriimaa (Students, School of Industrial Technology, MUST) <i>Host:</i> B.Batsuuri (Student, School of Information and Telecommunication Technology, MUST)
5	English Time №5. <b>English Olympiad</b>	<i>Guests:</i> Scott Poteet (English Language Fellow, SFL, MUST) G.Tugsbus (Student, School of Power Engineering, MUST) G.Enkhriimaa (Students, School of Industrial Technology, MUST) <i>Host:</i> B.Batsuuri (Student, School of Information and Telecommunication Technology, MUST)
6	English Time №6. <b>International Exam</b>	<i>Guest:</i> J.Odbayar (Officer, English Academy of MUST) <i>Host:</i> E.Saruul (Lecturer, SFL, MUST)
7	English Time №7. <b>Learning English</b>	<i>Guests:</i> O.Munkjin (Student, School of Power Engineering, MUST) E.Bilguun (Student, School of Information and Telecommunication Technology, MUST) <i>Host:</i> B.Batsuuri (Student, School of Information and Telecommunication Technology, MUST)
8	English Time №8. <b>Scholarships and Online Courses (MOOC)</b>	<i>Guest:</i> T.Altantsetseg (English Language Coordinator, U.S. Embassy) <i>Host:</i> E.Saruul (Lecturer, SFL, MUST)
9	English Time №9. <b>Visas, Scholarships, and Job Interview Questions</b>	<i>Guest:</i> Scott Poteet (English Language Fellow, SFL, MUST)
10	English Time №10. <b>New Innovation and Technology</b>	<i>Guest:</i> Scott Poteet (English Language Fellow, SFL, MUST)



## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

---

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖ, САНХҮҮ  
БҮРТГЭЛ, ДОТООД АУДИТ, БАЙР АШИГЛАЛТ**





## НАЙМ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖ, САНХҮҮ БҮРТГЭЛ, ДОТООД АУДИТ, БАЙР АШИГЛАЛТ

### 8.1 ТӨСӨВ

Бүрэлдэхүүн сургуулиудаас ирүүлсэн төсвийн төслийг 2 үе шаттай хэлэлцэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Удирдах зөвлөлд батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

2022 оны төсвийн төсөөлөл, 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах төсөл арга хэмжээний санал болон урсгал зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээнд холбогдох маягтын дагуу санал боловсруулан илгээсэн.

ШУТИС-ийн хэмжээнд 2021 онд 3.9 тэрбум төгрөгийн 160 нэрийн, 2022 онд 4.2 тэр бум төгрөгийн 167 нэрийн худалдан авалтын төлөвлөгөөг удирдах зөвлөлөөр тус тус батлуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвлөлөөр оруулан хянуулж, хөрөнгө олж авах, худалдан авалт хийх зөвшөөрөл бүхий тогтоолуудыг батлуулсан.

**I. ШУТИС-ийн хэмжээнд худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцыг хянан шалгаж, баталгаажуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах**

Худалдан авах үйл ажиллагааг ил тод үнэн зөв явуулах үүднээс Худалдан авах ажиллагааны удирдах академи төрийн бус байгууллагатай 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хамтран ажиллах гэрээг дүгнэн сунгаж үнэлгээний хорооны үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө үйлчилгээ авч, хараат бус 2-оос доошгүй гишүүдийг тогтмол авч ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны цахим системд батлагдсан төлөвлөгөөг оруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яамаар батлуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. 2021-2022 оны хичээлийн жилд нийт 2,8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгийн санхүүжилтээр худалдан авсан байна.

### Худалдан авах ажиллагааны цахим системд батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн худалдан авалтууд

Хүснэгт 8.1

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, багцлалт	Батлагдсан төсөвт өртөг(мян.төг)	Гэрээний дүн (мян.төг)
<b>1. Цахимаар зарласан тендерийн мэдээлэл</b>			
1	Оюутны II байрны ажлын зураг хийлгэх	145,000.00	124,108.98
2	Хичээлийн III байрны дээвэр засвар /Полимер мембрн Пластфойл ЕСО материалаар /	79,000.00	77,792.35
3	Оюутны III байрны дээвэр засвар /Полимер мембрн Пластфойл ЕСО материалаар /	75,000.00	76,084.85
4	Хичээлийн I байрны нийтийн эзэмшлийн талбай үүдний хэсгийн засварын ажил	70,000.00	68,407.83
5	Үйлдвэрлэлийн технологийн сургуульд дизайны салбарт сургалтын тоног төхөөрөмж худалдан авах	60,000.00	57,310.00
6	Оюутны "Student Lounge" чөлөөт бүс байгуулах	60,000.00	59,541.95
7	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн сургалтын тоног төхөөрөмжийн шинэчлэл	50,000.00	49,418.22
8	Хичээлийн II байрны нийтийн эзэмшлийн талбай үүдний хэсгийн засварын ажил	50,000.00	49,073.31
9	Эрчим хүчний сургуульд ухаалаг сүлжээ хөтөлбөрийн лабораторийн төхөөрөмж авах	36,000.00	35,965.50



10	Эрчим хүчний сургуульд дулаан үйлдвэрлэлт лабораторийн төхөөрөмж авах	35,000.00	31,540.00
11	Барилга, Архитектурын Сургуулийн хичээлийн III байрны цахилгааны нөөц шугамын засвар	30,000.00	29,480.12
12	ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд ухаалаг ангид таблет худалдан авах	30,000.00	28,322.80
13	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн хичээлийн байрны төв хаалганы засвар	25,000.00	24,000.00
14	Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн компьютер,проектор, принтерийн худалдан авалт	35,400.00	31,284.00
15	Эрчим хүчний сургуулийн автомат удирдлагын онол автоматжуулалтын лаборатори өргөтгөх тоног төхөөрөмжийн худалдан авалт	39,100.00	38,500.00
16	Гадаад хэдний сургуулийн суурин болон зөөврийн компьютер, техник хэрэгслийн худалдан авалт	50,500.00	45,781.92
17	Эрчим хүчний сургуульд цахилгаан системийн шинжилгээ судалгааны лаборатори байгуулах	80,000.00	78,579.27
19	Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн Оюутны байранд ор худалдан авах (70) ш	40,000.00	34,650.00
20	Геотехникийн лабораторийн засварын ажил	98,575.00	95,152.54
21	Механик, тээврийн сургуулийн барилга, байгууламжийн засварын ажил /Хичээлийн 7 дугаар байрны дээврийн засварын ажил	201,599.50	195,526.64
22	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн компьютерын лабораториудад шинэчлэл хийх	270,000.00	244,126.30
23	Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн аж ахуйн барилгын дээврийн засварын ажил	50,000.00	49,165.94
24	Хичээлийн VII байрны цонх солих хэсэгчилсэн засварын ажлын	80,000.00	79,999.94
25	ШУТИС-ын төв шатны хонгилын засварын ажил	69,000.00	68,349.78
26	Геологи, уул уурхайн сургуулийн хичээлийн 2-р байрны 1-р давхрын 00 өрөөний засварын ажил	70,000.00	65,657.67
27	Хичээлийн I байрны 1-р давхрын хойд жигүүрийн ариун цэврийн өрөөг нэгтгэн засах засварын ажил	40,000.00	39,181.67
28	НБТ-ийн европын холбооны санхүүжилтээр төсөлд ашиглах тоног төхөөрөмж нийлүүлэх	107,000.00	92,875.20
29	Барилга, архитектурын сургуульд хэрэгжиж буй төсөлд батиметрийн (усны ёроол) хэмжилтийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах	79,300.00	79,300.00
30	Төв номын сангийн албан хэрэгцээнд болон үйлчилгээнд ашиглах зориулалтаар тоног төхөөрөмж нийлүүлэх	24,000.00	18,544.14
31	Ерөнхийлөгчийн бэлтгэл хөтөлбөрийн сургалт явуулахад багш нарт шаардлагатай зөөврийн компьютер нийлүүлэх	60,000.00	65,997.80
32	Оюутны 5 дугаар байрны 430 тоот өрөөний засварын ажлын гүйцэтгэгчийг ШУТИС/202202006	32,600.00	32,000.00
33	Хичээлийн 7 байрны цахилгааны хүчдэлийг тогтворжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж	50,000.00	49,676.00
34	"Севес Эх газрын эрс тэс уур амьсгалтай, нарлаг бүс дахь барилгын эрчим хүчний хэмнэлттэй хөтөлбөр боловруулах" төслийн хүрээнд сургалтын зориулалттай стэнд нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер	155,072.57	152,162.00
<b>2. Уламжлалтаар зарласан тендерийн мэдээлэл</b>			
1	ШУТИС-ийн Инженерийн Ахисан Түвшний сургуулийн Европын холбооны ICT төслийн нээлттэй лабораторийн тоног төхөөрөмж	27,605.00	27,605.00
2	ШУТИС-ийн Инженерийн Ахисан Түвшний сургуулийн Европын холбооны ICT төслийн нээлттэй лабораторийн тоног төхөөрөмж	57,682.70	57,682.70



3	ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн ухаалаг лекцийн танхимд тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ШУТИС/202102002-1	20,000.00	19,580.00
4	ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн цахим сургалтын танхимд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ШУТИС/202102020	24,110.00	26,082.56
НИЙТ		2,506,544.76	2,398,506.96

Барилга, байгууламж барих зөвшөөрөл, техникийн нөхцөлийг бүрдүүлэх, төслийн өмнөх шатны судалгаа, тооцооны ажлыг гүйцэтгэх, барилга байгууламжийн хүчин чадал, техник, технологийн сонголт хийх арга хэмжээг зохион байгуулах

2022 онд хийгдэх ЗТА-ын хүсэлт, төсвийн төслөөр хийх ажлын урьдчилсан нэгтгэлийг авч засварын ажил болон 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлуудын төсвийн төслийн нэгтгэлийг гаргаж, удирдлагад танилцуулсан.

ШУТИС-ийн 2023 оны төсвийн төсөл хэлэлцэхтэй холбогдон томилогдсон ажлын хэсэгт ажиллаж 8 бүрэлдэхүүн сургуулийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төсөлтэй газар дээр нь очиж танилцсан.

2022 оны төлөвлөгөөнд тусгагдах төв байрны гадна фасад, гонхны засварын ажлын төсвийг металл, чулуун, гантг цоколтой байх хувилбараар ажлын тоо хэмжээг боловсруулан, засварлах объектуудын албан хүсэлт аж ахуйн ажилтнуудтай хамтран даалгаврын дагуу газар дээр нь үзэж хэмжилт хийж засал тохижилтын 28 ш ажлын төсвийн ажлын тоо хэмжээг боловсруулан төсвийн мэргэжилтэнд тус тус өгсөн. 894.0 сая төгрөгийн төсөвтэй 15 ш төсөв зохиож, 2022 оны төсвийн төсөлд тусгагдсан боловч тодотголоор хасагдсан 6 ш төсөв 2021 оны 2-р хагаст 3 ш төсөв боловсруулсан. Дотоод нөөц бололцоогоороо хийх аж ахуйн 7 төсөв, 77,1 сая төгрөгийн өртөгтэй төсөв зохиов.

Хичээлийн 12-р байранд /МОНЭНЗМ/ байгуулах ГУУС-ийн Геотехникийн лабораторийн засвар, хичээлийн 7-р байрны барилгын дээврийн засварын ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьсан.

МХТС –ийн Захирлын тушаалаар байгуулсан МХТС-ийн Хичээлийн 6-р байрны өргөтгөлийн /Койка/ барилгын байрыг барих ажлын зураг төслийг гүйцэтгэгчийн ажилд гэрээний дагуу хяналт тавьж ажиллаж байна.

2022 онд хийгдэх засвар тохижилтын ажлын төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэх, ажлын даалгавар, тайлагнах аргачлалын материал боловсруулж байр ашиглалтын менежерүүдэд мэргэжлийн зөвлөмж өгөв.

2021-2022 онд БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага болох КОЙКА-гаас хэрэгжүүлж буй “ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Хичээлийн 6 дугаар байрны гадна фасад, үүдний гонх засвар, дотор засал, дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж, холбоо дохиолол, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэсэн 4-н ажлуудын сонгон шалгаруулалтыг явуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар тус ажлуудын гүйцэтгэл нь 70 хувьд хүрсэн байна.



**“ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд  
хичээлийн 6 дугаар байрны засварт хийгдсэн ажлууд**

Хүснэгт 8.2

Д/д	Ажлын нэр	Гэрээний дүн /төгрөг/	Гүйцэтгэгчийн товч мэдээлэл	Тайлбар
1	БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага болох КОЙКА-гаас хэрэгжүүлж буй "ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд санхүүжилтээр гадна фасад, гонхны засварын ажил /КОЙКА-001/2019/	1,062,511,663	"Давхар өргөө" ХХК Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Авзага 10-1 Утас:88100536, 98194005	ШУТИС-ийн Хичээлийн 6 дугаар байрны 3653 м2 талбай бүхий гадна фасадыг металл фасадаар бүрэн шинэчлэн хийж байгаа. Ажлын явц 60 хувьтай байна. Төв хаалганы гонхыг шинэчлэн засварлах ажил хийгдэж байгаа.
2	БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага болох КОЙКА-гаас хэрэгжүүлж буй "ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд дотор заслын ажил /КОЙКА-002/2009/	485,532,714	"Цагаан зуун" ХХК Дархан-Уул аймаг Дархан сум 15-р баг, Мангирт хороо 45 тоот	ШУТИС-ийн Хичээлийн 6 дугаар байрны бүх ариун цэврийн өрөө буюу 6-н ширхэг өрөөг бүрэн засварт оруулсан засварлаж ашиглалтад оруулсан. Баруун жигүүрийн блокын 1, 2, 3 дугаар давхартуудын 381.9 м2 коридорын хана, тааз, шалны ажлыг бүрэн хийж дуусгасан. 1, 2, 3 дугаар давхрын вестибулоудыг засварлан оюутны буланг шинээр гарган тусгаарлах шилэн хаалт, хана, тааз, шалны ажил хийгдсэн. Том жижиг нийт 14 лабораторийн анги, танхимыг бүрэн засварлаж ашиглалтад хүлээлгэн өгсөн.
3	БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага болох КОЙКА-гаас хэрэгжүүлж буй "ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж, холбоо дохиоллын ажил /КОЙКА-003/2019/	235,000,000	"Эй Эс Эс инженеринг" ХХК СХД-ийн 6-р хороо, 13-1 тоот 88886248	ШУТИС-ийн Хичээлийн 6 дугаар байрны анги танхим, коридорын цахилгааны монтаж, гэрэлтүүлэг, унтраалга, залгуур болон холбоо дохиоллын ажлыг хийж гүйцэтгэж дууссан.
4	БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага болох КОЙКА-гаас хэрэгжүүлж буй "ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах /КОЙКА-004/2019/	285,139,000	"Нью телеком" ХХК СБД-ийн 6-р хороо, Сүхбаатарын гудамж -13, Метро бизнес төв А жигүүр 4 давхар 99091555	1. Хөргөлтийн систем 7833м3/цаг агаарын урсгалын чадалтай 2. Үл тасалдах тэжээлийн эх үүсвэрийн систем 380/400/415 В /Гурван фазын + саармаг цэг/ 3. Генератор 380/400/415 В /Гурван фазын + саармаг цэг/



**Боловсруулсан төсвийн жагсаалт**

Хүснэгт 8.3

д/д	Шифр	Сургууль	Төсвийн нэр	Нийт төсөвт өртөг /мян.төг/	Төсвийн үнэлгээ /мян.төг/
2021 оны 2-р хагас					
1	ШУТИС-төсөв 21-14	ЗА	ШУТИС. Спорт заалны хаяавчны хэсэгчилсэн болон агуулахын засварын ажлын	19,092.5	381.8
2	ШУТИС-төсөв 21-15	БАТС	5-119 тоот өрөөний засвар	29,757.8	595.2
3	ШУТИС-төсөв 21-16	ЗА	Санхүүгийн 1-219 тоот өрөөний засвар	19,649.4	393.0
2022 оны эхний хагас жилд					
1	ШУТИС-төсөв 22-01	ЗА	ШУТИС. Хичээлийн 7 дугаар байрны дээврийн засварын ажлын хяналтын төсөв	201,599.5	4,032.0
2	ШУТИС-төсөв 22-02	ЗА	ШУТИС. Хичээлийн 12 дугаар байранд байгуулах ГУУС-ийн Геотехникийн лабораторийн засварын ажлын хяналтын төсөв	98,575.7	1,971.5
3	ШУТИС-төсөв 22-03	ЗА	ШУТИС. Оюутны 5 дугаар байрны 430 тоот өрөөний засварын ажлын хяналтын төсөв	32,623.0	652.5
4		ЗА	БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох КОЙКА -гаас хэрэгжүүлж буй "ШУТИС.МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр санхүүжих ШУТИС.Хичээлийн 6-р байрны 1.2.3-р давхрын коридорын шал засварлах ажлын төсөв	27,319.6	546.4
5	ШУТИС-төсөв 21-04	ДаТС	Дархан-уул аймаг дахь ШУТИС ДаТС-ийн аж ахуйн барилгын дээврийн засварын ажлын хяналтын төсөв	50,323.8	1,006.5
6	ШУТИС-төсөв 21-05	МТС	ШУТИС. Хичээлийн 7 дугаар байрны цонх солих хэсэгчилсэн засварын ажлын хяналтын төсөв	80,046.1	1,600.9
7	ШУТИС-төсөв 21-06	МТС	ШУТИС. Хичээлийн 7 дугаар байрны 130 тоот /аэродинамикийн лабораторийн/ засварын ажлын хяналтын төсөв	19,991.7	399.8
8	ШУТИС-төсөв 21-07	ХШУС	ШУТИС. Хичээлийн 3 дугаар байранд байгуулах ХШУС-ийн химийн 404 тоот өрөөний лабораторийн засварын ажлын хяналтын төсөв	44,425.7	888.5
9	ШУТИС-төсөв 21-08	ХШУС	ШУТИС. Хичээлийн 1 дүгээр байранд байгуулах ХШУС-ийн багш нарын 119 тоот өрөөний засварын ажлын хяналтын төсөв	44,197.7	884.0
10	ШУТИС-төсөв 21-09	МХТС	ШУТИС. Хичээлийн 6 дугаар байрны 211 тоот өрөөний засварын ажлын хяналтын төсөв	12,974.5	259.5
11	ШУТИС-төсөв 21-10	ЗА	ШУТИС. Хичээлийн 1 дүгээр байр 1 давхар хойд жигүүрийн ариун цэврийн өрөөний засварын ажлын хяналтын төсөв	39,279.0	785.6



12	ШУТИС-төсөв 21-11	ЗА	ШУТИС. Хичээлийн 2 дугаар байр 1 давхар ариун цэврийн өрөөний засварын ажлын хяналтын төсөв	69,938.9	1,398.8
13	ШУТИС-төсөв 21-12	ЗА	ШУТИС. Хичээлийн 1 дүгээр байны хойд, урд тусгах шатны засварын ажлын хяналтын төсөв	44,014.5	880.3
14	ШУТИС-төсөв 21-13	ЗА	ШУТИС. Шинжлэх ухаан технологийн төв номын сангийн шатны хонгилын засварын хяналтын төсөв	68,862.9	1,377.3
15	ШУТИС-төсөв 21-14	ЗА	ШУТИС. Оюутны 3-р байрны 1-р давхрын халуун усны өрөөний засварын ажлын хяналтын төсөв	59,788.6	1,195.8
	дүн			893,961.4	17,879.2
КОЙКАГ-ийн төслийн төсвүүд					
1	ШУТИС.Хичээлийн 6-р байрны 1.2.3-р давхрын коридорын шал засварлах ажлын төсөв				
2	ШУТИС.Хичээлийн 6-р байрны урд талд байрлах галын шат хийх төсөв				
3	ШУТИС.Хичээлийн 6-р байрны Мультимедиа студи ба харааны лаборатори ЛАВ.2. ажлын төсөв				

## 8.2 ӨМЧ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАХ, МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, УДИРДЛАГЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай өмчийг эзэмшүүлэх гэрээ-2021 байгуулж, өмнөх “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний хавсралт мэдээлэл, тайланг хянаж, нэгтгэн 97 онооны үнэлгээтэй дүгнүүллээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн өмчийн программын ашиглалт, цахимд оруулсан мэдээллийн иж бүрдлийг хянаж шалган, уг мэдээллийг үндэслэн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж баталгаажууллаа. 2020 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр актлагдах хөрөнгийн жагсаалтыг нэгтгэж хянан, ШУТИС-ийн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн зохих газарт хандаж, нийт 1,9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, данснаас хасах зөвшөөрлийг авч тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 64 тоот тогтоолыг үндэслэн ШУТИС-ийн захиргаа болон бүрэлдэхүүн сургууль, нэгж тус бүр дээр Захирлын болон бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар тооллогын комисс байгуулагдан ажиллалаа.

ХОХГ нь Төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогод бэлтгэх зорилгоор ШУТИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирлын баталсан удирдамжийн дагуу бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд хяналтын үзлэг тооллогыг 2022 оны 5-р сарын 02-ны өдрөөс 5-р сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв. Мөн түүнчлэн бүрэлдэхүүн сургуулийн тооллогын комисст заавар, зөвлөгөө өгөх, тооллогын материалыг хүлээн авч шалгах, нэгтгэх зэрэг ажлууд хийсэн. ХОХГ нь бүрэлдэхүүн сургууль, нэгж, төвүүдийн тооллогын материалыг нэгтгэн, ТӨБЗГ-ийн тооллогын программд оруулсан ШУТИС-ийн хөрөнгийн тайланг шалгаж, илгээлээ. ШУТИС-ийн тооллогын нэгдсэн дүнг гаргалаа.

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, бага тойруу, Шинжлэх ухаан технологийн их сургууль РД: 9087087 нь улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийг “Улсын бүртгэлийн ерөнхий газар”-аас лавлагааг авч мэдээллийг тулган шалгаж, зөрүүтэй мэдээлэл байхгүй байна. Байгууллагын эзэмшил ашиглалтад буй авто тээврийн хэрэгслийн лавлагааг “Авто




тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын улсын нэгдсэн мэдээллийн систем дахь мэдээлэлтэй тулгаж, зөрүүтэй мэдээллийг холбогдох дүрэм журмын хүрээнд өөрчлөлтийг хийлгүүлж, үнэн зөв болголоо.

2020, 2021 оны ТӨБЗГ-тай хийсэн түрээсийн гэрээний дагуу бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 20 хувь хүн, албан байгууллагын түрээсэлсэн нийт 806 м2 талбайн сонгон шалгаруулалт, гэрээний биелэлтийг хянаж, түрээсийн төлбөрийн тооцоог хянан баталгаажуулж ажиллав. 2021 оны сүүлийн хагас жилд 469,7 сая төгрөгийн, 2022 оны эхний хагас жилд 303,1 сая төгрөгийн сургууль хооронд шилжиж хөрөнгийн хөдөлгөөнийг шийдвэрлэв.

### 8.3 СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН БОЛОН БУСАД АВЛАГЫГ БАГАСГАХ


#### Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүрээнд

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болж гэрээ байгуулагдаж уг гэрээ нь шүүхийн захирамжаар баталгаажиг байна. Нийт 320 өргөдөлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн байна (зураг 8.1).



Зураг 8.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн оюутнуудын мэдээлэл

ДАТС-31 оюутны 32.7 сая төгрөгийн, БАТС-13 оюутны 16.1 сая төгрөгийн, БАС-3 оюутны 1.0 сая төгрөгийн, ГХС-7 оюутны 9.1 төгрөгийн, ЭХС-6 оюутны 6,1 төгрөгийн, НБТ-ийн 15 оюутны 16,08 сая төгрөгийн, нийт 50,0 сая төгрөг бүхий маргааныг шүүхийн эвлэрүүлэн зуучлалаар гэрээ байгуулсан (зураг 8.2). Одоо ажиллагаанд байгаа 42 өргөдөл шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэж байна.




Зураг 8.2. Шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн



## Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нийт 9 төлбөр төлөгчийн 140.5 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

ДАТС-23,7 сая төгрөг, БАТС-13,4 сая төгрөг, БАС- 32,6 сая төгрөг, ГХС- 2,4 сая төгрөг, МехТС-6,05 сая төгрөг, ЭХС- 3,8 сая төгрөг, ГУУС- 94,6 сая төгрөг, НБТ-2,3 сая төгрөг, эвлэрүүлэн зуучлалын гэрээгээр болон бусад хэлбэрээр нийт 174,6 сая төгрөгийн авлага барагдуулсан байна (Зураг 8.3). ХОХГазраас зарласан бараа, ажил үйлчилгээ худалдан авах 45 гэрээний төсөл боловсруулсан.



Зураг 8.3. 2021-2022 оны хичээлийн жилд шүүхийн шийдвэрээр барагдуулсан авлага (сая. Төг)

## 8.4. САНХҮҮ, БҮРТГЭЛ

Санхүү нягтлан бодох бүртгэлийн алба нь НББОУС, УСНББОУС, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Татварын ерөнхий хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын их хурал, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын тушаал, тогтоолын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөж, зохион байгуулдаг. Мөн Монгол улсын хууль, олон улсын стандарт, төрийн захиргааны байгууллагуудын тушаал, тогтоолуудад нийцүүлэн боловсролын байгууллагын онцлогийг харгалзсан санхүү, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой батлагдсан өөрсдийн 40 гаруй дүрэм журам, тушаалыг мөрдөн ажиллалаа.

ШУТИС-ийн хэмжээнд тайлант хугацаанд 2024 үндсэн орон тоотой ажилласнаас гүйцэтгэх ажилтан 1221, үйлчилгээний ажилтан 406, гэрээт болон цагийн багш 391 хүн байна. 2022 оны 04 дүгээр сарын 8-ны байдлаар нийт оюутны тоо: идэвхтэй сурч буй сонголт хийсэн 15,761 оюутан суралцагчид суралцаж байна. Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны хувьд албаны дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, бүрэлдэхүүн нэгжүүдийн ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав зэрэг нийт 50 гаруй орон тоотой ажилласан.





**Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны зорилго нь: ШУТИС-ийн дунд болон богино хугацааны төлөвлөгөөний зорилго, зорилтууд, захирлын үр дүнгийн гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төсөв боловсруулахад санал өгөх, батлагдсан төсвийн дагуу зарцуулалт хийх, төсвийн зарцуулалтыг үнэн зөв бүртгэх, санхүүгийн тайлан гаргах, тайланд шинжилгээ хийх, төсвийн зарцуулалтад хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах**

Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны чиг үүрэг:

- ШУТИС-ийн захирлын болон бүрэлдэхүүн нэгжүүдийн захирлын үр дүнгийн гэрээнд тулгуурлан санхүүгийн орлого, зарлага, худалдан авах ажиллагааны төсөв, төлөвлөгөөг нэгтгэн батлуулахад санал өгөх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн орлого, зарлагын жилийн төсөв, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, Хөгжлийн хөтөлбөр төлөвлөлтийн газартай хамтран ажиллах
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн төсвийн зарчмыг хэрэгжүүлэхэд санхүүгийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэл хөтлөх
- НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу аккруэл сууриар нягтлан бодох бүртгэлийг хөтлөх
- ШУТИС-ийн 2021 он хүртэлх стратегийн төлөвлөгөө, замын зураглал, БСШУСЯ-ны их дээд сургуулийн шинэчлэлийн бодлогын хүрээнд тус сургуулийн олон улсын болон дотоодын ЭШ-ний төсөл, гэрээт ажлын төсвийн төслийг хянах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төслийн өмч хөрөнгийг бүртгэх, хадгалах, ашиглалтад хяналт тавих
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн мөнгөн хөрөнгийн бүртгэл тооцоо, хадгалалт, гүйлгээний мэдээлэл солилцоо, зээлийн болон бусад бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээнд арилжааны банкнуудтай хамтын ажиллагааны гэрээ боловсруулах, дүгнэх
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн бараа материал, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх, бүртгэх, тооллого хийх, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, Өмч хамгаалах комисс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар ашиглалтгүй актлах хөрөнгийг танилцуулах, шийдвэрлүүлэх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, тооллого, хадгалалт, хамгаалалттай хамааралтайгаар Хөрөнгө оруулалт хангамжийн газартай хамтран ажиллах
- Бүрэлдэхүүн нэгж, төсвийн өглөг, авлагын төлбөр тооцоог бүртгэх, хянах, өр төлбөр, авлагыг бууруулах, найдваргүй авлага, өр төлбөрийг Удирдах зөвлөлд танилцуулах, шийдвэрлүүлэх
- Төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, удирдлагын шийдвэр ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай байх зарчмын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь цахим хуудсанд байршуулах
- Бүрэлдэхүүн нэгжийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ШУТИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах
- УСНББОУС, СТОУС, Сангийн сайдын төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх зааврын дагуу санхүүгийн тайлан боловсруулах, тайлагнах
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн санхүүгийн тайланд нэгтгэх



- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын мэдээллийн нэгдсэн санд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээг мэдээлэх
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн мөнгөн хөрөнгө, бараа материал, өмч хөрөнгө, орлого, зарлага, төсөв, төсвийн гүйцэтгэл зэрэг нягтлан бодох бүртгэлийн мэдээ, мэдээллийг удирдлагад хүргүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах
- Бүх шатны бүрэлдэхүүн нэгжийн төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, хөтлөлт, санхүүгийн тайлагналыг санхүүгийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сүлжээгээр хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, санхүү нягтлан бодох бүртгэлийн цахим системийг хөгжүүлэх
- Бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн нэгдсэн системийн мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг хянах, зөвлөх
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, нэгжүүдийн санхүүгийн тайлагналын хүрээнд санхүүгийн үр дүнг тодорхойлж төсөв, төсвийн гүйцэтгэл, орлого, зарлагын төрлүүдээр санхүүгийн шинжилгээ хийн цаашид анхаарах, зөвлөмж гаргах, санхүүгийн үр дүнг хэлэлцүүлэх, үр дүнгийн нэмэгдэл тооцох
- Бүрэлдэхүүн нэгжийн үйл ажиллагааны онцлог, салбарын нөхцөл байдлаас хамаарч НББОУС, хууль, дүрэмд нийцүүлэн бүрэлдэхүүн нэгжийн мөрдөх санхүү, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмыг боловсруулах, батлуулах
- Бүрэлдэхүүн нэгжийн төсвийн зарцуулалт, тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд хяналт тавих
- Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн болон Үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий хуулийн дагуу Татварын ерөнхий газар, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Сангийн Яамны, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудын хяналт, шалгалтад хамрагдах, санхүү бүртгэлийн үйл ажиллагаагаа хянан баталгаажуулах
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн нягтлан бодогчдод тавигдах шаардлагад үндэслэсэн бүрэлдэхүүн нэгжийн ахлах нягтлан бодогчийн албан тушаалд тавигдах шаардлага, шалгуурыг тодорхойлох, мөрдөх
- Бүрэлдэхүүн нэгжийн ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав, бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогч, ажиллагчдыг харьяалагдах бүрэлдэхүүн нэгжийн захирал, Санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал, Захиргаа, хүний нөөцийн газартай зөвшилцөн томилж, чөлөөлөхөд санал өгөх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн сургалтын төлбөрийн бүртгэл хөтлөлт, төлөлтөд хяналт тавих, сургалтын авлага, өр төлбөрийг барагдуулах чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулан Сургалтын бодлого зохицуулалтын газартай хамтран ажиллах, ажлын тайлан бичих
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн сургалтын бус авлага, өр төлбөр барагдуулах чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулан Дотоод хяналтын албатай хамтран ажиллах, ажлын тайлан бичих, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар байгууллагыг төлөөлөн оролцох
- Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн нягтлан бодогч, нярав, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалтад хамруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.



Албаны хувьд 2021 онд санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн программд нэмэлт өөрчлөлтийг оруулж, санхүүгийн дүрэм, журмыг хэрэгжүүлэх, Захирлын зөвлөлийн хурлаар батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх, санхүүгийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаа. 2021 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүний 11 сургууль, 2 ахлах сургууль, ШУТИС-Коосен Технологийн коллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацын газар, Ой мод сургалт судалгааны хүрээлэн, Хэвлэлийн газар, Шинжлэх ухаах технологийн номын сан зэрэг нийт 20 нэгжүүд үйл ажиллагаа явуулж тайлан баланс гаргасан. Монгол улсын Сангийн сайдын 388 тоот санхүүгийн тайлан, тодруулга, 55 тоот эдийн засгийн ангилал болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12) зэргийг гарган өгч, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох УСНББОУС-д нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “И-Finance” санхүүгийн программаар санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. 2021 оны санхүүгийн хагас жилийн тайланд Үндэсний аудитын газар, “Амгалан ахуй аудит” аудитын компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдсэн.

### 8.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАЛАНС

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 15 тоот тогтоолын дагуу Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн хөрөнгө, өр төлбөрийг Технологийн сургуулийн балансаас балансад шилжүүлж, эхлэлтийн санхүүгийн тайлан гаргасан.

#### ШУТИС-ийн Санхүүгийн тайлан баланс/мян. төг/

Хүснэгт 8.4

Балансын үзүүлэлт	2020 оны IY улирал	2021 оны IY улирал	Өсөлт +, бууралт -	
			Дүн	Хувь
Мөнгөн хөрөнгө	23,762,109.5	24,785,114.9	1,023,005.4	4.3
Авлага	4,207,928.0	3,834,920.5	(373,007.5)	8.9
Үүнээс: 1. Сургалтын төлбөрийн авлага	2,854,223.8	2,906,600.0	52,376.2	1.8
Урьдчилгаа	752,524.7	776,524.7	24,000.0	3.2
Бараа материал	1,907,884.5	2,217,490.9	309,606.4	16.2
Үндсэн хөрөнгө	107,916,325.6	121,219,376.7	13,303,051.1	12.3
Нийт хөрөнгийн дүн	<b>138,546,772.3</b>	<b>152,833,427.7</b>	<b>14,286,655.4</b>	<b>10.3</b>
Өр төлбөр	9,499,640.8	10,220,566.3	720,925.5	7.6
Үүнээс: 1. Урьдчилж орсон орлого	8,815,185.5	9,275,647.2	460,461.7	5.2
2. Урт хугацаат өр төлбөр	57,158.0	52,187.7	(4,970.3)	8.7
Засгийн газрын хувь оролцоо	30,341,483.2	30,567,495.6	226,012.4	0.7
Хуримтлагдсан үр дүн	37,597,377.7	50,939,036.2	13,341,658.5	35.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,108,270.6	61,106,329.6	(1,941.0)	0.0
Өр төлбөр, эзний өмчийн дүн	<b>138,546,772.3</b>	<b>152,833,427.7</b>	<b>14,286,655.4</b>	<b>10.3</b>

Тайлант хугацаанд БШУЯамнаас цахим төгсөлтийн арга хэмжээний санхүүжилтэд 20,000.0, ХНХЯамнаас МехТС, ҮТС-ийн ОМССХ-ийн мэргэжлийн анхан шатны сургалтад 460,642.3, орон нутгийн төсвөөс ДаТС-ийн Ахлах сургууль, ШУТАхлах сургуулийн сургалтад 128,376.4, Инженер, техникийн дээд боловсрол төслөөс 50,000.0,



ШУТСангаас 705,197.3, БЗС-аас буцалтгүй тусламжийн санхүүжилт 1,690,603.0, Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагч гадаад оюутны сургалтын төлбөр, тэтгэлгийн 6,284.4, оюутны хөгжлийн зээлийн 1,220,645.9, Ерөнхийлөгчийн нэрэмжит оюутны тэтгэлгийн 440,004.8 мянган төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.

“Нийгмийн даатгалаас чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн дагуу 2021 оны 1-6 сарын ажил олгогчийн төлөх 531,980,631.79 төгрөгийн чөлөөлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр Засгийн газрын хөнгөлөлт дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусгалаа.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 4 банкны нийт 60 дансны үлдэгдэл хамрагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн байна. 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 81,521.88 ам.долларын үлдэгдэлтэй байсан ба Монгол банкны 2021 оны 12-р сарын 30-ны өдрийн хаалтын ханш 2,848.80 төгрөгөөр ханшийн тэгшитгэл хийж төгрөгт хөрвүүлж тайланд тусгасан.

Нийт авлага 3,834,920.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 373,007.5 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар буурсан.

Авлагын 2,906,600.0 мянган төгрөг буюу 75.8 хувь нь оюутнуудаас авах сургалтын төлбөрийн дутуу, СТС-ийн суутгал, байгууллага, хувь хүнээс авах авлага 24.2 хувийг эзэлж байна.

ШУТИС-ийн Захирлын 2021 оны 01-р сарын 29-ний өдрийн А/16, 06-р сарын 18-ны өдрийн А/108, 12-р сарын 24-ний өдрийн А/245 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургууль, нэгж хооронд 1,092,081,365.57 төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн, данс бүртгэлд бүртгэж, тайланд тусгалаа.

Тайлант хугацаанд гадаад, дотоодын байгууллага, хувь хүн, төслийн хөрөнгөөр бий болсон 11,258,921.2 мянган төгрөгийн хандивын үндсэн хөрөнгийг бүртгэсэн.

### ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын төсөв, гүйцэтгэл /төгрөгөөр/

Хүснэгт 8.5


№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Орлого төсөв	Гүйцэтгэл орлого	хувь
1	Барилга, Архитектурын сургууль	6,387,680,500	6,743,321,543	105.57%
2	Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	3,326,651,200	3,421,592,341	102.85%
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	2,040,471,500	2,308,502,206	113.14%
4	Геологи, Уул уурхайн сургууль	4,226,300,700	4,568,238,949	108.09%
5	Гадаад хэлний сургууль	532,459,360	516,224,020	96.95%
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	2,392,399,500	2,840,197,282	118.72%
7	Механик, Тээврийн сургууль	3,803,804,410	4,169,167,429	109.61%
8	Мэдээлэл, Холбооны технологийн сургууль	6,121,581,300	5,958,859,677	97.34%
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	1,110,727,200	933,772,168	84.07%
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	3,778,906,200	3,565,382,282	94.35%
11	Эрчим хүчний сургууль	6,250,575,600	6,191,380,059	99.05%
12	ШУТИС Нээлттэй боловсролын төв	50,052,800	60,592,638	121.06%
13	ШУТИС-Коосен технологийн сургууль	570,000,000	667,478,000	117.10%
14	ШУТИС Ахлах сургууль	504,000,000	602,727,500	119.59%
15	Дархан-Уул аймаг Ахлах сургууль	143,000,000	181,949,688	127.24%
16	Эрдэм шинжилгээ инновацын газар	365,000,000	435,288,570	119.26%



17	ШУТИС Төв номын сан	-	13,516,844	#DIV/0!
18	ШУТИС Хэвлэлийн газар	549,390,000	395,562,014	72.00%
19	ШУТИС Захиргаа	100,000,000	93,279,258	93.28%
20	ШУТИС Ой модны сургалт судалгааны төв	434,000,000	139,632,379	32.17%

ТӨБЗГ-ын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 503 тоот тогтоолын дагуу анхны өртгөөрөө элэгдлээ нөхсөн 8441 нэрийн 17,256,402,395.78 төгрөгийн үнэ бүхий 20463 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган 7,721,032,600.48 төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоохоос актлагдсан болон 2020 онд худалдан авсан хөрөнгийг хасаж тооцсоноор 17,232,802,863.16 төгрөгийн үнэ бүхий 20363 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган, 7,708,244,792.74 төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгав.

2021 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдээс ГХС, МХТС, ХШУС, УТС, ЭХС, Хэвлэх газар, Захиргаа, ОМССХүрээлэн орлогын төсөв биелэгдээгүй тасарсан байна.



Зураг 8.4. ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын гүйцэтгэл

ТӨБЗГ-ын 2021 оны 06-р сарын 04-ний өдрийн А-1/919 албан тоот, 06-р сарын 15-ны өдрийн 216 тоот тогтоолын дагуу 983,191,027.17 төгрөгийн үндсэн хөрөнгө актлахаас үлдэгдэл өртөгтэй 382,993.60 төгрөгийн хөрөнгийг хасаж тооцсоноор 982,808,033.57 төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, данс бүртгэлээс хасаж, санхүүгийн тайланд тусгав.

2021 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн ШУТИС, Санхүү эрхэлсэн дэд захирлын 5/100 тоот албан бичгийн хүрээнд дараах зардал, зарцуулалтыг зогсоон, бууруулан ажиллав.

- Зогсоосон зардал: шагнал урамшууллын зардал, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, гадаад мэргэжилтний зардал, гадаад томилолтын зардал, багшийг дэмжих зардал, мэргэжил дээшлүүлэх зардал, ойн арга хэмжээний зардал, багш ажилтны арга хэмжээний зардал, оюутны үйлчилгээний зардал



- Бууруулсан зардал: Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал, дотоод албан томилолтын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, сургалтын бичиг хэргийн зардал, захиргааны бичиг хэргийн зардал
- Хэмнэсэн зардал: Гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардал

### ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн зарлагын төсөв, гүйцэтгэл /төгрөгөөр/

Хүснэгт 8.6

№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Зарлага төсөв	Гүйцэтгэл зарлага	хувь
1	Барилга, Архитектурын сургууль	5,666,339,400	4,731,372,395	83.50%
2	Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	3,999,364,100	3,641,795,722	91.06%
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	1,086,996,300	878,917,380	80.86%
4	Геологи, Уул уурхайн сургууль	5,657,251,900	5,016,735,333	88.68%
5	Гадаад хэлний сургууль	2,735,622,400	2,373,325,771	86.76%
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	3,344,533,800	2,833,496,883	84.72%
7	Механик, Тээврийн сургууль	5,214,861,400	4,242,116,078	81.35%
8	Мэдээлэл, Холбооны технологийн сургууль	4,868,418,100	4,104,278,886	84.30%
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	4,244,580,800	3,676,598,102	86.62%
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	5,472,280,900	3,756,561,187	68.65%
11	Эрчим хүчний сургууль	4,384,436,700	3,536,789,185	80.67%
12	ШУТИС Нээлттэй боловсролын төв	835,753,600	546,648,248	65.41%
13	ШУТИС Коосен технологийн сургууль	694,221,600	497,473,467	71.66%
14	ШУТИС Ахлах сургууль	846,845,160	522,937,355	61.75%
15	Дархан-Уул аймаг Ахлах сургууль	233,853,650	209,275,487	89.49%
16	Эрдэм шинжилгээ инновацийн газар	467,740,000	363,344,607	77.68%
17	ШУТИС Төв номын сан	906,811,400	734,065,388	80.95%
18	ШУТИС Хэвлэлийн газар	472,183,800	341,033,230	72.22%
19	ШУТИС Захиргаа	7,842,343,000	6,727,195,369	85.78%
20	ШУТИС Ой модны сургалт судалгааны төв	546,321,200	244,114,497	44.68%

Тайлант хугацааны эцэст байгууллага, хүмүүст 892,731.4 мянган төгрөгийн өглөгийн, 9,275,647.2 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого (сургалтын болон оюутны байрны төлбөр, бусад төлбөр, төсөл, гэрээт ажлын) -ын үлдэгдэлтэй байна.


Урт хугацаат зээлийн 52,187.7 мянган төгрөгийн өглөг нь Төрийн өмчийн хорооны 2011 оны 11-р сарын 11-ний өдрийн тоот тогтоолын дагуу УБ Дулааны Сүлжээ ТӨХК-аас балансаас балансад шилжүүлэн бүртгэж авсан Халаалтын цогц төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр бөгөөд 2032 онд төлөгдөж дуусах гэрээтэй болно.

2021 онд Монгол улсын ЗГ-ын 43 тоот тогтоол, ШУТИС-ийн санхүү эрхэлсэн дэд захирлын 5/100 тоот албан бичгийн хүрээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн зардлыг зогсоон ажилласан. Тиймээс зардал хэтэрсэн бүрэлдэхүүн нэгжүүд байхгүй байна.

Өмнөх үеийн үр дүнг үндсэн хөрөнгө, авлага, өглөг, урьдчилгааны залруулга, акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжсэн дүн зэргээр нийт 40,309,856.79



төгрөгөөр нэмэгдүүлж, авлага, элэгдэл, урьдчилж орсон орлогын залруулга зэргээр нийт 55,531,880.00 төгрөгөөр бууруулан бичилт хийв.



Зураг 7.3. ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн зарлагын гүйцэтгэл

Мөн бүрэлдэхүүн сургууль, нэгжийн хооронд хөрөнгө, өр төлбөр шилжүүлсэнтэй холбоотой 66,491,495.00 төгрөгийн нэмэгдсэн, хасагдсан бичилтүүд хийгдсэн болно.

**ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн үр дүн /төгрөгөөр/**

Хүснэгт 8.7

№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Орлогын гүйцэтгэл	Зарлага гүйцэтгэл	Үр дүн
1	Барилга, Архитектурын сургууль	6,743,321,543	4,731,372,395	2,011,949,148
2	Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	3,421,592,341	3,641,795,722	- 220,203,381
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	2,308,502,206	878,917,380	1,429,584,826
4	Геологи, Уул уурхайн сургууль	4,568,238,949	5,016,735,333	- 448,496,384
5	Гадаад хэлний сургууль	516,224,020	2,373,325,771	- 1,857,101,752
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	2,840,197,282	2,833,496,883	6,700,398
7	Механик, Тээврийн сургууль	4,169,167,429	4,242,116,078	- 72,948,649
8	Мэдээлэл, Холбооны технологийн сургууль	5,958,859,677	4,104,278,886	1,854,580,792
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	933,772,168	3,676,598,102	- 2,742,825,934
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	3,565,382,282	3,756,561,187	- 191,178,905



11	Эрчим хүчний сургууль	6,191,380,059	3,536,789,185	2,654,590,875
12	ШУТИС Нээлттэй боловсролын төв	60,592,638	546,648,248	- 486,055,611
13	ШУТИС Коосен технологийн сургууль	667,478,000	497,473,467	170,004,533
14	ШУТИС Ахлах сургууль	602,727,500	522,937,355	79,790,145
15	Дархан-Уул аймаг Ахлах сургууль	181,949,688	209,275,487	- 27,325,799
16	Эрдэм шинжилгээ инновацийн газар	435,288,570	363,344,607	71,943,962
17	ШУТИС Төв номын сан	13,516,844	734,065,388	- 720,548,544
18	ШУТИС Хэвлэлийн газар	395,562,014	341,033,230	54,528,784
19	ШУТИС Захиргаа	93,279,258	6,727,195,369	- 6,633,916,111
20	ШУТИС Ой модны сургалт судалгааны төв	139,632,379	244,114,497	- 104,482,118

2021 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдээс БУХС, ГУУС, ГХС, МеТС, ХШУС, УТС, НБТ, ДаАС, Номын сан, Захиргаа, ОМССХүрээлэн хасах үр дүнтэй гарсан байна.

Сургууль хоорондын тооцооны орлого, зардал, өглөг, авлагыг бүрэлдэхүүн сургууль, нэгж тус бүрийн санхүүгийн тайланд тусгав.

Сургууль хоорондын тооцооны дараах гүйлгээг устгах бичилт хийж, нэгтгэсэн тайланг гаргалаа. Үүнд:

1. Авлага, өглөгийн эхний үлдэгдэл 243,298,324.07 төгрөг, эцсийн үлдэгдэл 288,388,567.57 төгрөг (эхний үлдэгдлээс сургууль хоорондын тооцооны-46,733,760.37 оюутны хөгжлийн зээлийн эрсдэлийн 5%-196,564,563.70, эцсийн үлдэгдлээс сургууль хоорондын тооцооны -30,791,710.37 оюутны хөгжлийн зээл, эрсдэлийн 5% -257,596,857.20)
2. Үндсэн хөрөнгө анхны өртгөөр 1,092,081,365.57 төгрөг, хуримтлагдсан элэгдэл 164,117,972.90 төгрөг, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг 927,963,392.67 төгрөг (Засгийн газрын хувь оролцоо данс)
3. Өмнөх үеийн үр дүн данс 66,491,495.00 (Сургууль хооронд шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр)
4. Бараа материал бэлтгэх урьдчилгаа, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа, бусад урьдчилгаа, төсөл, гэрээт ажлын зардлын урьдчилгаа, бусад төлбөрийн урьдчилж орсон орлогын эхний үлдэгдлээс 11,580,500.00 төгрөг, эцсийн үлдэгдлээс 22,671,700.00 төгрөг (БАТС, ГУУС, ГХС, УТС, ХШУС, Захиргаа, Хэвлэлийн газар)
5. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлого, зардал сургууль хоорондын тооцооны 83,600,692,236.32 төгрөг, Хэвлэлийн газрын 105,109,910.00 төгрөг
6. Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, зардал сургууль хоорондын 83,683,073,499.69 төгрөг, Хэвлэлийн газрын 164,031,160.00 төгрөг, БЗС-ийн санхүүжилт, кредит баталгаажуулалтын төлбөрийн 3,482,402,048.32





## 8.6 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН

ШУТИС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн АХГ-2022/07/НА-СТА-ТӨА код бүхий аудитын тайланг Үндэсний аудитын газраас 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу ШУТИС-ийн 2021 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлагналын аудит хийгдэж “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн албанаас 2021 оны ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайланг нэгтгэн Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн дагуу 2022 оны 2 дугаар сарын 04-нд ҮАГ/АА2021-241 тоот гэрээ байгуулан ҮАГ болон Амгалан ахуй аудит ХХК-нд санхүүгийн тайлангаа хүргүүлсэн. Аудитын байгууллагаас НББОУС, СТОУС, УСНББОУС, АОУС, АДБОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Аудитын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Дараах зөрчил дутагдал гарсан байна.

- Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тендерийн сонгон шалгаруулалт явагддаггүй байх зөрчил буюу гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй 41.1 сая төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгүүлсэн байна.
- Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг ня-бо бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх зөрчил буюу байр түрээслэх гэрээ байгуулаагүйгээр түрээсийн төлбөрт нийт 24 багш, ажилтнаас 31.3 сая төгрөгийн орлого санхүүгийн тайланд бүртгэсэн байна.
- Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон байх зөрчил буюу харьяа бүрэлдэхүүн 21 сургуулиуд нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 2351 мэдээллээс 16 мэдээлэл хугацаа хоцроосон. Үүнээс 5 сая төгрөгөөс дээш нийт 108,416.5 сая төгрөгийн мэдээ оруулахаас 25.9 сая төгрөгийн 4 мэдээг хоцроосон байна.
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй байх зөрчил буюу салбар сургуулийн ойн арга хэмжээний зардал 22.1 сая төгрөг, спортын уралдаан тэмцээний зардалд 13.6 сая төгрөг, албан конторын тавилга 105.4 сая төгрөг нийт 141.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Байгууллагаас авах нийт 22.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Гиймээс авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулах, аудитаар өгсөн зөвлөмжийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.
- Гадаадад доктор хамгаалахаар явсан багшийн тусгаарлах байрны төлбөрт 2.4 сая төгрөг зарцуулсан байна. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх

## 8.7 ДОТООД АУДИТ

Дотоод аудитын алба нь Монгол улсын төсвийн тухай хууль, ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” ШУТИС-ийн ректорын 2009 оны “ШУТИС-ийн дотоод хяналт шалгалтын журам”, “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ын хүрээнд:

1. ШУТИС-ийн хүрээнд мөрдөгдөх, хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал хэрэгжилтэд хяналт тавих;



2. Төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавих;
3. Төсвийн орлого, зардал, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд хяналт тавих;
4. ШУТИС-ийн захирлын шийдвэрээр төлөвлөгөөт бус аудит хийх;
5. Их сургуулийн өглөг, авлагын байдалд хяналт тавих;
6. Их сургуулийн орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
7. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих;
8. Их сургуулийн хэмжээнд хэрэгжиж буй гадаад болон дотоодын төсөл, хөтөлбөр, аж ахуйн нэгжүүдтэй хийсэн гэрээт ажлын санхүүжилтийн орлого зарцуулалтад хяналт тавих зэргээр хяналт шалгалтыг явуулдаг. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил дутагдлыг давтан гаргуулахгүй байх, хариуцлага тооцох, нөхөн төлүүлэх, залруулах арга хэмжээг авдаг.

### **Нэг . Хяналт шалгалтын ажлын талаар**

1. ШУТИС-ийн Дотоод аудитын албаны төлөвлөгөөний дагуу
  - Үйлдвэрлэлийн технологийн сургууль;
  - ШУТИС-ийн Захиргааны нэгж;
  - Геологи уул уурхайн сургуулийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.
2. Шилэн дансны хэрэгжилтийг 2022оны I улирлын байдлаар
  - Дархан-Уул аймгийн технологийн сургууль ;
  - ДаТС-ийн харьяа Ахлах сургууль;
  - Бизнесийн удирдлагын сургууль;
  - Үйлдвэрлэлийн технологийн сургуулийг тус тус шалгасан.
3. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтуудыг дараах бүрэлдэхүүн сургууль нэгжүүдэд явууллаа. Үүнд:
  - Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн 2017-2021 оны эхний 8 сар хүртэлх хугацааны сургалтын төлбөрийн буцаалтыг;
  - Эрчим хүчний сургуулийн 2021 оны эхний 8 сар хүртэлх хугацааны 153 оюутны 91,5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцаалтыг ;
  - Барилга архитектурын сургуулийн 2021 оны эхний 8 сар хүртэлх хугацааны 168 оюутны 81,4 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцаалтыг;
  - Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн 2021 оны эхний 8 сар хүртэлх хугацааны 144 оюутны 59,6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцаалтыг тус тус шалгав.
  - Барилга архитектурын сургуулийн санхүүгийн ерөнхий байдал, нийтлэг гарч байгаа зөрчлүүдийг илрүүлэх зорилгоор сүүлийн 2-3 жилийн Төсөл гэрээт ажлын цалинд шалгалт хийж холбогдох зөвлөмж зааврыг тухай бүрт нь өгч ажиллав.
  - Дархан-Уул аймгийн технологийн сургууль
  - ДаТС-ийн харьяа Ахлах сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв.

### **Хоёр. Үр дүнгийн хэрэгжилтийн талаар**

1. Шалгалтад хамрагдсан сургуулиудад төсвийн төлөвлөлт, зарцуулалт, санхүү нягтлан бодох бүртгэл, худалдан авалт, төсөл гэрээт ажил, сургалтын төлбөр гэсэн таван чиглэлд удирдамж гарган дотоод аудитыг хийж, аудитын шалгалтын үр дүнгийн тайланг захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, цаашид сайжруулах зөвлөмжийг



сургуулийн удирдлагуудад танилцуулан зөвлөмжийг сургуулийн удирдлагууд болон санхүүгийн ажилтнуудад өгч тухай бүрд нь танилцуулсан.

- Дотоод аудитын шалгалтын үр дүнгээр Үйлдвэр Технологийн сургууль, ШУТИС-ийн Захиргааны нэгж, Геологи уул уурхайн сургууль, Дархан -Уул аймгийн технологийн сургууль, ДаТС-ийн Ахлах сургуулиудад нийтдээ
  - Үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, зардалтай хамааралтай 3 зөвлөмж
  - Нягтлан бодох бүртгэл тайлагнал -6 зөвлөмж
  - Үндсэн хөрөнгө, бараа материал- 4 зөвлөмж
  - Худалдан авалттай холбоотой -4 зөвлөмж
  - Үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, зардалтай хамааралтай-3 зөвлөмж
  - Төсөл гэрээт ажил -3 зөвлөмжийг өгч ажилласан.

2. Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн 2017 оны сүүлийн хагас жил, 2018-2020 оны, 2021 оны эхний 8 сарын хугацааны 815 оюутны 507.9 сая төгрөгийн төлбөрийн буцаалтыг шалгахад 34.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 33.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, 1.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажилласан.

3. Сургалтын төлбөрийн буцаалт өндөртэй сургуулиудаас сонгож ЭХС, БАС, ҮТС-ийн 2021 оны эхний 8 сарын сургалтын төлбөрийн буцаалтыг шалгасан болно. Үүнд:

- БАС-ийн 168 оюутны 81.4 сая төгрөгийн
- ЭХС-ийн 153 оюутны 91.5 сая төгрөгийн
- ҮТС-ийн 144 оюутны 59.6 сая төгрөгийн

нийт 465 оюутны 232.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцаалтыг тулган баталгаажуулахад дээрх сургуулиудын зарим оюутнуудын санхүүгийн баримтад оюутны шилжсэн төгссөн тушаалыг хавсаргаагүй, оюутны буцаалт олгохыг хүссэн өргөдлийг онлайнар аваагүй, гарын үсэггүй анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу зэрэг зөрчилд зөвлөмж өгч ажилласан .

4. ШУТИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.6-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилт, шимтгэл төлөлтийг бодитой гаргах, төслийн үр дүнгийн хэрэгжилтийг сайжруулах” ажлын хүрээнд 2021-2020 оны хичээлийн жилд

2. Барилгын архитектурын сургуулийн захирал М.Нарантуяагийн гаргасан хүсэлтийн дагуу 2014-2020 онуудад хэрэгжсэн төсөл гэрээт ажилд ажилласан ажилтнуудын цалинд хяналт хийж дүгнэлт гаргасан.

3. ШУТИС-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Авлага өр төлбөрийг бууруулах” чиглэлээр санхүү нягтлан бодох бүртгэлийн албатай хамтран бүрэлдэхүүн сургууль салбар нэгжүүдийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй авлага өр төлбөрийг бууруулах удирдамжийн дагуу ажлын явцыг хэлэлцүүлж дүгнэлт зөвлөмж өгсөн.

#### **Гурав. Шалгалтын ажлын гүйцэтгэлийн хэрэгжилт**

Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээний хүрээнд бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн ажилтнуудад гарч байгаа нийтлэг алдаа, зөрчил дутагдлын шалтгааны талаар мэдээлэл хийж цаашид анхаарах зөвлөмжийг өгч ажилладаг. Шалгалтын мөрөөр зөрчил дутагдлыг арилгасан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох баримтын хамт авч гүйцэтгэлийг хянав.



**Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан биелэлтийн хувь  
/ сая төгрөгөөр /**

Хүснэгт 8.8

Нэгж	Зөрчлийн утга	Зөвлөмж	Албан шаардлага	Зөрчлийг арилгасан биелэлтийн %
MeTC	Төсөл гэрээ ажил	28.0	4.7	97.5%
УТС	Нягтлан бодох бүртгэл тайлагнал	12,9		90%
	Сургалтын төлбөр		0.2	100%
ГХС	Нягтлан бодох бүртгэл тайлагнал	0.2		90%
	авлага барагдуулах	0.3		100%
	Өр авлага	61.3	3.1	100%
БАС	Цалин хөлс	зөвлөмж		100%
БУХС	Сургалтын төлбөрийн буцаалт	1.6	33.6	100%
Захиргаа	Нягтлан бодох бүртгэл тайлагнал	260.7		91%
	Төсөл гэрээ ажил	1.3		100%
	Байрны төлбөр		5.2	100%
	Авлага барагдуулалт	322.2	0.5	2022 онд хэрэгжүүлэх
	Худалдан авалттай холбоотой Захирлын тушаалын хавсралтыг засварласан	68.5	1 зөрчил	
	ДаТС	Нягтлан бодох бүртгэл тайлагнал	2.9	
Худалдан авалттай холбоотой		13.5		
<b>Нийт</b>		<b>776.5</b>	<b>47.3</b>	

**Дөрөв. Бусад ажлын талаар :**

1. Үндэсний аудитын газрын 2021 оны шалгалтын багтай хамтарч ажилласан ба шаардлагатай тоо мэдээлэл, хийсэн шалгалтын үр дүнг танилцуулсан .
2. Дотоод аудитын албаны ажилтнууд их сургуулийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа ажлын хэсэг, сургалт семинар болон бусад ажлуудад хуваарийн дагуу оролцсон болно.

**8.8. БАЙР АШИГЛАЛТ**

2021-2022 оны хичээлийн жилд байр ашиглалтын нэгдсэн алба нь Дээд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд, коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комисс болон төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргасан тогтоол, тушаал, стандарт, ШУТИС-ийн дүрэм, журмуудыг мөрдөн ажиллалаа.

Тус алба нь Их сургуулийнхаа барилга байгууламжийн их болон урсгал засварын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийлгэх, хяналт тавих, орчны /гадаад, дотоод/ тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах, хичээлийн болон оюутны байруудын дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих, өмч хөрөнгийг үр ашигтай зарцуулах, түрээслэгчдийн болон харуул хамгаалалтын байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.



- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээний чиглэлээр

“ШУТИС-ийн хамтын гэрээ”-ний өөрийн үйл ажиллагааны холбогдох бүлэгт тусгагдсан зүйл заалтын хэрэгжилтийг зохих түвшинд хангуулахад анхаарч ажиллалаа. Бүрэлдэхүүн сургууль, эрүүл мэндийн төвтэй хамтран коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах чиглэлээр орчны эрүүл ахуйг сайжруулах, гар халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, халдваргүйжүүлэлтийг хийлгэх, зөвлөгөө мэдээллээр хангах, биеийн халууныг хэмжих нөхцөлийг бүрдүүлж ажиллаа.

Үйлчлэгч нарт ариутгах, халдваргүйжүүлэх цэвэрлэгээний бодис материалыг зөв хэрэглэх дадал олгох чиглэлээр, ШУТТНСангийн ажилтнуудад ХАБЭА-н сургалтыг тус тус явуулав.

Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилладаг үйлчилгээний ажилчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн биелэлтийг хангуулж ажиллалаа. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгалын ажлыг гэрээний дагуу зохион байгуулав.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж мөрдөн ажиллаа. Мөн “Үйлдвэрийн осол хурц хордлого”-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах түр журмын төслийг боловсруулж, батлууллаа.

- Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын талаар

Хичээлийн болон оюутны байрнуудын сантехникийн найдвартай ажиллагааг хангах үүднээс халаалтын улирал дуусмагц инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон халаах хэрэгслийн хаалт (винтель), сгон контур, муфтийг шинэчлэн солилоо.

Хичээлийн I, II, III, VIII байр орчмын гадна ариутгах татуургын 250 гаруй у/м шугамыг улирал тутам угаах, 16ш худгийг лайдах ажлыг хийлээ.

Хичээлийн VIII байрны 10 дугаар давхрын шим тэжээл судлалын лабораторийг өргөжүүлэх, ХШУС-ийн химийн лаборатори, ЭХС-ийн дулааны механикийн лаборатори хичээлийн III байр луу нүүж байгаатай холбогдуулан сантехникийн тоног төхөөрөмжийн угсралтын зураг хийх, ажлын даалгавар боловсруулж, сантехникийн шугам сүлжээ, тоноглолыг шинээр татан суурилуулав.

Оюутны III байрны ариутгах татуургын хуучин ширмэн шугам хоолойг хуванцар хоолойгоор бүрэн шинэчлэн солив.

ШУТТНС, хичээлийн II, VIII байрны нийт 9ш цахилгаан шатны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцан техникийн үзлэг, үйлчилгээг гэрээт байгууллагаар хийлгэж гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллав. Лифтний ээлжит магадлалыг Улаанбаатар НӨҮГ-аар хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгах талаар гэрээт байгууллагатай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хичээлийн I, II, III, IV, V, VII байр, ШУТТНС-ийн хотын болон дотуур утас, станц, шугам аппаратын найдвартай ажиллагааг ханган, лавлагаа мэдээлэл, засвар үйлчилгээг хариуцан ажиллалаа. Оюутны байруудын хяналтын камеруудыг шинэчлэх, засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хичээлийн болон оюутны байрнуудын цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хариуцан, цахилгаан системийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цахилгааны 28ш ерөнхий, 74ш групп хуваарилах самбарт (щит) техникийн үзлэгийг сар бүр тогтмол хийж осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Тайлант онд залгуур, унтраалга, гэрэл солих, цахилгаан хэрэгсэл суурилуулах, тэжээл татах, сургуулийн гадна орчинд зохиогддог арга хэмжээний үеэр цахилгаан тэжээл татах зэрэг ажлуудыг ямар нэг гомдол чирэгдэлгүй гүйцэтгэж ажилласан байна.



“Соргог” ХХК, “Дорнод монгол эрдэс” ХХК-ийн “Дорнод монгол секьюрити” хамгаалалтын байгууллагуудтай харуул хамгаалалтын чиглэлээр гэрээтэй ажиллаж байна. Харуулын албаны ахлагч нартай байнгын холбоотой ажиллаж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг анхааруулан холбогдох үүрэг чиглэлийг өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Хичээлийн I, II, III байр орчмын авто зогсоолд байрлах автомашины бүртгэл, судалгааг шинэчлэн гаргаж, автомашины нэвтрэлтийг камерын системээр зохицуулахаар өөрчлөн шинэчлэв.

Нийтийн эзэмшлийн зам талбай, орчны их цэвэрлэгээг улирал тутам зохион байгууллаа.

- Тайлант онд Удирдах зөвлөлийн 2021 оны 09 тоот тогтоолоор батлагдсан 2022 оны хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллалаа.
- Оюутны байр
  - 2020-2021 оны хичээлийн жилд оюутны 4 байранд 843 оюутан хүлээн авч тав тухтай сурч, амьдрах орчныг бүрдүүлж ажиллалаа.
  - Оюутныг оюутны байранд хүлээн авах бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж 2021-2022 оны хичээлийн жилээс мөрдөн ажиллалаа.
  - Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах БШУЯ, УОК-ын шийдвэрүүд, Их сургуулийн хэмжээнд КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах удирдамжийн дагуу оюутны байранд амьдарч байгаа оюутнуудад халдвар хамгааллын дэглэмийг өндөр түвшинд баримтлан зохион байгуулж ажиллалаа.
  - Оюутны байрны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай 170,0 сая төгрөгийн зардлыг захирлын 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/174 тоот тушаалаар “Төвлөрсөн сан”-гаас гаргаж зохицуулалт хийж ажиллалаа.
  - Оюутны байрнуудын урсгал засварт энэ хичээлийн жилд 120,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

**ГАРЧИГ**

Өмнөх үг.....	3
---------------	---

**НЭГ. Удирдлага, зохион байгуулалт**

1.1. Удирдах зөвлөл: .....	6
1.2. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа .....	7
1.3. Захирлын зөвлөл .....	10
1.4. Стратеги 2030 төлөвлөгөөний хэрэгжилт .....	11
1.5. Төсөв, төлөвлөлт .....	12

**ХОЁР. Сургалтын үйл ажиллагаа, цахим шилжилт**

2.1. Элсэлт .....	32
2.2. Шилжилт хөдөлгөөн, кредит дүйцүүлэлт .....	33
2.3. Бакалаврын сургалт, хичээл зохицуулалт .....	35
2.4. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл .....	36
2.5. Ерөнхий боловсролын ахлах сургууль .....	39
2.6. “ШУТИС-КООСЭН” технологийн коллеж .....	40
2.7. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн сургалт .....	42
2.8. “Ерөнхийлөгчийн илгээлт 2021” тэтгэлэгт бэлтгэл хөтөлбөрийн сургалт .....	44
2.9. Цагийн сургалт .....	46
2.10. Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт .....	47
2.11. Төгсөх оюутны дүн, төлөвлөгөө тулгалт .....	49
2.12. Оюутны сэтгэл ханамжийн судалгаа .....	49
2.12.1. Суралцагчийн ерөнхий сэтгэл ханамжийн судалгаа .....	49
2.13. Төгсөлт .....	51
2.14. Магистрын сургалт .....	54
2.14.1. Магистрын сургалтын үйл ажиллагаа .....	55
2.15. Боловсролын зээлийн сан .....	57
2.16. Суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн (гра) .....	59
2.17. Хөтөлбөрийн ерөнхий хорооны үйл ажиллагаа .....	70
2.18. Нээлттэй боловсрол.....	72
2.19. Мэдээллийн технологи, цахим шилжилт.....	82
2.19. Мэдээллийн технологийн хүрээнд шинээр хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ .....	83
2.19.1 удирдлагын мэдээлэлийн программ хөгжүүлэлт .....	92

**ГУРАВ. Эрдэм шинжилгээ, инновац, технологи дамжуулалт**

3.1. Эрдэм шинжилгээний арга хэмжээ.....	102
3.2. Судалгаа, боловсруулалтын ажил .....	108
3.2.1. Гэрээт ажил.....	108
3.2.2. Хамтын ажиллагаа .....	111
3.2.3. Гадаадын санхүүжилттэй бусад төсөл.....	113
3.3. “Инженер технологийн дээд боловсрол” (mjeed) төсөл .....	115
3.3.1. Судалгааны хүний нөөцийг чадавхжуулах .....	116
3.3.2. Судалгаа боловсруулалтын ажил.....	117
3.3.3. Судалгааны орчныг сайжруулах хүрээнд судалгааны лаборатори байгуулах ...	118
3.4. Судалгааны хүрээлэн.....	121
3.4.1. Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн .....	122
3.4.2. Уул уурхайн хүрээлэн.....	125
3.4.3. Ой модны сургалт судалгааны хүрээлэн .....	127
3.4.4. Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн .....	130
3.6. Судалгааны лаборатори .....	131
3.7. Судалгааны хүний нөөц.....	135
3.8. Эрдэм шинжилгээний хэвлэн нийтлэл.....	135
3.8.1. “Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл” .....	135
3.8.2. “Манай эрдэмтэд” цуврал бүтээл.....	136



3.8.3. “Шинжлэх ухаан, технологи” үйлдвэрлэл, танин мэдэхүйн сэтгүүл .....	137
3.8.4. ШУГИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргадаг дотоодын болон олон улсын сэтгүүл.....	137
3.8.5. Бусад их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын сэтгүүлд нийтэлсэн бүтээл.....	139
3.9. Багш нарын гуурвисан бүтээл .....	140
3.10. Олон улсад хэвлэгдсэн бүтээлүүд.....	140
3.11. Эрдэм шинжилгээний мэдээллийн систем.....	143
3.12. Докторын сургалтын үйл ажиллагаа .....	146
3.12.1. Докторантурын сургалтын элсэлтийн үйл ажиллагаа.....	149
3.12.2. Докторантурын сургалтын төгсөлтийн үйл ажиллагаа.....	153
3.12.3. Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалж, төгссөн эрдэмтдийн мэдээлэл.....	154
3.12.4. Докторантурт суралцагчдын голч дүнгийн судалгаа.....	156
3.13. Бүтээлийн хуулбарлалтыг шалгах программ хангамж.....	157
3.13.1. Бүтээлийн хуулбарлалт шалгах программ хангамжийн ашиглалт, үр дүн.....	157

### **ДӨРӨВ. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа**

4.1. Гадаад томилолт, мэргэжил дээшлүүлэлт .....	162
4.2. Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг .....	162
4.3. Гадаадын мэргэжилтэн, багш зочин профессор .....	163
4.4. Оюутан солилцоо, гадаадын тэтгэлэг .....	164
4.5. Гадаадын тэтгэлгүүд .....	165
4.6. Гадаадын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт .....	165

### **ТАВ. Оюутны хөгжил, эрүүл мэндийн үйлчилгээ**

5.1. Хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа .....	168
5.1.1. Сургалт, судалгаа .....	168
5.2. Эрдэм, шинжилгээ судалгааны ажил .....	177
5.3. Оюутны тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлт .....	186
5.4. Нэгдсэн арга хэмжээ .....	189
5.4.1. 2021-2022 оны намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа .....	189
5.4.2. ШУГИС-ийн урлагийн клубүүдийн “Оюутны хавар” тайлан тоглолт .....	190
5.4.3. “Must open mic” .....	191
5.4.4. Хотын соёл аян .....	193
5.4.5. Англи хэлний олимпиад .....	194
5.4.6. Монгол хэл бичгийн олимпиад .....	195
5.4.7. Чөлөөт уншлага төсөл .....	196
5.4.8. ШУГИС-ийн урлагийн XIX наадам .....	197
5.5. Төрийн өмчийн 6 их сургуулийн санамж бичигт тусгагдсан “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд .....	197
5.5.1. “Орлоготой оюутан” хөтөлбөрийн судалгаа .....	197
5.5.2. “Би орлоготой оюутан” видео контентын уралдаан .....	198
5.5.2. “Хотын соёл” аяныг төрийн өмчийн 6 сургуульд хэрэгжүүлнэ .....	200
5.5.3. Оюутны үнэт зүйлийн судалгаа .....	201
5.5.4. 2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улирлын “Ажлын байрны үзэсгэлэн яармаг” өдөрлөг .....	201
5.5.5. Төгсөгч оюутныг мөшгөх судалгаа .....	202
5.5.6. “Оюутан цэрэг” мэргэжил олгох сургалт .....	202
5.5.7. Оюутны клубүүдийн үйл ажиллагаа .....	204
5.6. Эрүүл мэндийн үйлчилгээ урьдчилан сэргийлэх үзлэг .....	209
5.6.1. Амбулаторийн үзлэгийн мэдээ .....	210
5.6.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ .....	211
5.6.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ .....	215
5.6.4. Корона вирусийн халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хяналт тандалт .....	219





### **ЗУРГАА. Номын сангийн үйлчилгээ, хэвлэн нийтлэл**

6.1. Шинжлэх ухаан, технологийн номын сан .....	228
6.2. Номын сангийн үйлчилгээ, фонд бүрдүүлэлт .....	228
6.3. Номын сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээ .....	232
6.4. Номын сангийн соёлын хөтөлбөрт ажил: .....	235

### **ДОЛОО. Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ**

7.1. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 стандарт .....	244
7.1.1. Чанарын талаарх мэдлэг, ойлголт .....	244
7.1.2. Эрсдэлийн менежмент .....	246
7.1.3. Үл тохирол, залруулах арга хэмжээ .....	248
7.1.4. Баримтжуулсан мэдээлэл .....	249
7.1.5. Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудит .....	249
7.1.6. Удирдлагын дүн шинжилгээний уулзалт .....	253
7.2. “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл” .....	255
7.2. Дотоод хяналт .....	256
7.2.1. БУХС-ийн 2019-2020 оны сургалтын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийв	256
7.2.2. ШУТИС-ийн 2021, 2022 оны эхний хагас жилийн хугацааны ил тод байдлын хууль эрх зүйн актын хэрэгжилтийг гаргаж, хяналт шинжилгээ хийсэн .....	256
7.2.3. ШУТИС-ийн захирлын тушаалаар шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. ....	257
7.3. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа .....	258
7.3.1. мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн ажил .....	258
7.4. Маркетинг, олон нийттэй харилцах .....	259
7.4.1. Мэргэжил сурталчлах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил .....	260
7.4.2. Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа .....	265
7.4.3. ШУТИС, МХТС-ийн “Scence fm 94.1” фм радио .....	267

### **НАЙМ. Хөрөнгө оруулалт, хангамж, санхүү бүртгэл, дотоод аудит, байр ашиглалт**

8.1. Төсөв .....	272
8.2. Өмч хөрөнгийн тайлан, мэдээ гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах .....	277
8.3. Сургалтын төлбөрийн болон бусад авлагыг багасгах .....	278
8.4. Санхүү, бүртгэл .....	279
8.5. Санхүүгийн тайлан баланс .....	282
8.6. Санхүү тайлангийн аудитын үр дүн .....	288
8.7. Дотоод аудит .....	288
8.8. Байр ашиглалт .....	291